



ШИНЭ ГЭРЭЭ 2019

Ирээд, Намайг дага— Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав

Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдарч, судалж, заах нь

ШИНЭ ГЭРЭЭ 2019

Ирээд, Намайг дага— Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав

Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдарч, судалж, заах нь

Агуулга

| | |
|------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Хөрвүүлэгдэх нь бидний зорилго | VV |
| <i>Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав</i> гарын авлагыг ашиглах нь | VI |
| Хувиараа судар судлах үйл явцыг сайжруулах санаанууд | VII |
| Гэр бүлээрээ судар судлах үйл явцыг сайжруулах санаанууд | IX |
| Нэмэлт эх сурвалж | XI |
| Бага насны хүүхдүүдэд заах нь | XII |
| 12-р сарын 31-ээс 1-р сарын 6: Бид өөрсдөө суралцах үүрэгтэй | 2 |
| 1-р сарын 7-13: Матай 1; Лук 1 | 6 |
| 1-р сарын 14-20: Лук 2; Матай 2 | 10 |
| 1-р сарын 21-27: Иохан 1 | 14 |
| 1-р сарын 28-аас 2-р сарын 3: Матай 3; Марк 1; Лук 3 | 18 |
| 2-р сарын 4-10: Матай 4; Лук 4-5 | 22 |
| 2-р сарын 11-17: Иохан 2-4 | 27 |
| 2-р сарын 18-24: Матай 5; Лук 6 | 32 |
| 2-р сарын 25-аас 3-р сарын 3: Матай 6-7 | 36 |
| 3-р сарын 4-10: Матай 8-9; Марк 2-5 | 41 |
| 3-р сарын 11-17: Матай 10-12; Марк 2; Лук 7; 11 | 46 |
| 3-р сарын 18-24: Матай 13; Лук 8; 13 | 50 |
| 3-р сарын 25-31: Матай 14-15; Марк 6-7; Иохан 5-6 | 54 |
| 4-р сарын 1-14: Матай 16-17; Марк 9; Лук 9 | 58 |
| 4-р сарын 15-21: Христийн амилсны баяр | 62 |
| 4-р сарын 22-28: Матай 18; Лук 10 | 66 |
| 4-р сарын 29-өөс 5-р сарын 5: Иохан 7-10 | 70 |
| 5-р сарын 6-12: Лук 12-17; Иохан 11 | 74 |
| 5-р сарын 13-19: Матай 19-20; Марк 10; Лук 18 | 78 |
| 5-р сарын 20-26: Матай 21-23; Марк 11; Лук 19-20; Иохан 12 | 82 |
| 5-р сарын 27-оос 6-р сарын 2 Иосеф Смит—Матай 1; Матай 25; Марк 12-13; Лук 21 | 86 |
| 6-р сарын 3-9: Иохан 13-17 | 90 |
| 6-р сарын 10-16: Матай 26; Марк 14; Лук 22; Иохан 18 | 94 |
| 6-р сарын 17-23: Матай 27; Марк 15; Лук 23; Иохан 19 | 98 |
| 6-р сарын 24-30: Матай 28; Марк 16; Лук 24; Иохан 20-21 | 102 |
| 7-р сарын 1-7: Үйлс 1-5 | 106 |
| 7-р сарын 8-14: Үйлс 6-9 | 111 |
| 7-р сарын 15-21: Үйлс 10-15 | 115 |
| 7-р сарын 22-28: Үйлс 16-21 | 119 |

| | |
|--------------------------------------------------------------------|-----|
| 7-р сарын 29-өөс 8-р сарын 4: Үйлс 22–28 | 123 |
| 8-р сарын 5–11: Ром 1–6 | 127 |
| 8-р сарын 12–18: Ром 7–16 | 132 |
| 8-р сарын 19–25: 1 Коринт 1–7 | 136 |
| 8-р сарын 26-аас 9-р сарын 1: 1 Коринт 8–13 | 140 |
| 9-р сарын 2–8: 1 Коринт 14–16 | 144 |
| 9-р сарын 9–15: 2 Коринт 1–7 | 149 |
| 9-р сарын 16–22: 2 Коринт 8–13 | 153 |
| 9-р сарын 23–29: Галат. | 157 |
| 9-р сарын 30-аас 10-р сарын 13: Ефес. | 161 |
| 10-р сарын 14–20: Филиппой; Колоссай. | 165 |
| 10-р сарын 21–27: 1 and 2 Тесалоник | 169 |
| 10-р сарын 28-аас 11-р сарын 3: 1 ба 2 Тимот; Тит; Филемон. | 173 |
| 11-р сарын 4–10: Еврей 1–6 | 178 |
| 11-р сарын 11–17: Еврей 7–13 | 182 |
| 11-р сарын 18–24: Иаков. | 186 |
| 11-р сарын 25-аас 12-р сарын 1: 1 ба 2 Петр. | 190 |
| 12-р сарын 2–8: 1–3 Иохан; Иуда. | 194 |
| 12-р сарын 9–15: Илчлэлт 1–11 | 198 |
| 12-р сарын 16–22: Христийн мэндэлсний баяр. | 202 |
| 12-р сарын 23–29: Илчлэлт 12–22. | 206 |

Сүмийн тогтмол цуглаанууд болохгүй ням гаргуудыг харгалзан, хуваариа өөрчилж болно. Тухайлбал, та тойрог, гадасны чуулгантай юм уу ариун сүмийн онцгойлон адислалт болох үед хоёр долоо хоногийн тоймыг нэг ням гаргийн хичээлд багтаан зааж болно. Хэрэв танай бүсэд Христийн амилсны баяр болон Христийн мэндэлсний баярыг энэ материал дахь жагсаалтад тусгасан өдрүүдэд тэмдэглэхгүй бол та суралцах хуваарийг өөрчилж болно.



Хөрвүүлэгдэх нь бидний зорилго

Сайн мэдээнээс суралцаж, заах бүхий л зорилго нь хөрвөлтөө гүнзгийрүүлж, Есүс Христтэй илүү адилхан болоход бидэнд туслах явдал юм. Энэхүү шалтгааны улмаас бид сайн мэдээнээс суралцахдаа зөвхөн шинэ мэдээлэл хайдаггүй, “шинэ бүтээл” болохыг эрмэлздэг (2 Коринт 5:17-г үзнэ үү). Энэ нь зүрх сэтгэл, хандлага, үйлдэл, мөн чанараа өөрчлөхийн тулд Христэд тулгуурлана гэсэн үг юм.

Бидний итгэлийг хүчирхэгжүүлж, хөрвөлтийн гайхамшигт өөрчлөлт рүү хөтөлдөг арга замаар сайн мэдээнээс суралцах үйл явц нэг дор тохиодоггүй. Энэ нь ангиас гарч, хувь хүний зүрх сэтгэл, гэр орон руу өргөжин тэлдэг. Энэ нь сайн мэдээг ойлгож, үүний дагуу амьдрах өдөр тутмын, байнгын хичээл зүтгэлийг шаарддаг. Жинхэнээсээ хөрвөхөд Ариун Сүнсний нөлөө шаардлагатай.

Ариун Сүнс биднийг үнэн рүү хөтөлж, тэрхүү үнэнийг гэрчилдэг (Иохан 16:13-ыг үзнэ үү). Тэр бидний

оюун санааг гэрэлтүүлж, ойлгоцыг түргэсгэж, бүхий л үнэний эх сурвалж болох Бурханаас ирэх илчлэлтээр зүрх сэтгэлд маань хүрдэг. Ариун Сүнс бидний зүрх сэтгэлийг ариусгадаг. Тэрээр бидний үнэний дагуу амьдрах хүслийг өдөөдөг бөгөөд үүнийг хийх арга замуудыг бидэнд шивнэн хэлдэг. Үнэнийг хэлэхэд, “Ариун Сүнс [бидэнд] бүх зүйлийг заана” (Иохан 14:26).

Эдгээр шалтгааны улмаас бид сайн мэдээний дагуу амьдарч, суралцаж, заахдаа хамгийн түрүүнд Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлэх хэрэгтэй. Энэхүү зорилго нь бидний сонголтуудыг тодорхойлж, бодол, үйлдлийг маань удирдаж байх ёстой. Бид Сүнсний нөлөөг урьдаг аливаа зүйлсийг эрэлхийлж, тэрхүү нөлөөг холдуулдаг зүйлсийг эсэргүүцэж байх хэрэгтэй. Учир нь бид Ариун Сүнсний оршихуйд байж чадахуйц зохистой байж чадвал Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христийн оршихуйд амьдрахуйц зохистой байж чадна гэдгийг бид мэддэг.

Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав гарын авлагыг ашиглах нь

Энэхүү эх сурвалж хэнд зориулагдсан бэ?

Энэ нь Сүмийн хувь хүн, гэр бүл болгонд зориулагдсан. Уг гарын авлага нь бие даан эсвэл гэр бүлээрээ сайн мэдээнээс суралцахад тань туслах зорилготой. Хэрэв та урьд нь сайн мэдээнээс тогтмол суралцаж байсан бол энэхүү эх сурвалж танд суралцаж эхлэхэд тусална. Хэрэв та сайн мэдээнээс суралцах сайн хэвшилтэй аль хэдийн болсон бол энэ нь танд илүү ач холбогдолтой туршлага олж авахад туслах болно.

Би энэ эх сурвалжийг хэрхэн ашиглах вэ?

Үүнийг өөртөө тустай ямар ч арга замаар ашиглаж болно. Энэ нь хувиараа болон гэр бүлээрээ судар судлах тусламж эсвэл удирдамж болохын хувьд танд тустай байж болох юм. Мөн та үүнийг гэр бүлийн үдэштээ ашиглаж болно. Тойм нь Шинэ Гэрээнд гардаг чухал зарчмуудыг тодотгож өгдөг бөгөөд хувь хүн, гэр бүлүүдэд зориулсан суралцах санаа, үйл ажиллагааг санал болгож, сэтгэгдлээ бичих зайг гаргаж өгдөг.

Та болон таны гэр бүлийнхэн сайн мэдээнээс аль хэдийн тогтмол суралцдаг болсон байж болно. Та Мормоны Номыг унших зорилго тавьсан байж ч магадгүй. Эсвэл та семинар юм уу институтийн ангидаа өөр судраас уншиж байж болно. *Ирээд, Намайг дага* суралцах материал нь таны аль хэдийн хийгээд эхэлчихсэн сайн зүйлсийг орлох эсвэл тэдгээртэй өрсөлдөх зорилгогүй. Энд бусад судар судлах зорилгоо биелүүлэх мөн Шинэ Гэрээнээс тогтмол суралцах арга зам байж болох юм. Жишээлбэл, та хувиараа судар судлахдаа Мормоны Номноос үргэлжлүүлэн уншиж, харин гэр бүлээрээ Шинэ Гэрээнээс уншиж болно (эсвэл эсрэгээрээ). Эсвэл та Шинэ Гэрээнээс уншихдаа суралцаж байгаа зүйлийг тань баталсан Мормоны Номын хэсгийг хайж олж болно. Бурханы үгнээс хэрхэн суралцах аргаа тодорхойлохын тулд Сүнсний удирдамжийг дага.

Энэхүү эх сурвалж Сүмд болж буй зүйлтэй хэрхэн холбогдож байна вэ?

Энэ эх сурвалжийн тойм долоо хоног тутмын унших хуваарийн дагуу бэлтгэгдсэн. Хүүхдийн хэсэгт болон Ням гаргийн ангиудад зааж байгаа хичээлүүд энэхүү хуваарийн дагуу явагддаг. Гэртээ сайн мэдээнээс суралцаж, үүнийхээ дагуу амьдрах хичээл зүтгэлээ нэмэгдүүлэхийн тулд багш нар тань долоо хоногийн турш судалсан судрын хэсгийнхээ талаарх асуулт, бодол санаа, туршлагыг хуваалцах боломжийг танд олгох болно.

Ирээд, Намайг дага—Хүүхдийн хэсэгт зориулав болон *Ирээд, Намайг дага—Ням гаргийн ангид зориулав* гарын авлагууд нь бүтэн жилийн хугацаанд Ерөнхий чуулган болдог хоёр ням гаргаас бусад бүх долоо хоногийн тоймыг багтаадаг. Гадасны чуулган болох юм уу өөр ямар нэгэн шалтгаанаар Сүмийн тогтмол цугларалтууд болоогүй тохиолдолд та гэртээ Шинэ Гэрээг үргэлжлүүлэн судлаарай. Сүмийн ангиуд тань энэ өдрүүдэд заагдах байсан хичээлүүдийн хуваариа дагахын тулд алгасах эсвэл хоёр хичээлийг нийлүүлэн зааж болно.

Би энэ хуваарийг дагах шаардлагатай юу?

Уг хуваарь танд Ням гаргийн ангид үзсэн зүйлтэй зэрэгцэж явахад туслах хэдий ч заавал үүнийг дагах ёстой гэсэн үг биш. Хуваарь нь зүгээр өөрийнхөө алхмыг хянахад танд туслах хөтөч юм. Хамгийн чухал зүйл бол та хувиараа болон гэр бүлээрээ сайн мэдээнээс суралцаж байгаа явдал билээ.





Хувиараа судар судлах үйл явцыг сайжруулах санаанууд

Судрууд дахь Бурханы үгсийг илүү үр дүнтэй суралцах зарим энгийн арга байдаг. Үүнд:

Есүс Христийн тухай үнэнийг эрж хай

Судрууд бидэнд бүх зүйл Христийг гэрчилдэг гэдгийг заадаг (2 Нифай 11:4; Мосе 6:63-ыг үзнэ үү) учраас Шинэ Гэрээний үйл явдал, түүх, сургаалуудаас Түүнийг эрж хай. Аврагчийн тухай болон Түүнийг хэрхэн дагах тухай заадаг шүлгүүдийг онцолж эсвэл тэмдэглэж болно.

Сүнслэг нөлөө бүхий үг, хэллэгүүдийг эрж хай

Танд онцгойлон зориулан бичсэн мэт нөлөөлж байгаа тодорхой үг, хэллэгүүдийг судруудаас олж болно. Тэдгээр нь хувь хүний хувьд танд хамаатай, сүнслэг нөлөө, урам зориг төрүүлэхүйц санагдаж магадгүй. Тэдгээр үг, хэллэгийг судар дээрээ тэмдэглэх юм уу судрын тэмдэглэл дээрээ бичиж болно.

Сайн мэдээний үнэнүүдийг эрж хай

Заримдаа сайн мэдээний үнэнүүдийг (ихэнхдээ сургаал эсвэл зарчмууд гэгддэг) шууд илэрхийлсэн байдаг бол зарим тохиолдолд жишээгээр эсвэл түүхээр дамжуулан тайлбарладаг. “Эдгээр шүлэгт

ямар мөнхийн үнэнүүдийг заасан байна вэ?” гэж өөрөөсөө асуу.

Сүнсийг сонс

Уншиж буй зүйлтэй тань хамааралгүй байсан ч бодол, мэдрэмжиндээ анхаарлаа төвлөрүүл. Эдгээр нөлөө нь Тэнгэрлэг Эцэгийн таныг сураасай хэмээн хүссэн зүйл ч байж магадгүй.

Судруудыг өөрийн амьдралтай адилтга

Та уншиж буй түүх, сургаалаа амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар эргэцүүлэн бод. Жишээлбэл, та өөрөөсөө “Надад уншиж буй зүйлтэй маань адил юу тохиолдсон билээ?” эсвэл “Судар дээрх энэ хүний үлгэр жишээг би хэрхэн дагаж чадах вэ?” гэж асууж болно.

Суралцаж байхдаа асуу

Таныг судруудаас суралцаж байхад оюун бодолд тань асуултууд орж ирж болно. Эдгээр асуулт нь таны уншиж байгаа зүйлтэй эсвэл ерөнхийдөө таны амьдралтай холбоотой байж болох юм. Та үргэлжлүүлэн судраас суралцаж байхдаа эдгээр асуултыг тунгаан бодож, хариултыг нь эрж хай.

Судар судлах тусламжийг ашигла

Уншиж буй шүлгүүдийнхээ талаар нэмэлт ойлголт олж авахын тулд зүүлт тайлбар, Topical Guide, Судруудын удирдамж, бусад судлах тусламжийг ашигла.

Төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ

Суралцаж байхдаа төрсөн сэтгэгдлээ тэмдэглэж авах олон арга зам бий. Жишээлбэл, та утга учир бүхий үг, хэллэгийг тэмдэглэж, төрсөн сэтгэгдлээ судар дээрээ бичиж болно. Мөн та хүлээж авсан ойлголт, мэдрэмж, сэтгэгдлээ тэмдэглэл дээрээ бичиж болно.

Хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг судал

Таны судраас олсон зарчмуудын талаар хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчид юу заасан тухай унш (жишээ нь, conference.lds.org болон Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг үзнэ үү).

Ойлголтуудаа хуваалц

Хувиараа судалж мэдсэн ойлголтынхоо талаар ярилцах нь бусдад заах сайн арга байхаас гадна уншсан зүйлийнхээ тухай ойлголтыг нэмэгдүүлэхэд тусалдаг.

Сурсан зүйлийнхээ дагуу амьдар

Судар судлах нь бидэнд сүнслэгээр нөлөөлөөд зогсохгүй биднийг амьдрах арга замаа өөрчлөхөд

хөтөлдөг. Уншиж байхад тань Сүнс юу хийхэд өдөөж байгааг сонс, дараа нь эдгээр өдөөлтийн дагуу үйлдэх амлалт өг.



Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бид судар уншиж, тунгаан бодох юм бол Сүнс бидний бодгальд зөөлнөөр шивнэх болно. Бид асуултынхаа хариуг олж чадах төдийгүй Бурханы зарлигуудыг сахиснаар ирдэг адислалуудыг ч мөн мэдэж авна. Түүнчлэн бид Тэнгэрлэг Эцэгийн болон бидний Аврагч Есүс Христийн талаар мөн Тэд биднийг хайрладаг тухай баттай гэрчлэлтэй болдог. Бид судар судлахаа залбиралтай хослуулснаар Есүс Христийн сайн мэдээ үнэн гэдгийг баттай мэдэж авч чадна. . . . Бид залбирч, судруудыг судлахад цаг гаргавал бидний амьдрал эцэс төгсгөлгүйгээр адислагдаж, ачаа маань хөнгөрөх болно” (“Бид хэзээ ч ганцаараа алхдаггүй,” 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 142–143) гэж хэлжээ.



Гэр бүлээрээ судар судлах үйл явцыг сайжруулах санаанууд

Гэр бүлээрээ судраас тогтмол суралцах нь гэр бүлдээ сайн мэдээнээс суралцахад нь туслах хүчирхэг арга юм. Гэр бүлээрээ хэр ихийг хэр удаан унших нь тогтмол хичээл зүтгэл гаргахтай адил тийм ч чухал биш. Та судар судлахыг гэр бүлийнхээ амьдралын чухал хэсэг болгосноор гэр бүлийнхээ гишүүдэд Есүс Христэд илүү ойртож, Түүний үгэн дээр суурилан гэрчлэлээ босгоход туслах болно. Дараах асуултуудыг тунгаан бод. Үүнд:

- Та гэр бүлийнхээ гишүүдийг хувиараа судруудаас суралцахад хэрхэн урамшуулж болох вэ?
- Та гэр бүлийнхнийгээ сурч байгаа зүйлсээ хуваалцахад урамшуулан дэмжихийн тулд юу хийж болох вэ?
- Өдөр бүрийн заах боломжтой мөчүүддээ Шинэ Гэрээнээс сурсан зарчмуудаа хэрхэн онцолж болох вэ?

Гэр орон бол сайн мэдээнээс суралцах хамгийн тохиромжтой газар юм гэдгийг сана. Сүмийн ангиудад боломжгүй тийм арга замаар гэртээ сайн мэдээнээс суралцаж, зааж болно. Гэр бүлдээ судраас суралцахад нь туслах арга замуудыг бодож олохын тулд санаачилгатай бай. Гэр бүлийнхээ судар судлах үйл явцыг сайжруулахын тулд дараах санаануудаас заримыг ашигла. Үүнд:

Утга учир бүхий судар хуваалц

Хувиараа суралцах үедээ олж мэдсэн утга учир бүхий судрын хэсгийг гэр бүлийнхэнтэйгээ хуваалцах цаг гарга.

Өөрийнхөө үгээр ярь

Судраас сурсан зүйлээ өөрийн үгээр дүгнэн хэлэхийг гэр бүлийнхнээсээ хүс.

Судруудыг амьдралдаа хэрэгжүүл

Судрын хэсгийг уншсаныхаа дараа үүнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх арга замуудыг хуваалцахад гэр бүлийнхнийгээ урь.

Асуулт тавь

Гэр бүлийнхнийгээ сайн мэдээний тухай асуулт тавихад уриад, уг асуултад хариулахад туслах шүлгийг эрж олоход цаг гарга.

Судар үзүүл

Танд утга учиртай санагдсан шүлгийг сонгож, гэр бүлийн гишүүдийнхээ тогтмол харж болох газарт байрлуул. Ээлжлэн үзүүлэх судраа сонгоход гэр бүлийнхнээ урь.

Судрын жагсаалт гарга

Гэр бүлээрээ ирэх долоо хоногт хэлэлцэх хэд хэдэн шүлэг сонго.

Судруудыг цээжил

Гэр бүлийн тань хувьд утга учир бүхий судрын хэсгийг сонгоод, гэр бүлийнхнээ өдөр бүр давтан уншихад эсвэл цээжлэх тоглоом тоглосноор уг хэсгийг цээжлэхэд урь.

Үзүүлэнт хичээлүүдийг заа

Гэр бүлээрээ уншиж буй бүлгүүд эсвэл шүлгүүдтэй холбоотой үзүүлэн ол. Судрууд дахь сургаал үзүүлэнгүүдтэй хэрхэн холбогдож байгаа тухай ярилцахыг гэр бүлийн гишүүдээс хүс.

Сэдэв сонго

Гэр бүлээрээ хамтдаа суралцах сэдвийг гэр бүлийн гишүүдээр ээлжлэн сонгуул. Тухайн сэдвийн тухай судрын хэсгийг олохын тулд Topical Guide эсвэл Судруудын удирдамж (scriptures.lds.org)-ийг ашигла.

Зураг зур

Гэр бүлээрээ хэдэн шүлэг уншсаны дараа уншсан зүйлтэйгээ холбоотой ямар нэгэн зүйл зурахад цаг зарцуул. Нэг нэгнийхээ зурсан зүйлийн тухай ярилцах цаг гарга.

Түүхийг жүжигчлэн тогло

Түүх уншсаныхаа дараа гэр бүлийнхээ гишүүдийг энэ тухай жүжигчлэн тоглоход урь. Дараа нь уг түүх хувь хүн бүрд болон гэр бүлд тань тохиолдож буй зүйлстэй хэрхэн холбогдож байгаа тухай ярилц.



Ахлагч Дэвид А.Бэднар “Гэр бүлийн залбирал бүр, гэр бүлээрээ судраас суралцах цаг мөч бүр мөн гэр бүлийн үдэш бүр бидний зүрх сэтгэл дэх зурган дээр нэгэн бийрээр зураас татдаг юм. Ямар нэгэн үйл явдал дангаараа дурсгалтай, сэтгэл хөдөлгөм байдаггүй байж болно. Гэхдээ шаргал, алтан шаргал, бор өнгөнүүд нэг нэгтэйгээ нэгдэн нийлж, гайхамшигт зургийг бий болгосон шиг бид жижиг зүйлсийг байнга хийх нь агуу сүнслэг байдалд хүргэнэ” (“Гэр орондоо анхаарал төвлөрүүлж, санаа тавьж байх нь,” 2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 18) хэмээн заажээ.



Нэмэлт эх сурвалж

Эдгээр бүх эх сурвалжийг Gospel Library аппликэйшн болон LDS.org вэбсайт дээрээс олж болно.

Сүмийн сэтгүүл

Лиахона сэтгүүлд гардаг түүх, үйл ажиллагаанууд нь *Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав* гарын авлагаас таны зааж буй зарчмуудад нэмэлт эх сурвалж болж чадна.

Сүмийн дуулал болон *Children's Songbook*

Ариун нандин хөгжим Сүнсийг урьдаг бөгөөд сургаалыг мартагдашгүй арга замаар заадаг. *Сүмийн дуулал* болон Хүүхдийн дуу зэрэг номын хэвлэмэл хувилбараас гадна music.lds.org дээр зарим дуулал, хүүхдийн дуунуудыг аудио хувилбараар олж болно.

Шинэ Гэрээний түүхүүд

Шинэ Гэрээний түүхүүд (2005) нь хүүхдүүдэд Шинэ Гэрээн дээр байдаг сургаал, түүхүүдээс суралцахад тусална. Gospel Library аппликэйшн болон medialibrary.lds.org вэбсайтаас эдгээр түүхийн видео бичлэгийг үзэж болно.

Институт, семинарын гарын авлага

Институт, семинарын гарын авлагуудад судруудад гардаг зарчим, шастирын сургаалын тайлбар, түүхэн үндэслэл агуулагддаг.

Медиа сан

Уран зураг, видео бичлэг, бусад медиа нь танд болон танай гэр бүлд Шинэ Гэрээнд гардаг сургаал, түүхүүдийг төсөөлөн бодоход тусална. Шинэ Гэрээнд гардаг үйл явдлуудыг зураглан харуулдаг Ариун Библийн видео бичлэгүүдийг багтаасан Сүмийн мэдээллийн эх сурвалжийн цуглуулгыг үзэхийн тулд Medialibrary.lds.org руу орно уу.

Итгэлдээ үнэнч байх нь

Сайн мэдээний энгийн зарчмуудыг ойлгоход нэмэлт тусламж хэрэгтэй бол *Итгэлдээ үнэнч байх нь* (2004) товхимлыг үзнэ үү. Энэхүү эх сурвалж нь сайн мэдээний сэдвүүдийг үсгийн дарааллаар жагсаан, энгийн тайлбар өгдөг.

Бага насны хүүхдүүдэд заах нь

Танай гэр бүл бага насны хүүхдүүдтэй бол дараах үйл ажиллагаанууд тэдэнд суралцахад нь туслах болно.

- *Түүх сонсох эсвэл жүжигчлэн үзүүлэх.* Бага насны хүүхдүүд судруудаас болон таны амьдралаас мөн Сүмийн түүх, сэтгүүл зэргээс түүхүүдийг сонсох дуртай байдаг. Түүхээ ярихдаа тэднийг оролцуулах арга замуудыг эрэлхийл. Тэд зураг эсвэл үзүүлэн барин зогсож, сонсож буй зүйлээ зурж, түүхийн үйл явдлыг жүжигчлэн үзүүлэх юм уу бүр түүх ярихад тусалж ч болно. Хуваалцаж байгаа түүхүүд дээрх сайн мэдээний үнэнийг ойлгож ухаарахад нь хүүхдүүддээ тусал.
- *Судар унших.* Бага насны хүүхдүүд тийм ч сайн уншиж чадахгүй байж болох ч та тэднийг судраас суралцахад оролцуулж болно. Та ганцхан шүлэг, түлхүүр үг хэллэг дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй байж болох юм. Судрын богино хэллэгийг хэд дахин давтан хэлбэл тэд цээжилж чадна. Тэд Бурханы үгийг сонсоод, Сүнснийг мэдэрнэ.
- *Зураг эсвэл видео бичлэг үзүүлэх.* Хүүхдүүддээ сайн мэдээний зарчим юм уу судрын түүхтэй холбоотой зураг харуулах эсвэл видео бичлэг үзүүлэхдээ харж байгаа зүйлээсээ суралцахад нь тус болох асуултуудыг тэдэнд тавь. Жишээлбэл, “Энэ зураг эсвэл бичлэг дээр юу болж байна вэ? Үүнийг үзэхэд та нарт ямар мэдрэмж төрж байна вэ?” гэж асууж болно. Сайн мэдээний номын сан аппликэйшн, Biblevideos.lds.org, medialibrary.lds.org, children.lds.org вэбсайтууд нь зураг, бичлэг олж үзэхэд тохиромжтой эх сурвалжууд юм.
- *Дуулах.* Hymns ба *Children's Songbook* номон дээрх дуунууд нь сургаалыг үр нөлөөтэй заадаг. Дуунуудын зааж буй захиасыг өөрсдийнхөө амьдралтай адилтгахад хүүхдүүддээ тусал. Жишээ нь, дууны шүлгэн дэх үг, хэллэгийн талаар асуултууд тавьж болно. Танай хүүхдүүд дуулахаас гадна дууны үгийг жүжигчлэн үзүүлж эсвэл өөр бусад

үйл ажиллагааг явуулах хооронд ард нь тавьсан хөгжмийг сонсож болно.

- *Хийж бүтээх.* Суралцаж байгаа зарчим, түүхүүдтэйгээ холбоотой ямар нэгэн зүйлийг барьж, зурж, будаж болно.
- *Хичээлд үзүүлэн материал ашиглах.* Энгийн үзүүлэн материал бүхий хичээл нь ойлгоход хэцүү сайн мэдээний зарчмуудыг хүүхдүүдэд ойлгуулахад тусалж болно. Үзүүлэнт хичээлийг заахдаа хүүхдүүдээ оролцуулах арга замуудыг хайж ол. Тэд зүгээр нэг үзэж харахаас илүү харилцан үйлддэг үйл ажиллагаанаас илүү ихийг сурна.
- *Дүр бүтээх.* Хүүхдүүд бодит амьдралд тулгарч болзошгүй нөхцөл байдлын талаар дүр бүтээхдээ сайн мэдээний зарчмууд тэдний амьдралд хэрхэн хэрэг болдгийг илүү сайн ойлгодог.
- *Үйл ажиллагаануудыг давтах.* Бага насны хүүхдүүд аливаа зүйлийг ойлгохын тулд хэд хэдэн удаа сонсох хэрэгтэй байж болно. Түүх, үйл ажиллагаануудыг хэд хэдэн удаа давтахаас бүү эмээ. Жишээлбэл, судрын түүхийг судраас унших, өөрийн үгээр товчилж ярих, бичлэг үзүүлэх, түүхүүдийг уншихдаа хүүхдүүдээрээ туслуулах, түүхийн утгыг жүжигчлэн үзүүлэхэд тэднийг урих гэх мэт өөр өөр арга замаар хэд хэдэн удаа хуваалцаж болно.





Дэл Парсон, Тэр амилсан



12-Р САРЫН 31-ЭЭС 1-Р САРЫН 6.

Бид өөрсдөө суралцах үүрэгтэй

Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав удирдамжийн зорилго нь Христэд ирж, Түүний сайн мэдээнд илүү гүн хөрвөгдөхөд тань туслах явдал юм. Энэхүү эх сурвалж нь судруудыг ойлгож, тэдгээрт байдаг танд болон гэр бүлд тань хэрэгтэй сүнслэг хүчийг олж авахад тусална. Ингэснээр та Сүмийн ангидаа санал бодлоо хуваалцах мөн бусад гэгээнтэнд Христийг дагахаар хичээж зүтгэж байгаад нь урам өгөх бэлтгэлтэй байх болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

“Та нар юу эрнэ вэ?” хэмээн Есүс шавь нараасаа асуусан (Иохан 1:38). Энэ жил таны Шинэ Гэрээнээс суралцах зүйлс эрж хайх зүйлээс тань шууд хамааралтай учраас та өөртөө энэ асуултыг тавьж болох юм. “Хай, тэгвэл та нар олно” (Матай 7:7) хэмээн Аврагч амласан. Суралцаж байх үедээ санаанд орж ирсэн асуултыг тавьж, хариултыг нь хичээнгүйлэн

эрэлхийл. Та Шинэ Гэрээнээс Есүс Христийн шавь нарын хүчирхэг сүнслэг туршлагын тухай унших болно. Та Аврагчийн итгэлтэй шавийн хувьд энэ ариун нандин номонд гардаг “Ирээд, Намайг дага” (Лук 18:22) хэмээх Түүний урилгыг хүлээн авснаар өөрийн гэсэн хүчирхэг сүнслэг туршлагыг олж авч чадна.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

Би чин сэтгэлээсээ Аврагчаас суралцахын тулд “Ирээд, Намайг дага” хэмээх Түүний урилгыг хүлээн авах ёстой.

“Ирээд, Намайг дага” хэмээсэн Аврагчийн урилга нь шавь байх зам дээр дөнгөж гарсан эсвэл бүхий л амьдралынхаа турш энэ замаар алхаж байгаа эсэхээс үл шалтгаалан бүх хүнд хамаатай. Энэ нь зарлигуудыг дагахыг хичээж байсан чинээлэг залуу эрд өгсөн Түүний урилга билээ (Матай 19:16–22-ыг үзнэ үү). Шавь байх гэдэг нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт бүхий л бодгиалиа зориулах гэсэн утгатай болохыг тэрээр ойлгож мэдсэн бөгөөд энэ нь бидний ч ойлгож авах ёстой зүйл юм. Тэднийг бүрэн дүүрэн дагахын тулд бидэнд юу дутагдаж байгаа болон юуг өөрчлөх, эрэлхийлэх хэрэгтэйг тодорхойлсноор бид шавь байх үйл явцдаа өсөж, хөгжиж байдаг.

Аврагчаас суралцах нь Түүний заасан зүйлсийг ойлгох хичээл зүтгэлээс эхэлдэг. Жишээ нь, дараах зүйлсийг судалж, мэдсэнээр өршөөл уучлалын талаарх таны ойлголт хэрхэн гүнзгийрсэн бэ?

Аврагчийн сургаалууд (Матай 6:14–15; 18:21–35-ыг үзнэ үү) _____

Аврагчийн амьдралын нэгэн жишээ (Лук 23:33–34-ийг үзнэ үү) _____

Гэвч Аврагчийн заасны дагуу амьдарч, Түүнийг дагахнаас нааш гүйцэд суралцаж чадахгүй. Та хэрхэн илүү өршөөнгүй байж чадах вэ? _____

Та энэ талаар илүү ихийг сурч мэдэхийг хүсвэл энэ дасгалыг хайр, даруу байдал зэрэг сайн мэдээний өөр зарчим дээр туршаад үзээрэй.

Би өөрөө суралцах үүрэгтэй.

Ахлагч Дэвид А.Бэднар “Та бид суралцагчийн хувьд үгийн дагуу үйлддэг, хийдэг хүмүүс байх ёстой

бөгөөд үйлдүүлдэг сонсогч төдий байж болохгүй. Та бид итгэлээр үйлддэг, суралцахыг эрэлхийлдэг хүмүүс үү эсвэл заалгахыг хүлээн, үйлдүүлэхийг хүсдэг хүмүүс үү? . . . Зөв зарчмуудын дагуу сонгох эрхээ ашигладаг суралцагч нь өөрийн зүрх сэтгэлийг Ариун Сүнсэнд нээж, Түүний зааж, гэрчлэх хүч болон нотлох гэрчийг урьдаг. Итгэлээр суралцах нь идэвхгүй хүлээн авахыг биш, харин сүнслэг байдал, оюун ухаан, бие бялдрын хувьд идэвхтэй хичээж чармайхыг шаарддаг” (“Итгэлээр суралцахыг эрэлхийл,” *Лиахона*, 2007 оны 9-р сар, 64) гэж заасан.

Та өөрөө суралцах үүрэгтэй гэдэг нь ямар утгатай вэ? Ахлагч Бэднарын хэлсэн үгээс болон дараах судруудаас боломжтой хариулуудыг ол. Иохан 7:17; 1 Тесалоник 5:21; Иаков 1:5–6, 22; 2:17; 1 Нифай 10:17–19; 2 Нифай 4:15; Алма 32:27 ба Сургаал ба Гэрээ 18:18; 58:26–28; 88:118. Та сайн мэдээнээс суралцахад илүү идэвхтэй байхын тулд ямар сүнслэг нөлөөллийг мэдэрдэг вэ?

Би үнэнийг өөрөө мэдэх хэрэгтэй.

Та амьдралд нь юу ч тохиолдож байсан бай, итгэлээ хэзээ ч алддаггүй мэт санагддаг хүмүүсийг мэдэх байх. Тэд танд Аврагчийн сургаалт зүйрлэлд гардаг ухаалаг таван охиныг санагдуулдаг байж болох юм (Матай 25:1–13-ыг үзнэ үү). Тэд үнэний талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд шаргуу хичээн зүтгэдэг нь танд харагддаггүй байж болно. Бид гэрчлэлээ хүчирхэгжүүлэхийн тулд хичээнгүйлэн эрэлхийлэх ёстой. Учир нь бид мунхаг охидын адил өөр хэн нэгний хөрвөлтийг зээлдэн хэрэглэж болохгүй.

Бид хэрхэн гэрчлэлтэй болж, үүнийгээ өсгөн нэмэгдүүлэх вэ? Дараах судруудыг тунгаан бодохдоо өөрт төрсөн бодлыг бичиж тэмдэглэ. Лук 11:9–13; Иохан 5:39; Иохан 7:14–17; Үйлс 17:10–12; 1 Коринт 2:9–11 болон Алма 5:45–46. (Түүнчлэн “Гэрчлэл” сэдвийг Судруудын удирдамж, topics.lds.org-оос үзнэ үү.)

Надад асуух зүйл байгаа үед би юу хийх ёстой вэ?

Сүнслэг мэдлэг эрэлхийлэх үед таны оюун бодолд асуултууд орж ирнэ. Дараах зарчмууд нь итгэл, гэрчлэлээ өсгөх замаар асуултуудаа тавихад танд тусална.

1. *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжуудаар дамжуулан ойлгохыг эрэлхийл.* Бурхан бол бүх үнэний эх сурвалж бөгөөд Тэрээр Ариун Сүнс, судар, бошиглогч, төлөөлөгчдөөрөө дамжуулан үнэнийг илчилдэг.

2. *Итгэлээр үйлд.* Хэрэв хариултууд тэр даруй ирэхгүй бол Их Эзэн зөв цагт хариултуудыг илчлэх болно гэдэгт итгэ. Тэр хугацаанд мэддэг үнэнийг хэзээ дагуу амьдар.
3. *Мөнхийн хэтийн төлөвийг баримтал.* Аливаа зүйлийг дэлхийн маягаар бус Их Эзэний адил харахыг хичээ. Асуултуудаа Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөнд хамааруулан хар.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 13:1-23

Энэ жил Шинэ Гэрээнээс суралцахаар бэлтгэхэд нь гэр бүлдээ туслах нэг сайн арга бол тариачны сургаалт зүйрлэлийг унших явдал юм. Гэр бүл тань сургаалт зүйрлэлд дүрсэлсэн олон янзын хөрсийг олж харахын тулд гэрийнхээ ойролцоох өөр өөр төрлийн газрыг харах нь зугаатай байж болно. Бид гэртээ “сайн хөрс” боловсруулахын тулд юу хийж болох вэ? (Матай 13:8).

ГАЛАТ 5:22-23; ФИЛИППОЙ 4:8

“Бид гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, сайн мэдээг судлах, зааварлах болон гэр бүлийн үр өгөөжтэй үйл ажиллагаануудад тэргүүн зэргийн ач холбогдол өгч байхыг эцэг эх, хүүхдүүдэд зөвлөж байна. Үр өгөөжтэй, тохиромжтой бусад ажил, үйл ажиллагаа байж болох ч, тэдгээр нь гагцхүү эцэг эх, гэр бүлийн гүйцэтгэж чадах тэнгэрлэг үүргийг орлох ёсгүй” (“Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг,” *Лиакхона*, 1999 оны 12-р сар, 1).

Жилийн эхэн үе бол гэр бүлийн зөвлөлөөрөө гэр бүлээ сайн мэдээнд илүү төвлөрүүлэх талаар хэлэлцэх маш тохиромжтой цаг юм. Галат 5:22-23, Филиппой 4:8-д өгүүлсэн зөвлөмж, адислалуудын тухай уншихад танд ямар санаа орж ирж байна вэ? Зорилгуудыг тань сануулах ханын сонин хийж, ханандаа хадаж болох юм.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Сургаалыг эрж ол. Сургаал бол мөнхийн, өөрчлөгдөшгүй үнэн юм. Ерөнхийлөгч Боид К.Пакэр “үнэн сургаалыг ойлговол энэ нь зан төлөв, харьцаа хандлагыг өөрчилдөг” хэмээн тунхагласан (“Little Children,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 17). Та гэр бүлтэйгээ судруудыг судлахдаа Аврагчтай илүү адил амьдрахад туслах үнэнийг олж хар.



Брэнт Боран, Дэлхийн гэрэл



1-Р САРЫН 7-13

Матай 1; Лук 1

“Хэлсэн үгсийн тань дагуу надад биелэх болтугай”

Матай 1, Лук 1-ийг уншаад, тунгаан бодож, хүлээн авсан сүнслэг сэтгэгдлээ бичиж тэмдэглэ. Та сургаалын ямар үнэнийг олсон бэ? Ямар захиас танд болон танай гэр бүлийн хувьд хамгийн үнэ цэнтэй байх вэ? Энэхүү тойм дахь суралцах санаанууд нь нэмэлт ойлголт олж авахад тань тус болж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Мөнх бус байдлын үүднээс бол энэ нь боломжгүй зүйл байсан юм. Онгон бүсгүй хүүхэд төрүүлж чадахгүй. Хүүхэд тээх наснаас хэтэрсэн, хүүсэр эмэгтэй ч мөн хүүхэд олж чадахгүй. Гэвч Бурхан Өөрийн Хүүгийн болон Иохан Баптистын төрөлтийг төлөвлөсөн байсан бөгөөд ямар ч саад бэрхшээлийг үл тоон Мариа, Елизабет хоёр ээж болцгоосон билээ. Боломжгүй мэт санагдсан ямар нэгэн зүйлтэй тулгарах бүрдээ тэдний гайхамшигтай туршлагыг санах нь бидэнд тус болж болно. Бид сул талуудаа ялан

дийлж чадах уу? Бид сургаалд тоомжиргүй ханддаг гэр бүлийнхээ гишүүний зүрх сэтгэлийг хөндөж чадах уу? Габриел “Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй” (Лук 1:37) хэмээн Мариад сануулахдаа бидэнд хандан ярьж байсан байж магадгүй. Мөн Бурхан Өөрийн хүслийг илэрхийлэхэд Мариагийн “Хэлсэн үгсийн тань дагуу надад биелэх болтугай” (Лук 1:38) гэж хэлсэн үгс бидний өгөх хариулт байж болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ, ЛУК НАРЫН САЙН МЭДЭЭ

Матай, Лук гэж ямар хүмүүс байсан бэ?

Матай татвар хураагч иудей хүн байсан бөгөөд Есүс түүнийг төлөөлөгчдийнхөө нэгээр дуудсан (Матай 10:3 мөн Судруудын удирдамж, Татвар хураагчийг үзнэ үү). Матай сайн мэдээгээ голчлон иудейчүүдэд зориулан бичсэн тул Есүсийн амьдрал, тохиуллаар дамжин гүйцэлдсэн Хуучин Гэрээн дэх Мессиагийн тухай бошиглолуудыг онцлон тодорхойлохыг зорьжээ.

Лук бол төлөөлөгч Паултай хамт аялан явдаг оточ харь хүн (иудей биш) байсан юм. Тэр Аврагчийг нас барсны дараа голчлон иудей биш уншигчдад зориулан сайн мэдээгээ бичсэн. Есүс Христ бол харийнхан болон иудей хүмүүсийн аль алиных нь Аврагч юм хэмээн тэр гэрчилсэн. Тэрээр Аврагчийн амьдралын үйл явдлуудыг нүдээр үзсэнээ цэдэглэн бичсэн бөгөөд бусад сайн мэдээтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн тухай түүхүүдийг илүү түлхүү багтаасан байдаг.

Судруудын удирдамжаас “Сайн мэдээнүүд,” “Матай,” “Лук”-ыг мөн үзнэ үү.

МАТАЙ 1:18–25; ЛУК 1:28–35

Аврагч яагаад мөнх бус эх, мөнхийн Эцэг хоёроос төрөх ёстой байсан бэ?

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Есүс Христийн Цагаатгал нь “үхэлд харьяалагддаггүй мөнх хүмүүнээр хийгдэх хувийн золиослолыг шаардаж байв. Тэрбээр үхээд Өөрийн бие махбодыг эргүүлэн авах ёстой байлаа. Аврагч үүнийг гүйцэлдүүлж чадах цорын ганц нь байсан юм. Тэрбээр эхээсээ үхэх хүчийг өвлөн авсан бол Эцэгээсээ үхлийг ялах хүчийг өвлөн авсан юм” хэмээн тайлбарласан (“Constancy amid Change,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 34).

ЛУК 1:5–25, 57–80

Бурханы адислалууд Түүний цаг хугацаанд ирдэг.

Ямар нэгэн шалтгаанаар Елизабет, Захариа хоёрын хүүхэдтэй болохыг хүссэн адислалыг тэдний

бодож байснаас хамаагүй хожуу өгсөн нь Бурханы цаг хугацааны зохицуулалт юм. Хэрэв та адислал ирэхийг хүлээж байгаа эсвэл Бурхан таны залбирлыг сонсохгүй байгаа мэт санагдаж байвал Елизабет, Захариа хоёрын түүх танд Бурхан таныг мартаагүй гэдгийг сануулах болно. Танд зориулсан төлөвлөгөө Түүнд байгаа бөгөөд Тэрээр зөв шударга гэгээнтнүүддээ өгсөн амлалтаа үргэлж биелүүлдэг билээ. Ахлагч Жэффри Р.Холландын амласнаар “Зарим адислал удалгүй ирдэг, зарим нь оройтож ирдэг, зарим нь тэнгэрт очих хүртэл ирдэггүй хэдий ч Есүс Христийн сайн мэдээг хүлээн авсан хүмүүсийн хувьд бол *заавал ирнэ*” (“An High Priest of Good Things to Come,” *Ensign*, 1999 оны 11-р сар, 38). Захариа, Елизабет хоёр хэрхэн итгэлтэй хэвээр байсан бэ? (Лук 1:5–25, 57–80-ыг үзнэ үү). Та адислал ирэхийг хүлээж байна уу? Хүлээж байхдаа юу хийхийг Их Эзэн танаас хүсэж байна гэж танд санагдаж байна вэ?

Энэхүү түүхэнд Их Эзэний танд зориулсан өөр ямар захиас байна вэ?



Елизабет, Захариа хоёр итгэлтэй хүлээсний эцэст хүүгээр адислагдсан билээ.

МАТАЙ 1:18–25; ЛУК 1:26–38

Итгэлтэй хүмүүс Бурханы хүслийг дуртайяа дагадаг.

Мариагийн адил бид заримдаа бидэнд зориулсан Бурханы төлөвлөгөө өөрсдийн маань төлөвлөж байснаас тэс өөр болохыг олж мэддэг. Та Мариагийн Бурханы хүслийг хүлээн зөвшөөрсөн тухай түүхээс юу сурсан бэ? Дараах хүснэгтэд тэнгэр элч, Мариа хоёрын хэлсэн үгсээс (Лук 1:26–38-ыг үзнэ үү) мөн тэдний үгсээс олж харсан захиасаа бичнэ үү.

| | |
|----------------------------------------|--------------------------------------------------------|
| Мариад хэлсэн Тэнгэр элчийн үгс | Надад зориулсан захиас |
| “Эзэн чамтай хамт байна” (28-р шүлэг). | Их Эзэн миний нөхцөл байдал, зовлон зүдгүүрийг мэддэг. |
| | |

| | |
|-----------------------------------------|--------------------------------------------|
| Мариагийн хариу үйлдэл | Надад зориулсан захиас |
| “Энэ нь яаж бүтэх билээ?” (34-р шүлэг). | Ойлгохгүй байгаа үедээ асуулт тавьж болно. |
| | |

Та Матай 1:18–25-д гардаг Иосефын зөвт үлгэр жишээг уншаад, Бурханы хүслийг хүлээн зөвшөөрөх тухай юу сурч болох бэ? Та Захариа, Елизабет

хоёрын туршлагаас юу сурч болох вэ? (Лук 1-ийг үзнэ үү).

Түүнчлэн Мозая 3:19; Лук 22:42; Хиламан 10:4–5 болон Судруудын удирдамжаас “Габриел”-ыг үзнэ үү.

ЛУК 1:46-55

Мариа Есүс Христийн номлолын тухай гэрчлэв.

Лук 1:46–55 дахь Мариагийн үгс Аврагчийн номлолыг урьдчилан хэлсэн байдаг. Та Мариагийн хэлсэн үгсээс Есүс Христийн тухай юу мэдэж авсан бэ? Эдгээр шүлгийг 1 Самуел 2:1–10 дахь Ханнагийн үгс, Матай 5:4–12 дахь Есүсийн ерөөлүүдтэй харьцуулснаар Аврагчийн санал болгодог адислалуудын тухай ямар нэмэлт ойлголтуудыг олж авсан бэ? Эдгээр ойлголтыг тунгаан бодох үед Сүнс танд юу заадаг вэ?



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 1:1-17

Гэр бүл тань Есүсийн удмын бичгийг уншиж байх хооронд та Түүний удам Иосефоос дээш Давид хаан хүртэл явдгийг тайлбарлаж болно. Давидын удмаар дамжин Мессиа ирэх болно хэмээн бошиглосон болохоор энэ нь маш чухал удам байсан (Иеремиа 23:5–6-г үзнэ үү). Энэ нь гэр бүлийнхээ түүхийг ярилцаж, өвөг дээдсийнхээ тухай түүхийг хуваалцах сайхан боломж байж болох юм. Гэр бүлийнхээ түүхийг мэдэх нь танай гэр бүлийг хэрхэн адислах вэ?

МАТАЙ 1:20; ЛУК 1:13, 30


Эдгээр шүлэгт гарсан хүмүүс яагаад айдастай байсан бэ? Юу бидний айдсыг хүргэдэг вэ? Бурхан бидэнд хэрхэн “бүү ай” хэмээн хэлж байж болох вэ?

ЛУК 1:37

Та “Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй” хэмээх итгэлийг хөгжүүлэхэд нь гэр бүлдээ туслахын тулд хамтдаа Лук 1-ээс Бурханы хийсэн боломжгүйд тооцогдох зүйлсийг олж болно. Тэд судраас эсвэл өөрсдийн амьдралд тохиолдсон боломжгүй мэт санагдах зүйлсийг Бурхан хийсэн тухай өөр ямар түүхийг хуваалцаж болох вэ?

Заах чадвараа сайжруулах

Судруудыг амьдралдаа хэрэгжүүл. Судрын хэсгийг уншсаныхаа дараа гэр бүлийнхнийгээ үүнийг амьдралдаа хэрэгжүүлэхэд урь (*Аврагчийн арга барилаар заах нь*, 21). Жишээлбэл, Матай 1 болон Лук 1 дээр гардаг хүмүүсийн үйлдлээс Их Эзэний дуудлагад хариулах тухай ойлгож авсан зүйлсээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ?



Волтер Райн, Эмэгтэйчүүдийн дундаас ерөөлтэй нь чи мөн



Дана Марио Вүүд, Бүгд Түүнийг мэгтъя

1-Р САРЫН 14-20

Лук 2; Матай 2

Бид Түүнд мөргөхөөр ирлээ

Эхлээд Лук 2, Матай 2-ыг уншаад, хүлээж авсан сүнслэг ойлголтууддаа анхаарлаа хандуул. Энэхүү тойм дахь санаанууд нь танд эдгээр бүлэгт орших хамгийн чухал, ач холбогдолтой зарим зарчмыг тодорхойлоход туслах боломжтой.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Төрсөн цагаасаа эхлэн Есүс энгийн хүүхэд биш гэдэг нь тодорхой байсан юм. Зөвхөн тэнгэрт гарсан шинэ од эсвэл тэнгэр элчийн баярт мэдээ Есүсийн нялх бага насыг онцгой болгоогүй. Түүнчлэн өөр өөр үндэстний, янз бүрийн мэргэжил, нөхцөл байдалтай олон итгэлтэй хүн тэр даруй Түүнд татагдаж эхэлсэн нь үүнийг нотолдог. Бүр Түүнийг “Ирээд, Намайг дага” (Лук 18:22) хэмээн урихаас өмнө тэд Түүн рүү ирсэн. Хүн бүр Түүнд ирээгүй. Үнэндээ олон хүн Түүнд анхаарлаа огтхон ч хандуулаагүй

төдийгүй Түүний амийг авахыг эрэлхийлсэн атаач удирдагч хүртэл байсан. Гэвч даруу, цэвэр ариун, зөв шударгыг тууштай эрэлхийлэгчид хайж байсан зүйлээ Түүнээс олсон. Тэдний сүсэг бишрэл бидний сүсэг бишрэлийг сүнслэгээр өдөөдөг. Учир нь хоньчдод авчирсан “үлэмж баярлуулах сайн мэдээ” нь “ард түмэнд” зориулагдсан бөгөөд “Аврагч, Эзэн Христ” бид бүгдийн төлөө тэр өдөр мэндэлсэн билээ (Лук 2:10–11-ийг үзнэ үү).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ЛУК 2:1-7

Есүс Христ даруу нөхцөл байдалд мэндэлсэн.

Хэдийгээр Есүс Христ “ертөнцийг бүтээхээс өмнө” (Иохан 17:5) Бурхан Эцэгийн хамт алдар суутай байсан ч даруу байдалд төрж, дэлхий дээр бидний дунд амьдрахыг хүссэн. Та Лук 2:1-7-г уншиж байхдаа Түүний даруухан төрөлтийн талаар юу олж харсан бэ? Энэ түүхээс өмнө нь анзаарч байгаагүй жижиг зүйл болон ойлголтыг олж тодорхойлохыг хичээ. Та Есүс Христийн төрөх үеийн нөхцөл байдлаас Түүний тухай юу мэдэж авдаг вэ? Эдгээр ойлголт нь Есүсийн талаарх таны бодол мэдрэмжинд хэрхэн нөлөөлдөг вэ?

ЛУК 2:8-38; МАТАЙ 2:1-12

Христийг төрөх үед олон гэрч байдаг.

Христийн төрөлт, нялх балчир үеийг малын хашаанд очиж харсан даруухан хоньчид, Түүний гэрт бэлэг авчирсан чинээлэг зурхайчид, ариун сүмд үйлчилж байсан бэлэвсэн эмэгтэй, Мессиагийн ирэхийг тэсэн ядан хүлээж байсан итгэлтэй шавь нар зэрэг янз бүрийн угсаа гаралтай гэрч, сүсэг бишрэлтнүүд гэрчилдэг. Та тэдний түүхийг судлахдаа Христийг гэрчилж, шүтэн бишрэх ямар ямар арга замыг олж мэдсэн бэ?

| Христийн гэрч | Би шүтэн бишрэх, гэрчлэх талаар юу мэдэж авсан бэ? |
|--------------------------|----------------------------------------------------|
| Хоньчид (Лук 2:8-20) | |
| Симеон (Лук 2:25-35) | |
| Анна (Лук 2:36-38) | |
| Зурхайчид (Матай 2:1-12) | |

Түүнчлэн 1 Нифай 11:13-23; 3 Нифай 1:5-21-ийг үзнэ үү.

МАТАЙ 2:13-23

Эцэг эхчүүд гэр бүлээ хамгаалахын тулд илчлэлт хүлээн авч болно.

Иосеф тэнгэрийн тусламжгүйгээр Есүсийг хүүхэд насанд нь хамгаалах үүргээ хэзээ ч биелүүлж чадахгүй байх байсан. Тэрээр зурхайчдын адил аюулаас сэрэмжлүүлсэн илчлэлт хүлээн авсан юм. Иосефын

туршлагын тухай уншихдаа өнөөгийн гэр бүлүүдэд тулгардаг материаллаг болон сүнслэг аюулуудын талаар бодоорой. Таныг болон гэр бүл, хайртай хүмүүсийг тань хамгаалсан Бурханы удирдамжийг мэдэрсэн туршлагынхаа талаар тунгаан бод. Энэ туршлагаа бусадтай хуваалцах талаар бодож үз. Ирээдүйд та ийм удирдамж хүлээн авахын тулд юу хийж болох вэ?

ЛУК 2:40-52

Есүс өсвөр насандаа хүртэл Эцэгийнхээ хүслийг биелүүлэхэд анхаарч байсан.

Аврагч залуу эрэгтэй байхдаа сайн мэдээг үнэхээр хүчирхэг зааж байсан бөгөөд Түүний “ухаан болон хариултауд” (Лук 2:47) бүр сүмд байсан багш нарын гайхлыг төрүүлж байв. Та Аврагчийн залуу эрэгтэй байх үеийг харуулсан шүлгүүдээс юу сурч мэдсэн бэ? Таны мэддэг залуу хүмүүс хэрхэн “Эцэгийнхээ ажлыг хийхийг” (Лук 2:49) хичээж байна вэ? Сайн мэдээний илүү гүн ойлголтыг олж авахад тань өсвөр үеийнхэн болон хүүхдүүд танд хэрхэн тусалсан бэ? Та Лук 2:40-52 болон Иосеф Смитийн Орчуулга, Матай 3:24-26 (Судруудын удирдамж) дахь Есүсийн хүүхэд насыг харуулсан жишээнүүдээс өөр юу сурсан бэ?



“Эцэгийнхээ гэрт байх ёстойг минь та нар мэдсэнгүй гэж үү?” (Лук 2:49).

Иосеф Смитийн Орчуулга гэж юу вэ?

Хэдэн зууны турш Ариун Библийн “олон тодорхой болоод эрхэм үнэт” үнэнүүд алдагдсан учир (1 Нифай 13:28; Мосе 1:41) Их Эзэн Иосеф Смитийн Орчуулга хэмээн нэрлэгдсэн Ариун Библийн сүнслэг нөлөө бүхий засварласан хэсгийг бичихийг

Иосеф Смитэд зарлиг болгожээ. Бошиглогчийн бичсэн олон засвар хэсэг нь хожмын үеийн гэгээнтнүүдийн хэвлэсэн судруудын хавсралтад багтдаг. Хаан Жэймсийн Ариун Библийн ХҮГ-ийн хэвлэл нь бошиглогчийн засварласан хэсгийг багтаасан зүүлт

тайлбартай. Иосеф Смит—Матай хэмээн нэрлэгддэг Иосеф Смитийн орчуулсан Матай 24-р бүлэг нь Агуу Үнэт Сувдад агуулагддаг. Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын удирдамж дахь “Иосеф Смитийн Орчуулга” аас үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлахад тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд танд Сүнс туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ЛУК 2

Гэр бүлийнхээ гишүүдийг Лук 2-т дүрсэлсэн нэг хүнийг сонгон авч, уг хүний Аврагчтай хэрхэн харилцаж байсан тухай хэдэн шүлэг уншаад, Есүс Христэд итгэх итгэлийг нь нэмэгдүүлсэн сурсан зүйлсээ хуваалцахад урь. Бид эдгээр дуунаас Аврагчийн төрөлтийн тухай юу сурах вэ?

ЛУК 2:49

“Эцэгийн ажил” гэж юу вэ? (Мосе 1:39-ийг үзнэ үү). Бид энэ түүхээс болон Есүс амьдралынхаа турш

зааж, хэлж байсан бусад зүйлээс тэрхүү ажлын тухай юу сурах вэ? Гэр бүлээрээ Эцэгийн ажилд оролцож болох арга замуудыг бичиж, шилэн дотор хий. Дараагийн долоо хоногт танай гэр бүл Тэнгэрлэг Эцэгийн ажлыг хийх арга замыг хайхдаа шилэн доторх санаануудаас сонгож болно. Туршлагаа хуваалцах цаг товло.

ЛУК 2:52

Бид Лук 2:52-оос Есүсийн амьдралдаа хэрхэн өсөж хөгжиж байсан талаар юу сурч болох вэ? Гэр бүлийн гишүүд ямар арга замаар “бие болон мэргэн ухаанаар өсөж, Бурханы болон олон түмний тааллыг” олж болох вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Судар судлахад туслах материалуудыг ашигла. Судруудаас суралцаж, нэмэлт ойлголт олж авахын тулд зүүлт тайлбар, Topical Guide, Судруудын удирдамж, бусад LDS.org, *Шинэ Гэрээний суралцагчийн гарын авлага* (Сүмийн Боловсролын Системийн гарын авлага, 2014) зэрэг эх сурвалжийг ашигла.



Дэлхийн Аврагч дэлхийд даруу байдалд ирсэн.



1-Р САРЫН 21-27

Иохан 1

Бид Мессиаг оллоо

Иохан 1-ийг уншаад, тунгаан бодохдоо төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ. Танд болон танай гэр бүлийн хувьд хамгийн үнэ цэнтэй ямар захиасыг та олж авсан бэ? Сүмийн ангидаа юу хуваалцаж болох вэ?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Хэрэв та Түүний мөнх бус амьдрал дахь тохинууллын үед амьдарч байсан бол Назарын Есүсийг Бурханы Хүү гэдгийг таних байсан болов уу? Олон жилийн турш Андрей, Петр, Филип, Натанаел зэрэг итгэлтэй израильчууд амлагдсан Мессиагийн ирэхийг хүлээн, залбирч байсан. Тэд Түүнтэй уулзаад, өөрсдийнх нь эрэлхийлж байсан Хүн мөн гэдгийг хэрхэн мэдсэн бэ? Тэд ч мөн “Ир, та нар харна”

(Иохан 1:39) хэмээсэн урилгыг хүлээн авч, бидний мэдсэн тэрхүү арга замаар Аврагчийг мэдэж авсан. Бид судруудаас Аврагчийн тухай уншиж, сургаалыг нь сонсон, амьдралынх нь арга барилыг ажигладаг бөгөөд Түүний Сүнсийг мэдэрдэг. Ингэх явцдаа бид Натанаелын адил Аврагч бидэнд хайртай бөгөөд биднийг “илүү агуу зүйлсийг” (Иохан 1:50) хүлээн авахад бэлтгэхийг хүсдэг гэдгийг мэдэж авдаг.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИОХАНЫ САЙН МЭДЭЭ

Иохан гэж хэн байсан бэ?

Иохан нь Иохан Баптистын шавь байсан бөгөөд сүүлд нь Есүс Христийн анхны дагалдагчдын нэг, Арван хоёр төлөөлөгчийн нэг болсон. Тэрээр Иоханы сайн мэдээ, хэд хэдэн захидал болон Илчлэлт номыг бичжээ. Иохан сайн мэдээндээ өөрийгөө “Есүсийн хайрласан хүн,” “нөгөө шавь” (Иохан 13:23; 20:3) хэмээн бичсэн байдаг. Иоханы сайн мэдээг тунхаглах хүсэл тэмүүлэл бодгалиудыг Христэд авчирч болохын тулд бүр Аврагчийн Хоёр дахь ирэлт хүртэл дэлхий дээр үлдэхийг хүсэхээр тийм хүчтэй байсан юм (С ба Г 7:1–6-г үзнэ үү).

Түүнчлэн Судруудын удирдамжаас “Иохан,” “Иоханы Сайн мэдээ”-г үзнэ үү.

ИОХАН 1:1–5

Есүс Христ “эхэнд Бурхантай хамт байсан.”

Иохан сайн мэдээгээ “Эхэнд . . . Үг [Есүс Христ] Бурхантай хамт байсан” хэмээн Христийн төрөхөөсөө өмнө хийсэн ажлыг дүрслэн эхлүүлдэг. Та 1–5-р шүлгээс Аврагч, Түүний ажлын талаар юу олж мэдэж болох вэ? Тус болох тодруулгыг (Судруудын удирдамж) Иосеф Смитийн Орчуулга, Иохан 1:1–5-аас олж болно. Аврагчийн амьдралын талаар суралцаж эхлэхэд Түүний мөнх бус байдлын өмнөх ажлыг мэдэж авах нь яагаад чухал вэ?

ИОХАН 1:1–18

Есүс Христийн шавь нар Түүнийг гэрчилдэг.

Иохан “жинхэнэ гэрлийн тухай гэрчлэхээр ирсэн” (Иохан 1:8–9, 15–18) хэмээн тунхагласан Иохан Баптистын гэрчлэлийн нөлөөгөөр Аврагчийг эрэлхийлэхээр өдөөгдсөн. Иохан өөрөө Аврагчийн амьдрал, номлолын тухай хүчирхэг гэрчлэлээ хуваалцсан юм.

Иоханы Христийн талаарх гэрчлэлийнхээ эхэнд оруулсан үнэнүүдээр жагсаалт гаргах нь сонирхолтой байж болох юм (1–18-р шүлэг, түүнчлэн [Судруудын удирдамж дахь] Иосеф Смитийн Орчуулга, Иохан 1:1–19-ийг үзнэ үү). Яагаад Иохан сайн мэдээгээ эдгээр үнэнээр эхлүүлсэн гэж та бодож байна

вэ? Та Есүс Христийн талаар гэрчлэлээ бичихдээ юуг хуваалцахыг хүсэх вэ? Аврагчийг танин мэдэж, дагахад ямар ямар туршлага танд тусалсан бэ? Таны гэрчлэлийг сонсоод хэн адислагдаж болох вэ?

ИОХАН 1:12

“Бурханы хүүхэд болох” гэдэг нь ямар утгатай вэ?

Хэдийгээр бид бүгдээрээ Бурханы сүнсэн хөвгүүд, охид ч гэсэн нүгэл үйлдэхдээ Түүнээс тусгаарлагдаж эсвэл холддог. Есүс Христ бидэнд буцах замыг санал болгодог. Түүний цагаатгах золиослолоор дамжуулан сайн мэдээний гэрээнүүдэд дуулгавартай байх үед Тэрээр “[бидэнд] Бурханы хөвгүүд охид болох эрхийг” дахин өгдөг. Бид дахин төрж, Эцэгтэйгээ эвлэрүүлэгдэн, Түүнд байдаг бүх зүйлийн мөнхийн өв залгамжлагчид байхаар зөв зохистой болдог (Ром 8:14–18; Иаков 4:11).

ИОХАН 1:18

Хэн нэг нь Бурханыг харж байсан уу?

Хуучин Гэрээнд Бурханыг харсан хүмүүсийн жишээг цэдэглэсэн байдаг (Эхлэл 32:30; Египетээс гарсан нь 33:11; Исаиа 6:5-ыг үзнэ үү). Иохан Баптист яагаад “Бурханыг хэн ч, хэзээ ч хараагүй” гэж хэлсэн бэ? Энэ шүлгийн Иосеф Смитийн Орчуулга (Иохан 1:18, зүүлт тайлбар в) Бурхан Эцэг хүмүүнд харагддаг бөгөөд ингэхдээ Өөрийн Хүүг гэрчилдэг гэдгийг тодорхой тайлбарладаг. Жишээлбэл, Тэр Ариун ойн цоорхойд Иосеф Смитэд үзэгдэхдээ Иосефт хандан “Энэ бол миний Хайртай Хүү, Түүнийг сонс!” хэмээн хэлсэн. (Иосеф Смит—Түүх 1:17 мөн С ба Г 76:23-ыг үзнэ үү). Хүмүүс Бурхан Эцэгийг үзэгдэлд харсан (Үйлс 7:55–56; Илчлэлт 4:2; 1 Нифай 1:8; С ба Г 137:1–3) эсвэл Хүүгээ гэрчилж буй Түүний дууг сонссон (Матай 3:17; 17:5; 3 Нифай 11:6–7-г үзнэ үү) тухай хэд хэдэн өөр жишээ цэдэглэгдсэн байдаг.

ИОХАН 1:19–23

Елиа гэж хэн бэ? “Өнөөх эш үзүүлэгч” гэж хэн бэ?

Иудейчүүдийн удирдагчид хэзээ нэгэн өдөр хүмүүсийн дунд ирэх бошиглогчийн тухай эртний бошиглолыг Иохан Баптист гүйцэлдүүлж байгаа юм болов уу хэмээн гайхацгааж байсан. Тэд түүнээс бүх

зүйлийг сэргээнэ хэмээн бошиггосон Елиас буюу грекээр *Елиа* хэмээх бошиглогч мөн үү гэж асуужээ (Малахи 4:5–6-г үзнэ үү). Мөн тэд “өнөөх Эш үзүүлэгч” мөн үү хэмээн түүнээс асуусан бөгөөд энэ нь Дэд хууль 18:15-д дурдсан “эш үзүүлэгч”-ийг хэлсэн

болов уу. Иохан өөрийгөө тэдгээр эш үзүүлэгчийн аль нь ч биш, харин Исаиагийн хэлсэн Их Эзэний замыг бэлтгэхээр ирсэн бошиглогч гэдгээ тайлбарласан (Исаиа 40:3-ыг үзнэ үү).

Судруудын удирдамжийн “Елиас”-ыг бас үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд танд Сүнс туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИОХАН 1:4-10

Та эдгээр шүлгээс гэрлийн тухай уншсан зүйлсээ төсөөлөн бодоход нь гэр бүлдээ хэрхэн тусалж болох вэ? Гэр бүлийн гишүүн тус бүрээр харанхуй өрөөнд гэрэл тусгуулж, Аврагч хэрхэн тэдний амьдралын Гэрэл болдог тухай хуваалцуулж болно. Тэгээд Иохан 1:4–10-ыг унших үед гэр бүлийн гишүүд Дэлхийн Гэрэл Есүс Христийн тухай Иоханы гэрчлэл дээр нэмэгдэх нэмэлт ойлголт олж авч болно.

ИОХАН 1:35-46

36-р шүлэгт буй Иохан Баптистын гэрчлэлийг анзаараарай. Түүний гэрчлэлийн үр дүн юу байсан бэ? (35–46-р шүлгийг үзнэ үү). Танай гэр бүл эдгээр шүлэгт дүрслэгдсэн хүмүүсээс сайн мэдээг хэрхэн хуваалцах талаар юу сурсан бэ?

ИОХАН 1:45-51

Натанаел Аврагчийн тухай гэрчлэлийг олж авахад тусалсан ямар зүйл хийсэн бэ? Бид гэрчлэлээ хэрхэн олж авсан бэ?

Заах чадвараа сайжруулах

Үзүүлэнт хичээлүүдийг заах. Гэр бүлээрээ уншиж байгаа сударт гарсан зарчмуудыг ойлгоход нь туслах үзүүлэнг олохыг гэр бүлийн гишүүдээсээ хүс. Жишээлбэл, тэд Христийн Гэрлийг лаагаар төлөөлүүлэн ашиглаж болно (Иохан 1:4-ийг үзнэ үү).



Волтэр Рэйн, Иехова дэлхийг бүтээсэн нь



Том Холдман, Иллиной дахь Науругийн ариун сүмийн өнгөт шилэн цонх

1-Р САРЫН 28-ААС 2-Р САРЫН 3

Матай 3; Марк 1; Лук 3

“Эзэний замыг бэлтгэгтүн”

Эхлээд Матай 3; Марк 1; Лук 3-ыг унш. Таныг эдгээр бүлгийг ойлгоход туслах Ариун Сүнсийг эрэлхийлэн залбирахад Тэр онцгойлон танд зориулсан ойлголтыг өгөх болно. Эдгээр ойлголт, сэтгэгдлээ бичиж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Есүс Христ болон Түүний сайн мэдээ таныг өөрчилж чадна. Иохан Баптистын номлол болон Аврагчийн ирсний нөлөөгөөр “Гуу жалга бүр дүүрч, уулс, толгод бүхэн доошлон, тахир нь шулуун болж, хотгор бүхэн тэгшрэх” мэт байх болно хэмээн дүрсэлсэн Исаиагийн эртний бошиг-лолыг Лук эш татсан (Лук 3:5 түүнчлэн Исаиа 40:4-ийг үзнэ үү). Энэ нь бид бүгдэд, тэр дундаа өөрчлөгдөж чадахгүй, өөрчлөлт хэрэггүй гэж

боддог хүмүүст ч зориулсан захиас юм. Уул толгод зэрэг тогтвортой суурин байдаг зүйлс тэгширч, хавтгай болж болох юм бол Их Эзэн бидэнд тахир замаа тэгшлэхэд тусалж чадах нь лавтай (Лук 3:4–5-ыг үзнэ үү). Бид Иохан Баптистын наманчил мөн өөрчлөгд гэсэн урилгыг хүлээн авснаар оюун ухаан, зүрх сэтгэлээ Есүс Христийг хүлээн авахад бэлтгэдэг. Ингэснээр бид ч бас “Бурханы авралыг үзэж” (Лук 3:6) болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАРКИЙН САЙН МЭДЭЭ

Марк гэж хэн байсан бэ?

Бид сайн мэдээнүүдийг бичсэн хүмүүсийн дундаас Маркийн талаар хамгийн бага зүйл мэддэг. Тэрээр Паул, Петр, өөр хэд хэдэн номлогчийн хамтрагч байсан гэдгийг бид мэднэ. Олон Библи судлаачид Петр Аврагчийн амьдралын үйл явдлыг цэдэглэн бичихийг Маркад зааварласан гэж итгэдэг. Маркийн сайн мэдээ нь бусад гурваас өмнө бичигдсэн байж болзошгүй.

Судруудын удирдамжийн “Марк”-ийг бас үзнэ үү.

МАТАЙ 3:1-12; МАРК 1:1-8; ЛУК 3:2-18

Наманчлал бол оюун ухаан, зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт юм.

Иохан Баптистын үүрэг бол хүмүүсийн зүрх сэтгэлийг Аврагчийг хүлээн авахад, Түүнтэй илүү адил болоход бэлтгэх явдал байсан юм. Тэр үүнийг хэрхэн хийсэн бэ? Тэрээр “Гэмшицгээ” (Матай 3:2) хэмээн тунхагласан. Тэр Христийг хүлээн авахын тулд наманчлахын ач холбогдлыг онцлон тодорхойлох гэж жимс, улаан буудай зэрэг дүрслэлийг ашиглаж байсан (Лук 3:9, 17).

Та Иохан Баптистын тохинууллын тухай шастираас өөр ямар ямар дүрслэлийг олсон бэ? Тэдгээрийг судар дээрээ тэмдэглэх юм уу судрын тэмдэглэл дээрээ зурж болно. Тэдгээр дүрслэл нь наманчлалын сургаал, хэрэгцээний тухай юу зааж байна вэ?

Чин сэтгэлийн наманчлал бол “Бурханд, өөртөө болон ерөнхийдөө амьдралд хандах шинэ хандлагыг авчирдаг оюун санаа хийгээд зүрх сэтгэлийн өөрчлөлт юм. . . . [Ингэснээр хүн] зүрх сэтгэл хийгээд хүсэл зоригоо Бурхан руу эргүүлнэ” (Судруудын удирдамж, “Наманчлал, наманчлах”) гэсэн үг юм. Лук 3:7-14-т Иохан хүмүүсийг Христийг хүлээн авахад бэлтгэхийн тулд ямар өөрчлөлт хийхэд урьсан бэ? Энэ зөвлөгөө тантай хэрхэн холбогдож болох вэ? Та чин сэтгэлээсээ наманчилсан гэдгээ хэрхэн харуулж болох вэ? (Лук 3:8-ыг үзнэ үү).

Мөн (Судруудын удирдамж дахь) Иосеф Смитийн Орчуулга, Лук 3:4-11; Судруудын удирдамж, “Иохан

Баптист”; Д.Тодд Кристоффэрсон, “Наманчлалын бурханлиг бэлэг,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 45-48-ыг үзнэ үү.

МАТАЙ 3:7; ЛУК 3:7

Фарисайчууд, садукайчууд гэж ямар хүмүүс байсан бэ?

Фарисайчууд нь Мосегийн хуулийг чанд сахидаг хэмээн өөрсдөөрөө бардамнадаг иудейчүүдийн шашны бүлгийн гишүүд байсан. Тэд шашныг ёс төдийхөн сахиснаар сулруулахыг оролдож байсан. Садукайчууд нь шашны болон улс төрийн чухал нөлөө бүхий чинээлэг иудейчүүдийн бүлэг байсан. Тэд Амилалтын сургаалд итгэдэггүй байв. Энэ хоёр бүлэг нь хоёулаа Бурханы хуулийн жинхэнэ зорилгоос гажсан бөгөөд тэдний гишүүдийн олонх нь Бурханы бошиглогч Иохан Баптистын захиасыг хүлээж авахаас татгалзаж байсан.

Түүнчлэн Матай 23:27; Иохан 1:19-24; Судруудын удирдамжаас “Фарисайчууд”, Садукайчууд”-ыг үзнэ үү.

МАТАЙ 3:13-17; МАРК 1:9-11; ЛУК 3:15-16, 21-22

Есүс Христ “аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн” тулд баптисм хүртсэн юм.

Та баптисм хүртэхдээ Аврагчийн жишээг дагасан. Аврагчийн баптисмыг дүрсэлсэн эдгээр шастираас сурч мэдсэн зүйлсээ өөрийнхөө баптисмын үеэр болсон зүйлстэй харьцуул.

| | |
|-------------------------------------------------------------|------------------------------------------------------------|
| Есүст ямар эрх мэдэлтэй хэн гэдэг хүн баптисм хүртээсэн бэ? | Танд ямар эрх мэдэлтэй хэн гэдэг хүн баптисм хүртээсэн бэ? |
| Есүс хаана баптисм хүртсэн бэ? | Та хаана баптисм хүртсэн бэ? |
| Есүс хэрхэн баптисм хүртсэн бэ? | Та хэрхэн баптисм хүртсэн бэ? |
| Есүс Христ яагаад баптисм хүртсэн бэ? | Та яагаад баптисм хүртсэн бэ? |

| | |
|------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тэнгэрлэг Эцэг Есүсээр бахархаж байгаагаа хэрхэн илэрхийлсэн бэ? | Тэнгэрлэг Эцэг танаар бахархаж байгаагаа хэрхэн илэрхийлсэн бэ? Тэр Түүнийг сайшаан баталж байгаагаа хэрхэн илэрхийлсэн бэ? |
|------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Нифай Аврагчийн баптисмын тухай хэдэн чухал сургаал цэдэглэсэн. 2 Нифай 31-р бүлэг дээрх түүний үгс танд юу зааж байна вэ? Өөрийнхөө баптисмын туршлагыг тэмдэглэлдээ бичээрэй.

Мөн Иохан 1:32–33; Мозая 18:8–11; Сургаал ба Гэрээ 13:1; 20:37, 68–74-ийг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлахад тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 3

Иохан Баптист Аароны санваарыг атгаж байсан. Бид түүний тухай суралцаж байхдаа Аароны санваарын талаар юу сурч мэдэж болох вэ? Иоханы үлгэр жишээ Аароны санваартнуудад үүргээ биелүүлэхэд нь хэрхэн тусалж чадах вэ? (С ба Г 13:1; 20:46–60-ыг үзнэ үү.)

МАТАЙ 3:11–17; МАРК 1:9–11; ЛУК 3:21–22

Гэр бүлийн гишүүддээ баптисм, Ариун Сүнсний бэлгийн тухай заахдаа тэдэнд ямар нэгэн бохир зүйл үзүүлээд, усаар угаалга. Энэ үйл ажиллагаа нь баптисмыг хэрхэн төлөөлж байна вэ? Дараа нь гэр бүлийнхнээсээ галын ариусгах шинж чанарын талаар ярихыг хүс. Яагаад Ариун Сүнсний бэлгийг

МАТАЙ 3:16–17; МАРК 1:9–11; ЛУК 3:21–22

Бурхан Тэргүүтэний гишүүд гурван тусдаа биетэй гэдгийг Ариун Библи заадаг уу?

Бурхан Тэргүүтэний гишүүд бол гурван тусдаа хүн гэдгийг батлах олон нотолгоог Ариун Библи агуулдаг. Жишээлбэл, Аврагчийн баптисмын тухай шастир нь Бурхан Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс гурав тусдаа хүмүүс гэсэн сургаалыг дэмждэг. Аврагчийг баптисм хүртэж байхад Бурхан Эцэг тэнгэрээс ярьж, Ариун Сүнс (тагтаагаар төлөөлүүлэн) Түүн дээр ирсэн. Энэхүү үнэнийг заадаг судрын бусад хэсэг: Эхлэл 1:26–27; Матай 17:1–5; Иохан 17:20–23; Үйлс 7:55–56; ба Сургаал ба Гэрээ 130:22.

“галын баптисм” гэж дүрслэн хэлдэг вэ? (Судруудын удирдамжийн “Ариун Сүнс”-ийг үзнэ үү.)



Биднийг баптисм хүртэхэд гэм нүгэл маань угаагддаг.

МАТАЙ 3:17; МАРК 1:11; ЛУК 3:22

Бид Бурханы таалалд нийцэж байгаа гэдгээ хэзээ мэдэрсэн бэ? Гэр бүлээрээ Бурханы таалалд нийцэхийн тулд бид юу хийж болох вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Их Эзэнээс тусламж хүс. Судруудыг илчлэлтээр өгдөг бөгөөд тэдгээрийг маш сайн ойлгохын тулд бидэнд хувийн илчлэлт хэрэгтэй. Их Эзэн “Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” (Матай 7:7) хэмээн амласан билээ.



Грэг К.Олсен, Иохан Баптист Есүст баптисм хүртээсэн нь



Роберт Т. Барретт, Христ Сатаныг ялсан нь

2-Р САРЫН 4-10

Матай 4; Лук 4–5

“Эзэний Сүнс Над дээр байна”

Эхлээд Матай 4, Лук 4–5-ыг уншаад, хүлээж авах сүнслэг ойлголтууддаа анхаарлаа хандуул. Энэхүү тойм дахь санаанууд нь танд эдгээр бүлэгт орших чухал зарчмуудыг тодорхойлоход туслах боломжтой.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Есүс өсвөр наснаасаа л онцгой, ариун нандин номлолынхоо талаар мэдэж байсан. Гэвч Есүсийг дэлхий дээрх тохинууллаа эхлүүлэхээр бэлтгэх үед чөтгөр эргэлзээ төрүүлэхийг хичээж байв. Сатан “Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол” (Лук 4:3, налуу бичлэг нэмэгдсэн) гэж хэлсэн. Харин Аврагч Тэнгэр дэх Өөрийн Эцэгтэй харилцаж байсан. Тэрээр судруудыг болон Өөрийнхөө хэн болохыг мэддэг байв. Түүнд хандан хэлсэн “Энэ бүх сүр

хүчийг би Чамд өгье” (Лук 4:6) гэсэн Сатаны үгс хий хоосон зүйл байсан. Учир нь Аврагчийн бүх л амьдралынхаа турш хийсэн бэлтгэл нь Түүнд “Сүнсний хүчийг” (Лук 4:14) олгосон юм. Есүс Христ уруу таталт, саад бэрхшээл, эсэргүүцлийг үл тоон “Би Бурханы хаанчлалыг . . . тунхаглах ёстой. Энэ зорилгын тулд Би илгээгдсэн билээ” (Лук 4:43) хэмээн хэлж, томилогдсон ажлаасаа хэзээ ч няцаагүй.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 4:1-2

Бурхантай харилцах нь намайг Түүнд үйлчлэхэд бэлддэг.

Есүс номлолдоо бэлтгэхийн тулд “Бурхантай хамт байхаар” (Иосеф Смитийн Орчуулга, Матай 4:1) цөл рүү явсан. Та Бурханд илүү ойр байхын тулд юу хийх талаар бод. Энэ нь Түүний хийгээсэй гэсэн ажлыг хийхэд таныг хэрхэн бэлтгэх вэ?

МАТАЙ 4:1-11; ЛУК 4:1-13

Есүс Христ уруу таталтыг эсэргүүцсэнээр надад үлгэр жишээ үзүүлсэн юм.

Заримдаа хүмүүс гэм нүгэл үйлдэхээр уруу татагдах үед гэм буруугаа мэдэрдэг. Гэвч “нүгэлгүй” (Еврей 4:15) амьдарч байсан Аврагч хүртэл уруу татагдаж байсан. Христ уруу таталттай тулгарч, үүнийг даван гарч байсан болохоор бидэнд тулгардаг уруу таталтуудыг мэддэг, тэдгээрийг даван гарахад бидэнд тусалж чадна (Еврей 2:18; Алма 7:11-12).

Та Матай 4:1-11, Лук 4:1-13-ыг уншихдаа уруу таталттай тулгарсан үед тань тус болох юуг ойлгож авч болох вэ? Та бодлуудаа иймэрхүү хүснэгтэд нэгтгэн бичиж болно.

| Есүс Христ | Би |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|
| Сатан Христийг юу хийхэд уруу татсан бэ? <i>Өлөө дарахын тулд хүчээ ашиглахад уруу татсан</i> | Сатан намайг юу хийхэд уруу татсан бэ? |
| Христ яагаад уруу таталтыг эсэргүүцэхэд бэлтгэгдсэн байсан бэ? <i>Тэр мацаг барьсан; Тэр Бурхантай хамт байхаар явсан; Тэр судруудыг мэдэж байсан.</i> | Би уруу таталтыг эсэргүүцэхэд хэрхэн бэлтгэх вэ? |
| | |

Бид Матай 4-ийн Иосеф Смитийн Орчуулгаас ямар нэмэлт ойлголтыг олж авах вэ?

Мөн 1 Коринт 10:13; Алма 13:28; Мосе 1:10-22-ыг үзнэ үү.

ЛУК 4:16-32

Есүс Христ бол бошиглогдсон Мессиа мөн.

Хэрэв танаас Есүс Христ дэлхий рүү юу хийхээр илгээгдсэнийг дүрслэн хэл гэвэл та юу хэлэх вэ? Лук 4:18-19-д Аврагч Өөрийн номлолыг тодорхойлохдоо Мессиагийн тухай бошиглосон Исаиагийн бошиглолуудын нэгийг эш татсан (Исаиа 61:1-2-ыг үзнэ үү). Та эдгээр шүлгийг уншаад, Түүний номлолын талаар юу олж мэдэж болох вэ?



Есүс Христ Өөрийгөө Мессиа хэмээн гэрчлэв.

Иудейчүүд хэдэн зууны турш Исаиагийн бошиглол биелэхийг хүлээж байсан ч Түүнийг “Энэхүү Судар өнөөдөр сонсголд тань биеллээ” (Лук 4:21) хэмээн тунхаглахад олонх нь Есүсийг Мессиа гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй. Та Лук 4:20-30-ийг (мөн Марк 6:1-6-г үзнэ үү) уншихдаа Назарын хүмүүсийн оронд өөрийгөө тавиад үзээрэй. Христийг өөрийнхөө хувийн Аврагчаар бүрэн хүлээн зөвшөөрөхөд тань саад болж байгаа ямар нэгэн зүйл байна уу?

Мозая 3:5-12-ыг үзнэ үү.

МАТАЙ 4:18-22; ЛУК 5:1-11

Их Эзэнд итгэхэд Тэр надад тэнгэрлэг чадавхдаа хүрэхэд тусалж чадна.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон “Тэрээр амьдралаа Бурханд зориулдаг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн амьдралыг өөрсдийнх нь чадахаас хамаагүй илүүгээр үр бүтээлтэй болгож чаддаг гэдгийг тэд олж мэддэг” (*Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson* [2014], 42) хэмээн заасан. Петрт болон түүнтэй хамт байсан загасчдад ийм зүйл тохиолдсон. Есүс тэдэнд загас барихаас илүү зүйлийг буюу “хүмүүсийн

загасчин” (Матай 4:19; мөн Лук 5:10-ыг үзнэ үү) болж чадна гэдгээ ойлгоход тусалсан. Үүнийгээ харахад нь туслахын тулд Есүс тэдэнд ойр жишээг ашигласан.

Аврагч Өөрийг нь дага хэмээн таныг дуудаж байгааг та хэзээ мэдэрсэн бэ? Та “бүхнийг [орхих]” (Лук 5:11) хүсэлтэй байгаагаа Их Эзэнд хэрхэн харуулж чадах вэ? Матай 4:18-22, Лук 5:1-11-ийг уншихдаа эдгээр асуултыг тунгаан бод.

Сүмийн дуулал номын 116-р хуудсан дээрх “Ирээд, Намайг дага” дууг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлахад тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 4:1-2; ЛУК 4:1-2

Есүс чөтгөрт уруу татагдахаасаа өмнө мацаг барьж байсан. Бид мацаг барилтын хүчний талаар энэ шастираас ямар ямар ойлголт олж авч болох вэ? Та мацаг барилтаас олж авсан туршлагаа хуваалцахыг гэр бүлийн гишүүдээсээ хүсэж болно. Танай гэр бүл тодорхой зорилгын төлөө гэр бүлээрээ хамтдаа мацаг барих төлөвлөгөөг залбирч гаргаж болох юм.

МАТАЙ 4:3-4; ЛУК 4:3-4

Сатан Христийг чулууг талх болгохыг ятгахдаа “Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол” (Матай 4:3, налуу бичлэг нэмэгдсэн) хэмээн Түүний бурханлаг чанарыг сорьсон. Яагаад Сатан биднийг бурханлаг чанартаа эргэлзэхэд уруу татахыг оролддог вэ? Тэр үүнийг хэрхэн хийдэг вэ? (Мосе 1:10-23-ыг үзнэ үү.)

ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГА, МАТАЙ 4:11.

Есүс бие махбодоор болон сүнслэгээр соригдсоныхоо дараа шоронд байсан Иохан Баптистын хэрэгцээний талаар бодож эхэлсэн. “Мөн эдүгээ Иохан шоронд хаягдсаныг Есүс мэдэв, мөн тэрээр тэнгэр элчүүдийг илгээв, мөн, болгоогтун, тэд ирж мөн түүнд тохинуулав” (Иосеф Смитийн Орчуулга, Матай 4:11). Бид өөрөөсөө түрүүнд бусдыг бодох Христийн үлгэр жишээг дагаснаар хэрхэн адислагддаг вэ? Бид Түүний жишээг хэрхэн дагаж чадах вэ?

ЛУК 4:16-21

Бид сэтгэлийн шархтай эсвэл үүнээсээ “чөлөөлөгдөх” хэрэгтэй хэн нэгнийг мэдэх үү? (Лук 4:18). Бид бусдад Аврагчийн эдгээлт, эрх чөлөөг хүлээн авахад нь хэрхэн тусалж чадах вэ? Та нар ариун сүмийн ёслолуудыг үйлдэх нь хэрхэн “олзлогдогсдод эрх чөлөөг” (Лук 4:18) авчрахад тусалж болох тухай ярилцаж болно.

Заах чадвараа сайжруулах

Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдар. “[Эцэг эх эсвэл багшийн хувьд] та нарын хийж чадах хамгийн чухал зүйл бол . . . бүхий л зүрх сэтгэлээрээ сайн мэдээний дагуу амьдрах явдал юм. Энэ нь Ариун Сүнсний нөхөрлөлийг хүлээн авах гол арга зам мөн. Та төгс байх шаардлагагүй ч тууштай хичээл зүтгэл гарган, бүдэрч унах бүрдээ Аврагчийн Цагаатгалаар дамжуулан өршөөл хүлээн авахыг эрэлхийлэх ёстой” (*Аврагчийн арга барилаар заах нь*, 13).



Хорхе Коко, Дудлага



2-Р САРЫН 11-17

Иохан 2–4

“Чи дахин төрөх ёстой”

Иохан 2–4-ийг унших үед Сүнс танд өөрийн тань хөрвөлтийн тухай зүйлсийг заах болно. Түүний өдөөлтийг тэмдэглэж аваарай. Та энэхүү тойм дахь суралцах санаануудаас нэмэлт сүнслэг ойлголтыг олж авч болох юм.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Кана хотод болсон хуриман дээр Христ усыг дарс болгож өөрчилсөн юм. Энэхүү үйл явдлыг Иохан “тэмдгүүдийн эхлэл” (Иохан 2:11) хэмээн нэрлэсэн. Энэ нь нэгээс олон утгатай. Энэ бол Есүсийн олны нүдэн дээр үйлдсэн анхны тэмдэг байсан бөгөөд биднийг Аврагчтайгаа илүү адилхан болох үе дэх зүрх сэтгэлийн өөрчлөлтийн үйл явцыг буюу өөр нэгэн тэмдгийн эхлэлийг бэлгэдэж болно. Амьдралын туршид үргэлжлэх энэхүү тэмдгүүд нь Есүс Христийг дагах шийдвэр, Түүгээр дамжуулан

амьдралаа өөрчилж, сайжруулахаас эхэлдэг. Эцэст нь энэхүү өөрчлөлт бүрэн гүйцэд болдог бөгөөд үүнийг “дахин төрөх” (Иохан 3:7) гэж тайлбарлах нь хамгийн тохиромжтой. Гэвч дахин төрөх нь шавь байхын зөвхөн эхлэл юм. Худаг дээрх самари эмэгтэйд хэлсэн Христийн үгс бидэнд хэрэв энэ замаар үргэлжлүүлэн явбал яваандаа сайн мэдээ бидний доторх “мөнх аминд хүртэл оргилох” “булаг” (Иохан 4:14) болох болно гэдгийг сануулдаг.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИОХАН 2:1–11

Есүс Христийн хүч намайг өөрчилж чадна.

Та Иохан 2:1–11-ээс Аврагчийн усыг дарс болгон өөрчилсөн тухай уншаад, таныг өөрчлөх Христийн хүчийн талаар ямар ойлголт олж авч болох вэ?

Та Мариа, шавь нар зэрэг тэнд байсан бусад өөр өөр хүний өнцгөөс эргэцүүлэн бодохдоо нэмэлт ойлголт олж авч болно. Энэ хүмүүс уг тэмдгийг хэрхэн үзсэн байж болох вэ? Та эдгээр шүлгэн дээрх тэмдгүүдийн тухай ойлгож авсан зүйлсээ Есүс Христийн Никодемд (Иохан 3:1–8) болон худаг дээрх эмэгтэйд (Иохан 4:3–26) заасан зүйлстэй харьцуулж болно.

ИОХАН 3:1–21

Би Бурханы хаант улсад орохын тулд дахин төрөх ёстой.

Никодем нууцаар Есүс дээр ирэхдээ хянамгай ажиглагч байсан. Харин дараа нь тэр олны өмнө Есүсийг өмөөрч хамгаалсан (Иохан 7:45–52-ыг үзнэ үү) бөгөөд итгэгчдийн хамт Аврагчийн оршуулгад оролцсон (Иохан 19:38–40-ийг үзнэ үү). Та Иохан 3:1–21-ээс Есүсийг дагаж, дахин төрөхөд нь Никодемд нөлөөлсөн байж болох ямар сургаалыг олсон бэ?

Бошиглогч Иосеф Смит “Дахин төрөх нь ёслолуудаар дамжин Бурханы Сүнсээр ирдэг” (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 111) гэж заасан байдаг. Дахин төрөхөд таны баптисм (“уснаас төрөх” [Иохан 3:5]) болон гишүүний баталгаа (“Сүнснээс төрөх” [Иохан 3:5]) ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Та өөрчлөлтийн энэхүү үйл явцыг үргэлжлүүлэхийн тулд юу хийж байгаа вэ? (Алма 5:11–14-ийг үзнэ үү).

Түүнчлэн Мозая 5:7; 27:25–26 болон Дэвид А.Бэднарын “Ye Must Be Born Again” хэлсэн үгийг 2007 оны 4-р сарын Ерөнхий чуулганы х. 19–22-оос үзнэ үү.

ИОХАН 3:16–17

Тэнгэрлэг Эцэг Есүс Христээр дамжуулан намайг гэсэн хайраа харуулдаг.

Ахлагч Жэффри Р.Холланд “мөнх оршихуйн хамгийн эхний агуу үнэн бол Бурхан биднийг бүх зүрх сэтгэлээрээ, Өөрийн бүх хүчин чадал, оюун хийгээд чадлаараа хайрладаг явдал юм” хэмээн заасан (“Маргааш ЭЗЭН та нарын дунд гайхамшигт зүйлсийг хийх болно,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 116). Та Бурханы хайрыг Түүний Хүүгийн бэлгээр дамжуулан хэрхэн мэдэрсэн бэ?

Ариун ёслол нь Бурханы хайр болон Түүний Хүүгийн бэлгийн талаар тунгаан бодох цаг олгодог. Ямар ямар дуулал танд энэхүү хайрыг мэдрэхэд тусалдаг вэ? Мормон Табернеклын найрал дуучдын дуулсан “Би гайхширна” (LDS.org) дууллын видео бичлэгийг үзэж болно. Та ариун ёслолыг илүү гүн гүнзгий утга учиртай болгохын тулд юу хийж болох вэ?

ИОХАН 4:24

Бурхан Сүнс үү?

Есүсийн хэлсэн Бурхан бол сүнс гэсэн үгсэд зарим хүн будилдаг. Энэхүү шүлгийн Иосеф Смитийн Орчуулгад чухал тодруулга оруулсан байдаг. “Учир нь ийм хүмүүст Бурхан өөрийн Сүнсийг амласан бөлгөө” (*Судруудын удирдамж*, Иосеф Смитийн Орчуулга, Иохан 4:26). Хожмын үеийн илчлэлтэд мөн Бурхан мах, яснаас бүрдсэн биетэй гэдгийг заадаг (С ба Г 130:22–23 болон Эхлэл 5:1–3; Еврей 1:1–3-ыг үзнэ үү).

ИОХАН 4:7–26

Христ надад амийн усыг өгдөг.

Есүс самари эмэгтэйд Өөрийнх нь өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй хэмээн хэлсэн нь ямар утгатай вэ? Сайн мэдээ хэрхэн амийн устай адил байдаг вэ?



Христийн сайн мэдээ бол бидний бодгалийг тэтгээдэг амийн ус юм.

Самари эмэгтэйд хандан хэлсэн Аврагчийн нэгэн захиас бидний хэрхэн бишрэн шүтэх нь хаана бишрэн шүтэхээс илүү чухал хэмээх захиас юм (Иохан 4:21–24). Та “Сүнсээрээ, үнэнээр Эцэгт мөргөхийн” тулд юу хийж байгаа вэ? (Иохан 4:23).

Мөн Судруудын удирдамж дахь “Бишрэн шүтэх”-ийг болон Дийн М.Дэйвийсийн “Шүтлэг бишрэлийн адислал” хэлсэн үгийг *Ensign* эсвэл 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 85–88-аас үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлахад тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИОХАН 2-4

Гэр бүлээрээ эдгээр бүлгийг уншихдаа Аврагч сүнслэг үнэнийг заахдаа өдөр бүрийн зүйлс буюу төрөлт, салхи, ус, хоол хүнс зэргийг хэрхэн ашигласан тал дээр анхаарлаа хандуулаарай. Та гэртээ байгаа ямар ямар зүйлийг ашиглан сүнслэг үнэнүүдийг зааж болох вэ?

ИОХАН 2:18-22

Гэр орныг тань материаллаг болон сүнслэг байдлаар цэвэр бус болгох зүйлсээс зайлсхийснээр гэр тань ариун сүм шиг ариун нандин газар болж чадна. Танай гэр бүл гэрээ ариун нандин байлгахын тулд юуг гаргаж хаях хэрэгтэй вэ? Та эдгээр зүйлийг гэрээсээ гаргаж хаяхын тулд юу хийх вэ?

ИОХАН 3:1-6

Гэр бүлийн гишүүдээс амьд, хөдөлгөөнтэй, оюун ухаантай хүнийг бүтээх үйл явц буюу жирэмслэлт,

төрөлтийн гайхамшгийн тухай бодохыг хүс. Христ биднийг Бурханы хаанчлалд орохоос өмнө дахин төрөх ёстой хэмээн заасан. Яагаад дахин төрөх нь Бурханы хаант улсад орохоос өмнө хийх шаардлагатай өөрчлөлтөд тохирсон сайн зүйрлэл болж байна вэ? Бид дахин төрөх үйл явцыг хэрхэн үзсэн бэ?

ИОХАН 3:16

Энэ шүлгийг найздаа тайлбарлаж байгаа мэт өөрийн үгээр хэлэхийг гэр бүлийнхнээсээ хүс. Амьдралдаа Бурханы хайрыг мэдрэхэд Христ бидэнд хэрхэн тусалсан бэ?

ИОХАН 4:5-15

Аврагч сайн мэдээгээ амийн устай зүйрлэхдээ бидэнд юу зааж байсан бэ? Аягатай ус бариад, гэр бүлийнхнээсээ усны шинж чанарыг дүрслэн хэлэхийг хүсэж болно. Бид яагаад өдөр бүр ус уух шаардлагатай вэ? Яагаад Есүс Христ сайн мэдээгээ “мөнх аминд хүртэл оргилох булаг”-тай зүйрлэсэн бэ? (Иохан 4:14).

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Тэмдгүүдийг эрж ол. Судруудад сүнслэг үнэнүүдийг төлөөлөх эд зүйл, үйл явдал, үйлдэл, сургаалыг олонтоо ашигладаг. Эдгээр тэмдэг нь заагдаж буй сургаалын талаарх таны ойлголтыг баяжуулах болно. Жишээлбэл, Аврагч хөрвөлтийг дахин төрөхтэй зүйрлэсэн.



Саймон Дуву, Амийн ус



Хорхе Кокко, Уулан Өзэрх Номлол

2-Р САРЫН 18-24

Матай 5; Лук 6

“Та нар ерөөлтэй еэ”

Та Матай 5, Лук 6-г унших үед төрөх сэтгэгдэлдээ анхаарал хандуулж, судар судлах тэмдэглэл дээрээ бичээрэй. Энэхүү тойм нь танд эдгээр бүлэгт орших хамгийн чухал, ач холбогдолтой зарим зарчмыг тодорхойлоход туслах боломжтой.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Тохинууллынх нь энэ цаг үед Есүсийн сургаал тэр үеийн хүмүүсийн сонсож дассан зүйлсээс өөр гэдэг нь тодорхой болсон. Ядуу хүмүүс Бурханы хаант улсыг хүлээн авна гэж үү? Дөлгөөн хүмүүс дэлхийг өвлөн авах юм уу? Хавчигдсан хүмүүс адислагдана гэж үү? Хуулийн багш нар болон фарисайчууд ийм зүйл заагаагүй. Харин Бурханы хуулийг үнэхээр ойлгодог хүмүүст эдгээр сургаал зөв санагдсан.

“Нүдийг нүдээр” болон “дайснаа үзэн яд” (Матай 5:38, 43) гэдэг нь доод хууль байсан бөгөөд эдгээр нь дээд хуулиар амьдрах хүсэлгүй хүмүүст өгөгдсөн юм. Гэсэн ч Христ доод хуулийг гүйцэлдүүлж (3 Нифай 15:2-10-ыг үзнэ үү), “Тэнгэрлэг Эцэг [маань] төгс байдаг шиг” (Матай 5:48) бидэнд ч мөн нэгэн өдөр төгс болоход туслах дээд хуулийг заахаар ирсэн.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 5:1-12; ЛУК 6:20-26

Үүрдийн аз жаргал Есүс Христийн заасан замаар амьдарснаар ирдэг.

Хүн бүр аз жаргалтай байхыг хүсдэг боловч хүн бүр ижил газраас аз жаргалыг хайдаггүй. Зарим хүн үүнийг дэлхийн сүр хүч, байр сууринаас хайдаг бол бусад нь эд баялаг, биеийн дур хүслийг хангах зүйлсээс хайдаг. Есүс Христ үүрдийн аз жаргалд хүрэх замыг заахаар, адислагдах гэдэг нь үнэхээр ямар утгатай болохыг заахаар ирсэн. Та Матай 5:1-12, Лук 6:20-26-аас үүрдийн аз жаргалыг олж авах талаар юу сурсан бэ? Энэ нь аз жаргалын талаарх дэлхийн үзэл бодлоос юугаараа ялгаатай вэ?

Таныг эдгээр шүлгийг нэг бүрчлэн уншиж байхад таны санаанд ямар асуулт эсвэл сэтгэгдэл төрж байна вэ? Эдгээр шүлэг танд Есүс Христийн шавь байх талаар юу зааж байна вэ? Та эдгээр шүлэгт дүрсэлсэн зан чанаруудыг хөгжүүлэхийн тулд юу хийхэд сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Түүнчлэн Иохан 13:17; 3 Нифай 12:3-12-ыг үзнэ үү.

МАТАЙ 5:13

Аврагч яагаад шавь нараа давстай зүйрлэсэн бэ?

Давсыг урт удаан хугацаагаар нөөшлөх, амтлах, ариутгах зорилгоор ашигласаар ирсэн. Давс мөн израильчуудын хувьд шашны утга санаа агуулдаг. Энэ нь Мосегийн хуулиар амьтан золиослох эртний дадалтай холбоотой байсан (Левит 2:13; Тооллого 18:19-ийг үзнэ үү). Давс амтаа алдахдаа үр нөлөөгүй болж, “юунд ч хэрэг болдоггүй” (Матай 5:13). Бусад элементтэй холилдож, бохирдсон бол ийм зүйл болдог. Христийн шавь нарын хувьд бид дэлхийн сүнслэг бохирдлоос зайлсхийж, “амтаа” хадгалдаг. Энэ нь бидэнд газрын давсны адил нөөшлөх, ариутгах ажлаа гүйцэтгэх боломж олгодог. Жишээ нь, сайн мэдээг хуваалцах, дэлхийд сайн нөлөө үзүүлэх (С ба Г 103:9-10-ыг үзнэ үү) гэх мэт.

МАТАЙ 5:17-48; ЛУК 6:27-35

Христийн хууль Мосегийн хуулийг орлодог.

Есүс шавь нараа Мосегийн хуулийг сайн дагадаг гэдгээрээ өөрсдөөрөө бардамнадаг хуулийн багш нар, фарисайчуудаас (Матай 5:20-ийг үзнэ үү) илүү зөв шударга байх хэрэгтэй хэмээн хэлсэн нь тэднийг цочирдуулсан байж болох юм. Гэвч Есүс зөвхөн бидний үйлдлийг төдийгүй үйлдлийг маань өдөөн урамшуулдаг бодол, мэдрэмжийг өргөн дэмждэг дээд хуулийг заасан. Энэхүү дээд хууль нь зүрх, сэтгэл, оюун ухаан гэх мэт илүү ихийг шаарддаг (Матай 22:37).

Та Матай 5:21-48, Лук 6:27-35-ыг уншихдаа Мосегийн хуулиар шаарддаг байсан зан байдлуудыг болон (“... та нар сонссон”) Есүсийн заасан ямар зүйлс тэдгээрийг өргөн дэмжиж байгааг тэмдэглэж болно.

Жишээлбэл, Есүс Матай 5:27-28-д бодлуудынхаа төлөө бидний хүлээх хариуцлагын талаар юу заасан бэ? Та оюун ухаан, зүрх сэтгэлд орж ирдэг бодлоо хэрхэн илүү сайн хянаж чадах вэ? (С ба Г 121:45).

МАТАЙ 5:48

Тэнгэрлэг Эцэг үнэхээр биднээс төгс байхыг шаарддаг уу?

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон:

“Төгс гэдэг үг нь грекийн ‘бүрэн’ гэсэн утга илэрхийлдэг *teleios* хэмээх үгнээс орчуулагдсан. Үйл үгийн тодорхойгүй төлөв нь *teleiono* буюу ‘цаад захад хүрэх, гүйцэд өсөж хөгжих, боловсронгуй болох эсвэл дуусгах’ гэсэн утгатай. Энэ үг нь ‘алдаанаас чөлөөлөх’ гэсэн утга илэрхийлдэггүй, харин ‘хол байгаа зүйлд хүрэх’ гэсэн утга илэрхийлдэг болохыг анхаараарай . . .

. . . Их Эзэн Эдүгээ та нар Бурханы оршихуйд ч, . . . тэсч чадах нь үгүй; иймийн тул, та нар төгөлдөржих хүртлээ тэвчээрт үргэлжлүүл’ [С ба Г 67:13] хэмээн заасан байдаг.

Хэрэв бидний төгс төгөлдөр болох гэсэн хичээнгүй чармайлт одоогоор давагдашгүй бөгөөд дуусашгүй мэт санагдаж байгаа бол бид зовох шаардлагагүй. Төгс байдал хүлээгдэж байна. Энэ нь зөвхөн амилуулалтын дараа, гагцхүү Их Эзэнээр дамжин бүрэн утгаараа ирэх болно. Энэ нь Түүнийг

хайрлаж, зарлигуудыг нь дагах бүх хүнийг хүлээдэг” (“Perfection Pending,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 88) хэмээн заасан.

Түүнчлэн Филиппой 3:13–15; 2 Петр 1:3–11; Илчлэлт 3:21–22; 3 Нифай 27:27; Моронай 10:32–33; Сургаал ба Гэрээ 76:69-ийг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлахад тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 5:1-9

Матай 5:1–9-д заасан аль аль зарчим танай гэр орныг илүү аз жаргалтай газар болоход тусалж чадах вэ? Дараагийн хэдэн долоо хоногт Уулан дээрх номлолын талаар судлахдаа нэг юм уу хоёр зарчим дээр анхаарлаа төвлөрүүлж болно. Жишээлбэл, аль сургаал гэр бүлийн гишүүдэд тань амар тайвныг тогтоогч байхад тусална гэж тэд бодож байна вэ? (Матай 5:21–25, 38–44). Та ямар ямар зорилго тавьж болох вэ? Үүнийгээ хэрхэн шалгах вэ?

МАТАЙ 5:14-16

Гэр бүлийнхэндээ “дэлхийн гэрэл” байна гэдэг нь ямар утгатай болохыг ойлгоход туслахын тулд та гэртээ болон гудамжиндаа мөн дэлхийд байдаг гэрэл гаргадаг зүйлсийн талаар судалж болно. Та гэрлийг нуухад юу болдгийг үзүүлбэл тустай байж болох юм. Есүс “Та нар бол дэлхийн гэрэл мөн” хэмээн хэлсэн нь ямар учиртай вэ? (Матай 5:14). Манай гэр бүлийн гэрэл нь хэн бэ? Бид хэрхэн бусдын гэрэл байж болох вэ? (С ба Г 103:9–10-ыг үзнэ үү).

МАТАЙ 5:43-44

Их Эзэн яагаад бидэнд найрсаг бус хандсан хүмүүсийн төлөө залбирахыг биднээс хүсдэг вэ? Бид гэр бүл дотроо энэ зарчмын дагуу хэрхэн амьдарч чадах вэ?

Заах чадвараа сайжруулах

Ажигч гярхай бай. Та хүүхдүүдийнхээ амьдралд юу болж байгаад анхаарал хандуулснаар заах онцгой боломжуудыг олж авах болно. Мөн өдрийн турш хүүхдүүдийн тань хэлсэн үг эсвэл тавьсан асуулт заах боломж руу хөтлөх боломжтой. (*Аврагчийн арга барилаар заах нь*, 16-г үзнэ үү).



"Та нар бол дэлхийн гэрэл мөн" (Матай 5:14).



Жэймс Тиссоп. Есүс далайн эрэг дээр хуримтлал зассан нь

2-Р САРЫН 25-ААС 3-Р САРЫН 3

Матай 6–7

Матай 6–7: “Тэр эрх мэдэлтэй нэгэн шиг тэдэнд зааж байв”

Бид оюун бодолдоо хариултыг нь олохыг хүссэн асуултаа мөн Тэнгэрлэг Эцэгийн биднийг хийгээсэй хэмээн хүсэж байгаа зүйлийг ойлгох чин хүслээр судраас уншихдаа Ариун Сүнсийг бидэнд сүнслэг өдөөлт өгөхөд урьдаг. Та Матай 6–7-г уншихдаа эдгээр өдөөлтөд анхаарлаа хандуулаарай.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Уулан дээрх номлол нь Христийн шашинтнуудын дундах хамгийн түгээмэл яриа юм. Аврагч уулан дээрх хот, талын сараана цэцэг, хонины арьс нөмөрсөн чоно зэрэг тодорхой дүрслэлүүдээр заасан. Гэвч Уулан дээрх номлол бол сайхан ярианаас хамаагүй илүү гүн утгатай. Аврагчийн шавь нартаа

заасан сургаалын хүч бидний амьдралыг, ялангуяа биднийг үүний дагуу амьдрах үед өөрчилдөг. Тэгснээр Түүний үгс үгсээс ч илүү; мөн мэргэн хүний байшинтай адил дэлхийн салхи салхилж, үер буухад бат зогсох амьдралын баттай суурь болдог (Матай 7:24–25-ыг үзнэ үү).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 6-7

Би зүрх сэтгэлээ бурханлаг зүйлс дээр тавих хэрэгтэй.

Бурханы зүйлсийг дэлхийн зүйлсээс түрүүнд тавих нь үргэлж амархан байдаггүй. Матай 6-7 дээрх Аврагчийн заасан зүйлсээс аль нь бурханлаг зүйлсэд анхаарлаа хандуулахад тань тусалдаг вэ? Түүний үгсээс суралцах үед танд ямар бодол сэтгэгдэл төрдөг вэ? Та юу хийхэд сүнслэгээр өдөөгдөж байна вэ? Сэтгэгдлээ бичиж тэмдэглэж болно. Жишээлбэл:

| | |
|-------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Матай 6:1-4 | Би хүмүүс миний талаар юу гэж бодож байгаа бол гэдгээс илүү Бурхан миний талаар юу гэж бодож байгаа бол гэдэгт санаа тавих ёстой. |
| | |

МАТАЙ 6-7

Би даруухан, чин сэтгэлийн залбирлаар дамжуулан Бурханд ойртож чадна.

Уулан дээрх номлол маш олон сэдвийг агуулдаг бөгөөд таны ажигласан сэдвүүд амьдралын тань одоогийн нөхцөл байдал, Их Эзэний танд хэлэхийг хүсэж буй зүйл дээр тодорхой хувиар тулгуурлах болно.

Матай 6-7-ийн нэг сэдэв бол залбирал юм. Залбирлаа дүгнэн бодоход цаг гарга. Та өөрийгөө залбирлаар дамжуулан Бурхантай илүү ойр болох хүчин чармайлтыг хэр гаргаж байна гэж бодож байна вэ? Матай 6-7-р бүлгийн ямар сургаал таныг залбирлаа сайжруулахад сүнслэгээр өдөөж байна вэ? Сүнсээр дамжуулан хүлээн авсан мэдрэмжээ бичиж тэмдэглэ. Жишээлбэл:

| | |
|------------|----------------------------------------------------------------------------------------|
| Матай 6:9 | Би залбирахдаа Тэнгэрлэг Эцэгийн нэрийг хүндэтгэлтэй хэрэглэх ёстой. |
| Матай 6:10 | Би залбирахдаа Их Эзэний хүсэл биелэгдэг хэмээн өөрийнхөө хүслийг илэрхийлэх хэрэгтэй. |

Та Уулан дээрх номлолыг дахин нэг удаа буюу энэ удаад танд хамааралтай захиасыг эсвэл өөр нэг нийтлэг сэдвийг олж харахаар уншиж болно. Олсон зүйлээ төрсөн бодол сэтгэгдлийн хамт судар судлах тэмдэглэл дээрээ бич.

МАТАЙ 6:7

Залбирахдаа “утгагүй хоосон давтах” гэдэг нь ямар утгатай вэ?

Хүмүүс “утгагүй хоосон давтах” гэдгийг ихэвчлэн нэг үгээ ахин дахин давтахыг хэлж байна гэж боддог. Гэсэн хэдий ч хоосон гэдэг үг нь ямар ч үнэ цэнгүй зүйлийг дүрсэлж болдог. Залбиралдаа “утгагүй хоосон давтах” нь чин сэтгэл, үнэн хүсэлгүйгээр залбирч байна гэсэн үг юм (Алма 31:12-23-ыг үзнэ үү).

МАТАЙ 6:9-13

Яагаад бид Их Эзэний залбирлыг цээжээр хэлдэггүй вэ?

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Их Эзэн залбирлынхаа өмнө дагалдагчдадаа ‘хоосон давталтаас’ [Матай 6:7] зайлсхийж, ‘энэ маягаар’ [Матай 6:9] залбирахыг хүссэн байдаг. Тийнхүү Их Эзэний залбирал бол дагах загвар болохоос биш, цээжилчихээд давтаж байх өгүүлбэр биш юм. Эзэн хилэнцийг эсэргүүцэж, үргэлж зөв шударга амьдрахын тулд Бурханы тусламжийн төлөө залбирахыг л биднээс хүсдэг билээ” (“Их Эзэний залбирлаас авах сургаамж,” 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 52) хэмээн заасан.

МАТАЙ 7:1-5

Би зөв шударгаар шүүх хэрэгтэй.

Матай 7:1-д Аврагч бидэнд шүүж болохгүй тухай заасан мэт санагдаж болох ч бусад сударт (мөн энэ бүлгийн бусад шүлэгт) Тэр бидэнд хэрхэн шүүх тухай удирдамж өгсөн. Хэрэв энэ нь ойлгомжгүй санагдаж байвал Иосеф Смитийн Орчуулгын энэ шүлэг тус болно. “Та нар шүүгдэхгүйн тулд шударга бусаар бүү шүү. Харин шударга шүүгч адил шүү”. Та Матай 7:1-5 болон энэ бүлгийн бусад шүлгээс хэрхэн “зөв шударгаар шүүх” тухай мэдэхэд тус болох юуг олж мэдсэн бэ?

Мөн *Итгэлдээ үнэнч байх нь* номын 62–63-р хуудсан дээрх “Бусдыг шүүх нь”; Линн Ж. Роббинсын “Зөв шударга шүүгч” хэлсэн үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы 89-өөс үзнэ үү.

МАТАЙ 7:21–23

Би Есүс Христийн тааллын дагуу үйлдсэнээр Түүнийг таньж мэднэ.

Матай 7:23-р шүлгэн дээрх “Би та нарыг огт танихгүй юм байна” хэмээх хэллэгийг Иосеф Смитийн

Орчуулга дээр “Та нар Намайг огт танихгүй байсан” хэмээн өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь 21–22-р шүлэгт Их Эзэний Өөрийнх нь хүслийг гүйцэлдүүлэх тухай заасан зүйлсийг илүү сайн ойлгоход танд хэрхэн тусалж байна вэ? Та Их Эзэнийг хэр сайн мэддэг гэж боддог вэ? Та Түүнийг илүү сайн мэдэхийн тулд юу хийж болох вэ?

Мөн Дэвид А.Бэднарын “Хэрэв та нар Намайг мэдсэн бол” хэлсэн үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 97–101-ээс үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ Уулан дээрх номлолын талаар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 6:5–13

Бид Аврагчийн залбирсан аргаас залбирлын тухай юу сурч болох вэ? Бид хэрхэн хувийн болон гэр бүлийн залбирлаа сайжруулахад Түүний залбирлыг жишээ болгон ашиглаж болох вэ? (Мөн Лук 11:1–13-ыг үзнэ үү.) Хэрэв та бага насны хүүхдүүдтэй бол хамтдаа залбирах дадлага хийж болно.

МАТАЙ 6:33

“Эхлээд Түүний хаанчлалыг . . . хайгтун” гэдэг нь ямар утгатай вэ? Бид үүнийг гэр бүлээрээ хэрхэн хийж байгаа вэ?

МАТАЙ 7:1–5

Та Аврагчийн заасан бусдыг шүүх тухай сургаалын талаар ярилцахдаа үртэс, дүнг хоёрыг төлөөлөх жижиг зомгол, том тайрдас мод ашиглаж болно. Хичээлийнхээ нэг хэсэг болгон *Итгэлдээ үнэнч байх нь* номын 62-р хуудсан дээрх “Бусдыг шүүх нь” гарчгаас эхний хэсгийг уншихыг бодож үз.

МАТАЙ 7:24–27

Мэргэн хүн ба мунхаг хүний тухай Аврагчийн зүйрлэлийг илүү сайн ойлгоход нь гэр бүлдээ туслахын тулд тэднээр элсэн дээр болон чулуун дээр ус асгуулж болно. Бид сүнслэг сууриа чулуун дээр хэрхэн тавьж чадах вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Ойлголтоо хуваалц. Хувиараа суралцсан зарчмуудынхаа тухай ярилцах нь бусдад заах сайн арга байхаас гадна уншсан зүйлийнхээ тухай ойлголтыг хөгжүүлэхэд тусалдаг. Энэ долоо хоногт гэр бүлтэйгээ эсвэл Сүмийн ангидаа суралцсан зарчмаа хуваалцахыг хичээ.



Дэл Парсон, Би Таны төлөө залбирсан



Жон Макнолтон, Эдгээх туяагаар гайзгуулах нь

3-Р САРЫН 4-10

Матай 8–9; Марк 2–5

“Итгэл чинь чамайг эдгээлээ”

Та Матай 8–9, Марк 2–5-ыг уншихдаа Ариун Сүнснээс ирэх мэдрэмжинд анхаарлаа төвлөрүүлээрэй. Хүлээж авсан мэдрэмжүүд болон тэдгээрийн дагуу үйлдэхийн тулд хийж болох зүйлүүдээ бичиж тэмдэглэ.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Халуунтай эмэгтэйгээс эхлээд нас барсан гэгдсэн охиныг хүртэл өвдөж, зовсон хүн бүрийг эдгээсэн Аврагчийн тухай олон шастирыг гайхаж бишрэхгүйгээр Шинэ Гэрээг уншина гэдэг хэцүү. Бид бие махбодыг эдгээсэн эдгээр гайхамшгаас ямар сургамж авч болох вэ? Нэгэн тодорхой захиас бол Есүс Христ бидний бие махбодын өвчин зовлон, төгс бус байдал зэрэг бүхий л зүйлээс дээгүүрх хүчийг агуулдаг Бурханы Хүү юм гэсэн захиас юм. Харин үл

итгэгч хуулийн багш нарт хандан хэлсэн “Хүний Хүү газар дээр нүглүүдийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд” (Марк 2:10) хэмээх Түүний үгсэд өөр нэг утга байна. Та сохор эсвэл уяман өвчтэй хүнийг эдгээсэн тухай уншихдаа Аврагчийг “Итгэл чинь чамайг эдгээлээ” (Марк 5:34) хэмээн хэлэхийг сонсон, Түүнээс авч болох сүнслэг болон бие махбодын аль алиных нь эдгэрлийн тухай бодож болох юм.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 8-9; МАРК 2; 5

Аврагч сул дорой байдал, өвчин зовлонг эдгээж чадна.

Эдгээр хэдэн бүлэгт Аврагчийн үйлдсэн олон гайхамшгийн жишээг цэдэглэсэн байдаг. Эдгээр эдгээлтийн талаар судлахдаа танд зориулсан байж болох захиасыг хай. Та өөртөө дараах хэдэн асуултыг тавьж болох юм. Энэ түүх итгэлийн тухай юу зааж байна вэ? Энэ нь Аврагчийн тухай юу зааж байна вэ? Бурхан намайг энэ гайхамшгаас юу сурахыг хүсэж байгаа бол?

- Уяман өвчтэй хүн (Матай 8:1-4)
- Зуутын даргын зарц (Матай 8:5-13)
- Петрийн хадам ээж (Матай 8:14-15)
- Хоёр сохор хүн (Матай 9:27-31)
- Саа өвчтэй хүн (Марк 2:1-12)
- Бузар сүнстэй хүн (Марк 5:1-20)
- Иайрын охин (Марк 5:22-23, 35-43)
- Цус алддаг өвчтэй эмэгтэй (Марк 5:24-34)

Түүнчлэн Даллин Х.Өүксийн “Өвчтөнийг эдгээх нь” хэлсэн үгийг 2010 оны 4-р сарын Ерөнхий чуулганы х. 55-59-өөс үзнэ үү.



Есүс өвчтөнийг эдгээсэн нь, Жозеф Брики, Хейнрих Хофманны бүтээлийг сэргээв.

МАТАЙ 8:5-13; МАРК 5:24-34

Би Бурханы тусламжийг авах эрхгүй мэт санагдсан ч Түүнээс тусламж эрж болно.

Зуутын дарга болох харь хүн өөрийгөө Аврагчийг гэртээ оруулах зохистой хүн биш гэж бодсон. Цус алддаг өвчтэй эмэгтэй цэвэр бусад тооцогдон иудейчүүдийн нийгмээс тусгаарлагдсан байсан. Гэвч Аврагч тэднийг хоёуланг адисалсан. Та Их Эзэнээс тусламж хүсэх тухай энэ хоёр түүхээс юу сурч болох вэ?

МАТАЙ 8:18-22; МАРК 3:31-35

Христийн шавь байх гэдэг нь амьдралдаа Түүнийг нэгдүгээрт тавина гэсэн үг юм.

Эдгээр шүлэгт Есүс бидэнд Өөрийнх нь шавь байх нь заримдаа бусад үнэ цэнтэй зүйлээ золиослох шаардлагатай байсан ч Түүнийг нэгдүгээрт тавихыг шаарддаг хэмээн заасан. Та эдгээр хэсгийг уншаад, өөрийгөө ямар шавь болохоо тунгаан бодоорой. Шавь нар яагаад Аврагчийг нэгдүгээрт тавих хүсэлтэй байх ёстой вэ? Та Есүсийг нэгдүгээрт тавихын тулд юунаас татгалзах шаардлагатай болж байна вэ? (Мөн Лук 9:57-62-ыг үзнэ үү.)

МАТАЙ 8:23-27; МАРК 4:35-41

Есүс Христ амьдралын шуурган дунд амар тайвныг тогтоох хүчтэй.

Есүсийн шавь нар далайн шуурган дунд давалгаалан ирэх ус завийг нь дүүргэхийг хараад “Багш аа, бидний үхэх нь Танд хамаагүй гэж үү?” хэмээн асуусны адил мэдрэмж танд төрж байсан уу?

Та Марк 4:35-41-р шүлгээс дөрвөн асуулт олох болно. Асуултуудыг нэг бүрчлэн жагсаан бичээд, эдгээр нь Есүс Христэд итгэх итгэлээр амьдралын саад бэрхшээлүүдийг даван гарах тухай юу зааж байгааг тунгаан бод. Аврагч амьдралын шуурган дунд амар амгаланг хэрхэн тогтоодог вэ?

МАТАЙ 9:1-13; МАРК 2:15-17**Би үнэн зарчмуудыг зааснаар итгэлээ хамгаалж чадна.**

Хүмүүс бидний шашны итгэл үнэмшлийг шүүмжлэхэд хэрхэн хариу өгөхөө мэдэх нь заримдаа хэцүү байдаг. Та Матай 9:1-13, Марк 2:15-17-г уншихдаа буруушаагчийн шүүмжлэлийг болон Аврагчийн хариултыг олж уншаарай. Шүүмжлэл болон хариултыг өөр өөр өнгөөр тэмдэглэж эсвэл бичиж авч болно. Та Аврагчийн заах арга барилын талаар юу анзаарсан бэ? Та сайн мэдээний зарчмыг эсвэл Сүмийн итгэл үнэмшлийг хамгаалах хэрэгтэй болбол Түүний үлгэр жишээг дагах нь танд хэрхэн туслах вэ?

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ Аврагчийн тохинууллын талаар үргэлжлүүлэн судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд тусална. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 8-9; МАРК 2; 5

Гэр бүлийнхээ гишүүн тус бүрээс нэг нэг гайхамшгийн тухай ярьж, (боломжтой бол зураг ашиглан) үүнээс ойлгож авсан зүйлээ хуваалцахыг хүсэж болно. Та орчин үеийн Сүмийн түүхээс уншсан юм уу өөрийнхөө нүдээр үзсэн гайхамшгийн нэг жишээг хуваалцаж болно.

МАТАЙ 9:10-13

Бусдын ад үзэж байсан татвар хураагчид, нүгэлтнүүдтэй харьцаж байсан Аврагчийн хандлагаас бид юу сурч болох вэ? Бид бусад хүнтэй харилцахдаа Түүний үлгэр жишээг хэрхэн дагаж чадах вэ?

МАТАЙ 9:1-8**Наманчлалын ачаар би зоригтой байж чадна.**

Саа өвчтэй хүнийг Аврагч руу авчрахад түүнийг бие махбодын хувьд эдгээх хэрэгтэй нь ойлгомжтой байсан. Харин Есүс түүнд нүглээс уучлагдах нь нэн тэргүүнд шаардлагатай болохыг хэлсэн. Тэр хүн бие махбод нь эдгээгдээгүй байсан ч “зоригтой бай” (Матай 9:2) хэмээх Есүсийн зөвлөгөөг дагах байсан. Та хэзээ өршөөгдсөнөө мэдээд баяр баяслыг мэдэрсэн бэ? (Мөн Алма 36:18-24-ийг үзнэ үү.)

МАТАЙ 9:36-38


Та сайн мэдээг хуваалцахад туслах ажилчдыг гуйсан Аврагчийн гуйлтыг ойлгоход нь гэр бүлийнхэндээ хэрхэн тусалж чадах вэ? Нэг хүн хийвэл урт хугацаа шаардагдах ажлыг хамтдаа хийх зэрэг энгийн зүйл хийж болно. Жишээ нь, оройн хоолоо идсэний дараа гал тогооны өрөөгөө цэвэрлэх гэх мэт. Бид сайн мэдээний захиасыг хуваалцахын тулд юу хийж болох вэ?

МАРК 4:35-41

Гэр бүлийн гишүүдийг айсан үед энэ түүх тус болох уу? Тэд 39-р шүлгийг уншаад, үймээн самуунтай эсвэл айдас түгшүүртэй үед амар тайванг мэдрэхэд нь Аврагч тусалсан тухай туршлагаасаа хуваалцаж болох юм.

Заах чадвараа сайжруулах

Үргэлж холбогдож, харилцахад бэлэн бай. Заах хамгийн онцгой боломж нь гэр бүлийн гишүүдийн сэтгэл дотроо тээж явдаг асуултуудаас эсвэл сэтгэлийг нь шаналгаж байдаг асуудлуудаас эхэлдэг. Та үг хэл, үйлдлээрээ гэр бүлийнхнийгээ сонсох хүсэлтэй байгаагаа тэдэнд харуул (Аврагчийн арга барилаар заах нь, 16).



Ж. Керк Ричардс, Христ ба саа өвчтэй хүн



3-Р САРЫН 11-17

Матай 10–12; Марк 2; Лук 7; 11

“Есүс эдгээр арван хоёрыг явуулжээ”

Та Матай 10–12; Марк 2; Лук 7; 11-ийг уншихдаа Ариун Сүнснээс хүлээж авсан мэдрэмжүүдээ тэмдэглэж аваарай. Тэдгээр мэдрэмжийнхээ талаар тунгаан бодож, бичиж авч болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Есүсийн эдгээлтийн гайхамшгуудын талаарх мэдээлэл хурдан тархав. Цугласан олон өвчнөөсөө ангижрах найдвар тээн, Түүнийг дагаж байлаа. Харин Аврагч тэдний зүг хараад, бие махбодын өвчнөөс илүүг харсан. Түүний зүрх сэтгэл нигүүлслээр дүүрч, “хоньчингүй хонин сүрэг”-ийг (Матай 9:36) олж харсан. Тэр “Ургац үнэндээ арвин боловч ажилчид нь цөөн байна” (Матай 9:37) гэж ажиглав. Тиймээс Тэр арван хоёр төлөөлөгчийг дуудан, “тэдэнд

эрх мэдлийг өгсөн” бөгөөд “Израилийн гэрийн төөрсөн хонинуудад” (Матай 10:1, 6) зааж, үйлчлүүлэхээр тэднийг илгээжээ. Өнөөдөр Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд үйлчлэх ажилчид тэр үеийнхтэй адил маш их хэрэгтэй байна. Арван хоёр төлөөлөгч одоо ч байгаа бөгөөд “Тэнгэрийн хаанчлал ойрхон байна” (Матай 10:7) хэмээн тунхаглах Есүс Христийн шавь нар урьд урьдынхаас илүү олон байна.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 10

Их Эзэн үйлчлэгчдэдээ Өөрийнх нь ажлыг хийх хүчийг өгдөг.

Матай 10-р бүлэгт Есүсийн өгсөн заавар Өөрийнх нь төлөөлөгчдөд зориулсан заавар байсан ч бид бүгдээрээ Их Эзэний ажилд үүрэг гүйцэтгэдэг. Есүс төлөөлөгчдөдөө номлолоо гүйцэтгэхэд туслах зорилгоор ямар хүчийг өгсөн бэ? Та дуудагдсан ажлаа хийхдээ Түүний хүчийг хэрхэн хүлээн авч болох вэ? (2 Коринт 6:1-10; С ба Г 121:34-46-г үзнэ үү).



Өнөө үед Арван хоёр төлөөлөгч Их Эзэний ажлыг гүйцэтгэдэг.

Та Христийн төлөөлөгчдөдөө өгсөн үүрэг даалгаврын талаар уншихдаа Их Эзэний танаас хийгээсэй хэмээн хүссэн ажлын талаар ямар нэг мэдрэмж хүлээн авч болох юм. Бодлоо цэгцлэхэд тань дараах хүснэгт тусалж болно.

| Матай 10 | Надад төрсөн мэдрэмжүүд |
|-------------------------------|-----------------------------------------------------------|
| Аврагч шавь нартаа хүч өгсөн. | Бурхан надад ажлаа хийхэд шаардлагатай хүчийг өгөх болно. |

Мөн Итгэлийн тунхаг 1:6 ба Судруудын удирдамжийн "Төлөөлөгч"-ийг үзнэ үү.

МАТАЙ 10:17-20

Их Эзэнд үйлчилж байхад маань Тэр миний хэлэх үгсийг сүнслэг өдөөлтөөр өдөөх болно.

Шавь нар нь өнөө үеийн шавь нарт тохиолдож болох зүйлстэй төстэй зүйл буюу итгэлийнхээ

талаар байцаагдаж хавчигдах болно гэдгийг Их Эзэн урьдчилан харсан. Гэвч Тэрээр тэдэнд Сүнсээр дамжуулан юу хэлэхээ мэдэх болно хэмээн амласан. Магадгүй, гэрчлэлээ хуваалцаж, адислал өгч эсвэл хэн нэгэнтэй ярилцаж байхад тань энэхүү тэнгэрлэг амлалт таны амьдралд биелж байсан туршлага бий юү? Туршлагаа хайртай хүнтэйгээ хуваалцаж эсвэл тэмдэглэлдээ бичиж болно.

Мөн Лук 12:11-12; Сургаал ба Гэрээ 84:85-ыг үзнэ үү.

МАТАЙ 10:34-39

Есүс "Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм" хэмээн ямар утгаар хэлсэн бэ?

Ахлагч Д.Тодд Кристоффэрсон "Та нарын заримыг Есүс Христийн сайн мэдээг хүлээн авч, Түүнтэй гэрээнд ороход аав, ээж, ах, эгч нар тань эсэргүүцэж, хөөж байсан гэдэгт би итгэлтэй байна. Ямар нэгэн байдлаар Христийг хайрлах агуу их хайрынхаа төлөө өөрсдийн хувьд үнэ цэнтэй харилцаагаа золиослох шаардлага гарч, та бүхэн нулимсаараа нүүрээ угаасан байх. Гэвч та нар энэ шаналал, зовлонг амсахдаа өөрийнхөө хайрыг багасгалгүй, Бурханы Хүүгийн өмнө нүүр улайхааргүй харагдаж байгаа" ("Finding Your Life," *Ensign*, 2016 оны 3-р сар, 28) хэмээн заасан.

Аврагчийг дагахын тулд дотно харилцаагаа алдах хүсэл нь "Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно" (Матай 10:39) хэмээх амлалттай хамт ирдэг.

МАТАЙ 11:28-30

Есүс Христэд болон Түүний Цагаатгалд найдах үед Тэр надад амралтыг өгөх болно.

Зарим нь бидний гэм нүгэл, алдаа дутагдлаас, зарим нь бусдын сонголтоос мөн бусад нь хэний ч буруугаас биш боловч дэлхий дээрх амьдралын нэг хэсгийн хувьд ирдэг ачаа дарамтыг бид бүгдээрээ үүрдэг. Зовлон зүдгүүрийн шалтгаануудаас үл хамааран Есүс бидний ачааг үүрэлцэж, тусламж дэмжлэг олж авахад тусалж болохын тулд биднээс Өөртөө ирэхийг гуйдаг (Мозая 24). Ахлагч Дэвид А. Бэднар "Ариун гэрээнүүдийг хийж, сахих нь биднийг

Их Эзэн Есүс Христтэй нэг болгон нэгтгэдэг билээ” (“Тэд ачаагаа амархан дааж чадахын тулд,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 106) хэмээн заасан. Үүнийг бодохын зэрэгцээ, эдгээр шүлэгт буй Аврагчийн үгсийг илүү сайн ойлгохын тулд дараах асуултуудтай адил асуултыг тунгаан бод. “Хийсэн гэрээнүүд маань намайг Аврагчтай хэрхэн нэгтгэдэг вэ?” “Христэд ирэхийн тулд би юу хийх хэрэгтэй вэ?” эсвэл “Аврагчийн буулга хэрхэн амархан болж, ачаа хөнгөрдөг вэ?”

Үүнийг уншихад өөр ямар ямар асуулт санаанд тань орж байна вэ? Тэдгээрийг бичиж аваад, энэ долоо хоногт судар болон бошиглогчдын үгсээс хариултуудыг нь хай. Зарим асуултынхаа хариултыг ахлагч Дэвид А.Бэднарын дээр дурдсан захиасаас олж болно.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 10:40

Хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы захиасуудыг авч үзвэл, бид гэр бүлээрээ өнөө үеийн төлөөлөгчдийн зөвлөгөөг хүлээн авч, дагахдаа хэр сайн байгаа вэ? Тэдний зөвлөгөөг дагах дуулгавартай байдал маань биднийг Есүс Христэд хэрхэн ойртуулсан бэ?

МАТАЙ 11:28-30

Та эдгээр шүлэгт буй Аврагчийн сургаалыг оюундаа төсөөлөхөд нь гэр бүлийнхэндээ туслахын

ЛУК 7:36-50

Нүглүүд маань уучлагдахад Аврагчийг хайрлах хайр минь гүнзгийрдэг.

Эдгээр шүлэгт буй Аврагчийн Симон нэртэй фарисай хүний гэрт зочилсон тухай түүхээс та өөрийгөө олж харж байна уу? Та Симонтой адил уу? Есүс Христийг хайрладгаа мөн даруу байдлаа харуулсан эмэгтэйн үлгэр жишээг дагахын тулд та юу хийж болох вэ? Та тэр эмэгтэйд үзүүлсэн Аврагчийн өрөвч сэтгэл, энэрэл нигүүлслийг хэзээ мэдэрч байсан бэ? Та уучлал өршөөл нь Аврагчийг хайрлах бидний хайрыг хэрхэн хүчирхэгжүүлдэг талаар эдгээр шүлгээс юу олж мэдсэн бэ?

тулд ямар нэгэн хүнд зүйлийг тэднээр эхлээд ганц ганцаар нь, дараа нь нэг нэгнийх нь тусламжтай өргүүлж үзэж болно. Бидний үүрдэг зарим ачаа юу вэ? Христийн буулгыг өөр дээрээ авах гэдэг нь ямар утгатай вэ? Энэхүү тоймтой холбоотой зураг харуулах нь буулга гэж юу болохыг тайлбарлахад тус болно.

МАТАЙ 12:10-13; МАРК 2:23-28

Бид Хүндэтгэлийн өдөр “сайныг үйлдэхийн” тулд юу хийж болох вэ? (Матай 12:12). Аврагч биднийг ямар арга замаар Хүндэтгэлийн өдөр эдгээж болох вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Сүнснийг сонс. Суралцаж байхдаа уншиж буй зүйлтэй тань хамааралгүй байсан ч бодол, мэдрэмжүүддээ анхаарлаа төвлөрүүл (С ба Г 8:2-3). Эдгээр нөлөө нь Бурханы таныг мэдэж, үйлдээсэй хэмээн хүссэн зүйл ч байж магадгүй.



Аврагч "Буулгыг минь өөр дээрээ ав" (Матай 11:29) хэмээсэн.



3-Р САРЫН 18-24

Матай 13; Лук 8; 13

“СОНСОХ ЧИХТЭЙ НЬ СОНСОГУН”

Та Матай 13, Лук 8, 13-ыг уншихдаа эдгээр зүйрлэл дэх Аврагчийн сургаалыг “сонсож” мөн талархахад өөрийгөө хэрхэн бэлдэх тухай бодоорой. Та эдгээр сургаалыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Аврагчийн хамгийн мартагдашгүй сургаалуудын зарим нь сургаалт зүйрлэлүүд гэж нэрлэдэг энгийн түүх хэлбэрээр байдаг. Эдгээр нь энгийн эд зүйл эсвэл үйл явдал, сонирхолтой явган яриа зэргээс хамаагүй илүү бөгөөд сүнслэгээр бэлтгэсэн хүмүүст зориулсан Бурханы хаант улсын талаарх гүн гүнзгий үнэнүүдийг агуулсан. Шинэ Гэрээнд бичигдсэн сургаалт зүйрлэлүүдийн хамгийн эхний сургаалт зүйрлэлийн нэг болох тариачны тухай зүйрлэл (Матай 13:3–23-ыг үзнэ үү) нь биднийг Бурханы үгийг хүлээн авахад бэлэн эсэхээ

шалгахад урьдаг. Есүс “Учир нь хэн хүлээж авна,” “түүнд ихээр өгөгдөж, элбэг дэлбэг байх болно” (Иосеф Смитийн Орчуулга, Матай 13:10) хэмээн тунхагласан. Тиймээс бид Аврагчийн сургаалт зүйрлэлийг эсвэл Түүний ямар ч сургаалыг судлахад бэлтгэх үедээ зүрх сэтгэлээ чагнаж, Бурханы үгэнд биднийг болон гэр бүлийг маань адисалж, элбэг дэлбэг байлгах ургац ургуулж, соёолуулж, цэцэглүүлэн, үр жимс өгүүлэх “сайн хөрс” өгч байгаа эсэхээ тодорхойлохоос эхлэх нь зөв эхлэл юм (Матай 13:8).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 13

Матай 13-т Христийн дурдсан “тэнгэрийн хаант улс” гэж юу вэ?

Энэ бүлэгт гарсан “тэнгэрийн хаант улс” нь Христийн үнэн сүм буюу дэлхий дээрх тэнгэрийн хаант улс юм. Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын удирдамжийн “Бурханы хаант улс буюу тэнгэрийн хаант улс-аас үзнэ үү.

МАТАЙ 13:3-23; ЛУК 8:4-15

Бурханы үгийг хүлээн авахын тулд би зүрх сэтгэлээ бэлдэх ёстой.

Яагаад зарим хүний зүрх сэтгэл үнэнийг хүлээж авахдаа амархан байдаг бол бусад нь эсэргүүцдэг вэ? Тариачны тухай сургаалт зүйрлэлийг унших нь танд Их Эзэний үнэнийг хэрхэн хүлээн авдаг тухайга бодож үзэх сайхан боломж олгоно. Матай 13-ын 3-8-р шүлгийг 18-23-р шүлэг дэх тайлбартай харьцуулах нь тустай байж болох юм. Та өөртөө “сайн хөрс” боловсруулахын тулд юу хийж болох вэ? Бурханы үгийг үнэн сэтгэлээсээ сонсож, дагахад ямар “хогийн ургамал” танд саад болох вэ?

Түүнчлэн Лук 13:34; Мозая 2:9; 3:19; Алма 12:10-11; 32:28-43 болон Даллин Х.Өүксийн “Тариачны сургаалт зүйрлэл” хэлсэн үгийг 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулганы х. 16-19-өөс үзнэ үү.

МАТАЙ 13:24-35, 44-52

Есүсийн сургаалт зүйрлэл надад Түүний Сүмийн өсөлт хөгжил, хувь заяаг ойлгоход тусалдаг.


Бошиглогч Иосеф Смит Матай 13-р бүлэг дэх сургаалт зүйрлэлүүд нь хожмын өдрүүд дэх Сүмийн өсөлт хөгжил, хувь заяаг тайлбарладаг хэмээн заасан (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 151). Та дараах сургаалт зүйрлэлийг уншихдаа энэ нь танд Их Эзэний Сүмийн талаар юу зааж байгааг бичиж тэмдэглээрэй (эдгээр сургаалт зүйрлэлийн талаар бошиглогч Иосефын заасан зүйлийг нэмж бичиж болно).

- Буудай ба зэрлэг өвс (13:24-30, 36-43): *Ёс бусчууд болон зөв шударга хүмүүс дэлхийн төгсгөл хүртэл хамтдаа өсөж хөгжих болно.*

- Гичийн үр (13:31-32):
- Исгэх хөрөнгө (13:33):
- Нуусан эрдэнэ ба их үнэтэй сувд (13:44-46):
- Загасны тор (13:47-50):
- Өрхийн тэргүүлэгч (13:52):

Та эдгээр сургаалт зүйрлэлийн талаар тунгаан бодсоныхоо дараа Христийн хожмын үеийн Сүмийн ажилд илүү бүрэн дүүрэн оролцохын тулд юу хийхээр өдөөгдөж байна вэ? Эдгээр сургаалт зүйрлэлийг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслах ямар ямар асуулт санаанд тань орж ирж байна вэ? Жишээлбэл, “Би Сүмийн төлөө ямар золиослол хийхэд бэлэн байна вэ?”

Түүнчлэн Судруудын удирдамжаас “Сургаалт зүйрлэл”-ийг үзнэ үү.



Есүс Христийн сайн мэдээ бол “их үнэтэй сувд” (Матай 13:46) юм.

МАТАЙ 13:24-30, 36-43

Зөв шударга хүмүүс дэлхийн төгсгөл хүртэл ёс бусчуудын дунд өсөж хөгжих ёстой.

Энэхүү сургаалт зүйрлэлийг нарийвчлан авч үзэх нэг арга бол үүнийг зураад, Матай 13:36-43, Сургаал ба Гэрээ 86:1-7 дээрх тайлбарын дагуу нэрлэх явдал юм. Зэрлэг өвс бол “түрүү нь гарах хүртлээ буудайтай адилхан харагддаг хорт ургамал” (Bible Dictionary, “Зэрлэг өвс”) билээ. Энэ сургаалт зүйрлэл дэх ямар үнэн таныг дэлхий дээрх ёс бусыг үл харгалзан итгэлтэй хэвээр үлдэхэд сүнслэгээр өдөөж байна вэ?

ЛУК 8:1–3**Ямар арга замаар “зарим эмэгтэйчүүд” Аврагчид үйлчилсэн бэ?**

“Эмэгтэй шавь нар сүнслэг байдлаар Есүсээс суралцаж, материаллаг зүйлсээр Түүнд үйлчлэн Есүсийг болон арван хоёрыг даган аялдаг байсан. . . . Эдгээр эмэгтэй Есүсийн тохинуулал буюу сайн мэдээний

баярт мэдээ, Түүний эдгээлтийн хүчний адислалыг хүлээн авахын зэрэгцээ эд материал, хайр халамжаа үзүүлэн Түүнд үйлчилж байсан” (*Daughters in My Kingdom* [2011], 4). Аврагчийг дагасан эмэгтэйчүүд тэрчлэн Түүний талаар хүчирхэг гэрчлэл хуваалцаж байсан (Линда К.Бертон, “Итгэлтэй эмэгтэйчүүд,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 130–133).

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ Аврагчийн сургаалыг судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 13

Гэр бүлийнхэн тань Аврагчийн сургаалт зүйрлэлүүдийг уншиж байхдаа дотно эд зүйл, нөхцөл байдлаа ашиглан тэнгэрийн хаант улсын (Сүмийн) тухай адилхан үнэнүүдийг заадаг өөрсдийн гэсэн сургаалт зүйрлэлийг бодон баясаж болох юм.

МАТАЙ 13:3–23; ЛУК 8:4–15

Бид зүрх сэтгэлдээ болон гэр орондоо “сайн хөрс” боловсруулахын тулд гэр бүлээрээ юу хийж болох вэ? (Матай 13:23). Танай гэр бүл бага насны хүүхэдтэй бол Бурханы үгийг сонсоход зүрх сэтгэлээ бэлдэх өөр өөр арга замыг гэр бүлийн зарим гишүүн жүжигчлэн үзүүлж, бусад нь тэдний юу хийж байгааг таавал хөгжилтэй байж болох юм.

МАТАЙ 13:13–16

Та гэр бүлийнхэндээ Христийн үгийг дуртайяа хүлээн авахын ач холбогдлыг ойлгоход хэрхэн тусалж чадах вэ? Жишээлбэл, та гэр бүлийнхээ нэг гишүүний чихийг таглаад, Матай 13:13–16-г намуухан уншиж болно. Тэр эдгээр шүлгээс юу ойлгосон бэ? Бурханы үгийг хүлээн авахад бидний нүд, чих, зүрх сэтгэл ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Бид ямар ямар арга замаар Бурханы үгсэд нүд, чих, зүрх сэтгэлээ таглаж байгаа мэт ханддаг вэ?

МАТАЙ 13:44–46

Энэ сургаалт зүйрлэлд гарч байгаа хоёр хүн юугаараа адилхан бэ? Бид хувь хүний хувьд төдийгүй гэр бүлийн хувьд Бурханы хаант улсыг амьдралдаа нэгдүгээрт тавихын тулд өөр ямар ямар зүйлийг нэмж хийх хэрэгтэй вэ?

ЛУК 13:11–17

Бид хэрхэн Аврагчийн жишээг даган, боолчлолд байгаа хүмүүсийг чөлөөлж болох вэ?

Заах чадвараа сайжруулах

Судар цээжил. Гэр бүлийн тань хувьд утга учир бүхий судрын хэсгийг сонгоод, цээжлэхэд гэр бүлийнхнээ урь. Ахлагч Ричард Г.Скотт “Цээжилсэн судар нь цаг хугацаа өнгөрсөн ч холдож хөндийрөхгүй үнэнч анд болдог” (“Судрын хүч,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, 6) хэмээн заасан.



Жорж Сөүлэр, Тариачны сургаалт зүйрлэл



Хорхе Кокко, Тэднийг хөвчлө

3-Р САРЫН 25-31

Матай 14–15; Марк 6–7; Иохан 5–6

“Бүү ай”

Та Матай 14–15; Марк 6–7 болон Иохан 5–6-г уншихдаа өөрийнхөө хувьд ач холбогдолтой үнэнүүдийг хай. Та өөртөө дараах асуултуудтай адил асуулт тавьж болох юм. “Эдгээр бүлэг дэх түүхүүд надтай хэрхэн холбогдож байна вэ?” “Би амьдралдаа тохирсон ямар захиасыг олж болох вэ?” эсвэл “Би гэр бүлтэйгээ юм уу бусадтай юу хуваалцах вэ?”

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Хүчтэй шуурга шуурч байх үед Галил нууран дундах аюулгүй завиа орхин явахад Петрт юу нөлөөлсөн бэ? Есүс усан дээгүүр алхаж чадаж байхад түүнийг ч бас чадна хэмээн итгэхэд юу хүргэсэн бэ? Бид тодорхой мэдэж чадахгүй ч, Бурханы Хүү зөвхөн хүмүүсийн төлөө гайхалтай зүйлсийг хийхээр ирээгүй, харин Өөртэй нь адил хүмүүст гайхалтай зүйл хийх хүч олгохоор ирсэн гэдгийг Петр ойлгож байсан байх. Эцсийн эцэст Есүсийн урилга “Ирээд, Намайг дага” (Лук 18:22) гэсэн урилга байсан билээ. Петр энэ урилгыг нэг удаа хүлээж авсан бөгөөд айдастайгаа нүүр тулан, боломжгүй мэт санагдах

зүйлийг хийх байсан ч дуртайяа хоёр дахь удаагаа хүлээн авсан. Их Эзэн шуурган дунд завинаасаа буухыг эсвэл олон мянган хүн өлсөж байхад тэдэнд яагаад ч хүрэлцэхээргүй талхаар тэднийг хооллохыг биднээс хүсэхгүй байх. Харин Тэрээр өгсөн зааврыг нь бүрэн ойлгохгүй байсан ч хүлээн авахыг биднээс хүсэж болно. Бидэнд хандсан Түүний урилга юу ч байж болох бөгөөд заримдаа гэнэтийн эсвэл айдас хүрмээр байж болно. Харин бид Петртэй адил айдас, эргэлзээ, хязгаарлагдмал ойлголтоо хойш тавин, Түүнийг итгэлтэйгээр дагах юм бол гайхамшгууд тохиох болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИОХАН 5:17-47

Есүс Христ Эцэгээ хүндэлдэг.

Тэнгэрлэг Эцэг болон Түүний хүүхэд бүрийн хоорондын харилцаа ариун нандин байх ёстой. Эдгээр шүлэгт Есүс Христ бидэнд Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах харилцаандаа дагах сүнслэг нөлөө бүхий жишээ өгсөн. Иохан 5:17-47-г уншаад, Эцэг гэсэн үгийн жишээ тус бүрийг тэмдэглэж эсвэл бичиж ав. Хүү Эцэгээ хэрхэн хүндэлдэг вэ? Та Түүний жишээг хэрхэн дагах вэ? Эцэг Хүүгийнхээ талаар ямар мэдрэмжтэй байдаг тухай та юу мэдэж авч болох вэ? Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаагаа хүчирхэгжүүлэх нь Түүний хүслийг эрэлхийлж, дуулгавартай дагах хүслийг тань хэрхэн нэмэгдүүлж болох вэ?

Мөн Иохан 17-г үзнэ үү.

МАТАЙ 14:16-21; МАРК 6:33-44; ИОХАН 6:5-14

Түүний зорилгыг биелүүлэх даруухан өргөлийг минь Аврагч нэмэгдүүлж чадна.

Та гэр орны болон харилцааны мөн нийгмийн гэх мэт өөрийнхөө эргэн тойрны хэрэгцээ шаардлагыг хангахад хангалтгүй мэт мэдэрч байсан уу? Есүсийн шавь нар тавхан талх, хоёрхон загасаар таван мянга гаруй өлссөн хүнийг (Матай 14:21-ийг үзнэ үү) хооллохыг тэднээс хүсэхэд хангалтгүй гэж мэдэрсэн байх. Дараа нь тохиолдсон гайхамшгийн тухай уншихдаа таны эргэн тойрны хүмүүсийг адислах үйлчлэлийн даруухан өргөлийг тань Бурхан хэрхэн ашиглаж болох талаар бод. Таныг Сүмд үйлчилж байхад хичээл зүтгэлийг тань Тэр хэрхэн нэмэгдүүлж болох вэ? Ерөнхийлөгч Жэймс Э.Фаустын хэлсэн үгийн мэдэгдлийн талаар эргэцүүлэн бодоорой. "Тавхан талх, хоёрхон жижиг загастай дүйцэхүйц бэлэг бүхий нэр нь үл мэдэгдэх олон хүн дуудлагуудаа эрхэмлэн биелүүлж, чухамдаа мянга мянган хүнийг хооллон, анхаарагдахгүй, сайшаал магтаал хүртэлгүйгээр үйлчилж байна" ("Five Loaves and Two Fishes," *Ensign*, 1994 оны 5-р сар, 5).

МАТАЙ 14:22-33; МАРК 6:45-52; ИОХАН 6:15-21

Есүс Христ намайг айдас, эргэлзээгээ хойш тавин, Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэхэд урьдаг.

Матай 14:22-33; Марк 6:45-52 болон Иохан 6:15-21 дээр тайлбарласан үзэгдлийн нарийн тодорхой байдлыг оюундаа дүрслэн бод. Петр болон бусад шавь юу мэдэрч байсныг төсөөлөн бод. Та эдгээр шүлгэн дээрх Аврагчийн үгс, үйлдлээс шавь байх тухай юу сурч болох вэ? Та Петрийн үг, үйлдлээс юу сурч болох вэ? (Мөн 1 Нифай 3:7-г үзнэ үү). Их Эзэн таныг завинаас буухтай адил ямар зүйлийг хийхэд урьж байна вэ? Эдгээр шүлгээс Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхэд урамшуулсан юуг олж болох вэ?

ИОХАН 6:22-71

Есүс Христийн шавийн хувьд би хийхэд хэцүү байсан ч үнэнд итгэн, хүлээн авах хүсэлтэй байх ёстой.

Есүс эзгүй талд цугласан олонд талх өгч, гайхамшигтайгаар хооллосны маргааш хурсан олон Түүнийг олоод дахин хоол эрэлхийлэв. Гэвч Түүнийг тэдэнд сүнслэг тэжээл болох "амийн талх" (Иохан 6:48) санал болгоход тэдний урам хугарч, бүр гомджээ. Олонх нь үүнийг "хэцүү үг" (Иохан 6:60) гэгцээсэн.

Аврагчийн эсвэл Түүний үйлчлэгчдийн нэгний заасан зүйлийг "хэцүү" эсвэл хүлээж авахад бэрх сургаал байна гэж бодож байсан туршлага танд бий юу? Энэ түүхийг буюу ялангуяа 68-69-р шүлэгт буй Петрийн үгсийг уншихдаа тийм туршлагынхаа талаар бодоорой. Аврагчийг дагах амлалтаа үргэлжлүүлэн биелүүлэхэд тань тусалсан ямар ямар "мөнх амийн үгс" (Иохан 6:68) байгаа вэ?

Мөн М.Рассэлл Баллардын "Бид хэн рүү явах юм бэ?" хэлсэн үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 81-84-өөс үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 14:16-21

Та таван мянган хүнийг хооллосон тухай уншихдаа талх болон загас идэж болно. Тэгээд таван мянган хүнийг хооллоход хэр их хэрэг болохыг төсөөлөн бод. Танай гэр бүл сүнслэг байдлын хувьд Христээр хэрхэн адислагдсан бэ? Тэр бусдыг хооллоход таныг хэрхэн ашигласан бэ?



Есүс таван талх, хоёр загасаар 5000 хүнийг гайхамшигтайгаар хооллов.

МАТАЙ 14:22-33

Танай гэр бүл эдгээр шүлэгт гардаг түүхийг дүрслэн харуулахдаа баяр баяслыг мэдрэх байх. Яагаад шавь нар нь айсан бэ? Яагаад Петр завинаас буун, айдсаа ялан дийлэх боломжтой байсан бэ? Тэрээр живж эхлэхдээ ч итгэлээ хэрхэн харуулсан бэ? Бид заримдаа Петртэй хэр адил байдаг вэ?

ИОХАН 5:1-16

Эдгээр шүлгэн дээрх “эрүүл болох” гэсэн хэллэгийн жишээнүүдийг олж анзаарахыг гэр бүлийнхнээсээ хүс. Есүс Христ ямар арга замаар хүмүүсийг эрүүл болгож чадах вэ? Тэр хэзээ, хэрхэн биднийг эрүүл болгосон бэ?

ИОХАН 6:28-58

Гэр бүлийнхээ гишүүн бүрд идэх зүсэм талх өгөөд, талх болон бусад эрүүл хүнснээс авдаг шим тэжээлийн талаар ярилц. Тэгээд эдгээр шүлгээс Есүс Христ яагаад Өөрийгөө “амийн талх” (Иохан 6:35) гэснийг эрж ол.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Сүнслэг ойлголт олж авахаар эрэлхийл. Хувиараа болон гэр бүлээрээ судлахдаа эдгээр тоймд өгөгдсөн судрын хэсгүүдээр өөрсдийгөө бүү хязгаарла. Энд ороогүй бүлгүүдэд танд зориулсан Их Эзэний захиас байж болно. Тэдгээрийг залбирч эрэлхийл.



Лиз Лэмон Свиндл, Салхийг сөрөн



Карл Хэйррих Блок, Хувиралт

4-Р САРЫН 1-14

Матай 16–17; Марк 9; Лук 9

“Та бол Христ”

Дараагийн хоёр долоо хоногийн турш Матай 16:15–17-д гардаг Петрийн гэрчлэлийг мөн Ерөнхий чуулганы үеэр сонсох бошиглогч, төлөөлөгчдийн гэрчлэлийн тухай тунгаан бод.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Фарисайчууд болон садукайчууд Есүсийг “тэнгэрээс тэмдэг үзүүлэхийг” шаардсан нь сонин биш гэж үү? Түүний олонд танигдсан гайхамшгууд хангалттай биш гэж үү? Түүний хүчирхэг сургаалууд эсвэл эртний бошиглолуудыг гүйцэлдүүлсэн олон арга зам юу болж таарах вэ? Тэдний шаардлага тэмдэг дутагдсанаас болоогүй, харин “тэмдгүүдийг ялгаж эс чадах,” тэдгээрийг хүлээн зөвшөөрөх хүсэлгүй байснаас нь үүдэлтэй. (Матай 16:1–4-ийг үзнэ үү.)

Петр фарисайчууд, садукайчуудтай адил Аврагчийн гайхамшгуудыг нүдээр үзэж, сургаалыг нь сонссон.

Гэвч ‘Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн’ хэмээх Петрийн лавтай гэрчлэл түүний “мах цус” буюу бие махбодын мэдрэмжээр дамжин ирээгүй. Харин түүний гэрчлэл “тэнгэр дэх бидний Эцэгээр” дамжин илчлэгдсэн юм.” *Илчлэлт* нь тухайн үед Аврагчийн дээр нь Сүмээ барьсан чулуу бөгөөд өнөө үед үйлчлэгчдэдээ тэнгэрээс өгөх илчлэлт юм. Энэ нь Есүс бол Христ бөгөөд Түүний үйлчлэгчид “хаанчлалын түлхүүрийг” атгадаг хэмээх илчлэлт буюу шавь байх сууриа тавих чулуу юм. Бид энэхүү суурин дээр босгогдсон цагт “үхэгсдийн орны хаалга [биднийг] дийлэхгүй” (Матай 16:15–19.)



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 16:13-17; ЛУК 9:18-21

Есүс Христийн тухай гэрчлэл илчлэлтээр дамжин ирдэг.

Хэрэв Есүс Христ өнөөдөр хүмүүсээс “Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна?” хэмээн асуувал хариултаар нь Түүний үед амьдарч байсан хүмүүсийн хариултаас өөр байх байсан. Өнөө үеийн хүмүүсийн Есүст хандах хандлага ямар байна гэж та анзаарсан бэ? Хэрэв Есүс танаас “Та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” гэж асуувал та юу гэж хариулах вэ? (Матай 16:13-15-ыг үзнэ үү.)

Аврагчийн тухай гэрчлэлээ мөн үүнийг хэрхэн хүлээн авсан талаар тунгаан бод. Гэрчлэлийг тань хүчирхэгжүүлж болох юуг та Матай 16:15-17-оос суралцах вэ? Хэрэв та гэрчлэл, хувийн илчлэлтийн талаар илүү ихийг суралцахыг хүсвэл дараах судруудыг судлаарай. Үүнд: Иохан 15:26; 1 Коринт 12:3; 2 Нифай 31:18; Алма 5:45-48 болон Сургаал ба Гэрээ 8:2-3.

МАТАЙ 17:1-9; МАРК 9:2-10; ЛУК 9:28-36

Хувиралтын уулан дээр юу болсон бэ?

Есүс Петр, Иаков, Иохан гуравтай хамт “өндөр ууланд” гаран, тэдний өмнө хувирч өөрчлөгдөв (эсвэл алдаршив). Мосе, Елиа нар үзэгдэн, төлөөлөгчдөд санваарын түлхүүрүүдийг олгов. Уг түлхүүрүүд нь Есүсийг амилсны дараа дэлхий дээр Христийн Сүмийг удирдах боломжийг тэдэнд өгсөн (Судруудын удирдамж, “Хувиралт”-ыг үзнэ үү). Эдгээр түлхүүр бидний үед ч бас сэргээгдсэн (С ба Г 110-ыг үзнэ үү).

МАТАЙ 16:13-19; 17:1-9

“Тэнгэрийн хаанчлалын түлхүүр” гэж юу вэ?

Аврагчийн Петрт өгөхөөр амласан “тэнгэрийн хаанчлалын түлхүүр” бол санваарын түлхүүр юм (Матай 16:19). “Санваарын түлхүүрүүд бол санваарын удирдагчдад Түүний санваарыг дэлхий дээр хэрэглэх, удирдах, хянах, засаглах Бурханаас олгосон эрх мэдэл юм. Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс санваарын эрх мэдлийг удирдан зохион байгуулдаг (С ба Г 65:2; 81:2; 124:123-ыг үзнэ үү).

Санваарын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс тухайн эрх мэдлийнхээ хүрээнд Сүмийг тэргүүлж, удирддаг” (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* [2010], 2.1.1).



“Тэнгэрийн хаанчлалын түлхүүр” бол санваарын түлхүүр юм.

Хувиралтын уулан дээр Петрт болон бусад төлөөлөгчид өгсөн санваарын түлхүүрүүд бидний үед дахин сэргээгдсэн (С ба Г 110:11-16-г үзнэ үү). Санваарын түлхүүрүүдийг Тэргүүн Зөвлөл, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга болон бусад ерөнхий эрх мэдэлтэн, ариун сүм, номлол, гадас, дүүргийн ерөнхийлөгч, бишоп, салбарын ерөнхийлөгч болон чуулгын ерөнхийлөгч атгадаг.

Түүнчлэн Нийл Л.Андэрсэны “Санваар дахь хүч” хэлсэн үгийг 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 106-110-аас мөн *Итгэлдээ үнэнч байх нь* номын х.166-171-ийг үзнэ үү).

МАТАЙ 17:14-21; ЛУК 9:14-29

Би илүү агуу итгэлийг олж авахаар эрэлхийлэх үедээ эхлээд өөрт байгаа итгэлдээ тулгуурлах ёстой.

Матай 17, Марк 9-д дурдсанаар тухайн эцэг Есүсийг хүүг нь эдгээж чадна гэдэгт эргэлзэх шалтгаантай байсан. Тэр Есүсийн шавь нараас хүүг нь эдгээхийг хүссэн боловч тэд чадаагүй. Харин Аврагч түүнээс итгэлээ бодит болгохыг хүсэхэд тэр эргэлзээндээ анхаарлаа хандуулаагүй. Тэр “Би итгэж байна” гэж хэлээд, итгэл нь төгс биш байгааг хүлээн зөвшөөрөн, “Итгэлгүй байгаад минь туслаач” хэмээн нэмж хэлсэн.

Эдгээр гайхамшгийн тухай уншиж байхад Сүнс танд юу заасан бэ? Итгэлээ нэмэгдүүлэхэд тань Тэнгэрлэг

Эцэг хэрхэн тусалсан бэ? Та өөрт байгаа итгэлээ өсгөн нэмэгдүүлэхийн тулд юу хийж болох вэ? Та итгэлийг тань хүчирхэгжүүлсэн судар, чуулганы захиас, туршлагаа жагсааж болно.

Жэффри Р.Холландын “Эзэн минь, би итгэж байна” хэлсэн үгийг 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулганы 108–111-р хуудаснаас үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 16:13-19; 17:1-9

Хүүхдүүддээ санваарын түлхүүрүүдийн тухай заахдаа ахлагч Гари Э.Стивэнсоны машиныхаа гадна түгжигдсэн тухай түүхийг ярьж өгч болно (Санваарын түлхүүр ба эрх мэдэл хаана байна вэ? 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 13–16). Та хүүхдүүдээрээ гэрийн болон машины эсвэл бусад зүйлийн цоожийг түлхүүр ашиглан онгойлгуулж болно. Сүмийн ерөнхийлөгчийн зураг үзүүлээд, түүнийг Петртэй адил санваарын бүхий л түлхүүрийг атгадаг гэдгийг гэрчилж болно.

МАТАЙ 17:20

Есүс Христэд итгэлтэй байдаг бошиглогчид уулыг нүүлгэж байсан (Иаков 4:6; Мосе 7:13-ыг үзнэ үү).


Бишоп Ричард С.Эжлигийн дараах гэрчлэл эдгээр шүлгийг гэр бүлтэйгээ холбоход тусална. Тэрээр: “Би хэзээ ч яг бодит уулыг нүүлгэхийг харан гэрчилж байгаагүй. Гэвч итгэлийн ачаар уул мэт их эргэлзээ, цөхрөл нь найдвар, өөдрөг үзлээр солигдохыг би харж байсан. Итгэлийнхээ ачаар би уул мэт их нүгэл наманчлал, өршөөлөөр солигдохыг биеэрээ үзсэн. Мөн би итгэлийнхээ ачаар уул мэт өвчин зовнил амар амгалан, найдвар, талархлаар солигдохыг биеэрээ гэрчилсэн билээ. Тийм ээ, би уул нүүлгэхдэхийг харсан” (“Итгэл—Сонголт нь та нарынх юм,” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 37–39). Бидний амьдралын ямар уулс нүүн шилжих хэрэгтэй вэ? Бид эдгээр уулыг нүүлгэхэд туслах Бурханы хүчинд итгэх итгэлээ хэрхэн үзүүлж чадах вэ?

ЛУК 9:61-62

Анжсан дээр гар тавьсан атлаа арагшаа харах гэдэг нь ямар утгатай вэ? Яагаад энэ хандлага биднийг Бурханы хаант улсад тэнцэхээргүй болгох вэ?

Заах чадвараа сайжруулах

Ойр ойрхон цугла. Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Есүс Христийн сургаалаас суралцахаар хүүхдүүдээ цуглуулах боломжийг хэзээ ч бүү алд. Дайсны хүч чармайлттай харьцуулбал ийм үе маш ховор байдаг” (“The Power of Teaching Doctrine,” *Ensign*, 1999 оны 5-р сар, 74) хэмээн заасан.



Волтер Рэйн, Багш аа, би хүүгээ Тан руу авчирсан



4-Р САРЫН 15-21

Христийн амилсны баяр

“Үхэл ээ, чиний хатгуур хаана байна вэ?”

Та энэхүү тойм дахь Аврагчийн Амилалтын тухай гэрчлэлүүдийг уншихдаа Ариун Сүнснээс ирэх мэдрэмж, сэтгэгдлийг тэмдэглэж аваарай.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Аврагчийн амьдралын сүүлийн долоо хоногийн туршид эргэн тойронд нь байсан олон иудей Дээгүүр өнгөрөх баярын уламжлалд оролцсон. Тэд хоол бэлдэж, дуу дуулан, Израилийн угсаа Египетийн боолчлолоос чөлөөлөгдсөнийг дурсан санах гэж цуглацгаасан. Гэр бүлүүд хурганы цусаар хаалган дээрээ тэмдэг тавьсан өвөг дээдсийнх нь гэр дээгүүр устгагч тэнгэр элчүүд өнгөрч байсан тухай түүхийг сонсож байв. Маш олон төрлийн тэмдгийг агуулдаг эдгээр тэмдэглэлт үйл явдлын

дунд харьцангуй цөөн хүн Бурханы Хурга Есүс Христ Өөрийн шаналал, үхэл, Амилалтаар дамжуулан тэднийг нүгэл, үхлийн боолчлолоос чөлөөлөх гэж байсныг мэдэж байсан. Хэдий тийм ч, Есүсийг өөрсдийн амлагдсан Мессиа, мөнхийн Чөлөөлөгч хэмээн таньж байсан хүмүүс байсан. Тэр өдрөөс эхлэн Есүс Христийн шавь нар бүх дэлхийд “Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, . . . гурав дахь өдөртөө амилуулагджээ” (1 Коринт 15:3-4) хэмээн гэрчилж байсан.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 21-28

Есүс Христ надад нүгэл, үхэл, сорилт бэрхшээл, сул дорой байдлыг даван гарахад туслах хүчтэй.

Энэ долоо хоногт Аврагчийн Цагаатгалын адислалд төвлөрөх нэг арга зам бол өдөр бүр Есүсийн амьдралын сүүлийн долоо хоногийн талаар уншихад цаг зарцуулах явдал юм (унших хуваарийг хавсаргав). Та эдгээр бүлгээс Аврагчийн хайрыг мэдрэхэд туслах юуг олж мэдэх вэ? Таныг нүгэл, үхлээс чөлөөлөх Түүний хүчийн талаар юу ойлгож авах вэ? Сорилт бэрхшээлийг тэвчин, сул дорой байдлыг даван гарах талаар юу мэдэж авах вэ? Та Түүний чөлөөлөх хүчинд итгэх итгэлээ хэрхэн хөгжүүлж байна вэ?

- Ням гараг: Ялгуусан байдалтай Иерусалимд орсон нь (Матай 21:6–11)
- Даваа гараг: Ариун сүмийг цэвэрлэсэн нь (Матай 21:12–16)
- Мягмар гараг: Иерусалимд заасан нь (Матай 21–23)
- Лхагва гараг: Үргэлжлүүлэн заасан нь (Матай 24–25)
- Пүрэв гараг: Дээгүүр өнгөрөх баяр ба Гетсемани цэцэрлэг дэх Христийн шаналал (Матай 26)
- Баасан гараг: Сорилт, цовдлолт, оршуулга (Матай 27:1–61)
- Бямба гараг: Сүнс нь сүнсний дэлхийд тохинуулж байхад (С ба Г 138) Христийн бие булшинд байсан нь (Матай 27:62–66)
- Ням гараг: Амилсан Христ үзэгдсэн нь (Матай 28:1–10)



Карл Хэйнрих Блок, Сүүлчийн зоог

МАТАЙ 28:1-10; ЛУК 24:13-35; ИОХАН 20:19-29; 1 КОРИНТ 15:1-8, 55

Олон гэрч Есүс Христийн Амилалтыг гэрчлэв.

Есүсийг доромжлуулж, ад үзэгдэж, цовдлуулж байхыг харах шавь нарт нь ямар байсныг төсөөл. Тэд Түүний сүр хүчийн гэрч байж, сургаалынх нь үнэнийг мэдрэн, Түүнийг Бурханы Хүү гэдэгт итгэх итгэлтэй байсан. Түүний үхлийн гэрч болох нь зарим хүний хувьд итгэлийн сорилт байсан байж болох ч удалгүй тэд Түүний Амилалтын агуу гайхамшгийн гэрч болсон билээ.

Та амилсан Аврагчийн гэрч болсон хүмүүсийн түүхээс юу сурч мэдэж болох вэ? Матай 28:1–10; Лук 24:13–35; Иохан 20:19–29; 1 Коринт 15:1–8, 55 дээрх хүн бүрийн туршлагыг тэмдэглэж, бичиж ав. (3 Нифай 11; Мормон 1:15; Ефер 12:38–39; Сургаал ба Гэрээ 76:19–24; 110:1–10; Иосеф Смит—Түүх 1:15–17-р шүлгүүдээс амилсан Христийн бусад гэрчийг олж болно.) Эдгээр түүхэн дэх юу нь таны Их Эзэний Амилалтад итгэх итгэлийг хүчирхэгжүүлж байна вэ? Аврагчийг амилсны дараа бусад хүн амилж, олон хүнд үзэгдсэн (Матай 27:52–53; 3 Нифай 23:9-ийг үзнэ үү). Үүнийг Ариун Библи, Мормоны Ном хоёрт хоёуланд цэдэглэсэн нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

1 ПЕТР 1:3-11

Есүс Христ надад итгэл найдвар, баяр баясал өгдөг.

Ахлагч Пол В.Жонсоны охин Алиса эдгэшгүй хорт хавдар тусаж, олон удаа хагалгаа хийлгэсэн бөгөөд 1 Петр 1:3–11-р шүлэгт Петрийн дүрсэлсэн “амьд найдвар”-ын үлгэр жишээ болсон. Ахлагч Жонсон Алисагийн нас барахаасаа өмнөхөн Христийн амилсны баярын үеэр бичсэн захидлыг хуваалцсан юм. “Христийн амилсны баяр нь надад өөртөө байлгахыг хүссэн бүхнийг сануулдаг. Нэгэн өдөр би эдгэрч, эрүүл саруул болно. Хэзээ нэгэн цагт миний бие доторх төмөр, хуванцар эд анги байхгүй болж, айж эмээх зүйлгүй, сэтгэлийн түгшүүргүй болно. Би . . . гайхалтай сайхан, мөнх бус байдлын дараах амьдралд чин сэтгэлээсээ итгэдэгтээ талархаж явдаг” (“Тэнд цаашид үхэл үгүй болно,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 111).

1 Петр 1:3–11 дэх ямар үг эсвэл хэллэг танд Есүс Христээс ирэх найдварыг өгч байна вэ? Та хэзээ тэр найдварыг мэдэрсэн бэ? Та Есүс Христээр дамжуулан авсан найдвараа хайртай хүмүүстэйгээ хэрхэн хуваалцаж болох вэ?

Мөн Алма 27:28; 36:1–24; 3 Нифай 9:11–17; Моронай 7:40–41-ийг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

Mormon.org

Mormon.org/easter-ийн “Holy Week” хэсэгт Аврагчийн амьдралын сүүлчийн долоо хоногийн өдөр бүр юу тохиолдсоныг тайлбарласан он цагийн хэлхээс байгаа. Долоо хоногийн өдөр бүр гэр бүлээрээ Аврагчийн тухайн өдөр юу хийснийг харахын тулд эдгээр тайлбарыг унших юм уу судраас Түүний сүүлчийн долоо хоногийн тухай уншиж болно (“Хувиараа судар судлахад зориулсан санаанууд” хэсэгт санал болгосон жагсаалтыг хар).

Сүмийн дуулал болон Хүүхдийн дуу

Энэ долоо хоногийн турш Аврагчийн Цагаатгал, Амилалтын тухай дуунууд болон сайн мэддэггүй дуунуудаа ч дуулж болно (Сүмийн дуулал болон Хүүхдийн дуу зэрэг номын гарчгаас “Тусгай сэдвүүд” хэсэг дэх дуунуудыг хар). Гэр бүлийнхэндээ дуунуудыг сурахад нь туслахын тулд үгсийг төлөөлөх зургуудыг харуулж болно.

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл”

Гэр бүлээрээ “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл” (LDS.org)-ийг уншиж, хүн бүрийг энэ гэрчлэлээс Христийн амилсны баяртай холбоотой захиас сонгож, бусадтай хуваалцахад урь. Жишээлбэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гэрийнхээ хаалга, цонхон дээр тавих зурагт хуудас хийж болно.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Биелүүлж болохуйц зорилго тавь. Судраас судлахад өдөрт ядаж хэдхэн минут зарцуулах нь таны амьдралыг адислах болно. Өдөр бүр суралцах амлалт өг, амлалтыг тань сануулах арга замыг хайж ол, үүнийгээ хамгийн сайнаараа дага.



Адам Абрам, Гетсемани



Ден Берр, Сайн самари хүн

4-Р САРЫН 22-28

Матай 18; Лук 10

Матай 18; Лук 10: “Мөнх амийг өвлөн авахын тул би яах ёстой вэ?”

Матай 18 ба Лук 10-ыг залбирч уншихдаа, Ариун Сүнснээс ирэх намуухан сүнслэг нөлөөнд анхаарлаа хандуул. Тэрээр эдгээр сургаал, түүх танд хэрхэн хамааралтай болохыг шивнэх болно. Хүлээж авсан мэдрэмжээ бичиж тэмдэглэ.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Та Их Эзэнээс асуугаад, бодож байгаагүй хариултаа хүлээн авч болох юм. Миний хөрш гэж хэн бэ? Таны тусламж, хайр хэрэгтэй байгаа хэн ч байж болно. Тэнгэрийн хаанчлалд хэн хамгийн агуу нь байх вэ? Хүүхэд, Гомдоосон хүнийг долоон удаа уучлах нь хангалттай юу? Үгүй, та дал дахин долоон удаа

уучлах хэрэгтэй. (Лук 10:29–37; Матай 18:4, 21–22.) Хэрэв та Их Эзэний хүслийг эрэлхийлж байгаа бол “[өөрийгөө] бүү зөвтгө” (Лук 10:29. Харин та үнэхээр Түүнээс суралцахыг хүсэж байвал Их Эзэн танд Түүнтэй хамт амьдрах мөнх амьдрал руу хөтлөх замаар хэрхэн амьдрахыг заах болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 18:21-35

Би Их Эзэний өршөөлийг хүртэхийг хүсэж байгаа бол бусдыг уучлах хэрэгтэй.

Бусдыг долоон удаа уучлах Петрийн зөвлөгөө маш өгөөмөр санагдаж байгаа ч Есүс үүнээс дээгүүрх хуулийг заасан. Түүний “Би чамд долоон удаа гэж хэлэхгүй. Харин дал дахин долоон удаа гэж хэлье” хэмээх хариулт нь тоо заагаагүй, харин Христийнхтэй адил өршөөнгүй зан чанарын тухай зааж байна. Та нигүүлсэх сэтгэлгүй боолын сургаалт зүйрлэлийг уншихдаа Бурханы нигүүлсэл, нинжин сэтгэлийг мэдэрч байсан тухайгаа тунгаан бодоорой. Таны нигүүлсэл, нинжин сэтгэлийг мэдрэх хэрэгтэй хүн байгаа юу?

Далын ахлагч Дэвид И.Сорэнсон “Нүглийг уучлах гэдэг нь муу зүйлтэй эвлэрэх гэсэн үг биш гэдгийг би тодорхой болгомоор байна. . . . Биднийг гэмтээсэн хөршөө бид уучлах ёстой ч дахин гэмтэхээс сэргийлэхийн тулд болгоомжтой хандах хэрэгтэй” (“Forgiveness Will Change Bitterness to Love,” *Ensign* эсвэл *Liahona*, 2003 оны 5-р сар, 12) гэжээ.

Түүнчлэн Судруудын удирдамж дахь “Өршөөх, уучлах”-ыг үзнэ үү.

ЛУК 10:1-20

Далын гишүүд гэж хэн бэ?

Есүс Христ Хуучин Гэрээнд зохион байгуулагдсан бүтцийг даган (Эхлэл 24:1; Тооллого 11:16-г үзнэ үү), Өөрийг нь гэрчилж, сайн мэдээг нь тунхаглаж, Өөрт нь болон ажилд нь туслах зорилгоор арван хоёр төлөөлөгчөөс гадна “өөр далан хүнийг томилжээ.” Энэхүү бүтэц зохион байгуулалт нь сэргээгдсэн Сүмд үргэлжлэн оршдог. Далын гишүүд бүх дэлхий дэх Есүс Христийн онцгой гэрчүүдийн хувиар арван хоёрт туслахаар дуудагдсан. Дал нь чуулгуудад зохион байгуулагддаг. Эхний хоёр чуулгын гишүүд нь Далын ерөнхий эрх мэдэлтнээр, харин бусад чуулгын гишүүд нь Бүсийн далаар онцгойлон адислагддаг. (С ба Г 107:25–26, 33–34, 97-г үзнэ үү.)

ЛУК 10:25-37

Би мөнх амьдралыг олж авахын тулд Бурханыг болон хөршөө өөрийн адил хайрлах ёстой.

Сайн самари хүний сургаалт зүйрлэл нь “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” хэмээх асуултад хариулсан Есүсийн арга зам байсныг санах нь тустай. Та энэ сургаалт зүйрлэлийг уншихдаа уг асуултыг дотроо бодоорой. Та ямар ямар хариулт олсон бэ?

Есүсийн үед иудейчүүд, самаричуудын хоорондын дайсагнал хэдэн зуун дамжин үргэлжилж байсан. Самаричууд бол Самари нутагт амьдарч, харь хүмүүстэй ураг барилцсан Иудейн удмынхан юм. Иудейчүүд самаричуудыг харийнхантай холбогдон завхарсан, урвасан гэж үздэг байжээ. Иудейчүүд Самари нутгаар дайран өнгөрөхгүйн тулд асар холуур тойрон явдаг байв. (Мөн Лук 9:52–54; 17:11–18; Иохан 4:9; 8:48-ыг үзнэ үү.)

Яагаад Аврагч хөршөө хайрлаж, нигүүлсэнгүй байхын жишээ болгон иудейчүүдийн үзэн яддаг самари хүнийг сонгосон гэж та бодож байна вэ? Энэ сургаалт зүйрлэл таныг бусдад илүү нигүүлсэнгүй хандахын тулд юу хийхэд өдөөж байна вэ?

Түүнчлэн Мозая 2:17 ба “Сайн самари хүний сургаалт зүйрлэл” (видео бичлэг, LDS.org)-ийг үзнэ үү.

ЛУК 10:38–42

Бид мөнх амьдрал руу хөтлөх сонголтуудыг хийснээр “сайныгаа” сонгодог.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Д.Паркин “Мариа, Марта хоёр бол та бид юм. . . . Энэ хоёр Их Эзэнд хайртай бөгөөд хайраа үзүүлэхийг хүсэж байсан. Энэ тохиолдолд Мариа Түүний үгийг сонссоноор хайраа илэрхийлж байхад Марта Түүнд үйлчилснээр хайраа үзүүлж байсан. Есүс Мартагийн зовнилыг үл ойшоогоогүй, харин ‘сайныгаа’ сонгон ав хэмээн анхаарлыг нь өөр зүйлд хандуулсан. Тэр нь юу вэ? . . . Хэрэгтэй байсан зүйл бол

мөнх амьдралыг сонгох явдал юм [2 Нифай 2:28-ыг үзнэ үү]. Бид өдөр бүр сонголт хийдэг” гэж заасан (“Choosing Charity: That Good Part,” *Ensign* эсвэл *Liahona*, 2003 оны 11-р сар, 104). Та Мартад хандан

хэлсэн Их Эзэний зөвлөгөөг өөрийн үгээр хэрхэн тоймлон ярих вэ? Цагийн хуваариа шалга. Илүү анхаарал хандуулах шаардлагатай “хэрэгтэй” зүйл байна уу?



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 18; ЛУК 10

Эдгээр бүлэгт заасан үнэнүүдийг харуулах ямар ямар дууг гэр бүлээрээ дуулж болох вэ? Эдгээр дууллын үгс Аврагчийн сургаалыг илүү сайн ойлгоход танай гэр бүлд хэрхэн туслах вэ?

МАТАЙ 18:1-11

Яагаад Есүс биднийг бяцхан хүүхэд шиг болоосой хэмээн хүсдэг вэ? Бидний амьдралдаа хэрэгжүүлбэл зохих, хүүхдүүдийн ямар зан чанар биднийг Христтэй илүү адил болгох вэ? (Мозая 3:19-ийг үзнэ үү).

ЛУК 10:25-37


Сайн самари хүний сургаалт зүйрлэл нь танай гэр бүлийн хувьд юуг илүү чухал болгох вэ? Тэд хувцас өмсөж, жүжигчлэн үзүүлэхийг хүсэх үү? Гэр бүлийнхэндээ сайн самари хүнтэй хэрхэн адил болж болохыг олж харахад туслаарай. Сургууль эсвэл сүм дээр бидний анзаараагүй, тусламж хэрэгтэй хүн байна уу? Бид тэр хүний төлөө юу хийж болох вэ?

ЛУК 10:40-42

Гэр бүлийнхээ хуваарьт сүнслэг зүйлсийг багтаах нь хэцүү байдаг уу? Мариа, Марта хоёрын түүх нь гэр бүлийн зөвлөлийн хурлаар эсвэл гэр бүлийн үдшээрээ эдгээрийг хэрхэн хийх өдөөлт болж болно. Гэр бүлээрээ “сайныгаа” (Лук 10:42) сонгох арга замуудын жагсаалт гаргаж болох юм.

Заах чадвараа сайжруулах

Хайрын уур амьсгалыг бий болго. Гэр бүлийн гишүүдийн бие биедээ хандах хандлага, мэдрэмж нь гэр орны сүнслэг уур амьсгалд гүнзгий нөлөөлж болдог. Туршлага, асуулт, гэрчлэлээ чөлөөтэй хуваалцах боломжтой хайраар дүүрэн, хүндэтгэлтэй орчинг үүсгэхийн тулд гэр бүлийнхээ бүх гишүүнд тус тусынхаа үүргийг гүйцэтгэхэд нь тусал (*Аврагчийн арга барилаар заах нь*, 15.)



Волтер Рэйч, Христ Мариа, Марта хоёрын гэрт



Лив Лэмон Свиндл, Нугалзгуй хүн нь

4-Р САРЫН 29-ӨӨС 5-Р САРЫН 5

Иохан 7–10

“Би бол сайн хоньчин мөн”

Та Иохан 7–10-р бүлгийг уншихдаа эдгээр бүлэг дэх сургаалын зарчмуудын тухай мэдрэмжийг Ариун Сүнснээс хүлээн авч болно. Мэдрэмжүүдээ бичих нь тэдгээрийг дагах төлөвлөгөө гаргахад тань тус болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Хэдийгээр Есүс Христ “хүмүүст амар тайван [хийгээд] сайн сайхныг” (Лук 2:14) авчрахаар ирсэн ч “Есүсээс болж олон түмний дотор хагарал гарчээ” (Иохан 7:43). Эдгээр үйл явдлыг хоёуланг нь харсан хүмүүс Есүсийн тухай маш өөр дүгнэлтүүдийг гаргасан. Зарим нь “Тэр сайн хүн” гэхэд бусад нь “Тэр ард олныг төөрөлдүүлж байна” (Иохан 7:12) гэцгээсэн. Түүнийг Хүндэтгэлийн өдөр сохор хүнийг эдгээхэд зарим хүн “Тэр Амралтын өдрийг сахидаггүй учир Бурханаас ирсэн хүн биш” гэсэн бөгөөд бусад нь “Нүгэлт хүн тийм тэмдгүүдийг

хэрхэн үйлдэж чадах билээ?” гэцгээж байв (Иохан 9:16). Гэсэн ч энэ бүх төөрөгдлийг үл харгалзан, үнэнийг эрэлхийлж байсан хүмүүс Түүний үгээс хүчийг олж харсан. Учир нь “Энэ хүний ярьж байгаа шиг ярьсан хүн ер үгүй билээ” (Иохан 7:46). Иудейчүүд Есүсээс Христ мөн эсэхээ “бидэнд шуудхан хэлээч” гэхэд Тэр “Миний хонин сүрэг дууг минь сонсдог. Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг юм” (Иохан 10:27) хэмээх үнэнийг худлаас ялган танихад тус болох зарчмыг илчилсэн.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИОХАН 7:14-17

Би Есүс Христийн заасан үнэнүүдийн дагуу амьдарснаар эдгээр нь үнэн болохыг мэдэж авна.

Есүсийг суралцаагүй атлаа ихийг мэдэж байгаад иудейчүүд гайхаж байв (15-р шүлгийг үзнэ үү). Тэр тэдний мэдэх аргаар суралцаагүй байлаа. Есүс тэдэнд хариулахдаа, үнэнийг мэдэх өөр арга байдаг бөгөөд энэ нь боловсрол, амьдралын нөхцөл байдлаас үл шалтгаалан хүн бүрд боломжтой гэдгийг заасан. Иохан 7:14-17-д дурдсанаар, Есүсийн заасан сургаал үнэн гэдгийг хэрхэн мэдэж болох вэ? Энэхүү үйл явц нь сайн мэдээний гэрчлэлээ хөгжүүлэхэд танд хэрхэн тусалсан бэ?

ИОХАН 8:2-11

Аврагчийн нигүүлсэл бүх хүнд боломжтой.

Завхайрч байгаад баригдсан эмэгтэйтэй харьцсан Аврагчийн харилцааны тухай ахлагч Дэйл Г. Рэнланд “Есүс садар самууныг зөвтгөөгүй нь лавтай. Гэхдээ Тэрээр уг эмэгтэйг ч бас буруутгаагүй. Тэрээр эмэгтэйд амьдралаа өөрчлөхийг зөвлөсөн. Уг эмэгтэй Түүний нинжин сэтгэл, нигүүлслийн ачаар өөрчлөгдөх хүсэлтэй болжээ. Иосеф Смитийн Библийн орчуулгад тэр эмэгтэйн ямархуу шавь байсан талаар ‘Мөн уг эмэгтэй тэр цагаас эхлэн Бурханыг алдаршуулан мөн түүний нэрэнд итгэв’ хэмээн өгүүлдэг” гэж хэлсэн [Иохан 8:11, зүүлт тайлбар 8] (“Бидний Сайн Хоньчин,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 16).

Аврагчид эмлүүлэхийн оронд нигүүлсэл хүлээж авсан эмэгтэйтэй адил мэдрэмжийг та хэзээ мэдэрч байсан бэ? Та хэзээ нүгэлгүй биш атлаа бусдыг шүүж, буруутгасан хуулийн багш нар, фарисайчуудын адил байсан бэ? (Иохан 8:7-г үзнэ үү). Хуулийн багш нартай болон фарисайчуудтай мөн завхайрч байгаад баригдсан эмэгтэйтэй харьцсан Аврагчийн харилцаанаас та юу сурч мэдэж болох вэ? Та эдгээр шүлгийг уншаад, Түүний өршөөлийн талаар юу сурч байна вэ?

ИОХАН 8:58-59

Иудейчүүд Есүсийг “Абрахамыг бий болохоос өмнө Би байдаг” хэмээн хэлэхэд яагаад уурласан бэ?

Иехова Мосед Өөрийгөө Эхлэл 3:14-т цэдэглэснээр “Би байдаг” хэмээн танилцуулдаг байсан. Есүс “Би байдаг” хэмээн хэлэхдээ Хуучин Гэрээний Бурхан, Иеховагийн хувиар Өөрийгөө танилцуулсан. Иудейчүүд үүнийг доромжлол хэмээн үзсэн бөгөөд Мосегийн хуулиар бол шийтгэл нь чулуугаар шидүүлж үхэх ял байв.

ИОХАН 9

Бурхан сорилт бэрхшээлээр маань дамжуулан Өөрийгөө бидний амьдралд үзүүлж болно.

Нүгэл ихэвчлэн сөрөг үр дагавар дагуулж байдаг учраас бид зарим азгүйтлээ буруу үйлдлийнхээ үр дүн гэж үзэж болно. Хэдийгээр Аврагчийн шавь нар төрөлхийн сохор эрийг эцэг эх нь нүгэл үйлдсэн учраас сохор төрсөн гэж таамагласан боловч Есүс тэднийг засаж залруулсан юм. Иохан 9:3 дээрх Аврагчийн үгс өөрийнхөө болон бусдын сорилт бэрхшээлийн талаарх таны үзэл бодлыг хэрхэн өөрчилж байна вэ? Та Иохан 9-ийг уншихдаа, хэрхэн “Бурханы ажлуудыг харуул[сан]”-ыг (Иохан 9:3) тунгаан бод. Таныг сорилт бэрхшээлтэй тулгарах үед тэдгээр нь хэрхэн харагдсан бэ?

Иохан 9:3-т гардаг дагалдагчдын асуулт Их урвалтын үед Христийн шашинтнуудын дунд алдагдсан боловч бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн сургаалд буюу мөнх бус амьдралын өмнөх оршихуйд тэдний итгэдэг байсныг илтгэж байгаа нь хачирхалтай (С ба Г 93:29; Мосе 4:1-4; Абрахам 3:22-26-г үзнэ үү).

ИОХАН 10:16

Иохан 10:16-д Аврагчийн дурдсан “өөр хонин сүрэг” гэдэг нь хэнийг хэлж байгаа вэ?

Аврагч амилсныхаа дараа Америкт зочлохдоо Түүний өөр хонин сүрэг хэн болохыг тайлбарласан (3 Нифай 15:21-16:5-ыг үзнэ үү).



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИОХАН 7:24

Та Иохан 7:24 дээрх Есүсийн сургаалыг ойлгоход нь гэр бүлийнхэндээ хэрхэн тусалж чадах вэ? Нэг арга бол гадаа гараад, гэр бүлийнхээ нэг гишүүнийг халтар бохир болгох явдал юм. Гаднах төрхийг нь харсан танихгүй хүн түүний талаар юу гэж бодох бол? Түүний гаднаас нь хараад дүгнэх боломжгүй сайн талуудыг жагсаан бич (мөн 1 Самуел 16:7-г үзнэ үү).

ИОХАН 8:31-36

Бид заримдаа хэрхэн нүглийн боол болдог вэ? Есүсийн заасан ямар ямар үнэн биднийг чөлөөлж чадах вэ?

ИОХАН 9

Та гэр бүлдээ Иохан 9-д гардаг сохор хүнийг эдгээсэн Есүсийн түүхийг төсөөлөн бодоход хэрхэн тусалж болох вэ? Хамтдаа уг түүхийг жүжигчлэн үзүүлэх юм уу “Jesus Heals a Man Born Blind” (LDS.org) видео бичлэгийг үзэж болно. Түүхийг үе үе зогсоо, тэгээд гэр бүлийн гишүүд Иохан 9-өөс тохирох шүлгүүдийг уншиж болно. Тэднийг уг түүхээс ямар сургамж авснаа бичиж авахад урь. Жишээ нь, Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдөх гэдэг нь ямар утгатай болохыг тэд ойлгосон байж болно.

ИОХАН 10:1-18, 27-29

Сайн Хоньчны тухай сургаалт зүйрлэлээс суралцахад гэр бүлийн гишүүдийг оролцуулахын тулд гэр бүлийн гишүүн бүрээс дараах зүйлсийн аль нэгийг зурахыг хүс. Үүнд: хулгайч, үүд, хоньчин, хөлсний хүн (хөлсний ажилчин), чоно, хонь. Тэднийг Иохан 10:1-18, 27-29-ийг уншихад уриад, дараа нь тэдний зурсан зүйлсийн талаар Аврагч юу гэж заасан тухай ярилц.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Сүнслэг нөлөө бүхий үг, хэллэгүүдийг ол. Таныг уншиж байх хооронд Сүнс зөвхөн танд зориулан бичсэн мэтээр эсвэл таныг урамшуулж, сүнслэгээр өдөөх тодорхой үг, хэллэгүүдийг таны санаанд оруулж болно. Иохан 7-10 дахь танд сүнслэгээр нөлөөлсөн үг, хэллэгүүдийг тэмдэглэж болно.



Грэг К.Олсен, Дахиж алдагдагүй



Лив Лэмон Свиндл, Урлагч хүү

5-Р САРЫН 6-12

Лук 12–17; Иохан 11

“Би алдагдсан хонио олсон тул надтай хамт баярлагтун”

Та Лук 12–17, Иохан 11-ийг уншихдаа Тэнгэрлэг Эцэг таныг юуг мэдэж авч, юу хийгээсэй хэмээн хүсэж байгааг залбирч эрэлхийл. Та эдгээр бүлгийг судалснаар зөвхөн танд зориулсан захиасуудад зүрх сэтгэл тань нээгдэх болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Ихэнх тохиолдолд 100-аас 99-ийг онцсайн гэж үздэг ч Бурханы хайртай хүүхдүүдийг энэ тоо төлөөлөхгүй (С ба Г 18:10-ыг үзнэ үү). Энэ тохиолдолд алдагдсан хонины сургаалт зүйрлэлд Аврагчийн зааснаар нэг ч гэсэн бодгаль “[бид] түүнийг олтол” (Лук 15:4) нэгд нэггүй, цөхрөнгөө бартал эрж, хайлгуулах эрхтэй. “Гэмших шаардлагагүй ерэн есөн зөвт хүнээс илүүгээр гэмшсэн нэг

нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох” (Лук 15:47) учраас баярлаж эхлэх нь зүйтэй. Хэрэв энэ нь шударга бус санагдаж байвал бодит байдал дээр “гэмших шаардлагагүй” нэг ч хүн байдаггүй гэдгийг санах нь тустай. Бид бүгдээрээ аврагдах хэрэгтэй. Мөн бид бүгдээрээ аврах ажилд тусалж, аврагдсан бодгаль бүрийн төлөө хамтдаа баясаж болно (С ба Г 18:15–16-г үзнэ үү).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ЛУК 12; 14-16

Би зүрх сэтгэлээ дэлхийн зүйлсээс илүүтэй, мөнхийн ач холбогдолтой зүйлсэд төвлөрүүлэх хэрэгтэй.

Том амбаар бариад, ажлынхаа үр жимсийг хураасан амжилттай хүнийг Бурхан яагаад “Мунхаг чи” хэмээн хэлсэн бэ? (Лук 12:16-21-ийг үзнэ үү). Лукийн номон дахь эдгээр бүлэгт Аврагч бидэнд дэлхийн зүйлсийг давж харан, мөнхийн зүйлс рүү хараагаа чиглүүлэхэд туслах хэд хэдэн сургаалт зүйрлэлийг заасан. Эдгээрээс заримыг жагсаав. Та захиас бүрийг хэрхэн нэгтгэн дүгнэх вэ? Их Эзэнийг танд юу хэлж байна гэж та бодож байна вэ?

Мунхаг баян хүн (Лук 12:13-21)

Их зоог (Лук 14:12-24)

Үрэлгэн хүү (Лук 15:11-32)

Шударга бус нярав (Лук 16:1-12)

Баян хүн, Лазар хоёр (Лук 16:19-31)

Мөн Матай 6:19-34; 2 Нифай 9:30; Сургаал ба Гэрээ 25:10-ыг үзнэ үү.

ЛУК 15

Алдагдсан хүмүүсийг олдоход Тэнгэрлэг Эцэг баярладаг.


Нүгэл үйлдсэн эсвэл “алдагдсан” хүмүүсийн талаар Тэнгэрлэг Эцэг ямар мэдрэмжтэй байдаг бол гэж та өмнө нь бодож байсан уу? Фарисайчууд болон хуулийн багш нар Есүсийг тиймэрхүү хүмүүстэй харилцахад хүртэл буруушааж байсан. Хариуд нь Есүс Лук 15-д гардаг алдагдсан хонь, алдагдсан зоос, үрэлгэн хүүгийн тухай гурван сургаалт зүйрлэлийг ярьсан.

Эдгээр сургаалт зүйрлэлийг уншихдаа тэдний хоорондын ижил төстэй болон ялгаатай талуудыг жагсаан бичиж болно. Жишээлбэл, та юу яагаад алдагдсан, хэрхэн олдсон мөн олдоход нь хүмүүс хэрхэн хүлээж авсныг олж бичиж болно. Есүст “алдагдсан” хүмүүс болон өөрсдийгөө алдагдсан гэж бодохгүй байгаа хүмүүст зориулсан ямар

захиас байсан бэ? Алдагдсан хүмүүсийг хайдаг хүмүүст хандсан ямар захиас Түүнд байсан бэ?

Мэдээж хэрэг алдагдахгүй байх нь ямагт сайн. Лук 15:7-ийн тухай ахлагч Жэймс Э.Талмэйж “Наманчлагч нүгэлтэн нь нүглийг эсэргүүцдэг зөвт хүнээс илүү чухал гэсэн санааг зөвтгөх ёсгүй” (*Jesus the Christ* [1916], 461) гэж бичсэн байдаг. Гэсэн хэдий ч, бид бүгдээрээ нүгэл үйлддэг бөгөөд аврагдах хэрэгтэй. Бурхан нэг ч бодгалийг үрэгдүүлэхийг хүсдэггүй учраас Аврагчийн сургаалт зүйрлэл дэх тайтгарлын нэг захиас нь хүн бүр наманчилж, зөвт байдал руу эргэн ирж чадах явдал юм.

Мөн Сургаал ба Гэрээ 18:10-16-г үзнэ үү.



Жэймс Тиссот, Алдагдсан мөнгөн зоос

ЛУК 16:1-12

Есүс шударга бус няравын сургаалт зүйрлэлээр юу заасан бэ?

Ахлагч Жэймс Э.Талмэйж уг сургаалт зүйрлэлээс сурч болох нэгэн сургамжийг “Хичээнгүй бай. Учир нь дэлхийн баялгаа ашиглаж болох өдрүүд удахгүй дуусна. Шударга бус явдал, хилэнцээс хүртэл сургамж ав. Хэрэв тэд өөрсдийн санаа зовж буй цорын ганц ирээдүйн төлөө хашир аргаар бэлтгэж байгаа гэвэл мөнхийн ирээдүйд итгэдэг та нар хэчнээн илүү их бэлтгэх хэрэгтэй билээ! Хэрэв та ухаалаг байдал, ‘шударга бус эд баялгийг’ ашиглахдаа хашир хянамгай байхад суралцаагүй бол илүү тэсвэртэй эд баялгийг та нарт хэрхэн хариуцуулах билээ?” гэж тайлбарласан (*Jesus the Christ*, 464).

ЛУК 17:11-19**Адислалууддаа талархах нь намайг Бурханд илүү ойртуулах болно.**

Хэрэв та уяман өвчтэй арван хүний нэг байсан бол өөрийгөө эргэж ирээд Аврагчид талархах байсан гэж бодож байна уу? Талархсан уяман өвчтэй хүн талархал өргөснөөрөө ямар ямар адислал хүлээж авсан бэ? Талархлаа илэрхийлэх нь таны сүнслэг байдалд хэрхэн нөлөөлдөг вэ? Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн “Ай, санагтун, санагтун” хэмээх захиастаа дүрсэлсний адил талархаж байгаа зүйлүүдээ тэмдэглэлдээ бичиж эхлэх нь үр дүнтэй байж болох юм.

**Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ЛУК 15:1-10

Ямар нэгэн зүйлээ алга болгох эсвэл өөрөө төөрөх нь ямар байдгийг гэр бүлийнхэн тань ойлгодог уу? Өөрсдийн туршлагаас хуваалцах нь алдагдсан хурга, алдагдсан зоосны сургаалт зүйрлэлийн талаарх яриаг эхлүүлж болох юм. Эсвэл нэг нь нуугдаад, бусад нь түүнийг олох тоглоом тоглож болно. Энэ үйл ажиллагаа нь эдгээр сургаалт зүйрлэлийг ойлгоход хэрхэн туслах вэ?

ЛУК 15:11-32

Бид хайртай хүнээ алдсан үедээ энэ түүхэнд гардаг эцэгтэй хэрхэн адил байж чадах вэ? Том хүүгийнх нь

ИОХАН 11:1-46**Есүс Христ бол Амилалт ба Амь мөн.**

Лазарыг үхлээс босгосон гайхамшиг нь Есүсийг үнэхээр Бурханы Хүү, амлагдсан Мессиа мөн гэдгийг харуулсан хүчирхэг, няцаашгүй гэрчлэл байсан. Иохан 11:1–46-д гардаг ямар үг, хэллэг эсвэл тодорхой мэдээлэл Есүс Христ бол “амилалт ба амь мөн” гэдэгт итгэх итгэлийг тань хүчирхэгжүүлдэг вэ? Энэ мэдлэг таны амьдралд болон сонголтод хэрхэн нөлөөлдөг вэ?

туршлагаас бид Христтэй илүү адил байхад бидэнд туслах юуг ойлгож авч болох вэ? Энэ сургаалт зүйрлэл дэх эцэг ямар байдлаар Тэнгэрлэг Эцэгтэй адилхан байна вэ?

ЛУК 17:11-19

Та уяман өвчтэй арван хүний түүхийг хэрэгжүүлэхэд нь гэр бүлийнхэндээ туслахын тулд тэднийг талархлын нууц зурвас бичээд, гэр дотроо энд тэнд байрлуулахыг хүс. Та нар хамтдаа *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу* номын 7-р хуудасны “Адислал бүрээ тоол” дууллыг дуулж, хүлээж авсан адислалуудынхаа талаар ярилц.

ИОХАН 11:1-46

Гэр бүлийн гишүүд Есүс Христийн тухай гэрчлэлээ хуваалцаж болно.

Заах чадвараа сайжруулах

Сайн мэдээний зарчмуудыг заахдаа түүх, жишээнүүдийг ашигла. Аврагч ихэвчлэн түүх, сургаалт зүйрлэл ашиглан сайн мэдээний зарчмуудыг заадаг байсан. Гэр бүлийн тань хувьд сайн мэдээний зарчмуудыг амилуулж болох өөрт тохиолдсон түүх, жишээнүүдийг бод (*Аврагчийн арга барилаар заах нь*, 22).



Лиз Лэмон Свиндл, Бусад ес нь хаана байна?



5-Р САРЫН 13-19

Матай 19–20; Марк 10; Лук 18

“Надад өөр юу дутагдаж байна вэ?”

Та Матай 19–20; Марк 10 болон Лук 18-ыг уншиж, тунгаан бодохдоо хүлээж авах сүнслэг өдөөлтүүдээ анхаарлаа хандуулаарай. Өдөөлтүүдээ тэмдэглэж аваад, тэдгээрийн дагуу хэрхэн үйлдэхээ тодорхойл.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Хэрэв танд Аврагчид асуулт тавих боломж байсан бол юу асуух байсан бэ? Нэгэн баян залуу эр Есүс дээр анх удаа ирээд, “Мөнх амийг олохын тул би ямар сайн юм хийх ёстой вэ?” (Матай 19:16) гэж асуужээ. Аврагч хариулахдаа түүний хийсэн сайн зүйлсэд талархаж байгаагаа мөн илүү ихийг хийхийг хайраар урамшуулан дэмжиж буйгаа харуулсан. Бид мөнх амьдралын боломжийн талаар тунгаан бодохдоо бидэнд хийх илүү их зүйл байгаа болов уу гэж үүний адил боддог байж болно. Бид “Надад

өөр юу дутагдаж байна вэ?” (Матай 19:20) гэж өөр өөрийн арга замаар асуух үед Их Эзэн бидэнд баян залуу эрд хариулсны адил хувийн шинжтэй хариулт өгч болно. Их Эзэн биднээс юу ч хийхийг хүссэн бай Түүний хариултын дагуу үйлдэх нь өөрийн зөвт байдлаас (Лук 18:9–14-ийг үзнэ үү) илүү Түүнд итгэх итгэл хийгээд “Бурханы хаанчлалыг хүүхэд адил хүлээн авахыг” (Лук 18:17 мөн 3 Нифай 9:22-ыг үзнэ үү) биднээс үргэлж шаардах болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 19:1–9; МАРК 10:1–12

Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэлт Бурханаар томилогдсон.

Аврагч болон фарисайчуудын хооронд өрнөсөн энэхүү харилцан яриа нь гэрлэлтийн талаар Аврагчийн тодорхой заасан зүйлс бичигдсэн цөөн хэдэн жишээний нэг юм. Матай 19:1–9, Марк 10:1–12-ыг уншаад, гэрлэлтийн талаарх Аврагчийн үзэл бодлыг өөрийнхөөрөө товчлон жагсааж бич. Эцэгийн авралын төлөвлөгөөний талаарх таны мэдлэг эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэлт Бурханаар томилогдсон шалтгааныг ойлгоход танд хэрхэн туслах вэ?



Мөнхийн гэрлэлт нь Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг юм.

МАТАЙ 19:3–9; МАРК 10:2–12

Есүс салалтыг хэзээ ч хүлээн зөвшөөрч боломгүй зүйл эсвэл салсан хүмүүс дахин гэрлэж болохгүй гэж заасан уу?

Ахлагч Даллин Х.Өүкс салалтын тухай хэлсэн үгэндээ Тэнгэрлэг Эцэг гэрлэлтийн харилцааг мөнхийн байхаар төлөвлөсөн гэж заасан. Гэсэн ч Бурхан “яагаад гэвэл [бидний] зүрх хатуу тул” хосын нэгнийх нь эсвэл хоёулангийнх нь аминч үзэл, буруу сонголтын улмаас зарим тохиолдолд салах шаардлагатай байдаг гэдгийг ойлгодог.

Ахлагч Өүксийн тайлбарласнаар, Их Эзэн “гэр бүлээсээ салсан хүмүүсийг селестиел хуулинд зааснаар ёс суртахуунгүй байдлын толбогүйгээр дахин гэрлэхийг зөвшөөрдөг. Гэр бүлээсээ салсан гишүүн ноцтой нүглүүд үйлдээгүй л бол бусад гишүүнд хамаарах тэрхүү зохистой байдлын жишгийн дагуу

ариун сүмийн эрхийн бичиг авах эрхтэй” (“Divorce,” *Ensign* эсвэл *Liahona*, 2007 оны 5-р сар, 70).

МАТАЙ 19:16–22; МАРК 10:17–22; ЛУК 18:18–23

Хэрэв би Их Эзэнээс асуувал Тэр надад мөнх амийг өвлөн авахын тулд юу хийх хэрэгтэйг зааж өгнө.

Баян залуу эрийн түүх итгэлтэй, бүх насаараа шавь байгаа хүмүүст ч санаа зовох шалтгаан болж болно. Та Марк 10:17–22-ыг уншиж байхдаа залуу эрийн итгэлтэй байдал, чин сэтгэлийг харуулсан ямар нотолгоог олж харсан бэ?

Баян залуу эрийн адил бид бүгдээрээ төгс бус, дутагдалтай учраас шавийн хувьд “Надад өөр юу дутагдаж байна вэ?” гэж амьдралынхаа турш асуух хэрэгтэй. Биднийг үнэн мөн чанараар маань болгоодог Нэгнээс хайраар өгсөн хариултыг анзаараарай (Марк 10:21-ийг үзнэ үү). Та Их Эзэнээс өөр юу дутагдаж байгаагаа асуухад бэлтгэхийн тулд мөн Түүний хариултыг хүлээн авахын тулд юу хийж чадах вэ?

Түүнчлэн Ларри Р.Лорэнсын “Надад юу дутагдаж байна вэ?” хэлсэн үгийг 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 17–19-өөс; С. Марк Палмэрын “Есүс түүнийг ширтэн харж, хайрлав” хэлсэн үгийг 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулганы х. 105–107-оос үзнэ үү.

МАТАЙ 20:1–16

Сайн мэдээг хэзээ хүлээн авснаасаа үл шалтгаалан хүн бүр мөнх амьдралын адислалыг хүлээн авч чадна.

Усан үзмийн талбайд ажиллагсдын аль нэгнийх нь туршлага тантай ямар нэгэн байдлаар холбогдож байна уу? Та энэ хэсгээс өөртөө тохирох ямар сургамж авч байна вэ? Ахлагч Жэффри Р.Холландын “Талбайд хөдөлмөрлөгсөд” (2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган, х. 32–34) хэлсэн үг энэхүү сургаалт зүйрлэлийг хэрэгжүүлэх шинэ арга замуудыг олж харахад танд тусалж болох юм. Ямар нэмэлт өдөөлтийг Сүнс танд өгч байна вэ?



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 19:1-9; МАРК 10:1-12

Гэрлэлт, гэр бүлийн тухай Бурханы сургаалыг ярилцах нь танай гэр бүлд үр нөлөөтэй юү? Тийм бол Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"-ийг уншиж болно (LDS.org). Уг тунхаг дээрх сургаал нь гэрлэлт, гэр бүлийн талаарх дэлхийн захиасын гажуудал, буруу ойлголтыг хэрхэн тодорхой болгодог вэ?

МАРК 10:23-27

Баялагтай байх, баялагт итгэх хоёр юугаараа ялгаатай вэ? (Марк 10:23-24-ийг үзнэ үү). Та 27-р шүлгийг уншихдаа Иосеф Смитийн Орчуулгыг дурдаж болно. "Баялгуудад итгэж найддаг хүний хувьд энэ нь боломжгүй; гэхдээ Бурханд итгэж найдан, Бурханы төлөө бүхнээ орхидог хүнд энэ нь боломжтой. Учир нь түүний хувьд эдгээр бүх зүйл боломжтой."

МАТАЙ 20:1-16

Матай 20:1-16 дахь зарчмуудыг үлгэрлэн үзүүлэхийн тулд богино зайд гүйх зэрэг энгийн уралдаан зохион байгуулж, түрүүлсэн хүнд шагнал амлаж болно. Хүн бүрийг уралдаанд оролцож дууссаны дараа бүх хүнд адилхан шагнал өг. Ингэхдээ хамгийн сүүлд орсон хүнээс эхэлж өгөөд, түрүүлсэн хүнд хамгийн сүүлд өгөөрэй. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд хэн мөнх амьдралын адислалыг хүртдэг тухай бидэнд юу зааж байна вэ?

МАТАЙ 20:25-27; МАРК 10:42-45

"Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог" гэсэн хэллэг ямар утгатай вэ? (Матай 20:27). Есүс Христ хэрхэн энэ зарчмын үлгэр жишээ болдог вэ? Бид гэр бүл, тойрог, салбар, эргэн тойрондоо Түүний жишээг хэрхэн дагаж чадах вэ?

ЛУК 18:1-14

Бид эдгээр шүлгэн дээрх хоёр сургаалт зүйрлэлээс залбирлын тухай юу сурч болох вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Өөрийнхөө хувьд боломжтой цагийг ол. Судраас судлахдаа ямар нэгэн саад болох зүйлгүй бол суралцахад хамгийн амар байдаг. Өөрийнхөө хувьд хамгийн тохиромжтой цагийг сонгож, өдөр бүр яг тэр цагтаа тогтмол суралцахын тулд хамаг сайнаараа хичээ.



Хайнрих Хофманн, Христ, залуу баян захирагч хоёр



Жэймс Тиссоп. Инжир модон дээрх Заххай

5-Р САРЫН 20-26

Матай 21–23; Марк 11; Лук 19–20; Иохан 12

“Харагтун, чиний Хаан ирж явна”

Энэхүү тойм дахь санаануудыг уншихаасаа өмнө Матай 21–23; Марк 11; Лук 19–20; Иохан 12-ыг унш. Гэр бүлийнхэндээ эсвэл Сүмийн ангидаа хуваалцаж болох сэтгэгдлээ бичиж тэмдэглэ.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Аврагч Бетанаас Иерусалим руу аялсны дараа өлссөн байсан бөгөөд зайдуухан байсан инжрийн мод жимстэй мэт харагджээ. Гэвч Есүс ойртон очоод, ямар ч жимсгүй болохыг олж харав (Матай 21:17–20; Марк 11:12–14, 20-ийг үзнэ үү). Нэг талаар инжрийн мод нь Иерусалим дахь шашны удирдагчидтай адил хоёр нүүртэн мэт байв. Тэдний заадаг хоосон сургаал, гаднаа ариун мэт харагдах байдал ямар ч сүнслэг тэжээл өгөөгүй. Фарисайчууд болон хуулийн багш нар олон зарлиг тушаалыг дагаж байгаа мэт харагдсан ч хамгийн агуу хоёр тушаал болох Бурханаа болон хөршөө өөрийн адил

хайрлахыг орхигдуулсан (Матай 22:34–40; 23:23-ыг үзнэ үү).

Хариуд нь олон хүн Есүсийн сургаалын сайн үр жимсийг анзаарч эхэлсэн. Түүнийг Иерусалимд ирэхэд тэд модноос мөчир огтлон замыг нь засаж, эцэст нь “хаан чинь очиж байна” (Зехариа 9:9) хэмээх эртний бошиглолд баясан угтаж авав. Энэ долоо хоногт уншихдаа өөрийн амьдрал дахь Аврагчийн сургаал, цагаатгах золиослолын үр жимсийг болон хэрхэн “олон үр жимс бий болгож” (Иохан 12:24) болох талаараа бодоорой.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 23; ЛУК 19:1–10; 20:45–47

Их Эзэн гаднаас харагдах байдлаар шүүдэггүй, харин зүрх сэтгэлийн хүслээр шүүдэг.

Есүсийн үед олон хүн татвар хураагчдыг шударга бус, хүмүүсээс хулгайлдаг гэж боддог байсан. Закхай татвар хураагчдын ахлагч, баян хүн байсан тул илүү их сэрдэгддэг байсан байх. Харин Есүс Закхайн зүрх сэтгэлийг харсан. Лук 19:1–10 Закхайн зүрх сэтгэлийн талаар юуг илчилдэг вэ? Та эдгээр шүлэгт буй Закхайн Аврагчид үнэнч гэдгээ харуулахын тулд хийсэн зүйлийг дүрсэлсэн үгсийг тэмдэглэж болно. Таны зүрх сэтгэлийн хүсэл юу вэ? Та Закхайн адил Аврагчийг эрэлхийлэхийн тулд юу хийж байна вэ?

Хуулийн багш нар, фарисайчуудтай харилцсан Аврагчийн үйлдэл Закхайтай харилцсан үйлдэлтэй нь харьцуулахад сонирхолтой зөрчилдөөн үүсгэдэг. Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф “Харин бусдын нүдэнд зөв шударга мэт харагдсанаар дэлхийн магтаал, нөлөө болон эд баялгийг авч, адислагдах ёстой байсан ард иргэдийг дарангуйлж буй бичээчид, фарисайчууд, садукайчууд шиг хоёр нүүртнүүдийг Тэрээр зөвт эсэргүүцлээр эсэргүүцэн боссон билээ” (“Чин үнэнч байх нь,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 66) хэмээн тайлбарласан.

Матай 23-т Аврагч хоёр нүүртэнг дүрслэхийн тулд хэд хэдэн зүйрлэл ашиглажээ. Эдгээр зүйрлэлийг тэмдэглэж эсвэл жагсаан бичиж, уг зүйрлэлүүд хоёр нүүртний тухай юу зааж байгааг тэмдэглэн авч болно. Та Аврагчийн сургаал дээр тулгуурлан юуг өөрчлөхөд сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

Мөн Сургаал ба Гэрээ 88:62–63; 137:9-ийг үзнэ үү.

МАТАЙ 21:1–11; МАРК 11:1–11; ЛУК 19:29–44; ИОХАН 12:12–16

Есүс Христ бол миний Хаан юм.

Матай 21:1–11; Марк 11:1–11; Лук 19:29–44; Иохан 12:12–16 дээрх түүхүүд нь Аврагчийн Иерусалим руу ялгуусан байдалд орсныг оролцуулан амьдралынх нь сүүлчийн долоо хоногийн эхлэлийг дүрсэлдэг. Хаанаа гэж таньсан хүмүүс нь Түүнийг тосолж (Иохан 12:1–8), Иерусалим руу орох Түүний зам

дээр хувцас, далдуу модны мөчир тавьж, магтаалын дуугаар хашгиралдан, үнэнч байдлаа харуулж байв. Дараах эх сурвалжууд Аврагчийн амьдралын сүүлчийн долоо хоногт эхэлсэн үйл явдлуудын талаарх таны ойлголтыг хэрхэн гүнзгийрүүлж болох талаар бод.

- Хааныг тосолж буй эртний жишээ: Хаадын дэд 9:1–13
- Ялгуусан оролтын тухай эртний бошиглол: Зехариа 9:9
- Хосанна хэмээх үгийн утга: Судруудын удирдамж, “Хосанна”
- Аврагч хэрхэн дахин ирэх талаарх бошиглолууд: Илчлэлт 7:9–10; 19:11–16

Та Аврагчийг өөрийн Их Эзэн, Хааны хувиар хэрхэн хүлээн авч болох вэ?

МАТАЙ 22:34–40

Хамгийн агуу хоёр тушаал бол Бурханыг болон бусдыг өөрийн адил хайрлах явдал юм.

Есүс Христийг дагахаар хичээх үедээ шантарвал Матай 22-т гардаг хуульчдын хэлсэн Аврагчийн үгс танд шавийн замдаа анхаарлаа хандуулж, амар хялбар байлгахад тусална. Үүнийг хийх нэг арга зам болох Их Эзэний хэд хэдэн зарлиг тушаалыг жагсаан бич. Жагсааж бичсэн зүйлс тань агуу хоёр тушаалтай тус бүрдээ хэрхэн холбогдож байна вэ? Агуу хоёр тушаал дээр анхаарлаа хандуулах нь бусад тушаалыг сахихад танд хэрхэн туслах вэ?

МАТАЙ 23:5

Сахиус гэж юу вэ?

Сахиус гэдэг нь судрын хэсгүүдийг бичсэн урт нарийн илэг унжуулсан арьсан хайрцаг юм. Иудейчүүд зарлигуудыг санах арга зам болгон ийм жижиг хайрцгуудыг арьсаар ороож, духандаа юм уу гарандаа зүүдэг байжээ (Дэд хууль 6:6–8). Фарисайчууд бардамналынхаа учир Бурханы үгсэд хэчнээн их хайртайгаа бусдад харуулахын тулд ердийнхөөс том сахиус зүүдэг байв.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИОХАН 12:1–8

Мариа Аврагчийг хайрладгаа хэрхэн харуулсан бэ? Бид Түүнийг хайрладаг гэдгээ хэрхэн харуулж болох вэ?



Брайн Колл, Есүсийн хөлийг угаасан нь

ИОХАН 12:42–43

Бусад хүнийг шашны үзэл бодлоо илэрхийлж, хамгаалж байгаа үед бид тэдэнд хүндэтгэлтэй хандаж

байгаагаа хэрхэн илэрхийлж болох вэ? Нийгмийн ямар ямар үр дагавар заримдаа Христэд итгэх итгэлээ илэрхийлж, хамгаалах эр зоригийг маань мохоодог вэ? Нийгмийн дарамт шахалтад бууж өгөөгүй хүмүүсийн жишээг Даниел 1:3–20; 3; 6; Иохан 7:45–53; 9:1–38; Мозая 17:1–4-өөс хараарай.

МАТАЙ 21:12–17

Бид ариун сүмд хэрхэн бишрэл хүндэтгэлтэй хандах вэ? Ариун сүм бол “залбирлын гэр” (Матай 21:12–13), сүнслэг эдгээлтийн газар гэдэг туршлагыг олж авахад бидэнд саад болох ямар ямар зүйлийг бид амьдралаасаа “хөөн гаргаж” болох вэ?

МАТАЙ 21:28–32


Хоёр хүүтэй хүний сургаалт зүйрлэлийн ямар сургамж танай гэр бүлд тус болох вэ? Жишээлбэл, чин сэтгэлийн дуулгавартай байдал, наманчлалын ач холбогдлын талаар ярихдаа уг түүхийг ашиглаж болно. Гэр бүлээрээ сургаалт зүйрлэлийг жүжиг болгон бичээд, өөр өөр дүрд ээлжлэн тоглож болох юм.

МАТАЙ 22:15–22

Бурханд өгч болох “Бурханы юм” (21-р шүлэг) гэж юу байна вэ?

Заах чадвараа сайжруулах

Гэр бүлийнхнийхээ анхаарлыг татахын тулд урлагийн бүтээл ашигла. Жишээлбэл, энэхүү тоймд хавсаргасан зураг нь Христийн Иерусалим руу орсон тухай түүхийг амилуулахад тус болж болно.



Волтер Рэйн, Ялгусан оролт



Харри Андерсон, Хоёр дахь ирэлт

5-Р САРЫН 27-ООС 6-Р САРЫН 2

Иосеф Смит—Матай 1; Матай 25; Марк 12–13; Лук 21

“Хүний Хүү ирэх болно”

Та Иосеф Смит—Матай 1; Матай 25; Марк 12–13; Лук 21-ийг уншихдаа “Эдгээр бүлэгт манай гэр бүлд эсвэл миний дуудлагад зориулсан ямар захиас байна вэ? гэж асууж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Есүсийн шавь нар Түүний Иерусалимын агуу ариун сүм буюу иудейчүүдийн сүнслэг, соёлын төв бүрмөсөн устгагдаж, “нэг чулуу нөгөө дээрээ үлдэхгүйгээр доош хаягдах болно” хэмээх бошиглолыг сонсоод гайхсан нь лавтай. Шавь нар нь илүү ихийг мэдэхийг хүсэн, “Эдгээр зүйл чинь хэзээ болох юм бэ?”, “Таны ирэлтийн тэмдэг нь юу вэ?” (Иосеф Смит—Матай 1:2–4) хэмээн асуусан нь мэдээж. Аврагчийн хариултууд Иерусалимд агуу устгал ирж байна (МЭ 70 онд гүйцэлдсэн бошиглол) гэсэн бошиглол сүүлчийн өдрүүдэд Түүний ирэхийг илтгэсэн тэмдгүүдтэй харьцуулахад

харьцангуй жижиг болохыг илчилдэг. Нар, сар, одод, үндэстэн, далай зэрэг Иерусалим дахь ариун сүмээс илүү бат бөх мэт харагдах зүйлс түр зуурынх юм гэдгийг баталдаг. Тэр ч бүү хэл “тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдэх болно” (Иосеф Смит—Матай 1:33). Хэрэв бид сүнслэг байдлаараа соргог байвал энэхүү сүйрэл жинхэнэ хувиршгүй зүйлсэд итгэл найдвараа тавих талаар бидэнд заадаг. Есүсийн амласнаар “тэнгэр хийгээд газар алга . . . болно, гэвч, миний үгс алга болох нь үгүй. Мөн миний үгийг нөөцлөх хэн боловч хууртагдах нь үгүй” (Иосеф Смит—Матай 1:35, 37).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИОСЕФ СМИТ—МАТАЙ

Иосеф Смит—Матай гэж юу вэ?

Агуу Үнэт Сувд дахь Иосеф Смит—Матай ном нь Ариун Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүвэр юм. Энэ нь Матай 23-ын сүүлчийн шүлэг, Матай 24-ийн бүх шүлгийн залруулгыг агуулдаг (Судруудын удирдамж дахь “Иосеф Смитийн Орчуулга”-ыг үзнэ үү). Иосеф Смитийн сүнслэг нөлөө бүхий залруулгууд нь алдагдсан эрхэм үнэнүүдийг сэргээсэн. Иосеф Смит—Матай 12–21-р шүлэгт эртний Иерусалимын устгалыг дурдаж; 21–55-р шүлэгт сүүлчийн өдрүүдийн тухай бошиглолуудыг агуулсан байдаг.

ИОСЕФ СМИТ—МАТАЙ 1:21–37; МАРК 13:21–37; ЛУК 21:25–38

Аврагчийн Хоёр дахь ирэлтийн тухай бошиглолууд надад ирээдүйтэй итгэлтэйгээр нүүр тулахад туслах болно.

Есүс Христийн Хоёр дахь ирэлтийг угтан тохиох үйл явдлуудын тухай унших нь санааг тань зовоож болно. Гэвч Есүс эдгээр үйл явдлын тухай бошиглохдоо шавь нартаа “та нар тэвдэн сандрахгүй байхаа мэдэгтүн” (Иосеф Смит—Матай 1:23) хэмээн хэлсэн. Та газар хөдлөлт, дайн, худал хуурмаг, өлсгөлөнгийн тухай сонсоод яаж “тэвдэн сандрахгүй” байж чадах вэ? Эдгээр шүлгийг уншаад, энэ асуултын тухай бодоорой. Санааг тань амраасан ямар нэгэн зөвлөгөө олбол бичиж, тэмдэглээрэй.

Мөн Сургаал ба Гэрээ 29:14–21; 38:30; 45:16–52; 88:86–94;

ИОСЕФ СМИТ—МАТАЙ 1:26–27, 38–55; МАТАЙ 25:1–13; ЛУК 21:29–36-Г ҮЗНЭ ҮҮ.

Би Аврагчийн Хоёр дахь ирэлтэд үргэлж бэлэн байх ёстой.

Бурхан хүний Хүүгийн ирэх “тэр өдрийг ч, цагийг ч” (Матай 25:13) илчлээгүй. Гэвч Тэр бидэн дээр тэр өдрийг “гэнэт” (Лук 21:34) ирээсэй хэмээн хүсдэггүй учир хэрхэн бэлтгэх тухай зөвлөсөн.

Эдгээр шүлгийг судлах явцад Аврагчийн Хоёр дахь ирэлтэд үргэлж бэлтгэлтэй байхыг заахдаа Түүний ашигладаг байсан харьцуулалт, сургаалт зүйрлэлүүдийг олж тогтоо. Та эдгээрээс юу ойлгож авч байна вэ? Та юу хийхэд сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

МАТАЙ 25:14–30

Тэнгэрлэг Эцэг намайг Өөрийнх нь бэлгүүдийг ухаалгаар ашиглаасай хэмээн хүсдэг.

Аврагчийн үед “талант” гэж мөнгийг хэлдэг байсан. Харин Их Эзэний талантын сургаалт зүйрлэл Өөрийнх нь өгсөн аливаа адислалыг хэрхэн ашиглаасай гэж биднээс хүсдэг тухай заадаг. Их Эзэн өгсөн зүйлсээ хөгжүүлэхийг биднээс хүсдэг. Та энэ сургаалт зүйрлэлийг уншихдаа Тэнгэрлэг Эцэгийн танд өгсөн зарим боломж, адислалыг жагсаан бич. Тэр эдгээр адислалаа хэрхэн ашиглахыг танаас хүсдэг вэ? Та эдгээр бэлгийг хэрхэн илүү ухаалгаар ашиглаж болох вэ? Их Эзэнд үйлчлэхэд авьяас чадвар тань хэрхэн өсөн нэмэгдсэн бэ?

МАТАЙ 25:31–46

Би бусдад үйлчилснээр Бурханд үйлчилдэг.

Хэрэв та амьдралыг тань Их Эзэн хэрхэн шүүх бол гэж бодож байсан бол хонь, ямааны сургаалт зүйрлэлийг уншаарай. Христийн өмнө зогсоход танд юу хамгийн чухал байх вэ?

Мөн Мозая 2:17-г үзнэ үү.

МАРК 12:18–27

Гэрлэлт Амилалтын дараа үргэлжлэх үү?

Бид Есүсийн хэлсэн “үхэгсдээс амилахад тэд гэрлэх ч үгүй, хадамд гарах ч үгүй” гэдэг үгс селестиел гэрлэлтийн гэрээнд ороогүй хүмүүсийг хэлж байгааг хожмын үеийн илчлэлтээс мэдэж авдаг (С ба Г 132:15–16-г үзнэ үү). Селестиел гэрлэлт буюу “эр хүн . . . шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр нэг эхнэртэй гэрлэх” нь эхнэр, нөхөр хоёр гэрээндээ үнэнч байснаар “үүрд мөнхөөр дамжуулан” үргэлжлэх болно (С ба Г 132:19).



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИОСЕФ СМИТ—МАТАЙ

Гэр бүлдээ энэ бүлгийг судлахад нь туслахын тулд Аврагчийн Хоёр дахь ирэлтэд хэрхэн бэлтгэх тухай Түүний сургаалыг хайж олохыг тэднээс хүс (жишээ нь, 22–23, 29–30, 37, 46–48-р шүлгийг үзнэ үү). Энэ зөвлөгөөг дагахын тулд танай гэр бүл юу хийж болох вэ?

ИОСЕФ СМИТ—МАТАЙ 1:22, 37

Бурханы үгийг нөөцлөх гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Бид үүнийг гэр бүлээрээ хэрхэн хийж чадах вэ? Үүнийг хийх нь бидэнд хууртагдахаас зайлсхийхэд хэрхэн туслах вэ?

МАТАЙ 25:1–13

Матай 25:1–13-р шүлгийн тухай ярилцахдаа энэхүү тоймд хавсаргасан арван охины зургийг ашиглаж болно. Гэр бүлийнхэн тань эдгээр шүлэгт дүрсэлсэн ямар нарийн тодорхой мэдээллийг зурган дээрээс олж харж байна вэ?

Та гэрийнхээ эргэн тойронд тосны дусал шиг хэлбэртэй цаасан хайчилбарууд нуугаад, гэр

бүлийнхнээрээ олуулбал тэдэнд хөгжилтэй санагдах болов уу? Та судрууд, сүмийн хувцас, ариун сүмийн зураг гэх мэт танай гэр бүлийнхний гэрчлэлийг хүчирхэгжүүлж, Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийг төлөөлсөн зүйлс дээр хайчилбаруудыг тогтоож болно.

МАРК 12:38–44; ЛУК 21:1–4

Гэр бүлийнхэн тань бэлэвсэн эмэгтэйн жишээнээс юу сурч болох вэ? Аврагч шавь нартаа өргөлийн талаар юу гэж заасан бэ? Аравны нэгийн өргөлийн хуудас үзүүлж, гэр бүлийнхээ Их Эзэнд өргөдөг өргөлүүдийн тухай болон эдгээр нь Бурханы хаант улсыг байгуулахад хэрхэн тусалдаг тухай ярилц. Танай гэр бүл аравны нэгийн хуудас дээр бичих боломжгүй өргөлийг өгч байгаа юу?



Сандра Раст, Бэлэвсэн эмэгтэйн зоос

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Орчин тойрноо бэлд. “Бидний орчин тойрон үнэний талаар сурч, мэдрэхэд ихээхэн нөлөөлдөг” (Аврагчийн арга барилаар заах нь, 15). Ариун Сүнсний нөлөөг урихуйц судар судлах боломжтой газар олохыг хичээ. Мөн урам зориг оруулах хөгжим болон зураг Сүнсийг урьж болно.



Волптер Рэйн, Тэдний тав нь ухаалаг болой



Волтер Рэйн, *Номойг дурсах*

6-Р САРЫН 3-9

Иохан 13–17

“Миний хайр дотор байгтун”

Таныг Иохан 13–17 дээрх Аврагчийн сургаалыг уншихад Ариун Сүнс танд зориулсан захиасыг мэдэхэд тань туслах болно. Хүлээж авсан мэдрэмжээ бичиж тэмдэглэ.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Өнөөдөр бид “Сүүлчийн зоог” хэмээн нэрлэдэг ч Есүсийн шавь нар жил бүрийн Дээгүүр өнгөрөх баярын зоог дээр цугларахдаа энэ нь Багшийгаа үхэхээс өмнө Түүнтэй хамт барьж байгаа хамгийн сүүлчийн зоог байх болно гэдгийг бүрэн ухаарсан эсэхийг мэдэхгүй. Гэсэн хэдий ч Есүс “цаг нь болсныг мэдэж байсан” (Иохан 13:1). Тэрээр удалгүй Гетсемани дахь зовлон шаналал, хамгийн дотны найзуудынхаа урвалт, үгүйсгэл хийгээд загалмай дээрх үхлийн тарчлалтай нүүр тулах гэж байсан. Есүс удахгүй Өөрт нь тохиох гэж байсан

энэ бүх зүйлийг үл тоон, Өөртөө биш, харин шавь нартаа үйлчлэхэд анхаарлаа хандуулж байсан. Тэрээр даруухнаар тэдний хөлийг угаасан. Тэр тэдэнд хайрын тухай заасан. Нэг утгаараа Тэр тэднийг хэзээ ч орхихгүй, тэд Түүнийг хэзээ ч орхих хэрэггүй хэмээн тайвшруулж байв. Шавь нар тэр үед болон одоо ч “Би та нарыг өнчрүүлж орхихгүй” (Иохан 14:18) хэмээх Аврагчийн амлалтаас амар амгаланг олдог. “Та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно” (Иохан 15:10).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИОХАН 13-15

Би Түүний хайрла гэсэн тушаалыг сахиснаар Есүс Христийг хайрладгаа харуулдаг.

Хамгийн агуу хоёр тушаал бол хайрлах тухай тушаал юм гэдгийг Есүс аль хэдийн заасан байсан (Матай 22:34-40-ийг үзнэ үү). Энэхүү онцлогт нийцүүлэн, Түүний төлөөлөгчдөдөө өгсөн сүүлчийн заавруудын гол сэдэв нь хайр байсан юм. Иохан 13-15-ыг уншихдаа *хайр* гэсэн үгийн хэрэглээ тус бүрийг тэмдэглэж эсвэл бичиж ав.

Эдгээр бүлэгт *тушаалууд* гэдэг үг *хайр* гэдэг үгтэй олон удаа холбогдож байгааг та анзаарах болно. Та Аврагчийн сургаалаас хайр, тушаалууд хэмээх үгсийн хоорондох уялдаа холбооны талаар юу сурч мэдэж болох вэ? Эдгээр бүлэгт өөр ямар ямар үг *хайр* гэдэг үгтэй олон дахин холбогдож байна вэ? Сурсан зүйлдээ тулгуурлан хайрын тухай Аврагчийн хэлсэн сургаалыг хураангуйлан бичиж болно.

Мөн Д.Тодд Кристоффэрсоны “Миний хайр дотор бай” хэлсэн үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 37-оос үзнэ үү.

ИОХАН 14-16

Ариун Сүнс надад Есүс Христийн шавийн хувьд зорилгоо биелүүлэхэд тусалдаг.

Есүс Христ удахгүй шавь нараа орхин явахаа, Түүнийг явсны дараа тэдэнд сүнслэг дэмжлэг хэрэг болно гэдгийг мэдэж байсан. Энэхүү дэмжлэгийг хэрхэн хүлээн авахыг ойлгоход нь туслахын тулд Тэрээр Ариун Сүнсний тухай заасан. Та дараах шүлгүүд дэх Аврагчийн үгсээс Ариун Сүнсний үүргийн талаар юу мэдэж авсан бэ?

- Иохан 14:16-17, 26 _____
- Иохан 15:26 _____
- Иохан 16:7-11 _____
- Иохан 16:12-15 _____

Яагаад шавь нарт Ариун Сүнсний иймэрхүү тусламж хэрэгтэй байсан бэ? Ариун Сүнс таны амьдралд

эдгээр үүргийг хэрхэн биелүүлсэн бэ? Та Шинэ Гэрээнээс үргэлжлүүлэн суралцахдаа Есүсийн шавь нарыг Ариун Сүнс адисалсан арга замуудыг эрж хай. Хэрэв Ариун Сүнсийг өөртөө илүү гүнзгий нөлөөлөхөд уривал таны амьдрал хэрхэн өөрчлөгдөх вэ?

Мөн Мозая 3:19; 5:1-3; 3 Нифай 27:20; Моронай 8:25-26; 10:5; Сургаал ба Гэрээ 11:12-14; Мосе 6:61-ийг үзнэ үү.

ИОХАН 15:1-8

Би Христ дотор байснаар сайн үр жимс өгөх болно.

“[Христ] дотор байх” гэдэг нь юу гэсэн утгатай вэ? (Иохан 15:4). Ямар “жимс” таныг Есүс Христийг төлөөлдөг модонд залгаатай байгааг харуулдаг вэ?

ИОХАН 17

Есүс Христ шавь нараа өмгөөлөв.

Иохан 17-д бичигдсэн Есүсийн үгс өмгөөллийн залбирал гэж танигдсан. Есүс энэхүү залбиралдаа Өөрийн төлөөлөгчид, “тэдний үгээр дамжуулан [Түүнд] итгэх хүмүүсийн төлөө” (Иохан 17:20) залбирсан. Энэ нь Тэр таны төлөө залбирсан гэсэн үг юм. Есүс Эцэгээсээ таны болон бусад бүх итгэгчийн төлөө юу гуйсан бэ?

Энэхүү залбирал нь мөн гүн гүнзгий, мөнхийн үнэнийг заадаг. Та үүнийг уншаад, ямар ямар үнэнийг олсон бэ?

ИОХАН 17:11, 21-23

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ хэрхэн нэг байдаг вэ?

Есүс Иохан 17 дээр гардаг залбиралдаа Эцэгтэй нэгдмэл байдгаа онцолсон ч энэ нь Эцэг, Есүс хоёр нэг хүн гэсэн үг биш юм. Аврагч Эцэгтэйгээ нэг “байдгийн адил” (Иохан 17:22) буюу тийм байдлаар нэг байхын төлөө өөрсдийн шавь нарыг залбирахдаа нэг хүн бол гэж хэлээгүй. Харин Түүний хүсэл бол Эцэгтэйгээ зорилго, зүрх сэтгэл, оюун бодлоороо төгс нэгдмэл байдгийн адил тэднийг нэгдэн баясаасай хэмээн хүссэн.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИОХАН 13:1-17

Танай гэр бүл эдгээр шүлэг дэх Аврагчийн үлгэр жишээнээс юу сурч болох вэ? Бид ямар ямар арга замаар Түүний үлгэр жишээг дагаж болох вэ?

ИОХАН 13:34-35; 15:9-14

Аврагчийн заасан хайрын тухай сургаалын талаар ярилцахдаа ерөнхийлөгч Томас С.Монсоны дараах үгсийн талаар ярилцаж болно. “Өнөөгийн дэлхийд гэр орноос өөр хаана ч хайрын бат бөх суурь байхгүй. Мөн хайрыг гэр бүлийнхээ гол утга учир болгосон хожмын үеийн гэгээнтнүүдийн гэр орноос илүү сайн, ийм суурь болох жишээ дэлхийн хаанаас ч олдохгүй. . . . Хайр бол сайн мэдээний хамгийн чухал хэсэг бөгөөд хүмүүний бодгалийн хамгийн сайхан зан чанар билээ” (“Би та нарыг хайрласны адилаар,” *Лиахона*, 2017 оны 2-р сар, 1-2).

Бие биенийхээ юунд нь хайртайгаа илэрхийлэн зураг зурах юм уу, зүрхэн хэлбэртэй цаасан дээр бичих нь танай гэр бүлийнхэнд таалагдаж болох юм. Эдгээр зүрхээ нэг нэгнээ хайрлах хайрын сануулга болгон гэрийнхээ эргэн тойронд байрлуулж болно.

ИОХАН 15:1-8

Эдгээр шүлгийг гадаа усан үзмийн ороонго, мод эсвэл ямар нэгэн ургамлын дэргэд уншвал сонирхолтой санагдах байх. Энэ үйл ажиллагаа нь

Аврагчийн сургаалыг илүү сайн ойлгоход танай гэр бүлд хэрхэн туслах вэ?



Есүс “Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд” (Иохан 15:5) хэмээн заасан.

ИОХАН 15:17-27; 16:1-7

Есүс Христ яагаад шавь нартаа хавчлага мөрдлөгийн талаар сэрэмжлүүлсэн гэж та бодож байна вэ? Өнөө үед Христийн шавь нар хэрхэн хавчигдаж байна вэ? Эдгээр шүлэг дэх Аврагчийн зөвлөгөө бидэнд хавчлага дарамттай тулгарах үед хэрхэн тусалж болох вэ?

ИОХАН 16:33

Христ дэлхийг хэрхэн ялан дийлсэн бэ? Түүний Цагаатгал бидэнд амар амгалан, урам зоригийг хэрхэн авчирсан бэ? (мөн С ба Г 68:6-г үзнэ үү).

ИОХАН 17:21-23

Танай гэр бүл Есүс Христ, Тэнгэрлэг Эцэг хоёртой адил хэрхэн илүү нэгдмэл байж чадах вэ? Яагаад Их Эзэн биднийг нэгдмэл байлгахыг хүсдэг вэ? (мөн С ба Г 38:27-г үзнэ үү).

Заах чадвараа сайжруулах

Чанга унш. Гэр бүлдээ судраас заахдаа чанга унших нь судрын түүхүүдийг илүү бодитой болгоход тусалдаг. Ялангуяа Иохан 13-17-д Аврагчийн үгс их байдаг учраас чанга унших нь хүчирхэг санагдаж болно.



Дэл Парсон, Эзэн Үйлчлэгч



Бэнжамин Макферсон, Тэгээд шөнө байе

6-Р САРЫН 10-16

Матай 26; Марк 14; Лук 22; Иохан 18

“Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог”

Та Матай 26; Марк 14; Лук 22; Иохан 18-д дүрсэлсэн үйл явдлуудыг уншихдаа хүлээж авах мэдрэмжүүддээ, ялангуяа амьдралаа өөрчлөхөд сүнслэгээр нөлөөлсөн мэдрэмжинд анхаарлаа хандуулаарай.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Гетсеманийн цэцэрлэгт Есүс Христийн шаналахыг харсан гуравхан мөнх бус гэрч байдаг бөгөөд тэд ихэнх хугацааг унтаж өнгөрүүлсэн. Есүс цэцэрлэгт мөн дараа нь загалмай дээр байхдаа бүхий л цаг үеийн хүн бүрийн гэм нүгэл, өвчин шаналал, зовлон зүдгүүрийг Өөр дээрээ авсан ч тэр үед амьд байсан бараг хэн ч юу болж байгааг ойлгоогүй. Харин мөнх оршихуйн хамгийн чухал үйл явдлууд ихэнхдээ дэлхийн анхаарлыг татахгүй өнгөрдөг. Гэсэн ч Бурхан Эцэг мэдэж байсан. Тэрээр итгэлтэй Хүүгийнхээ “Эцэг минь, хэрэв Та хүсэж байгаа бол

энэ аягыг Надаас зайлуулаач. Гэвч Миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг” хэмээх гуйлтыг сонссон. “Тэгтэл тэнгэрээс тэнгэр элч Түүнд үзэгдэн, Түүнийг тэнхрүүлж байлаа” (Лук 22:42–43). Бид энэ дуулгавартай байдал, амиа үл хайрласан үйлдлийг нүдээр харж гэрчлээгүй ч тодорхой байдлаар Есүс Христийн Цагаатгалын гэрч байж чадна. Бид наманчилж, нүглүүдийнхээ өршөөлийг хүлээж авах бүрдээ мөн Аврагчийн хүчирхэгжүүлэх нөлөөг мэдрэх бүрдээ Гетсеманийн цэцэрлэгт юу болсныг гэрчилж чадна.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 26:17-30; МАРК 14:12-26; ЛУК 22:7-39

Ариун ёслол бол Аврагчийг дурсан санах нэгэн боломж.

Та өөрийн амьдралд чухал байр суурь эзэлдэг хүмүүсийг эргэн санахын тулд юу хийдэг вэ? Аврагч шавь нартаа ариун ёслолыг танилцуулахдаа "Намайг дурсаж үүнийг үйлд" (Лук 22:19; мөн 3 Нифай 18:7-г үзнэ үү) хэмээсэн. Энэхүү ёслолын талх, ус болон бусад хэсэг нь Түүнийг болон Түүний зовлон шаналлыг дурсан санахад танд хэрхэн тусалдаг вэ? Та анхны ариун ёслолын тухай уншихдаа энэ асуултыг тунгаан бодоорой. Түүнчлэн Иосеф Смитийн Орчуулга дээрх залруулгыг үзээрэй (Судруудын удирдамж).

Долоо хоног бүр ариун ёслолын үеэр олж авсан туршлагаудынхаа талаар тунгаан бодох цаг гарга. Илүү утга учиртай болгохын тулд та юу хийж болох вэ? Аврагч, Түүний сургаал, хайрын үйлдлүүд болон Түүнтэй илүү ойр байгаагаа мэдэрсэн үе, Түүний таны төлөө Өөр дээрээ авсан нүгэл, өвчин шаналлын тухай дурсан санахаар өдөөгдөж байгаа хэдэн зүйлээ жагсаан бичиж болно.

Мөн 3 Нифай 18:1-13; Сургаал ба Гэрээ 20:76-79-ийг үзнэ үү.

МАТАЙ 26:36-46; МАРК 14:32-42; ЛУК 22:40-46

Аврагч Гетсеманид миний төлөө зовж шаналсан.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон биднийг "Аврагчийн болон Түүний цагаатгагч золиослолын тухай судлахад цаг гарга" ("Есүс Христийн хүчийг амьдралдаа татан авах нь," 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 26) хэмээн урьсан.

Та ерөнхийлөгч Нэлсоны урилгыг хүлээн авахын тулд юу хийх тухайгаа бод. Та эдгээр шүлэгт дүрслэгдсэн Гетсемани дахь Аврагчийн зовлон шаналлын тухай залбирч, тунгаан бодож, төрсөн сэтгэгдэл, асуултаудаа бичиж авснаар эхэлж болно.

Аврагч, Түүний Цагаатгалыг илүү гүн гүнзгий судлахын тулд дараахтай төстэй асуултуудын хариултыг бусад судраас олохыг хичээ.

- Яагаад Аврагчийн Цагаатгал зайлшгүй шаардлагатай байсан бэ? (2 Нифай 2:5-10, 17-26; 9:5-26; Алма 34:8-16; 42:9-26-г үзнэ үү.)
- Аврагч зовж шаналж байхдаа юу мэдэрсэн бэ? (Исаиа 53:3-5; Мозая 3:7; Алма 7:11-13; С ба Г 19:16-19-ийг үзнэ үү.)
- Христийн зовлон шаналал миний амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? (Иохан 10:10-11; Еврей 4:14-16; 1 Иохан 1:7; Алма 34:31; Моронай 10:32-33; Даллин Х.Өүкс, "Есүс Христийн Цагаатгалаар хүчирхэгжсэн," 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 50-53.)
- Надад байгаа бусад асуулт:

Гетсеманид юу болсон талаар судлахдаа Гетсемани нь чидун модны цэцэрлэг байсан бөгөөд тэнд гэрэл, хүнс хоол, эмчилгээнд ашиглахын тулд чидун жимсийг бяцалж, тос шахаж гаргах тээрэм байдаг байсныг мэдэх нь сонирхолтой байж болох юм (Лук 10:34-ийг үзнэ үү). Чидун жимсний тос гаргахын тулд хүнд жин ашиглах үйл явц нь Аврагч бидний төлөө гэм нүгэл, өвчин шаналлын хүнд даралтыг үүрснийг бэлгэддэг (Д.Тодд Кристоффэрсон, "Миний хайр дотор бай," 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 37-г үзнэ үү).

МАРК 14:27-31, 66-72; ЛУК 22:31-32

Хөрвөлт бол байнгын үйл явц юм.

Петрийн харсан гайхамшиг, суралцсан сургаалууд зэрэг Аврагчтай хамт байхдаа олж авсан туршлагаудын талаар бод. Тэгэхэд Аврагч яагаад Петрт хандан "Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул" хэмээн хэлсэн бэ? (Лук 22:32; налуу бичилт нэмэгдсэн.) Ахлагч Дэвид А.Бэднар гэрчлэлтэй байх, жинхэнээсээ хөрвүүлэгдэх хоёрын ялгааг юу гэж заасан бэ? ("Их Эзэнд хөрвүүлэгдэв," 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 130-133-ыг үзнэ үү). Та Марк 14:27-31, 66-72 дээр гардаг Петрийн туршлагын тухай уншихдаа өөрийнхөө хөрвөлтийн тухай бод. Та Петрээс ямар ямар сургамж авч болох вэ? Та Шинэ Гэрээг үргэлжлүүлэн уншихдаа Петрийн

хөрвөлт, бусдыг батжуулж, хүчирхэгжүүлэх гэсэн түүний хүчин чармайлтын талаар ямар нотолгоо олсон бэ? Ариун Сүнсний бэлэг хүлээж авсан нь

түүний хөрвөлтөд ямар нөлөө үзүүлсэн бэ? (Иохан 15:26-27; Үйлс 1:8; 2:1-4-ийг үзнэ үү).



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ Аврагчийн амьдралын сүүлчийн долоо хоногийн талаар үргэлжлүүлэн судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 26:17-30; МАРК 14:12-26; ЛУК 22:7-39

Долоо хоног бүрийн ариун ёслолын үеэр танай гэр бүл ямар туршлагатай болдог вэ? Анхны ариун ёслолын тухай унших нь ариун ёслолын ач холбогдлын талаар мөн гэр бүлийн гишүүд сүсэг бишрэлээ илүү утга учиртай болгох арга замын талаар ярилцахад нөлөөлж болно. Ариун ёслолын өмнө, дундуур, дараа нь юу хийж болох талаарх санаануудаа бие биетэйгээ хуваалцаж болно.

ЛУК 22:40-46

Гэр бүл тань эдгээр шүлгийг уншихдаа “Аврагч Гетсеманид миний төлөө зовж шаналсан” гэсэн нэртэй хувиараа судраас судлах хэсгийн санал болгосон судруудаас юу сурснаа хуваалцаж болно.

ЛУК 22:50-51

Энэ туршлагаас бид Есүсийн талаар юу сурах вэ?

МАТАЙ 26:36-46; МАРК 14:32-42; ЛУК 22:40-46

Бид эдгээр шүлгэн дээрх Аврагчийн үгсээс юу ойлгож авах вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн үгсийг судал. Судраас олсон зарчмуудын тань талаар хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчид юу заасан тухай унш. Жишээ нь, хамгийн сүүлийн *Ерөнхий чуулганы* сэтгүүлээс та “Цагаатгал” гэсэн сэдвийг хайж болно (*Аврагчийн арга барилаар заах нь*, 21-ийг үзнэ үү).



Волгэр Рэйч, Миний хүсэл бус, харин Таны хүсэл



Антонио Цицери, Энэ хүнийг харгалуун

6-Р САРЫН 17-23

Матай 27; Марк 15; Лук 23; Иохан 19

“Гүйцэлдлээ”

Матай 27; Марк 15; Лук 23 болон Иохан 19 нь Аврагчийн мөнх бус амьдралын эцсийн мөчүүдийг дүрслэн харуулдаг. Аврагчийн золиослол, үхлийн талаар судлахдаа Түүний хайрыг мэдрэхийг эрэлхийл.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Есүс Христ үг, үйлдэл бүрээрээ цэвэр хайрыг буюу төлөөлөгч Паулын хэлснээр энэрлийг үлгэрлэн үзүүлж байсан (1 Коринт 13-ыг үзнэ үү). Аврагчийн мөнх бус амьдралын эцсийн мөчүүдээс өөр ямар ч цаг үед энэ нь ийм тод томруун нотлогдож байгаагүй. Тэрээр худал хуурмагт гүтгүүлж байхдаа хүндэтгэлтэйгээр чимээгүй байсан нь Түүний “уурладаггүй” (1 Коринт 13:5) зан чанарыг харуулсан. Тарчлаахыг зогсоох хүч чадлаа хазаарлан барьж, ташуурдах, элэглэн шоолох, цовдлох зэргийг тэвчих хүсэл нь Түүний “тэвчээртэй,” “бүгдийг далдалдаг” (1 Коринт

13:4, 7) чанарыг харуулсан. Харьцуулшгүй ихээр зовж, шаналж байхдаа ч Түүний ээждээ хандсан нинжин сэтгэл, Өөрийг нь цовдолсон хүмүүст үзүүлсэн нигүүлсэл “[Өөрийнхийг] эрдэггүй” (1 Коринт 13:5) гэдгийг нь харуулж байсан. Есүс дэлхий дээрх сүүлчийн хэдхэн хоромдоо, мөнх бус амьдрал дахь үйлчлэлийнхээ үеэр хийсэн зүйлээ хийж байсан буюу үлгэр жишээгээрээ зааж байсан. Энэрэл бол ‘Христийн цэвэр хайр’ (Моронай 7:47) гэдэг нь гарцаагүй.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 27; МАРК 15; ЛУК 23; ИОХАН 19

Есүс Христийн зовж шаналахад бэлэн байсан нь Түүний Эцэгийг болон бид бүгдэд хайртай болохыг нь харуулдаг.

Хэдийгээр Аврагчид тоо томшгүй “олон тэнгэр элчийг” (Матай 26:53) дуудах хүч чадал байсан ч Тэрээр сайн дураараа шударга бус шүүлт, элэглэл доромжлол, төсөөлшгүй бэрх бие махбодын өвчин шаналлыг тэвчихийг сонгосон. Тэр яагаад үүнийг хийсэн бэ? Нифай үүнийг “Хүмүүний үрсийн зүг хандах өөрийн өгөөмөр хайр мөн өөрийн хүлцэнгүй тэсвэрлэлийн учир” (1 Нифай 19:9) хэмээн гэрчилсэн.

Та 1 Нифай 19:9-ийг уншнаар Аврагчийн сүүлчийн мөчүүдийн талаарх судалгаагаа эхэлж болно. Та Есүсийг тэвчих болно гэж Нифайн хэлсэн бүх зүйлийн жишээг Матай 27; Марк 15; Лук 23, Иохан 19-ийн аль хэсгээс олох вэ?

“[Тэд] гологдсон зүйл мэт түүнийг шүүх болно” _____

“[Тэд] түүнийг ташуурдах” болно _____

“[Тэд] түүнийг цохих” болно _____

“[Тэд] түүнийг нулимаж бөлгөө” _____

Аль аль хэсэг танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын танд хандсан “өгөөмөр хайрыг” мэдрэхэд туслах вэ? Та Аврагчийн үзүүлсэн зан чанаруудаас алиныг нь илүү бүрэн хөгжүүлэхэд сүнсээр нөлөөлөгдөж байна вэ?

МАТАЙ 27:27-49, 54; МАРК 15:16-32;

ЛУК 23:11, 35-39; ИОХАН 19:1-5

Бурханы үнэнийг элэглэн шоолж байгаа нь миний итгэлийг сулруулах ёсгүй.

Есүс үйлчлэлийнхээ турш доог тохуурхлыг тэвчиж байсан ч энэ нь ташуурдуулж, цовдлуулж байх үед нь улам дэвэрсэн. Гэвч энэ доог тохуурхал Есүс бол Бурханы Хүү хэмээх үнэнийг өөрчилж чадахгүй. Та Есүсийн тэвчиж байсан доромжлолын тухай уншихдаа өнөөдөр Түүний ажилд тулгарч буй эсэргүүцэл, доог тохуурхлын талаар бодоорой. Та эсэргүүцлийг тэвчих тухай ямар ойлголт олж авсан бэ? Матай 27:54 дэх зуутын даргын хэлсэн үгсийн юу нь таныг гайхшируулж байна вэ?

МАТАЙ 27:46; МАРК 15:34

Тэнгэрлэг Эцэг Есүсийг загалмай дээр орхисон уу?

Ахлагч Жэффри Р.Холланд дараах ойлголтыг өгсөн. “Түүний төгс Эцэг Хүүгээ тэр мөчид *орхиогүй* юм гэдгийг би . . . хэлж байна. Гэсэн хэдий ч Эцэг Хүүгийнхээ агуу золиослолыг ганцаардмал байсан шиг нь бүрэн төгс байлгахыг хүссэн тул түр зуур Өөрийн Сүнсний тайвширлыг мөн Өөрийн хувийн оршихуйн дэмжлэгийг ч Есүсээс холдуулсан. . . . Цагаатгалаа агуу хийгээд мөнхийн байлгахын тулд Тэрээр зөвхөн бие махбодын хувьд үхээд зогсохгүй, сүнсээрээ үхэх нь тэнгэрлэг Сүнс холдон одох, тэр чигтээ ямар ч найдваргүй ганцаараа хоцорсон мэт мэдрэмж ямар байдгийг өөрийн биеэр амсах хэрэгтэй байлаа” (“Түүнтэй хамт хэн ч байсангүй,” 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 97).

ЛУК 23:34

Аврагч уучлал өршөөлийн үлгэр жишээ юм.

Таныг Лук 23:34 дээрх Аврагчийн үгсийг унших үед ямар мэдрэмж төрсөн бэ? Ерөнхийлөгч Хэнри Б. Айринг Аврагчийн үгсийн талаар “Бид өөрсдийгөө гомдоосон хүмүүсийг уучилж, өс санахгүй байх ёстой. Аврагч загалмай дээрээс үлгэр жишээ үзүүлсэн. . . . Биднийг гомдоосон хүмүүсийн зүрх сэтгэлийг бид мэдэхгүй шүү дээ” (“That We May Be One,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 68) хэмээн заасан. Хэрэв та хэн нэгнийг уучилж чадахгүй шаналж байгаа бол энэ шүлэг танд хэрхэн тусалж чадах вэ?

ЛУК 23:39-43

Аврагчийн хулгайчид хэлсэн үгс дэх “диваажин” гэдэг нь ямар утгатай вэ?

Судрууд дахь *диваажин* хэмээх үг ихэвчлэн зөв шударга хүмүүст зориулан бэлтгэгдсэн газар буюу “зуурдын амьдралын дараах сүнсний дэлхийд аз жаргал хийгээд амар амгалангийн газар” гэсэн утгатай байдаг. Бошиглогч Иосеф Смит Лук 23:43-т гардаг *диваажин* гэдэг үгийн талаар энэ нь “буруу орчуулга бөгөөд Их Эзэн үнэндээ тэрхүү хулгайчийг Түүнтэй хамт сүнсний дэлхийд байх болно хэмээн хэлсэн” гэж заасан (*Итгэлдээ үнэнч байх нь*, 84-85-ыг үзнэ үү). Сүнсний дэлхийд хулгайч сайн мэдээг сонсох болно.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 27:3-10

Иудас хэдийгээр Есүсийг мэддэг байсан ч “[Есүсээс] нүүр буруулж, түүний үгсэд гомдсон” (Иосеф Смитийн Орчуулга, Марк 14:31). Хүчтэй гэрчлэлтэй мэт санагдаж байсан хүмүүс Аврагчаас нүүр буруулахад юу нөлөөлдөг вэ? Бид Есүс Христэд хэрхэн чин үнэнчээр үлдэж чадах вэ?

МАТАЙ 27:11-26; МАРК 15:1-15; ЛУК 23:12-24; ИОХАН 19:1-16

Пилат Есүсийг буруугүй гэдгийг мэдэж байсан мөртлөө яагаад цовдлуулахаар явуулсан бэ? Пилатын туршлагаас бид зөв гэж мэддэг зүйлээ хамгаалах тухай юу ойлгож авч болох вэ? Зөв зүйлийг

хамгаалах дадлага хийх боломж олгон, жүжигчилсэн тоглолт хийх нь гэр бүлийнхэнд тань тустай байж болох юм.

МАТАЙ 27:46; ЛУК 23:34, 43, 46; ИОХАН 19:26-28, 30

Эдгээр шүлгэн дээрх Аврагчийн загалмай дээр байхдаа хэлсэн үгсийг гэр бүлийнхэндээ тус бүрд нь нэг юм уу түүнээс олныг даалгаж өгөөд, Аврагчийн болон Түүний номлолын тухай ойлгож мэдсэн зүйлээ хуваалцахыг хүсэж болно.

МАРК 15:39

Цовдлуулалтын тухай уншаад, Есүс бол “Бурханы Хүү” хэмээх бидний гэрчлэл хэрхэн хүчирхэгжсэн бэ?

ИОХАН 19:25-27

Бид эдгээр шүлгээс гэр бүлийнхнээ хайрлаж, дэмжих талаар юу сурах вэ?

Заах чадвараа сайжруулах

Аврагчийн амьдралыг даган дуурай. “Аврагчийн заах арга барилыг буюу Түүний хэрэглэсэн аргачлал, хэлсэн үгийг судлах нь тустай. Гэхдээ Аврагчийн заах, бусдыг өргөн дэмжих хүч нь . . . хэн байснаас нь үүдэлтэй. Та Есүс Христийнхтэй адил амьдралаар амьдрахыг хичээх тусам Түүнтэй адил заах боломжтой болно” (Аврагчийн арга барилаар заах нь, 13).



Карл Хэйнрих Блок, Загалмай дээрх Христ



Камилл Корри, Мангид хоньдыг тэжээ

6-Р САРЫН 24-30

Матай 28; Марк 16; Лук 24; Иохан 20–21

“Тэр амилсан”

Матай 28; Марк 16; Лук 24, Иохан 20–21-ийг залбирч уншаад, Христийн амилсны ачаар танд байгаа баяр баяслын тухай эргэцүүл. Энэхүү үйл явдлын талаарх гэрчлэлээ хэрхэн хуваалцах талаар тунгаан бод.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Олон ажиглагчид Назарын Есүсийн үхэл гайхалтай амьдралын егөөдөлтэй төгсгөл мэт санагддаг байж болох юм. Энэ чинь Лазарыг үхлээс босгосон хүн биш үү? Тэр фарисайчуудын алах заналхийллийг удаа дараа сөрж гарсан биш бил үү? Тэр сохор, уяман өвчтэй, саа өвчтэй хүмүүсийг эдгээх хүчтэй гэдгээ харуулсан. Салхи болон далай Түүний үгэнд орсон. Гэтэл Тэр энд загалмайд хадуулан, “гүйцэлдлээ” (Иохан 19:30) хэмээн хэлээд байж байсан. “Тэр бусдыг аварсан боловч Өөрийгөө аварч чаддаггүй” (Матай 27:42) хэмээх эзлэглэн шоглосон үгсэд чин

сэтгэлийн гайхширал байсаар байна. Гэвч бид Есүсийн үхэл энэ түүхийн төгсгөл биш байсныг мэднэ. Бид булшин дахь нам гүм байдал түр зуурынх байсан бөгөөд Христийн авралын ажил дөнгөж эхэлж байсныг мэднэ. Тэрээр өнөөдөр “үхэгсдийн дунд” (Лук 24:5) биш, харин амьд хүмүүсийн дунд байгаа. Христийн сургаал мартагдахгүй, учир нь Түүний үнэнч шавь нар “үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” хэмээх амлалтад нь итгэн, сайн мэдээг “бүх үндэстэнд” (Матай 28:19–20) тунхаглах болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 28; МАРК 16; ЛУК 24; ИОХАН 20

Есүс амилсан учраас би ч бас амилуулагдах болно.

Эдгээр хэсэгт хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн чухал үйл явдал болох Есүс Христийн Амилалтын тухай унших болно. Уншихдаа Амилалтын эргэн тойронд болсон үйл явдлуудын гэрч болсон хүмүүсийн оронд өөрсдийгөө тавиад үзээрэй. Эдгээр гэрч юу мэдэрсэн бол? Та Аврагчийн Амилалтын тухай уншихдаа юу мэдэрч байна вэ? Энэ нь амьдралын талаарх таны үзэл бодол, бусадтай харьцах харилцаа, Христэд итгэх итгэл, сайн мэдээний бусад үнэнд итгэх итгэл зэрэгт хэрхэн нөлөөлсөн талаар эргэцүүлэн бод.

Мөн Судруудын удирдамжаас “Амилуулалт”-ыг үзнэ үү.

ЛУК 24:13–35

Бид Аврагчийг “бидэнтэй хамт байхад” урьж болно.

Аялж явахдаа амилсан Аврагчтай таарсан хоёр шавийн туршлага шавь байх замд адилхан байдаг. Христийн шавийн хувьд таны туршлага, энэ түүх хоёр хоорондоо ямар холбоотой байна вэ? Та өнөөдөр хэрхэн Түүнтэй хамт алхаж мөн Түүнийг жаахан удаан хамт “байхыг” урьж болох вэ? (Лук 24:29). Та амьдралдаа Түүний оршихуйг хэрхэн олж харах вэ? Ариун Сүнс ямар арга замаар Есүс Христийн бурханлаг байдлыг танд гэрчилж байсан бэ?

ЛУК 24:36–43; ИОХАН 20

Есүс Христ бие махбодтой юу?

Амилсан Их Эзэний Магдалын Мариад үзэгдсэн мөн дараа нь шавь нартайгаа харилцсан тухай түүхүүдээр дамжуулан бид Есүсийн Амилалт бол жинхэнэ, бие махбодын амилалт байсан гэдгийг мэдэж авдаг. Тэрээр амилсан мөн алдар суут биеэрээ шавь нартайгаа хамт алхаж, ярьж, зооглосон. Бусад сударт ч

гэсэн Есүс Христийг мах, яснаас бүрдсэн бие махбодтой гэдгийг гэрчилдэг. Тухайлбал: Филиппой 3:20–21; 3 Нифай 11:13–15; Сургаал ба Гэрээ 110:2–3; 130:1, 22.

ИОХАН 20:19–29

“Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ.”

Бодит баримт харахгүйгээр ямар нэгэн зүйлийг үнэн гэдэгт итгэхэд хэцүү. Та заримдаа “үзэхээс нааш би итгэхгүй” (Иохан 20:25) хэмээн хэлсэн Томастай адил мэдрэмж мэдэрч болох юм. Аврагч хариуд нь Томаст “Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй еэ!” (Иохан 20:29) хэмээсэн. Та харж чадахгүй сүнслэг зүйлсэд итгэснээр адислагдаж байсан уу? Та Аврагчийг харж чадахгүй байсан ч Түүнд итгэлтэй байхад юу тусалдаг вэ? Та бодит нотолгоогүй өөр ямар үнэнд итгэдэг вэ? “Үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд” итгэх итгэлээ үргэлжлүүлэн хэрхэн хөгжүүлэх вэ? (Алма 32:21 мөн Ифер 12:6-г үзнэ үү). Та Есүс Христэд итгэхэд тусалсан туршлагаа тэмдэглэлдээ бичиж, таньдаг хүндээ хуваалцаж болно.

ИОХАН 21:1–17

Аврагч намайг Өөрийнх нь бусад хонийг тэжээхэд урьдаг.

Иохан 21 дээр гардаг Аврагчийн төлөөлөгчидтэйгөө харилцах харилцааг Лук 5:1–11-д цэдэглэгдсэн анх тэдэнд загасны тороо хаяхыг тушаасан түүхтэй харьцуулах нь сонирхолтой санагдах байх. Та ямар адил мөн ялгаатай талыг олсон бэ? Та шавь байх тухай ямар ойлголтыг олж авсан бэ?

Иохан 21:15–17 дээр буй Аврагчийн Петрт хэлсэн үгс тантай хэрхэн холбогдох вэ? Их Эзэний хоньдод тохинуулахад саад болж байгаа зүйл танд байна уу? Хэрэв Их Эзэн танаас “Намайг хайрладаг уу?” хэмээн асуувал та юу гэж хариулах вэ? Их Эзэнийг хайрладаг гэдгээ хэрхэн харуулж болох талаар тунгаан бод.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ сайн мэдээнүүдийг уншиж дуусгах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 28:6

“Тэр энд байхгүй. Учир нь Тэр амилсан” хэмээх үгс яагаад хамгийн чухал, хамгийн их найдвар тээсэн үгсийн нэг байдаг вэ?

МАТАЙ 28; МАРК 16; ЛУК 24; ИОХАН 20-21

Гэр бүлээрээ эдгээр бүлгийг уншихдаа түүх бүр дээрх Есүстэй харилцсан хүмүүст анхаарлаа төвлөрүүлээрэй. Жишээлбэл, та нэг удаа Аврагчийн булшинд айлчилж ирсэн хүмүүс дээр төвлөрч болно. Өөр тохиолдолд та Еммау хүрэх зам дээр явж байсан төлөөлөгчид, шавь нарын үйлдлийг анхааралтай судалж болно.

МАТАЙ 28:16-20; МАРК 16:14-20; ЛУК 24:44-53

Христийн төлөөлөгчдөөсөө хийхийг хүссэн ажлын талаар гэр бүлээрээ ярилц. Бид энэ ажлыг гүйцэлдүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ? “Эзэн [тантай] хамт ажиллаж” Өөрийнх нь зорилгыг биелүүлэхэд танд тусалж байсныг мэдэрсэн үеэ хуваалцаж болно (Марк 16:20).

ИОХАН 21:15-17

Хамтдаа хоол идэж байхдаа эдгээр шүлгийг уншиж болно. Энэ нь “Миний хургануудыг тэжээ” хэмээх Аврагчийн үгсийг илүү утга учиртай болгох байх. Шинэ Гэрээнд Есүсийн хонины тухай заасан зүйл дээр үндэслэн (жишээлбэл, Матай 9:35-36; 10:5-6; 25:31-46; Лук 15:4-7; Иохан 10:1-16) хонь тэжээх нь яагаад Бурханы хүүхдүүдийг хооллож, халамжлахад тохирох зүйрлэл болж байна вэ? Уг зүйрлэл Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёрын бидний талаар ямар мэдрэмжтэй байдаг тухай ноу зааж байна вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Сүнсийг урьж, сургаалаас суралцахад дуу хөгжим ашигла. Сүмийн дуулал болон хүүхдийн дуу номын 54, 55-р хуудасны “Тэр амилсан!” эсвэл “Христ энэ өдөр амилсан” зэрэг дууллаудыг сонсож эсвэл дуулах нь Сүнсийг урьж, Аврагчийн Амилалтын тухай сурахад танд тусална.



Жозеф Брики, Христ, Мариа хоёр булшны дэргэд



Сидней Кинг, Пентекостын өдөр

7-Р САРЫН 1-7

Үйлс 1–5

Үйлс 1–5: “Та нар Намайг гэрчлэх болно”

Таныг Үйлс 1–5-ыг судалж байхад Ариун Сүнс таны амьдралд чухал хамааралтай үнэнүүдийг олоход сүнслэгээр өдөөж чадна. Танд онцгой сэтгэгдэл төрүүлсэн шүлгүүдийг тэмдэглэн, сурч буй зүйлсээ хуваалцах боломжуудыг эрэлхийл.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Петр бусад төлөөлөгчийн хамт Есүсийг Эцэг рүүгээ дээш одохыг харж, “тэнгэр өөд гөлрөн” байхдаа юу бодож, мэдэрч байсан бол гэж та төсөөлөн бодож байсан уу? (Үйлс 1:10). Бурханы Хүүгийн байгуулсан Сүмийг одоо Есүс Бурханы бошиглогч Петрээр дамжуулан удирдаж байв. “Бүх үндэстнийг дагалдагч болгох” оролдлогыг удирдах үүрэг хариуцлага одоо Петрт оногдов (Матай 28:19). Гэвч бид түүнийг өөрийгөө тохирохгүй гэж бодож эсвэл айж байсан эсэх тухай Үйлс номноос ямар ч нотолгоог олж хардаггүй. Харин бид эрэмгий гэрчлэл, хөрвөлтийн үлгэр жишээ, гайхамшигт

эдгээлт, сүнслэг нотолгоо, Сүмийн гайхалтай өсөлт хөгжлийг олж хардаг. Одоо Ариун Сүнсний бэлэгтэй болсон Петр Галил нуурын эргээс Есүсийн олсон туршлагагүй загасчин биш болсон. Хэдхэн долоо хоногийн өмнө Назарын Есүсийг таньдаг гэдгээ үгүйсгэснээсээ болж гашуунаар уйлж байсан ухаангүй эр ч биш болсон.

Та Үйлс номноос Есүс Христ, Түүний сайн мэдээний талаарх хүчирхэг тунхаглалыг унших болно. Түүнчлэн сайн мэдээ хүмүүсийг мөн таныг ч хэрхэн Бурханы мэдэж байгаа тэрхүү зоригтой шавь болгон өөрчилж чадахыг харах болно.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ҮЙЛС 1:1-8, 15-26; 2:1-42; 4:1-13, 31-33

Есүс Христ Ариун Сүнсээр дамжуулан Өөрийн Сүмийг удирддаг.

Үйлсийн номонд Аврагчийг дээш одсоны дараа Есүс Христийн Сүмийг байгуулах гэсэн төлөөлөгчдийн хүчин чармайлтыг цэдэглэсэн байдаг. Хэдийгээр Есүс Христ дэлхий дээр байхгүй болсон ч Ариун Сүнсний илчлэлтээр дамжуулан Өөрийн Сүмийг удирдаж байсан. Дараах судрын хэсгүүдийг уншихдаа Христийн Сүмийн шинэ удирдагчдыг Ариун Сүнс хэрхэн удирдан чиглүүлж байсан тухай эргэцүүлэн бодоорой. Үйлс 1:1-8, 15-26; 2:1-42; 4:1-13, 31-33.

Их Эзэн танд ямар ямар даалгавар, дуудлага эсвэл үүрэг хариуцлага өгсөн бэ? Та эдгээр эртний төлөөлөгчийн туршлагаас Ариун Сүнсээр удирдуулахын тулд Түүнд хэрхэн тулгуурлаж болох талаар юу сурсан бэ?

Түүнчлэн Судруудын удирдамжийн “Ариун Сүнс”-ийг үзнэ үү.

ҮЙЛС 2:1-18

Хэлний бэлгийн зорилго юу вэ?

Хэлний бэлэг гэдэг нь заримдаа хэний ч ойлгохгүй хэлээр ярихыг хэлдэг. Гэсэн хэдий ч, бошиглогч Иосеф Смит сүнсний энэхүү бэлэг нь “хэлийг нь ойлгох боломжгүй хүмүүст Пентекостын өдөр тохиосонтой адилаар [сайн мэдээг] номлох зорилгын төлөө . . . өгөгдсөн юм. . . . Олон янзын хэлээр ярих [бэлгийн] туйлын зорилго нь гадаадын хүмүүстэй хэл нэвтрэлцэх явдал мөн” (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2008], 434-435) хэмээн тодотгохын тулд Үйлс 2 дээрх үйл явдлуудыг дурдсан. Иудейчүүдийн гол баяр болох Пентекостын зоог иудейчүүдийг олон үндэстнээс Иерусалимд авчирсан. Хэлний бэлгийн ачаар уг зочид уугуул хэлээрээ ярьсан төлөөлөгчдийн үгсийг ойлгох боломжтой байжээ.

ҮЙЛС 2:36-47; 3:13-21

Сайн мэдээний анхдагч зарчмууд хийгээд ёслолууд нь Христэд ирэхэд надад тусалдаг.

Та Пентекостын өдөр иудейчүүдийн мэдэрч байсан шиг “зүрхийг [тань] хөндсөн” мэдрэмжийг мэдэрч

байсан уу? (Үйлс 2:37). Магадгүй та харамсах зүйл хийсэн эсвэл зүгээр л амьдралдаа өөрчлөлт хийхийг хүсэж байж болох юм. Та ийм мэдрэмж мэдэрсэн үедээ яах хэрэгтэй вэ? Үйлс 2:38-д иудейчүүдэд өгсөн Петрийн зөвлөгөө гардаг. Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолууд (заримдаа Христийн сургаал гэгддэг итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлгийг багтаадаг) нь Үйлс 2:37-47-д цэдэглэснээр эдгээр хөрвөгчид нөлөөлсөн.

Та аль хэдийн баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгээ хүлээн авсан байж болно. Иймээс Христийн сургаалыг хэрхэн үргэлжлүүлэн дагадаг вэ? Ахлагч Дэйл Г.Рэнландын хэлсэн дараах үгсийн талаар эргэцүүлэн бодоорой. “Бид [Христэд] итгэх итгэлээ хөгжүүлж, нүглээ наманчилж, баптисмын гэрээнүүд болоод адислалуудаа шинэчлэхийн тулд ариун ёслолоос хүртэж, Ариун Сүнсийг байнга мөнхийн хамтрагчаа болгон хүлээн авах зэргээр Христийн сургаалд . . . төгөлдөржинө. Бид эдгээрийг үйлдсэнээр Христтэй илүү адил болж, эцсээ хүртэл тэвчдэг” (“Хожмын үеийн гэгээнтнүүд шантралгүй хичээсээр байдаг,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 43).

Түүнчлэн 2 Нифай 31; 3 Нифай 11:31-41; 27; Брайн К.Аштоны хэлсэн “Христийн сургаал” хэмээх үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы 102-105-р хуудаснаас үзнэ үү.

ҮЙЛС 3:19-21

“Сэргээх цаг” ба “бүхнийг сэргээх үе” гэж юу вэ?

“Сэргээх цаг” гэж Есүс Христийн дэлхий дээр эргэн ирэх үе буюу Мянган жилийг хэлж байна. “Бүхнийг сэргээх үе” гэдэг нь сайн мэдээний Сэргээлтийг хэлж байгаа юм.

ҮЙЛС 3; 4:1-31; 5:12-42

Есүс Христийн шавь нарт Түүний нэр дээр гайхамшгуудыг үйлдэх хүч өгөгдсөн байдаг.

Хазгар хүн ариун сүмд ирсэн хүмүүсээс мөнгө авна хэмээн найдаж байв. Харин Их Эзэний шавь нар хамаагүй илүүг түүнд өгсөн. Та Үйлс 3; 4:1-31; 5:12-42-ыг уншихдаа гайхамшгууд дараах хүмүүст хэрхэн нөлөөлснийг тунгаан бодоорой.

Хазгар хүн _____

Тэргүүн тахилчид болон захирагчид _____

Петр, Иохан хоёр _____

Бусад гэгээнтэн _____

Ариун сүмд байсан гэрчүүд _____

Түүнчлэн “Peter and John Heal a Man Crippled Since Birth,” “Peter Preaches and Is Arrested” видео бичлэгүүдийг үзнэ үү (LDS.org).



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ҮЙЛС 2:37

Хэзээ бид хэн нэгнийг сайн мэдээг зааж байх үед “[бидний] зүрхийг хөндсөн” мэдрэмж мэдэрч байсан бэ? Энэ мэдрэмж нь ямар утгатай вэ? Ийм мэдрэмж мэдэрсэн үедээ “Бид одоо яах вэ?” хэмээн асуух нь яагаад чухал вэ?

ҮЙЛС 3:1-8

Ариун сүмд байсан эр хэрхэн бодож байснаасаа өөрөөр адислагдсан бэ? Бид Тэнгэрлэг Эцэгийн адислалууд хэрхэн төсөөлж байгаагүй арга замаар ирэхийг харж байсан бэ?

ҮЙЛС 3:12-26; 4:1-21; 5:12-42

Петр, Иохан нарын итгэлтэй байдлын юу нь танд гүнзгий сэтгэгдэл төрүүлж байна вэ? Бид Есүс Христийг гэрчлэхдээ хэрхэн зоримог байж чадах вэ?

ҮЙЛС 4:32-5:11

Танай гэр бүлд Ананиа, Сапфир нарын түүхийг энгийн өмсгөл, зоос ашиглан жүжигчлэн тоглох нь зугаатай санагдаж болох юм. Энэ түүхээс бид ямар сургамж авах вэ? Гэр бүлийнхнийхээ хэрэгцээнд тулгуурлан шударга байдлын тухай, Сүмийн удирдагчдыг дэмжин батлах эсвэл ариулан адислах тухай хэлэлцэж болно.

Заах чадвараа сайжруулах

Сэдэв сонго. Гэр бүлээрээ хамтдаа суралцах сэдвийг Үйлс 1-5-р бүлгээс гэр бүлийн гишүүдээр ээлжлэн сонгуул.



Виллиам Хэнри Маргэтсон, Их Эзэн дээш одсон нь



Сайм Ловлор. Бид тийн амьдрал

7-Р САРЫН 8-14

Үйлс 6–9

“Та надаар юу хийлгэмээр байна вэ?”

Үйлс 6–9-ийг уншсанаар эхэл. Энэхүү тойм дахь санаанууд нь танд эдгээр бүлэгт орших чухал зарчмуудыг тодорхойлоход туслах боломжтой ч та өөрөө судалж байхдаа бусад зарчмыг олж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Хөрвөгдөх шинжгүй хүн гэвэл Христийн шашинтнуудыг мөрдөн хавчдагаараа алдартай фарисай хүн болох Саул л байсан байж магадгүй. Их Эзэн Ананиа гэгдэх шавьдаа Саулыг эрж олоод, түүнд адислал өг гэхэд Ананиа эргэлзэж байсан нь ойлгомжтой байв. Тэрээр “Эзэн, би түүний тухай олон хүнээс, . . . Таны ариун хүмүүст тэр хичнээн их хор хүргэснийг сонссон” (Үйлс 9:13) хэмээв. Харин Их Эзэн “Тэр бол харь үндэстнүүд, хаад болон Израилийн хөвгүүдийн өмнө Миний нэрийг үүрэхийн

тулд Миний сонгогдсон сав” (Үйлс 9:15) хэмээн Саулын зүрх сэтгэл, чадамжийг мэдэж байсан бөгөөд Түүний санаанд Саулд зориулсан үүрэг даалгавар байсан. Тиймд Ананиа дуулгавартай даган, мөрдөн хавчигч байсан эрийг олоод, “Саул дүү минь” (Үйлс 9:17) хэмээн дууджээ. Хэрэв Саул бүрэн өөрчлөгдөж, Ананиа түүнийг чөлөөтэйгөөр угтан авч чадсан бол бид ч бас өөрчлөгдөх шинжгүй хэн нэгнийг, түүний дотор өөрийгөө авч үзэж болохгүй гэж үү?



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ҮЙЛС 6-8

Миний зүрх “Бурханы өмнө зөв” байх хэрэгтэй.

Сүм өсөж буй нь хаант улсад үйлчлэх шавь нарын хэрэгцээ өсөж байна гэсэн үг юм. Үйлс 6:1-15-д гарснаар арван хоёр төлөөлөгч ямар шинж чанартай хүмүүсийг хамт үйлчлэхээр хайж байсан бэ? Та Үйлс 6-8-ыг уншихдаа Стефан, Филип нар шиг хүмүүс эдгээр болон бусад шинж чанараа хэрхэн харуулж байсныг олж хар. Симонд юу дутагдаж байсан хийгээд өөрчлөгдөх хүслийн талаар түүнээс бид юу сурч болох вэ?

Зүрх сэтгэлээрээ “Бурханы өмнө зөв” байгаа гэдгээ баттай болгохын тулд танд өөрчлөхөөр сүнслэгээр өдөөгдөж байгаа ямар нэгэн зүйл байна уу? (Үйлс 8:21-22). Бурханд үйлчилж байхад тань энэхүү өөрчлөлт таныг хэрхэн адисалж болох вэ?

ҮЙЛС 6-7

Ариун Сүнсийг эсэргүүцэх нь Аврагчийг болон Түүний бошиглогчдыг үл тоомсорлоход хөтөлдөг.

Иудейчүүдийн захирагчид хүмүүсийг Мессиагийн ирэлтэд бэлтгэх үүрэгтэй атлаа бардам зан, эрх мэдэл эрэлхийлсний улмаас Есүс Христийг үл тоомсорлож, Түүнийг цовдлохыг шаардсан. Энэ нь хэрхэн тохиолдсон бэ? Стефан тэдэнд “та нар Ариун Сүнсийг үргэлж эсэргүүцдэг” (Үйлс 7:51) хэмээн тунхагласан. Та Ариун Сүнсийг эсэргүүцэх гэдгийг ямар утгатай гэж бодож байна вэ? Ариун Сүнсийг эсэргүүцэх нь яагаад Аврагчийг болон Түүний бошиглогчдыг үл тоомсорлоход хүргэдэг вэ?

Та Үйлс 6-7-г уншихдаа Стефаны иудейчүүдэд заасан бусад захиасыг олж уншаарай. Тэр ямар зан байдлын эсрэг сэрэмжлүүлсэн бэ? Та тиймэрхүү зан байдлыг өөрөөсөө олж хардаг уу? Стефаны үгс Ариун Сүнсийг эсэргүүцэхийн үр дагаврын талаар танд юу зааж байна вэ? Та амьдралдаа Ариун Сүнсний өдөөлтөд хэрхэн илүү мэдрэмжтэй, уриалгахан хариулж чадах вэ?

Мөн “Стефаныг хөнөөсөн нь” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

ҮЙЛС 7:54-60

Есүс Христийн тухай гэрчлэлийнхээ төлөө Стефанаас гадна хэн хэн хөнөөгдсөн бэ?

Стефаныг Есүс Христийг амилсны дараа хөнөөгдсөн анхны Христийн шашинтан хүн (итгэлийнхээ улмаас алагдсан хүн) гэж үздэг. Түүхэнд бусад олон гэгээн-тэн Есүс Христэд итгэх итгэлээ үгүйсгээгүйн улмаас хөнөөгдөж байсан. Эдгээрийн заримыг дараах судруудад дурдсан байдаг. Үүнд: Шастирын дэд 24:20-21; Марк 6:17-29; Үйлс 12:1-2; Илчлэлт 6:9-11; Мозая 17:20; Алма 14:8-11; Хиламан 13:24-26; Сургаал ба Гэрээ 109:47-49; 135:1-7; Абрахам 1:11. Аврагчийг амилсны дараа Иоханаас бусад шавь нь бүгд алуулсан байж магадгүй.

ҮЙЛС 8:26-39

Бусдыг Есүс Христ рүү удирдан чиглүүлэхэд Ариун Сүнс надад туслах болно.

Та Үйлс 8:26-39 дэх түүхээс сайн мэдээг хуваалцах талаар юу сурах вэ? Ариун Сүнс Филипт хэрхэн тусалсан бэ? Сайн мэдээг бусадтай хуваалцах нь хэрхэн удирдамж болдог вэ? (Үйлс 8:31-ийг үзнэ үү).

ҮЙЛС 9:1-31

Би Их Эзэний хүслийг дагахдаа Түүний мутар дахь зэмсэг болж чадна.

Саулын хөрвөлт гэнэтийн мэт санагддаг. Тэрээр Христийн шашинтнуудыг шоронд хорьдог байснаа “шууд л” синагогуудад Христийг тунхагладаг болсон (Үйлс 9:20). Та түүний түүхийг уншихдаа түүнийг яагаад өөрчлөгдөхөд тийм бэлэн байсан тухай тунгаан бодоорой. (Саулын хөрвөлтийнхөө тухай дүрслэн бичсэнийг Үйлс 22:1-16 болон 26:9-18-аас үзнэ үү. Эдгээр түүхэнд Саулын нэр Паул болон өөрчлөгдсөнийг анзаараарай.)

Ихэнх хүний хувьд хөрвөлт нь удаан хугацааны үйл явц байдаг учир Саулын туршлага ердийн биш нь үнэн. Үүний зэрэгцээ танд хөрвөлтийн талаар Саулаас суралцаж болох зүйл байна уу? Та Саулын хөрвөлтөд нөлөөлсөн Ананиа болон бусад шавийн

хандлагаас юу сурах вэ? Та эдгээр сургамжийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ? Та Саулын адил залбиралдаа “Та надаар юу хийлгэмээр байна вэ?” хэмээн асууснаар эхэлж болно. Эсвэл энэхүү асуулыг тэмдэглэлийнхээ гарчиг болгон бичээд, үе үе сэтгэгдлээ бичиж тэмдэглэж болно.

Түүнчлэн Дийтр Ф.Угдорфын хэлсэн “Дамаск орох зам дээр хүлээн сууна” хэмээх үгийг 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулганы 77-р хуудас; “Дамаск орох зам” (LDS.org, видео бичлэгүүд) зэргээс үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ҮЙЛС 6:8–7:60

Үйлс 6:8, Үйлс 7:51–60 дээрх Стефаны түүхийг Лук 23:1–46 дээрх Аврагчийн түүхтэй харьцуул. Стефан Аврагчийн үлгэр жишээг хэрхэн дагасан бэ?

ҮЙЛС 7:51–60

Ариун Сүнс Стефаныг хавчигдан мөрдөгдөж байхад нь хэрхэн адисалсан бэ? Бид хэзээ хүнд хэцүү цагт Ариун Сүнснээс хүчийг хүлээн авч байсан бэ?

ҮЙЛС 9:5

Танай гэр бүлийнхэн “шилбүүр өшиглөх” гэдэг үгийн утгыг мэдэх үү? *Шилбүүр* гэдэг нь амьтдыг туухдаа ашигладаг байсан жад юм. Амьтад шилбүүрдүүлэхдээ ихэвчлэн буцааж өшиглөдөг бөгөөд ингэхэд нь жад уг амьтны биед илүү гүн шигдэн ордог аж. Энэхүү зүйрлэл нь ямар замаар бидэнд хамааралтай байж болох вэ?



Фрэклэтон Гагон, Табита бос

ҮЙЛС 9:32–43

Гэр бүлийн гишүүдээс Үйлс 9:32–43 дээрх түүхийг зурахыг хүсэж болно. Тэд Айна, Табита, Иоппагийн бэлэвсэн эмэгтэйчүүдээс үнэнч шавь байх талаар юу сурах вэ? “Сайн үйлсээр баян” хүн бусдыг Их Эзэнд итгэхэд нь хэрхэн тусалж чадах вэ? (мөн Үйлс 9:36, 42; “Бүлэг 60, Петр Табитаг амьдралд эргүүлэн авчирсан нь” *Шинэ Гэрээний түүхүүд*, 156–157 эсвэл LDS.org дээрээс үүнтэй холбоотой видео бичлэг үзнэ үү).

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Судруудыг өөрийн амьдралтай адилтга. Та уншиж байхдаа судрууд дахь түүх, сургаалууд амьдралд тань хэрхэн хэрэгжиж байгаа талаар эргэцүүлэн бодоорой. Тухайлбал, та хэзээ сорилт бэрхшээл, хавчлага мөрдлөгтэй тулгарсан үедээ “Ариун Сүнсээр дүүрч” байсан бэ? (Үйлс 7:55).



Волтер Рэйн, Бурханы баруун гар талд зогсож байгаа Хүний Хүүг би харж байна



7-Р САРЫН 15-21

Үйлс 10–15

“Эзэний үг түгэн түгсээр байлаа”

Сүнсийг өөртөө бодол, мэдрэмжээр нөлөөлүүлэх цаг гарган, Үйлс 10–15-ыг анхааралтай унш. Эдгээр бүлэгт таны суралцаж болох зүйл юу байна вэ?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Мөнх бус амьдрал дахь тохинууллынх нь үед Есүс Христийн сургаал ихэвчлэн хүмүүсийн удаан хугацаанд дагаж ирсэн уламжлал, итгэлийг сорьж байсан бөгөөд Түүнийг тэнгэр өөд одсоны дараа ч зогсоогүй. Бүхний дараа Тэрээр илчлэлтээр дамжуулан Өөрийн сүмийг удирдсаар байсан. Тухайлбал, Есүсийг амьдарч байх үед Түүний шавь нар зөвхөн иудейчүүддээ сайн мэдээг номлож байсан. Харин Аврагчийг нас барсны дараахан Петр Сүмийн бошиглогч болж, Есүс Христ иудей биш хүмүүст сайн мэдээг номлох цаг болсныг Петрт илчилсэн. Сайн мэдээг харийнхантай хуваалцах санаа нь өнөө үед тийм ч гайхмаар зүйл биш юм. Тиймээс энэ түүхэнд бидэнд зориулсан ямар

сургамж байна вэ? Нэг нь эртний болон орчин үеийн Сүмийн аль алиных нь бодлого журам, уламжлалд орох өөрчлөлтүүд нь Их Эзэнээс Түүний сонгосон удирдагчдад илчлэлтээр ирдэг гэсэн сургамж байж болно (Амос 3:7; С ба Г 1:38). Тасралтгүй үргэлжлэх илчлэлт бол Есүс Христийн үнэн бөгөөд амьд Сүмийн гол онцлог юм. Бид Петрийн адил тасралтгүй үргэлжлэх илчлэлтийг хүлээн зөвшөөрөхөд мөн “[Түүний] илчилсэн бүгдэд, эдүгээ түүний илчилж буй бүгдэд” мөн “Тэрээр цаашид илчлэх” “Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг” (Итгэлийн тунхаг 1:9) багтаасан “Бурханы үг бүрээр” (Лук 4:4) амьдрахад бэлэн байх ёстой.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ҮЙЛС 10

“Бурхан бол нүүр тал хардаггүй.”

Иудейчүүд олон үеийн турш “Абрахамын үр удам” байх эсвэл Абрахамын шууд удам байх гэдэг нь Бурханд таалагдсан (сонгогдсон) хүн гэсэн утгатай гэдэгт итгэдэг байсан (Лук 3:8-ыг үзнэ үү). Бусад бүх хүн Бурханд таалагдаагүй, “цэвэр бус” харийнхан гэж тооцогддог байжээ. Үйлс 10-р бүлэгт Их Эзэн Петрт “Түүнд хэн таалагддаг” тухай юу заасан бэ? (Үйлс 10:35). Та энэ бүлгээс Корнел Их Эзэнд таалагдахуйц зөв шударга амьдралаар амьдарч байсан гэсэн ямар нотолгоог олох вэ? “Бурхан бол нүүр тал хардаггүй” (34-р шүлэг) буюу бүх хүн сайн мэдээний дагуу амьдарвал үүний адислалуудыг хүлээн авах боломжтой гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ? (1 Нифай 17:35-ыг үзнэ үү).

Иудейчүүд Абрахамын үр удам биш хүмүүсийг дорд үздэг байсны адил та өөрөөсөө өөр хэн нэгний талаар таагүй эсвэл буруу таамаглал гаргаж байгаага аанзаарч байсан уу? Та энэ байдлаа хэрхэн ялан дийлж чадах вэ? Хэдэн өдөр энгийн үйл ажиллагааг туршиж үзэх нь сонирхолтой байж болох юм. Та хэн нэгэнтэй харьцах бүрдээ “Энэ хүн бол Бурханы хүүхэд” хэмээн дотроо бодож үз. Ингэж байхдаа та бусадтай харилцах, тэдний тухай бодох байдалдаа ямар өөрчлөлтийг ажигласан бэ?

Түүнчлэн Д.Тодд Кристоффэрсоны “Миний хайр дотор бай” хэлсэн үгийг *2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы* 81–84-р хуудаснаас; 1 Самуел 16:7 мөн “Сайн мэдээг харийнханд хүргэх Петрийн илчлэлт” (LDS.org, видео бичлэгүүд) видео бичлэгийг үзнэ үү.

ҮЙЛС 10; 11:1–18; 15

Тэнгэрлэг Эцэг надад илчлэлтээр дамжуулан шат шатаар заадаг.

Петр Үйлс 10-т дүрслэгдсэн үзэгдлийг харахдаа эхлээд ойлгохгүй зовсон бөгөөд “[энэ нь] ямар утгатай болохыг ойлгож ядан байсан” (17-р шүлэг). Харин Петр ойлгохыг хичээхэд Их Эзэн түүнд илүү агуу ойлголтыг өгсөн. Та Үйлс 10, 11, 15-р бүлгүүдийг уншихдаа үзэгдлээ ойлгох Петрийн ойлголт цагаас цагт улам гүнзгийрч байсныг анзаараарай. Та асуух зүйл гарсан үедээ Бурханаас илүү агуу ойлголтыг хэрхэн эрэлхийлж, хүлээн авч байсан бэ?

Үйлс 10, 11, 15-д Их Эзэн илчлэлтээр дамжуулан үйлчлэгчдээ удирдаж байсан жишээнүүдийг өгүүлсэн байдаг. Эдгээр бүлгийг уншиж байхдаа илчлэлтийн тухай олсон зүйлсээ бичиж тэмдэглэх нь тустай байж болно. Сүнс тантай хэрхэн ярьдаг вэ?

Мөн Судруудын удирдамжаас “Илчлэлт”-ийг topics.lds.org-оос; Роналд А.Расбандын “Ариун Сүнс биднийг хөтөлдөг” хэлсэн үгийг *2017 оны 4-р сарын Ерөнхий чуулганы* 81–84-р хуудаснаас мөн “Иерусалимын чуулган” (LDS.org, видео бичлэгүүд) видео бичлэгийг үзнэ үү.

ҮЙЛС 11:26

Би Есүс Христэд итгэж, дагадаг учраас Христийн шашинтан юм.

Христийн шашинтан хэмээн дуудуулах нь ямар ач холбогдолтой вэ? (Үйлс 11:26-г үзнэ үү). Христийн шашинтан гэдгээр танигдах эсвэл Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авна гэдэг нь таны хувьд ямар

утга учиртай вэ? (С ба Г 20:77-г үзнэ үү). Нэрнүүдийн ач холбогдлыг эргэцүүлэн бод. Жишээлбэл, овог тань таны хувьд ямар утга учиртай вэ? Сүмийн нэр өнөө үед яагаад чухал вэ? (С ба Г 115:4-ийг үзнэ үү).

Түүнчлэн Мозая 5:7–15; Алма 46:13–15; 3 Нифай 27:3–8 болон М.Рассэлл Баллардын “Нэрний ач холбогдол” хэлсэн үгийг 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулганы 93–96-р хуудаснаас үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ҮЙЛС 10:17, 20

Бид сүнслэг туршлага олж авсан ч дараа нь сурсан эсвэл мэдэрсэн зүйлдээ эргэлзэж байсан уу? Бид эргэлзээгээ даван гарахад бидэнд туслах ямар зөвлөгөөг нэг нэгэндээ өгч болох вэ? (Роналд А. Расбандын “Та мартагчгүйн тулд” хэлсэн үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы 110–113-р хуудаснаас үзнэ үү.)

ҮЙЛС 12:1-17

Петрийг шоронд хоригдоход Сүмийн гишүүд цугларч, түүний төлөө залбирсан. Танай гэр бүл хэн нэгний төлөө залбирахад сүнслэгээр өдөөгдөж байна уу? Энэ нь Сүмийн аль нэг удирдагч эсвэл хайртай хүн тань байж болно. “Хичээнгүйлэн залбирна” гэдэг нь ямар утгатай вэ? (Үйлс 12:5).

ҮЙЛС 14

Та нарыг энэ бүлгийг хамтдаа унших явцад гэр бүлийн зарим гишүүн шавь нарт болон Сүмд ирсэн адислалуудыг, бусад гишүүн шавь нарт тулгарсан эсэргүүцэл, сорилт бэрхшээлүүдийг тэмдэглэж болно. Яагаад Бурхан зөв шударга хүмүүст хүнд хэцүү зүйл тохиолдохыг зөвшөөрдөг вэ?

ҮЙЛС 15:1-21

Эдгээр шүлэгт харийн (иудей биш) хөрвөгчид гэрээний нэг тэмдэг болгон, хөвч хөндүүлэх шаардлагатай эсэх талаарх Сүмд үүссэн маргааныг дүрсэлсэн байдаг. Төлөөлөгчдийг энэ сэдвийн талаар хэлэлцэхээр цуглан, сүнслэг нөлөө бүхий хариулт хүлээн авсны дараа уг маргаан шийдэгдсэн. Энэ нь уг хэв маяг одоо ч хэвээрээ гэдгийг гэр бүлийнхэндээ заах тохиромжтой цаг байж болно. Гэр бүлээрээ хамтдаа хариултыг нь олохыг хүсэж байгаа сайн мэдээний асуултыг сонго. Судрууд, хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн сургаалаас ойлголтуудыг хамтдаа хай. (Судруудын удирдамж болон чуулганы үгсийг нийтэлсэн Сүмийн сэтгүүлүүд дээрх сэдэвчилсэн гарчиг тус болж болно.)

Заах чадвараа сайжруулах

Зураг зур. Зургууд нь гэр бүлийн гишүүдэд судрын сургаал, түүхүүдийг төсөөлөн бодоход тус болох боломжтой. Та хэдэн шүлэг уншсаны дараа гэр бүлийнхээ гишүүдэд таны уншсан зүйлтэй холбоотой ямар нэгэн зүйл зурах цаг гарга. Жишээлбэл, гэр бүлийнхэнд тань Үйлс 10-т гардаг Петрийн үзэгдлийг зурах нь зугаатай байж болох юм.



Зуутын дарга Корнелийн Петртэй уулзах гайхамшигт үзэгдэл болон аялал нь "Бурхан бол нүүр тал хардаггүй" (Үйлс 10:34) гэдгийг харуулдаг.



7-Р САРЫН 22-28

Үйлс 16–21

“Бурхан биднийг сайн мэдээг тунхагла гэж дуудлаа”

Таныг сайн мэдээг номлох Паулын хичээл зүтгэлийн талаар унших үед Сүнс танд бодол, мэдрэмжүүдээр нөлөөлж болно. Эдгээр нөлөөллийг бичиж тэмдэглээд, үйлдэл болгон хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Их Эзэний төлөөлөгчдөдөө хандан хэлсэн эцсийн үгс дунд “Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа” (Матай 28:19–20) хэмээх зарлиг байсан. Төлөөлөгчид бүх үндэстэнд хүрч чадаагүй ч Үйлс 16–21-д Паул болон түүний хамтрагчид Сүмийг зохион байгуулахад томоохон ахиц гаргасныг харуулдаг. Тэд зааж, баптисм хүртээн, Ариун Сүнсний бэлгийг өгсөн. Тэд гайхамшгуудыг үйлдэж, бүр үхсэн хүнийг хүртэл амилуулж, агуу урвалтыг урьдчилан хэлсэн (Үйлс 20:7–12; 20:28–31).

Тэдний эхлүүлсэн ажлыг Паулын хэзээ ч төсөөлж чадахааргүй арга замаар Аврагчийн даалгаврыг биелүүлэхэд тусалж байгаа амьд төлөөлөгчид болон таны адил үнэнч шавь нар өнөөдөр үргэлжлүүлж байгаа. Та магадгүй Тэнгэрлэг Эцэгийг эсвэл Түүний сайн мэдээг мэдэхгүй хүмүүсийг таних байх. Та Түүний тухай мэддэг зүйлсээ тэдэнд хуваалцахаар “сүнсээрээ эгдүүцэн” байсан байж магадгүй (Үйлс 17:16). Хэрэв та сайн мэдээг хуваалцахдаа Паулын даруу байдал, зоримог зангийн жишээг дагавал “Эзэн зүрхийг [нь] нээсэн” (Үйлс 16:14) хэн нэгнийг олж болох юм.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ҮЙЛС 16–21

Сүнс намайг сайн мэдээг хуваалцах хичээл зүтгэлд минь удирдан чиглүүлнэ.

Хүн бүрд Есүс Христийн сайн мэдээ хэрэгтэй ч зарим хүн хүлээн авахдаа бусдаас илүү бэлтгэгдсэн байдаг. Сайн мэдээг хуваалцахад бэлэн байгаа хүмүүс рүү биднийг удирдан чиглүүлэхэд Ариун Сүнс хэрэгтэй байдгийн нэг шалтгаан нь энэ юм. Та Үйлс 16–21-ийг уншихдаа Паулыг болон түүний хамтрагчдыг Сүнс удирдан чиглүүлсэн жишээнүүдийг анзаараарай. Тэдэнд Сүнсийг дагасны ачаар ямар ямар адислал ирсэн бэ? Та хэзээ сайн мэдээг хуваалцах хичээл зүтгэлдээ Сүнсний өдөөлтийг мэдэрч байсан бэ?

Түүнчлэн Алма 7:17–20; Даллин Х.Өүксийн “Сэргээгдсэн сайн мэдээг хуваалцах нь” хэлсэн үгийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганы 48–52-р хуудаснаас; Миний сайн мэдээг номло номын 102–103-р хуудаснаас үзнэ үү.

ҮЙЛС 16–21

Би бүхий л нөхцөл байдалд сайн мэдээг тунхаглаж чадна.

Сайн мэдээг номлосныхоо улмаас шоронд хаягдах нь номлохоо болих хүндэтгэх шалтгаан мэт санагдаж байж болно. Харин Паул, Силас нарын хувьд энэ нь шоронд хоригдож буй хүмүүсийг хөрвүүлэх боломж болсон юм (Үйлс 16:16–34-ийг үзнэ үү). Үйлс 16–21-ээс хүн бүртэй гэрчлэлээ хуваалцах гэсэн Паулын хүслийн бусад жишээг олоорой. Тэр яагаад тийм эрэлхэг, зоригтой байсан гэж та бодож байна вэ? Та Паулын үлгэр жишээнээс юу сурах вэ?

16–21-р бүлэгт сайн мэдээг хуваалцах тухай олон захиас бий. Хэрэв та анхааралтай судалбал, ялангуяа танд тохиромжтой байж болох зарим жишээг олох боломжтой. Энэхүү зорилгыг дотроо бодон, эдгээр бүлгийг уншихыг хичээ. Та юу олсон бэ?

ҮЙЛС 17:16–34

“Бид Бурханы үр удам”

Афинд байхдаа Паул өөр өөр үзэл бодол, шашны итгэл үнэмшилтэй хүмүүсийг олсон. Тэд үргэлж “шинэ зүйл сонсохыг” эрэлхийлж байсан ба Паулын санал болгох зүйл нь тэдний хувьд яах аргагүй шинэ байв (Үйлс 17:19–21-ийг үзнэ үү). Тэд олон бурхныг шүтэж байсан бөгөөд тэдгээрийн дотор “үл мэдэгдэх бурхан” (Үйлс 17:23) гэж дуудагдах нэгэн ч байсан. Гэвч тэд бурхад бол сүр хүч эсвэл хүч чадал мөн бөгөөд харин амьд, биет хүн, тэр дундаа бидний Эцэг биш хэмээн итгэдэг байлаа. Паулын хэлсэн Бурханыг мэдэж авахад туслах зүйлсийг уншаад, Бурханы зан чанарын талаар олсон зүйлсээ тэмдэглэ. “Бурханы үр удам” байна гэдэг нь таны хувьд юу гэсэн үг вэ? (Үйлс 17:29). Таны бодлоор Бурханы хүүхэд байна гэдэг нь зөвхөн Түүний бүтээлүүдийн нэг байхаас юугаараа ялгаатай вэ? Хэрэв та Паулыг гэрчилж байх үед хажууд нь зогсож байсан бол бидний Тэнгэрлэг Эцэгийн тухай эртний грекчүүдэд юу гэж хэлэх байсан бэ? Таны гэрчлэлийг сонсоод тус дэм авах хэн нэгнийг та нар таних уу?

Түүнчлэн Ром 8:16; 1 Иохан 5:2; “Бид Бурханы үр удам” (LDS.org, видео) видео бичлэгийг үзнэ үү.



Лиз Лэммон Свиндл, Бодгалийн үнэ цэн



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ҮЙЛС 16-21

Эдгээр бүлэгт юу болж байгааг төсөөлөн бодоход нь гэр бүлдээ туслахын тулд хамт уншихдаа Паулын очсон хотуудыг газрын зураг дээр тэмдэглэх нь сонирхолтой байж болох юм (энэхүү тоймын төгсгөл дэх газрын зургийг харна уу).

ҮЙЛС 17:11; 18:24-28

Бид хэрхэн эдгээр судар дээрх гэгээнтнүүдтэй адил байж чадах вэ? Судруудаас өдөр бүр суралцах нь биднийг хэрхэн илүү “уужим сэтгэлтэй” болгох вэ? (Үйлс 17:11). Бид “судрыг сайн мэддэг” болохын тулд юу хийж чадах вэ? (Үйлс 18:24).

ҮЙЛС 19:1-7

Бошиглогч Иосеф Смитийн заасан эдгээр сургаал Үйлс 19:1-7-г судлахад танай гэр бүлд тус болох юм. “Усаар гүйцэтгэдэг баптисм нь хагас баптисм бөгөөд нөгөө хагас нь болох Ариун Сүнсний

баптисмгүйгээр хий, хоосон зүйл болох юм. . . . ‘Ус болон Сүнснээс төрнө’ гэдэг нь нүглээс ангижрахын төлөө усанд умбуулж, дараа нь Ариун Сүнсний бэлэг хүлээж авна гэсэн утгатай. Энэ нь Бурханаас эрх мэдэл олгогдсон хэн нэгний гар тавилтаар өгөгддөг” (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*, 110–111). Ариун Сүнсний бэлэг хүлээн авснаар бидэнд ямар ямар адислал ирсэн бэ?

ҮЙЛС 19:13-20

Эдгээр шүлэгт гардаг хүмүүст “тавин мянган мөнгөн зоосны” үнэтэй номнуудаа шатаахад юу нөлөөлсөн бэ? (Үйлс 19:19). Тэнгэрлэг адислалуудыг хүлээн авахын тулд бидний орхих хэрэгтэй дэлхийн эд хөрөнгө эсвэл үйл ажиллагаа бий юү?

ҮЙЛС 20:32-35

Хэзээ танай гэр бүл “авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” хэмээх Христийн сургаалыг туршлагаараа мэдэж авсан бэ? (Үйлс 20:35). Танай гэр бүлийн өгч болох үйлчлэл, цаг зав, бэлэгнээс тус дэм авч болох хэн нэгэн байгаа юу? Гэр бүлээрээ хэн нэгэнд үйлчлэх санаануудыг хэлэлцэж, төлөвлөгөө гарга. Бид бусдад үйлчлэх үедээ юу мэдэрдэг вэ? Яагаад авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ. Ямар нэгэн сэтгэгдэл юм уу гүн ойлголт төрөхөд бичиж тэмдэглэ. Тухайлбал, та бодож байгаагаа судрынхаа зайд, Gospel Library аппликэйшнд эсвэл судлах тэмдэглэлдээ бичиж тэмдэглэж болно. “Та сүнслэг сэтгэгдлээ бичиж тэмдэглэснээр Их Эзэний удирдамжийг үнэлдэг гэдгээ Түүнд харуулахаас гадна, Тэр танд илчлэлтийг илүү ойр ойрхон өгч адислах болно” (*Аврагчийн арга барилаар заах нь*, 12 мөн 30-ийг үзнэ үү).



Төлөөлөгч Паулын номлолын аяллууд



7-Р САРЫН 29-ӨӨС 8-Р САРЫН 4

Үйлс 22–28

“Гэрч, үйлчлэгч”

Ариун Сүнсний өдөөлтүүд нь ихэвчлэн намуухан, заримдаа агшин зуурынх байдаг. Төрсөн сэтгэгдэл, өдөөлтүүдээ бичиж тэмдэглэх нь тэдгээрийг илүү гүнзгий тунгаан бодох боломжийг танд олгоно. Та Үйлс 22–28-ыг уншихдаа өөрт төрсөн санаа бодол, мэдрэмжийг бичиж аваад, тунгаан бодох цаг гарга.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бид Их Эзэний ажлыг гүйцэтгэх үед, Их Эзэний туслалцааг авах эрхтэй” хэмээн амласан (“Сурах, хийх, байх,” 2008 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 74–75). Гэсэн ч бид дардан зам, тасралтгүй урсан ирэх амжилтын эзэн байх эрх ямбатай гэсэн үг биш юм. Үүний нотолгоог олъё гэвэл бид төлөөлөгч Паул руу харахад л хангалттай. Түүний хийх ёстой Аврагчийн ажил бол “харь үндэстнүүд, хаад болон Израилийн хөвгүүдийн өмнө Миний нэрийг үүрэх” (Үйлс 9:15) явдал байсан. Үйлс 22–28-р бүлгээс бид Паул энэхүү ажлыг гүйцэлдүүлж байсан бөгөөд

гинжлүүлж, шоронд хоригдон, бие махбодын хүчирхийлэл, хөлөг онгоцны осол, бүр могойн дайралтад өртөх зэрэг агуу их сөргөлдөөнтэй тулгарч байсныг хардаг. Гэвч бид Есүс “Паулын дэргэд зогсон, —Зоригтой байгтун” (Үйлс 23:11) хэмээснийг түүнчлэн хардаг. Паулын туршлагауд нь Их Эзэний үйлчлэгчдийг “явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун” хэмээх Түүний дуудлагыг хүлээн авах үед тэдэнд өгсөн “Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:19–20) гэсэн амлалтаа Тэрээр биелүүлэх болно хэмээх сүнслэг өдөөлт бүхий сануулга болдог.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ҮЙЛС 22:1-21; 26:1-29

Есүс Христийн шавь нар гэрчлэлээ зоригтой хуваалцдаг.

Паул Үйлс 22, 26-р бүлгүүдэд цэдэглэгдсэн хүчирхэг гэрчлэлүүдээ хүргэхдээ Ромын цэргүүдэд баригдан, хоригдсон байсан. Түүний ярьсан хүмүүс түүнд үхлийн ял оноох хүчтэй байсан. Гэвч тэрээр Есүс Христийн тухай болон өөрийн хүлээж авсан “тэнгэрлэг үзэгдлийг” (Үйлс 26:19) зоригтой гэрчлэхийг сонгосон. Түүний үгсийн юу нь танд сүнслэгээр нөлөөлдөг вэ? Гэрчлэлээ хуваалцах ямар ямар боломж танд байгааг эргэцүүлэн бод. Тухайлбал, та сайн мэдээний талаарх гэрчлэлээ хэрхэн олж авсан тухайгаа гэр бүлийнхэн эсвэл бусадтай хэзээ хамгийн сүүлд хуваалцсан бэ?

ҮЙЛС 22:1-21; 26:9-20

Есүс Христийн талаарх Паулын үзэгдлийн гурван түүх яагаад хоорондоо ялгаатай байна вэ?

Үйлсийн номонд Дамаск орох зам дээр Паулын үзсэн үзэгдлийн тухай гурван түүх гардаг (Үйлс 9:3-20; 22:1-21; 26:9-20-ийг үзнэ үү). Түүх бүр хоорондоо бага зэргийн ялгаатай бөгөөд зарим нь бусдаасаа илүү нарийн тодорхой мэдээлэл агуулдаг. Түүхүүд нь өөр өөр хүмүүст өөр өөр зорилгоор хэлэгдсэн учраас Паул сонсогч бүрд туршлагынхаа ялгаатай хэсгүүдийг онцлон тодруулахаар сонгосон байх боломжтой.

Үүний адил Иосеф Смит Анхны үзэгдлийнхээ түүхийг хэд хэдэн удаа бичсэн байдаг (“First Vision Accounts,” Gospel Topics, topics.lds.org-ыг үзнэ үү). Олон төрлийн түүх өөр өөр хүмүүст янз бүрийн зорилгоор өгөгдсөн бөгөөд ганц түүх бичигдсэн байсан тохиолдолд тодорхойгүй байх байсан гүн ойлголтуудыг агуулдаг.

ҮЙЛС 23:10-11; 27:13-25, 40-44

Их Эзэн Өөрт нь үйлчлэхийг хичээдэг хүмүүстэй хамт зогсдог.

Паулын үйлчлэл нь амьдралын маань хүнд хэцүү бэрхшээлүүд бидний хийж байгаа ажлыг Бурхан буруушааж байгаагийн тэмдэг биш гэдгийг

тодорхой харуулдаг. Үнэн хэрэгтээ, бид заримдаа Түүний дэмжлэгийг хэцүү бэрхшээлтэй үедээ хамгийн их мэддэг. Хамгийн сүүлд Паулын хийсэн үйлчлэлийн талаар уншсан зүйлсээ эргэцүүлэн дүгнэж, түүний тэвчсэн зарим зүйлийг жагсаан бичих нь сонирхолтой байж болох юм (жишээ нь, Үйлс 14:19-20; 16:19-27; 21:31-34; 23:10-11; 27:13-25, 40-44-ийг үзнэ үү). Их Эзэн хэрхэн түүнтэй хамт зогссон бэ? Энэ нь Их Эзэний үйлчлэл дэх таны хичээл зүтгэлийн талаар юу зааж байна вэ?

ҮЙЛС 24:24-27; 26:1-3, 24-29; 27

Би Бурханы үйлчлэгчдийн үгсийг хүлээж авах эсвэл эсэргүүцэхийг сонгож болно.

Паул үйлчлэлийнхээ туршид Есүс Христ, Түүний сайн мэдээний талаар хүчирхэг гэрчлэлээ хуваалцсан. Олон хүн түүний гэрчлэлийг хүлээн авсан ч зарим хүн хүлээж аваагүй. Та Үйлс 24:24-27, Үйлс 26:1-3, 24-29-ийг уншихдаа Иуда дахь Ромын дараах захирагчид Паулын заасан зүйлсэд хэрхэн хандсаныг үзүүлсэн үг, хэллэгүүдийг бичиж тэмдэглэ.

Феликс _____

Фест _____

Агрипп хаан _____

Паул Цезариар соригдохоор Ром руу аялж байхдаа усан онгоцонд болон зорчигчдод “том гарз учрах” (Үйлс 27:10) болно хэмээн бошиглосон. Паулын сэрэмжлүүлгийг түүнтэй хамт явж байсан хүмүүс хэрхэн хүлээн авсан тухай 27-р бүлгээс олж уншина уу. Та тэдний туршлагаас өөртөө тохирох ямар нэгэн сургамж олсон уу?

Та Сүмийн удирдагчдын сургаалыг сонсоод, энэ хүмүүсийн хэн нэгнийхтэй нь адил үйлдэл гаргаж байсан уу? Иймэрхүү хариу үйлдлийн үр дагавар юу байж болох вэ? Та эдгээр түүхээс үйлчлэгчдээрээ дамжуулан өгдөг Их Эзэний зөвлөгөөг анхааран сонсох тухай юу сурч болох вэ?

Түүнчлэн 2 Нифай 33:1-2; Иосеф Смит—Түүх 1:24-25; Д.Тодд Кристоффэрсоны “Сэрэмжлүүлгийн дуу хоолой” хэлсэн үгийг 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулганы 97-101-р хуудаснаас үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ҮЙЛС 24:16

Паул хөрвөгдөхөөсөө өмнө Бурханы өмнө үйлдсэн зөрчлийн урт түүхтэй байсан. Гэвч тэр наманчлах хүсэлтэй байсан учраас “Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө хүний мөсөөр гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ” хэмээн хэлэх боломжтой болсон (мөн С ба Г 135:4-ийг үзнэ үү). Бид Бурхан болон хүмүүсийн өмнө үйлдсэн гэм буруугийн зовнилоосоо хэрхэн ангижрах вэ?

ҮЙЛС 26:16-18

Эдгээр шүлэгт Их Эзэн Паулаар юу хийлгэхээр дуудсан бэ? Иймэрхүү зүйл хийх ямар ямар боломж бидэнд байгаа вэ?

ҮЙЛС 28:1-9

Танай гэр бүлээс хэн нэг нь могойнд дуртай юу? Та тэр хүнээс эсвэл гэр бүлийн өөр нэг гишүүнээс Үйлс 28:1-9-д гардаг түүхүүдийг ярьж өгөхийг хүсэж болно. Танай хүүхдүүдийн хувьд эдгээр түүхийн талаар зураг зурах эсвэл жүжигчлэн үзүүлэх нь зугаатай байж болох юм. Бид эдгээр түүхээс ямар сургамж авч болох вэ? Нэг нь Их Эзэн үйлчлэгчдэдээ өгсөн

амлалтуудаа биелүүлдэг гэсэн сургамж байж болно. Жишээ нь, та Марк 16:18-д өгөгдсөн амлалтуудыг Паулын туршлагаудад хэрхэн биеллээ олсонтой харьцуулж болно. Мөн та сүүлийн үеийн Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс Их Эзэний үйлчлэгчдийн амласан, гэр бүлийн тань хувьд утга учир бүхий амлалтуудын нэгийг олж, гэртээ байрлуулж болно. Бид энэхүү амлалт биелэх болно гэдэгт итгэх итгэлээ хэрхэн харуулж чадах вэ?



Хортой могой Паулыг хазахад Бурхан түүнийг хамгаалсан.

ҮЙЛС 28:22-24

Паулын үеийн Сүмийн адил (22-р шүлэгт бүлэглэл гэж нэрлэсэн) өнөөгийн Сүмийг ихэвчлэн “эсэргүүцэн ярьдаг”. Хүмүүс Аврагчийг болон Түүний Сүмийг эсэргүүцэн ярихад Паул хэрхэн хариу өгсөн бэ? Бид Паулын туршлагаас юу сурч болох вэ?

Заах чадвараа сайжруулах

Гэр бүлийг тань адислах зарчмууд дээр анхаарлаа төвлөрүүл. Та судраас судлахдаа “Манай гэр бүлд чухал ач холбогдолтой байж болох юуг би эндээс олж болох вэ?” хэмээн өөрөөсөө асууж бай. (Аврагчийн арга барилаар заах нь, 17-р хуудсыг үзнэ үү.)



Даниал А.Луис. Есус Христийн тухай гэрчлэлд нэн хүчтэй байх нь Паул Азрийл хааны өмнө



8-Р САРЫН 5-11

Ром 1–6

“Авралд хүргэх Бурханы хүч”

Сүнслэг өдөөлтүүдээ бичиж тэмдэглэх нь танд Сүнсний зааж буй зүйлийг санахад тусална. Эдгээр сүнслэг өдөөлт нь танд Аврагчийн талаар юуг мэдрүүлдэг вэ?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Паулыг иудей болон харийнхнаас бүрдсэн өөр төрлийн бүлэг болох Ромын Сүмийн гишүүдэд хандан захидал бичих үед Есүс Христийн Сүм Галилын итгэгчдийн жижигхэн бүлгээс хамаагүй илүү өргөжин тэлсэн байсан. Аврагчийг амилснаас хойш 20-оод жилийн дараа төлөөлөгчдийн очих боломжтой бараг бүх газарт Христийн шашинтнуудын цуглаан

байдаг байв. Тэдний дунд агуу хаант улсын нийслэл Ром байлаа. Паулын хандаж бичсэн захидлын эзэд Ромын гэгээнтнүүд байсан ч түүний захидал нийтлэг бөгөөд өнөөдөр бид бүгдийг хамардаг буюу “Сайн мэдээ . . . нь итгэгч хүн бүрийг, . . . авралд хүргэх Бурханы хүч мөн” (Ром 1:16, налуу бичилт нэмэгдсэн).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

РОМ-ФИЛЕМОН

Захидлууд гэж юу вэ? Тэдгээр нь хэрхэн бүрэлдсэн бэ?

Захидлууд нь дэлхийн өөр өөр хэсэгт байгаа гэгээнтнүүдэд зориулан Сүмийн удирдагчдын бичсэн захиа юм. Төлөөлөгч Паул Ромоос эхлээд Филемон хүртэлх Шинэ Гэрээн дэх ихэнх захидлыг бичсэн. Түүний захидлууд хэмжээгээрээ бүрэлдсэн. Ром бол Шинэ Гэрээн дэх хамгийн эхний захидал боловч үнэндээ Паулын номлолын төгсгөл үед бичигдсэн юм. Захидлуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын удирдамжийн “Паулын захидлууд”-аас үзнэ үү.

РОМ 1-6

Би зарлигуудыг нь сахиснаар Аврагчид итгэдэг гэдгээ харуулахдаа Түүний ач ивээлээр зөвтгөгддөг.

Дараах тодорхойлолтууд ромчуудад бичсэн захидлыг илүү сайн ойлгоход танд тусалж болно.

Хууль: Паул “хууль” хэмээн бичсэн нь Мосегийн хуулийг хэлж байгаа. Үүний адил Паулын бичээс дэх “үйлс” хэмээх үг нь Мосегийн хуулийн ёслолууд, зан үйлийг илэрхийлдэг. Паул энэхүү хуулийг “итгэлийн хуультай” (Ром 3:27–31-ийг үзнэ үү) буюу бидний авралын жинхэнэ эх сурвалж болох Есүс Христийн сургаалтай харьцуулсан.

Хөвч хөндүүлэх, хөвч хөндүүлээгүй байх Эрт үед хөвч хөндүүлэх нь Абрахамтай хийсэн Бурханы гэрээний бэлгэ тэмдэг буюу бэлгэдэл байсан. Паул “хөвч хөндүүлсэн” гэх хэллэгээр иудейчүүдийг (гэрээт хүмүүс), “хөвч хөндүүлээгүй” гэдгээр харийнхныг (Абрахамын гэрээний бус хүмүүс) илэрхийлж байсан. Хөвч хөндүүлэх ёслол нь Бурханы Өөрийн хүмүүстэй хийсэн гэрээний шаардлагатай бэлгэ тэмдэг байхаа больсон (Үйлс 15:23–29-ийг үзнэ үү).

Зөвтгөл, зөвтгөх, зөвтгөгдсөн: Эдгээр хэллэг нь нүглийн ангижрал буюу өршөөлийг хэлж байна. Бид зөвтгөгдсөн үедээ өршөөгдөж, гэм зэмгүй гэгдэж, нүглүүдийнхээ шийтгэлээс үүрд чөлөөлөгддөг.

Паулын тайлбарласнаар энэ нь Есүс Христээр дамжуулан боломжтой болсон (Судруудын удирдамж, “Зөвтгөл, зөвтгөх,” scriptures.lds.org-ийг үзнэ үү; түүнчлэн D. Todd Christofferson, “Justification and Sanctification,” *Ensign*, June 2001, 18–25-ыг үзнэ үү). Ром номонд гардаг зөв болон зөвт байдал хэмээх үгсийг *шударга*, *зөвтгөл* гэсэн үгстэй адил утгатай гэж үзэж болно.

Ач ивээл: Ач ивээл гэдэг нь “бурханлиг тусламж буюу хүч, Есүс Христийн өгөөмөр нигүүлсэл хийгээд хайраар дамжин өгөгддөг.” Ач ивээлээр дамжуулан бүх хүн амилуулагдаж, үхэшгүй байдлыг хүлээн авах болно. Үүнээс гадна, “ач ивээл нь чадах бүхнээ хийсний эцэст мөнх амьдрал, өргөмжлөлийг хүлээж авах боломжийг эрэгтэй, эмэгтэй хүмүүст олгодог хүч юм.” Бид өөрсдийн хичээл зүтгэлээр ач ивээлийг олж авдаггүй, харин ач ивээл нь бидэнд “сайн үйлийг хийх хүч хийгээд тусламжийг өгдөг бөгөөд өөрөөр [бид] тийн үйлдэх боломжгүй юм” (Судруудын Удирдамж, “Ач ивээл”; түүнчлэн Дийтр Ф. Угдорф, “Ач ивээлийн бэлэг,” 2015 оны 4-р сарын *Ерөнхий чуулган*, 95–99; 2 Нифай 25:23).

РОМ 2:17-29

Миний гаднах үйлдэл дотоод хөрвөлтийн тусгал мөн хүчирхэгжүүлэгч байх ёстой.

Паулын сургаал Ром дахь зарим иудей Христийн шашинтны Мосегийн хуулийн зан үйл, ёслолыг дуулгавартай дагах нь аврал авчирдаг гэдэгт итгэсэн хэвээр байсныг харуулдаг. Бид Мосегийн хуулийн дагуу амьдардаггүй болохоор энэ нь хэрэгсэхгүй асуудал мэт санагдаж болох юм. Харин та Паулын бичээс буюу ялангуяа Ром 2:17–29-ийг уншихдаа сайн мэдээний дагуу амьдрах хичээл зүтгэлийнхээ талаар бодоорой. Ариун ёслолоос хүртэх, ариун сүмд орох зэрэг таны гадаад үйлдэл таныг хөрвөлт рүү хөтөлж, Христэд итгэх итгэлийг тань хүчирхэгжүүлж байна уу? (Алма 25:15–16-г үзнэ үү). Таны гадаад үйлдэл зүрх сэтгэлийг тань өөрчлөхөд хүргэж байгаа эсэхийг хэрхэн батлах вэ?

Мөн Даллин Х.Өүкс, “The Challenge to Become,” *Ensign*, 2000 оны 11-р сар, 32–34-ийг үзнэ үү.

РОМ 3:10-31; 5**Есүс Христээр дамжин би нүглүүдээсээ өршөөгдөж чадна.**

Зарим хүн Паулын “Зөвт хүн алга. Ганц ч алга” (Ром 3:10) хэмээх зоримог тунхаглалаас болж сэтгэлээр унаж магадгүй. Гэвч Ром номонд найдвар агуулсан захиасууд ч бий. Тэдгээрийг 3, 5-р бүлгээс хайж, “Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй” (Ром 3:23) гэдгийг санах нь яагаад Есүс Христээр дамжуулан “найдварт баярлаж” сурахад чухал алхам болдгийг эргэцүүлэн бод (Ром 5:2).

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

РОМ 1:16-17

Бид “Христийн сайн мэдээнээс ичихгүй” гэдгээ хэрхэн харуулж чадах вэ?

РОМ 3:23-28

Зарим хүн бид “зөвхөн [Бурханы] нигүүлслээр зөвтгөгдсөн” (Joseph Smith Translation, Romans 3:24 [in Romans 3:24, footnote a]) учраас нигүүлслийг хүлээн авах шаардлага бидэнд байхгүй гэж хэлж магадгүй. Хэдийгээр бид Бурханы нигүүлслийг “олж авахад” хангалттай ихийг хэзээ ч хийж чадахгүй ч Бурхан үүнийг хүлээж авахын тулд тодорхой зүйлсийг

РОМ 6.**Есүс Христийн сайн мэдээ намайг “шинэ амийн дотор явахад” урьдаг.**

Паул сайн мэдээ бидний амьдралын хэв маягийг өөрчлөх ёстой хэмээн заасан. Та сайн мэдээ “шинэ амийн дотор явахад” тань хэрхэн тусалсныг ойлгоход нь хэн нэгэнд туслахын тулд Ром 6 дээрх ямар мэдэгдлийг ашиглах вэ? (4-р шүлэг). Та ямар ямар хувийн туршлагаасаа хуваалцах вэ?

хийхийг биднээс хүсдэг. Бид нигүүлслийг хүлээж авахын тулд юу хийж болох вэ?

РОМ 5:3-5

Бид ямар ямар зовлонтой учирсан бэ? Тэдгээр зовлон бидэнд тэвчээр, туршлага, найдвараа хөгжүүлэхэд хэрхэн тусалсан бэ?

РОМ 6:3-6

Паул эдгээр шүлэгт баптисмын бэлгэдлийн талаар юу заасан бэ? Танай гэр бүл удахгүй болох баптисмын үйл ажиллагаанд оролцох төлөвлөгөө гаргаж болох юм. Эсвэл танай гэр бүлийн хэн нэг нь өөрийнхөө баптисмын зураг юм уу дурсамжаас хуваалцаж болно. Баптисмын гэрээ байгуулж, сахих нь “шинэ амийн дотор явахад” бидэнд хэрхэн туслах вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Суралцаж байхдаа асуулт тавь. Таныг судруудаас суралцаж байхад оюун бодолд тань асуултууд орж ирж болно. Эдгээр асуултыг тунгаан бодож, хариултыг нь эрж хай. Жишээлбэл, та Ром 1-6-аас “Нигүүлсэл гэж юу вэ?” гэсэн асуултын хариултыг эрж хайж болно.



Грэг К.Олсен, Бүү ай



8-Р САРЫН 12-18

Ром 7–16

“Бузар мууг сайнаар дийлэгтүн”

Ром 7–16 дахь сайн мэдээний зарчмуудаас зөвхөн цөөн хэд нь энэхүү тоймд багтсан учраас энд гарсан зүйлсээр өөрийгөө бүү хязгаарла. Сурч байхдаа хүлээж авсан сүнслэг өдөөлтүүдээ анхаарлаа хандуул.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Паул ромчуудад хандан бичсэн захидлаа эхлүүлэхдээ “ариун хүмүүс байхаар дуудагдсан” “Бурханы хайртай” хүмүүс хэмээн Ром дахь Сүмийн гишүүдтэй мэндчилсэн. Тэрээр тэдний “итгэл бүх ертөнц даяар тунхаглагдаж [байсан]” хэмээн онцолсон (Ром 1:7–8). Хэдийгээр Паул захидлынхаа ихэнхийг хуурамч үзлүүд, алдаа дутагдалтай зан байдлуудыг засахад зарцуулсан ч эдгээр шинэ Христийн шашинтан хөрвөгчийг үнэхээр Бурханы хайртай ариун хүмүүс хэмээн илэрхийлэхийг хүссэн мэт санагддаг. Паул бусдын зовлонг ойлгох чанараа даруухнаар илтгэн,

зарим үед өөрийгөө “золгүй хүн” (Ром 7:24) мэт бодож байсан ч Есүс Христийн сайн мэдээ түүнд нүглийг даван гарах хүчийг өгсөн гэдгийг илэрхийлсэн байдаг (Иосеф Смитийн Орчуулга, Ром 7:22–27 [Судруудын удирдамж]-ийг үзнэ үү). Тэрээр хайрлуулдаг гэдгээ мэдэхийг хичээж байгаа, ариун хүн болох нь боломжгүй мэт санадаг бид бүгдэд зориулан хайрын зөвлөгөө өгсөн. Тэрээр дэлхийд болон бидний дотор буй бузар муугийн алиных нь хувьд ч “бузар муугаар бүү дийл,” “харин бузар мууг сайнаар дийлэгтүн” (Ром 12:21) хэмээн хэлсэн.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

РОМ 7-8

Хэрэв би Сүнсийг дагавал нүглийг давж, Бурхантай хамт өв залгамжлахад бэлтгэж чадна.

Та баптисмын ёслолоор “шинэ амийн дотор” орсныхоо дараа ч (Ром 6:4) Паулын Ром 7-д дүрсэлсэн эгэл хүн болон бидний зөвт хүслүүдийн хоорондох “дайн” буюу дотоод сөргөлдөөнийг мэдэрч байсан байх (Ром 7:23). Харин Паул Ром 8:23-25-д найдварын тухай мөн ярьсан. Та 8-р бүлгээс энэхүү найдварын ямар ямар шалтгааныг олсон бэ? Түүнчлэн “та нарын дотор орших Бурханы Сүнстэй” (Ром 8:9) хамт байхаас ирдэг адислалуудыг эрж олж болно. Та амьдралдаа Ариун Сүнсний нөхөрлөлийг хэрхэн илүү бүрэн дүүрэн эрэлхийлж чадах вэ?

РОМ 8:17-39

Итгэлтнүүдийн хүлээж байдаг мөнхийн алдар суу мөнх бус байдлын зовлон бэрхшээлээс хамаагүй илүү агуу билээ.

Паулыг энэхүү захидлыг бичсэнээс хэдхэн жилийн дараа Ром дахь гэгээнтнүүд аймшигт хавчлага мөрдлөгөөс болж зовж шаналсан. Хавчлага мөрдлөгийн үед гэгээнтнүүдэд тусалсан байж болох юуг та Ром 8:17-39-өөс олсон бэ? Эдгээр үг тантай болон одоо танд тохиолдож байгаа зовлон бэрхшээлтэй хэрхэн холбогдож болох вэ?

Эдгээр шүлэг болон Линда С.Рийвс эгчийн хэлсэн дараах үгийн хоорондын уялдаа холбоог ол. “Яагаад бид ийм их сорилттой тулгардаг учир шалтгааныг би мэдэхгүй ч авах шагнал нь агуу, мөнхийн хийгээд үүрдийн, төсөөлөхийн аргагүй гайхалтай учраас бид нигүүлсэнгүй хайрт Эцэгтээ энэ *бүхний* төлөө ийм өчүүхэн зүйлс шаардагдсан гэж үү хэмээн дуу алдах байх гэж би хувьдаа боддог. Хэрэв бид өдөр бүр Тэнгэрлэг Эцэг, Аврагчийн биднийг хайрлах хайр хэчнээн гүн болохыг санаж, хүлээн зөвшөөрөх юм бол Тэдний дэргэд буцаж очихын тулд ямар ч зүйлийг хийхэд бэлэн байх юм. . . . Хэрэв энэ амьдралдаа туулах зовлон зүдгүүр маань эцсийн эцэст Тэдэнтэй хамт Бурханы хаант улсад мөнх амьдрал, алдар суугаас хүртэх эрхийг олгох тэр зүйл

нь юм бол энд бидний юуг үзэж туулсан нь тийм чухал байна гэж үү?” (“Бидэнд амлагдсан адислалуудад зохистой байх нь,” 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 139).

Таныг хайрлах Бурханы хайрыг “өдөр бүр санаж, хүлээн зөвшөөрөхийн” тулд юу хийхээ шийд.

РОМ 8:29-30; 9-11

Паул “урьдаас тогтоосон”, “сонгогдсон”, “урьдаас мэдсэн” хэмээх хэллэгээр юу илэрхийлсэн бэ?

Паул эдгээр хэллэгийг Бурханы зарим хүүхэд дэлхийн бүх үндэстнийг адислахаар онцгой адислал, үүрэг хариуцлагыг хүлээн авахын тулд урьдаас тогтоогдсон буюу өмнө нь томилогдсон байдаг гэдгийг заахын тулд ашигласан (Судруудын удирдамж, “Сонгогдсон”-ыг үзнэ үү). Энэ нь Есүс Христийг дагаж, Түүнтэй адил болох хүүхдүүдийнхээ хүслийн талаар урьдчилан мэддэг Бурханы мэдлэг дээр тулгуурладаг (түүнчлэн Ефес 1:3-4; 1 Петр 1:2-ыг үзнэ үү). Гэсэн хэдий ч, Паул Ром 9-11-р бүлэгт биднийг Израилийн угсаанд хэрхэн орсон эсвэл хэрхэн Сүмийн гишүүн болсноос үл хамааран бүх хүн Есүс Христэд итгэх итгэл, Түүний зарлиг тушаалуудыг дагах дуулгавартай байдлаараа дамжуулан хувийн авралыг хүлээн авах ёстой хэмээн онцгойлон хэлсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг Алма 13:1-5; Судруудын удирдамж дахь “Урьдчилсан томилолт,” (topics.lds.org)-ыг үзнэ үү.

РОМ 12-16

Паул намайг жинхэнэ гэгээнтэн, Есүс Христийн дагалдагч болоход урьдаг.

Ромын сүүлийн таван бүлэг гэгээнтнүүд хэрхэн амьдрах хэрэгтэй талаар хэдэн арван тодорхой зааварчилгааг агуулдаг. Та энэхүү зөвлөгөөг бүгдийг нь нэг дор хэрэгжүүлэх боломжгүй байж болох ч Сүнсийг сонс. Тэрээр танд өнөөдөр хэрэгжүүлж эхэлж болох нэг юм уу хоёр зөвлөгөөг олоход тусалж чадна. Залбиралдаа Тэнгэрлэг Эцэгтэй хүслүүдээ хуваалцаж, Түүний тусламжийг хүс.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

РОМ 7:23

Энэхүү шүлэгт Паулын дүрсэлсэн “дайтах” талаар илүү сайн ойлгоход нь гэр бүлийнхэндээ туслахын тулд ахлагч Шэйн М.Бөүэний “Agency and Accountability” (*New Era*, Sept. 2012, 8–9) хэмээх өгүүлэл дэх чонын тухай түүхийг хуваалц.

РОМ 9:31-32

Ахлагч Вилфорд В.Андэрсэний “Сайн мэдээний хөгжим” (2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 40–42) нэртэй захиас Паулыг хууль, үйлс, итгэлийн талаар юу заасныг дүрслэхэд тусалж чадна. Танай гэр бүлийнхэнд түүний хэлсэн үгсийн талаар ярилцаж, хөгжимтэй болон хөгжимгүйгээр бүжиглэж үзэх нь таалагдаж болох юм. Хөгжимгүй бүжиглэх нь итгэлгүйгээр сайн мэдээг дагахтай юугаараа адилхан бэ?

РОМ 10:17; 15:4

Бурханы үгийг судлах нь бидэнд эдгээр шүлэгт дүрсэлсэн адислалуудыг хэрхэн авчирдаг вэ? Гэр бүлийн гишүүд дуртай судраасаа хуваалцаж болох юм (мөн 2 Нифай 25:26-г үзнэ үү).

РОМ 12

Өөрсдийгөө “Бурханд тааламжит, амьд, ариун тахил” болгох гэдэг ямар утгатай вэ? (Ром 12:1).

РОМ 14:13-21

Бусдын хувьдаа эрхэмлэдэг зүйлсийг шүүх, марган мэтгэлцэх тухайд өгсөн Паулын зөвлөгөөг судлах нь танай гэр бүлд тустай байж болно. Та бусдын сонголт таныхаас өөр байх тохиолдолд хэрхэн хариулж болох арга замуудын талаар ярилцаж болох юм. Сонголтууд маань бусдад хэрхэн нөлөөлдөг талаар бид яаж илүү анхааралтай байж чадах вэ? “Бусдыг шүүж байна уу? Боль!”, “Цонхоор харах нь” (LDS.org) видео бичлэгүүд энэ сэдвээр нэмэлт ойлголт өгөх боломжтой.

Заах чадвараа сайжруулах

Хүүхдүүдэд бүтээлч сэтгэлгээгээ илэрхийлэх боломж олго. “Та хүүхдүүдийг сайн мэдээний зарчимтай холбоотой ямар нэгэн зүйлийг бүтээхэд урихдаа тэдэнд уг зарчмыг илүү сайн ойлгоход тусалж . . . байгаа хэрэг юм. Тэдэнд барьж, зурж, будаж, бичиж, бүтээх боломж олго” (*Аврагчийн арга барилаар заах нь*, 25-ыг үзнэ үү).



Del Parson

Дэл Парсон, Надтай хамт бай



Коринт, Фивей Грек Нээлттэй хэлмүүрэг, олон нийтийн төв,
Balage Balogh/www.Archaeology Illustrated.com

8-Р САРЫН 19-25

1 Коринт 1–7

“Та нар бүгд нягт нэгд”

1 Коринт 1–7-г уншихдаа төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ. Эдгээр сэтгэгдэл нь нэг санааг гүнзгийрүүлэн судлах, сурсан зүйлээ бусадтай хуваалцах эсвэл амьдралдаа өөрчлөлт хийх сүнслэг өдөөлтүүдийг багтааж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Паулын Коринтод өнгөрүүлсэн саруудад “коринтчуудаас олон хүн [түүний] үгийг сонсоод итгэж, баптисм хүртэцгээж байлаа” (Үйлс 18:8). Хэдхэн жилийн дараа Коринтын гэгээнтнүүдийн дунд “хагарал” болон “мэтгэлцээн” бий болсныг мөн түүний эзгүйд тэд “ертөнцийн мэргэн ухааныг” (1 Коринт 1:10–11, 20) анхаарч эхэлсэн тухай сонсох нь Паулын хувьд зүрх эмтрэм байсан нь гарцаагүй. Паул үүнд хариу болгон эдүгээ бидний мэдэх 1 Коринт хэмээх захидлаа бичжээ. Энэ нь маш гүн сургаалаар дүүрэн байхын зэрэгцээ гэгээнтнүүд өөрсдөд

нь өгөхийг хүссэн бүх сургаалыг хүлээн авахад бэлэн биш байгаад Паул сэтгэл дундуур байсан мэт харагддаг. Тэрээр “Ах дүү нар аа, сүнслэг хүмүүстэй ярихын адил би та нартай ярьж чадсангүй,” “учир нь та нар одоо хүртэл махан биеийнхээ дагуу байна” (1 Коринт 3:1–3) хэмээн гашуудсан. Бид Паулын үгсийг уншихад бэлдэхдээ Сүнсийг анхааран сонсох, гэр бүл, бусад гэгээнтэнтэй болон Бурхантай нэгдмэл байхыг хичээх хүслээ мөн үнэнийг хүлээж авахад бэлэн байгаа эсэхээ шалгаж, шинжлэх нь тустай байж болох юм.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 КОРИНТ 1:10-17; 3:1-11

Христийн Сүмийн гишүүд нэгдмэл байв.

Бид Коринтын гэгээнтнүүдийн дунд дутагдаж байсан эв нэгдлийн талаар дэлгэрэнгүй мэдэхгүй ч *өөрсдийн* харилцаан дахь эв нэгдлийн дутагдлыг мэднэ. Нэгдмэл байдал тус болох амьдралынхаа нэгэн харилцааны талаар бод. Тэгээд Коринтын гэгээнтнүүдийн дунд дутагдаж буй эв нэгдлийн тухай 1 Коринт 1:10-17; 3:1-11 дээр Паул юу заасныг ол. Та бусадтай илүү бат эв нэгдлийг хэрхэн бэхжүүлэх талаар ямар ямар ойлголт олж авч болох вэ?

Түүнчлэн Мозая 18:21; 4 Нифай 1:15-17; Сургаал ба Гэрээ 38:23-27; 105:1-5 мөн Судруудын удирдамж дахь “Эв нэгдэл”, topics.lds.org-ыг үзнэ үү.

1 КОРИНТ 1:17-31; 2

Бурханы ажлыг гүйцэлдүүлэхийн тулд надад Бурханы мэргэн ухаан хэрэгтэй.

Мэргэн ухааныг олж болох хаанаас ч болов эрэлхийлэх нь сайн мөн бүр урамшуулан дэмжихээр зүйл бөгөөд (2 Нифай 9:29; С ба Г 88:118-ыг үзнэ үү) Паул “энэ ертөнцийн мэргэн ухаан” хэмээн нэрлэсэн хүмүүний алдаатай мэргэн ухааны талаар хүчирхэг үгтэй сэрэмжлүүлэг өгсөн. Та 1 Коринт 1:17-25-ыг уншихдаа энэхүү хэллэг нь ямар утгатай болох талаар тунгаан бодоорой. Паул “Бурханы мэргэн ухаан” гэсэн хэллэгээр ямар утгыг илэрхийлсэн гэж та нар бодож байна вэ? Бурханы ажлыг гүйцэлдүүлэхийн тулд бидэнд яагаад Бурханы мэргэн ухаан хэрэгтэй вэ?

Та Бурханы ажлыг гүйцэлдүүлэх үүргээ биелүүлэхээр хичээж зүтгэхдээ Паулын Коринт дахь гэгээнтнүүдэд зааж байхдаа мэдэрсэн “айдас, үлэмжийн чичрэл”-ийг мэдэрч байсан уу? (1 Коринт 2:3). Та 1-5-р шүлгээс танд урам өгсөн юуг олсон бэ? Та “Бурханы хүчинд” “хүмүүсийн мэргэн ухаанаас” илүү итгэдэг гэдгээ хэрхэн харуулж болох талаар эргэцүүлэн бод.

Мөн Сургаал ба Гэрээ 1:17-28-ыг үзнэ үү.

1 КОРИНТ 2:9-16

Бурханы зүйлсийг ойлгохын тулд надад Ариун Сүнс хэрэгтэй.

Хэрвээ та автомашины эд анги эсвэл дундад зууны үеийн уран барилгын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл юу хийх вэ? 1 Коринт 2:9-16-д цэдэглэснээр “хүмүүний бодол санааг” ойлгож сурах нь “Бурханыхыг” сурахаас юугаараа ялгаатай вэ? Бурханы зүйлсийг ойлгохын тулд бидэнд яагаад Ариун Сүнс хэрэгтэй вэ? Эдгээр шүлгийг уншсаны дараа сүнслэг зүйлсийг илүү бүрэн дүүрэн ойлгохын тулд юу хийх хэрэгтэй гэж танд мэдрэгдэж байна вэ? Паулын үгс гэрчлэлээрээ суларч байгаа хүнд хэрхэн тусалж чадах вэ?

1 КОРИНТ 6:13-20

Миний бие махбод бол ариун нандин зүйл юм.

Коринт дахь олон хүн бэлгийн ёс суртахуунгүй байдал нь хүлээн зөвшөөрөгдсөн зүйл бөгөөд бие махбод бол зугаа цэнгэлийн тулд бүтээгдсэн гэж боддог байсан. Өөрөөр хэлбэл, Коринт өнөөгийн дэлхийгээс тийм ч өөр байгаагүй. Паулын 1 Коринт 6:13-20-д заасан зүйлс цэвэр ариун амьдралаар амьдрахыг хүсэж байгаагаа бусдад тайлбарлахад тус болох юуг танд заасан бэ?

Вэнди В.Нэлсон эгч “Хайр ба гэрлэлт” (Залуучуудад зориулсан дэлхий дахины онцгой цугларалт, 2017 оны 1-р сарын 8, broadcasts.lds.org) хэмээх хэлсэн үгэндээ гэгээнтнүүдийг цэвэр ариун амьдралаар амьдрахад хэрхэн урамшуулан дэмжсэнийг харах нь сонирхолтой байж болох юм. Нэлсон эгчийн дүрсэлсэн хайр, бэлгийн харьцааны талаарх үнэн нь дэлхийн захиасаас ямар ялгаатай байна вэ?

Түүнчлэн Ром 1:24-27; Судруудын удирдамж дахь “Ариун явдал,” topics.lds.org-ыг үзнэ үү.

1 КОРИНТ 7:29–33**Паул гэрлэснээс гэрлээгүй байсан нь дээр гэж заасан уу?**

1 Коринт 7-р бүлгийн хэдэн шүлэгт гэрлэлт нь хүлээн зөвшөөрөгдсөнөөс гадна ганц бие хэвээр үлдэж, бэлгийн харьцаанаас бүрмөсөн татгалзах нь илүү дээр хэмээн зөвлөж байгаа мэт санагддаг. Гэсэн хэдий ч, Иосеф Смитийн Орчуулга дахь 1 Коринт 7:29–33 (Судруудын удирдамжийг үзнэ үү)

нь бидэнд Паул бүрэн цагийн номлогч байхаар дуудагдсан хүмүүс номлолынхоо үеэр ганц бие хэвээр байвал Бурханд илүү сайн үйлчлэх боломжтой гэдгийг ажигласнаар ийн зөвлөсөн гэдгийг ойлгоход тусалдаг. Их Эзэн гэрлэлт нь Түүний мөнхийн төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд өргөмжлөлийг хүртэхэд шаардлагатай гэдгийг Паул зэрэг үйлчлэгчдээрээ дамжуулан заасан (1 Коринт 11:11; С ба Г 131:1–4-ийг үзнэ үү).

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

1 КОРИНТ 1:10–17; 3:1–11

Гэр бүлийн гишүүдээ эдгээр шүлгийг уншиж байхад илүү эв нэгдэлтэй байхад туслах ойлголтуудыг олохыг тэднээс хүс.

1 КОРИНТ 3:1–2

Та бор хоол идэж, сүү ууж байхдаа эдгээр шүлгийг уншаад, нялх хүүхдүүд насанд хүрэн, өсөж том болдог арга замыг бидний сүнслэгээр өсөж хөгждөг арга замтай харьцуулж болох юм.

1 КОРИНТ 3:1–9

Паул номлогчийн хичээл зүтгэлээ үр суулгахтай харьцуулжээ. Түүний харьцуулалт бидэнд бусадтай

сайн мэдээг хуваалцахдаа хэрхэн хандах тухай юуг санал болгодог вэ?

1 КОРИНТ 6:19–20

Паулын адил бие махбодоо ариун сүмтэй харьцуулах нь бие махбодынхоо ариун нандин байдлын тухай заах үр дүнтэй арга байж болох юм. Та энэхүү тоймын хавсралт болсон ариун сүмийн зургийг харуулж болно. Ариун сүмүүд яагаад ариун нандин байдаг вэ? Бидний бие махбод ариун сүмтэй хэрхэн адил вэ? Бид бие махбоддоо ариун сүм мэт хандахын тулд юу хийж болох вэ? (“Бэлгийн харьцааны цэвэр ариун байдал,” *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 35–37-г үзнэ үү) Хэрэв боломжтой бол хамтдаа ариун сүмд ор эсвэл ариун сүмийн гаднах талбайд оч. Энэ нь ариун сүм, бие махбодынхоо ариун нандин байдлын тухай ярилцах яриаг илүү баяжуулж болно.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Өөртөө тэвчээртэй ханд. Биднийг сайн мэдээнээс суралцаж байхад бор хоолноос өмнө сүү байдаг хэмээн Паул заасан (1 Коринт 3:1–2-ыг үзнэ үү). Хэрэв зарим сургаалыг ойлгоход хэцүү байвал тэвчээртэй байгаарай. Итгэлтэй байж, хичээнгүйлэн суралцах үед хариулт нь ирэх болно гэдэгт итгэ.



Paulist бидний бие махбодыг ариун сүмийн ариун нандин байдалтай харьцуулсан. Зүүн дээд талаас цагийн зүүний дагуу. Мексикийн Тихуана ариун сүм, Тайванийн Тайлэй ариун сүм, Гондурасын Тээжусгалта ариун сүм, Техасын Хьюстон ариун сүм.



8-Р САРЫН 26-ААС 9-Р САРЫН 1

1 Коринт 8–13

“Та нар Христийн бие”

Таныг 1 Коринт 8–13-ыг уншиж байхад Ариун Сүнс тантай намуухан ярьж болно (Хаадын дээд 19:11–12-ыг үзнэ үү). Эдгээр сэтгэгдлээ бичиж тэмдэглэх нь суралцаж байх үедээ мэдэрсэн мэдрэмж, бодлоо эргэн санахад тус болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Паулын үед Коринт Ромын эзэнт гүрний өнцөг булан бүрээс ирсэн оршин суугчидтай чинээлэг худалдааны төв газар байсан юм. Уг хотынхны маш олон өөр төрлийн соёл иргэншил, шашин шүтлэг дунд Коринт дахь Сүмийн гишүүд эв нэгдлээ хадгалан үлдэх гэж зовж байв. Тиймээс Паул тэдэнд Христэд итгэх итгэлдээ эв нэгдлийг олоход нь туслахыг оролдож байсан. Энэхүү эв нэгдэл нь зөвхөн амар тайван зэрэгцэн оршихоос илүү зүйл байсан бөгөөд Паул тэднээс ердөө л бие биенийхээ ялгаатай байдлыг тэвчихийг хүсээгүй. Харин тэр Есүс Христийн Сүмд элсэхдээ та нар “нэг бие уруу баптисм хүртсэн” ба биеийн хэсэг бүр нь хэрэгтэй хэмээн заасан (1 Коринт 12:13). Нэг гишүүнээ алдвал нэг эрхтнээ

алдаж байгаатай адил бөгөөд үр дүнд нь бие улам сул дорой болно. Нэг гишүүн зовох үед бид бүгдээрээ түүний зовлонг үүрэлцэж, үүнээс ангижрахад нь туслахын тулд хүн бүр өөрт оногдсоноо хийх хэрэгтэй. Энэ төрлийн эв нэгдэлд ялгаатай талууд нь зөвхөн танигдаад зогсохгүй үнэлэгддэг. Учир нь өөр өөр авьяас, чадвартай гишүүдгүй бол бие нь бүрэн бус, хязгаарлагдмал байх болно. Та сүмд байхдаа үргэлж гэртээ байгаа юм шиг санагддаг эсвэл энэ үнэхээр байх ёстой газар минь мөн үү гэж бодож байгаа бол танд зориулсан Паулын захиас эв нэгдэл бол адилхан байх гэсэн үг биш гэсэн захиас юм. Танд гэгээнтэн найзууд тань хэрэгтэй, гэгээнтэн найзууддаа ч та хэрэгтэй.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 КОРИНТ 10:1–13

Бурхан уруу таталтаас ангижрах арга замаар хангадаг.

Сүнслэг туршлагууд, бүр гайхамшигтай туршлагууд ч “хүнд тохиолддог л” (1 Коринт 10:13) уруу таталтуудаас биднийг чөлөөлдөггүй. Энэ нь Мосегийн үеийн израильчууд агуу гайхамшгуудыг харсан атлаа уруу таталттай хэрхэн тэмцэлдэж байсан тухай Паулын бичсэн нэг шалтгаан байж болно (Египетээс гарсан нь 13:21; 14:13–31). 1 Коринт 10:1–13-ыг уншихад израильчуудын туршлагын ямар сэрэмжлүүлэг нь таны хувьд тохиромжтой санагдаж байна вэ? Тэнгэрлэг Эцэг таныг уруу таталтаас “ангижрах” ямар аргаар хангасан бэ? (мөн Алма 13:27–30; 3 Нифай 18:18–19-ийг үзнэ үү).

1 КОРИНТ 10:16–17; 11:16–30

Ариун ёслол нь биднийг Есүс Христийг дагагчдын хувиар нэгтгэдэг.

Хэдийгээр ариун ёслол нь хувь хүн, Их Эзэн хоёрын хоорондын амлалтыг хамруулсан боловч гэгээнтнүүдийн биеийн хувьд бараг үргэлж хамтдаа ариун ёслолоос хүртдэг бусадтай хуваалцдаг туршлага юм. Ариун ёслолын талаар Паул юу гэж заасныг уншаад, энэхүү ариун нандин ёслол нь хэрхэн “олныг” Христэд “нэг” болоход тусалж болох талаар бод (1 Коринт 10:17). Та бусад итгэгчийн хамт ариун ёслолоос хүртсэнээр хэрхэн хүчирхэгжиж болох вэ? Энэ нь ариун ёслолоос хүртэх арга барил, баптисмын гэрээгээ сахихаар хичээж байгаа байдалд тань яаж нөлөөлөх вэ?

1 КОРИНТ 11:3–15

Паул яагаад толгойгоо бүтээх тухай болон үсний хэв маягийн талаар бичсэн бэ?

Тэрээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон Их Эзэний хоорондын харилцааны талаар заахын тулд хувцаслалт, цэмцгэр байдлын уламжлалт ёс заншлыг дурдсан. Өнөө үед бид эдгээр ёс заншлыг дагадаггүйгээс гадна 1 Коринт 11:11 дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёулаа Их Эзэний төлөвлөгөөнд гэрлэлт болон сүмд хэрэгтэй байдаг гэсэн Паулын тунхгаас суралцаж болно. Ахлагч Дэвид А.Бэднар өргөмжлөл өөд хамтдаа өсөж хөгжихдөө “эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биеэсээ суралцах, нэг нэгнээ хүчирхэгжүүлэх, адислах, төгс болгохын тулд бүтээгджээ” хэмээн заасан (“Бид ариун явдалд итгэдэг,” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 50 мөн Марк 10:6–9-ийг үзнэ үү).

1 КОРИНТ 12–13

Сүнсний бэлгүүд нь Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдийн ашиг тусын тулд өгөгдсөн.

1 Коринт 12–13 дахь сүнсний бэлгүүдийн жагсаалт нь бүгдийг хамраагүй. Гэвч энэ нь Тэнгэрлэг Эцэгийн танд өгсөн сүнсний бэлгүүдийг таньж мэдэн, тунгаан бодож эхлэх тохиромжтой цэг билээ. Судруудын удирдамж дахь “Сүнсний бэлгүүд” (topics.lds.org) хэсэг нь танд эдгээр бэлгийг илүү сайн ойлгоход туслах болно. Та бусдаас болон өөрөөсөө мөн судрууд дахь хүмүүсээс харсан бэлгүүдээ Паулын жагсаалт дээр нэмж болно. Хэрэв та патриархын адислалаа авсан бол энэ нь зарим сүнсний бэлгийг тань дурдсан байж болно. Эдгээр бэлэг нь бидэнд Бурханы хаант улсыг байгуулахад хэрхэн тусалдаг вэ? “Үлэмж агуу бэлгүүдийг” (1 Коринт 12:31) эрлэхийлэхийн тулд юу хийхээ эргэцүүлэн бод.

Түүнчлэн Моронай 10:8–21, 30; Сургаал ба Гэрээ 46:8–26; Итгэлийн тунхаг 1:7-г үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үедээ гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд сүнслэг мэдрэмжийг эрэлхийл. Дараах зөвлөмжүүд тус болж мэднэ.

1 КОРИНТ 9:24-27

Паул сайн мэдээний дагуу амьдрахыг уралдаанд гүйхтэй харьцуулсан болохоор түүний гол санааг харуулахын тулд гэр бүлээрээ уралдаж болно. Уралдааныг дуусгасан хүн бүрд титэм гардуулж өгөөд, энэ амьдралд Есүс Христийг дагахдаа дуулгавартай байсан бүх хүн “үл муудах” шагналыг хэрхэн хүртэх тухай ярилц (1 Коринт 9:25 мөн 2 Тимот 4:7-8-ыг үзнэ үү). Гүйлтийн аварга уралдаанд бэлтгэхийн тулд юу хийж болох вэ? Үүний адил бид Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиход бэлтгэхийн тулд юу хийж чадах вэ?

1 КОРИНТ 12:1-11

Хүн бүрд гэр бүлийн өөр нэг гишүүний нэрийг дээд захад нь бичсэн цаас өг. Тухайн хүнээс ажигласан сүнсний бэлгүүдийг жагсаан бичихийг хүн бүрээс хүс. Дараа нь хүн бүр гэр бүлийнхээ гишүүн бүрийн бэлгийн талаар бичих хүртэл цааснуудыг тойруулан дамжуул.

1 КОРИНТ 12:3

Яагаад Есүс Христийн тухай гэрчлэлийг олж авахад Ариун Сүнс хэрэгтэй байдаг вэ? Бид Түүний талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд Ариун Сүнсийг урихын тулд юу хийж болох вэ?

1 КОРИНТ 12:12-27

Бие махбодын талаарх Паулын адилтгал гэр бүлийн эв нэгдлийн тухай ярилцах дурсгалтай арга зам байж болох юм. Тухайлбал, гэр бүлийн гишүүд зөвхөн нүд эсвэл чихнээс бүрдсэн хүний бие зурахыг оролдож болно (17-р шүлгийг үзнэ үү). Эдгээр шүлэг нь бид гэр бүлийн хувьд бие биедээ хэрхэн хандах талаар юу санал болгодог вэ?

1 КОРИНТ 13:4-8

Энэрлийн талаарх Паулын тодорхойлолт танай гэр бүлийг сүнслэгээр өдөөх уриа болж болно. Та гэр бүлийн гишүүн бүрд 4-8-р шүлэг дэх хэллэгүүдийг судлах үүрэг өгөөд, бусад гишүүндээ тодорхойлолт, жишээ, хувийн туршлагаа ашиглах нь ямар утгатай болох талаар зааж болох юм. Аврагч хэрхэн эдгээр зан чанарын үлгэр жишээ болдог вэ? Та мөн эдгээр хэллэг тус бүрийг харуулсан үзүүлэн хийгээд, гэртээ хадаж болно. Бүтээлч бай!

Заах чадвараа сайжруулах

Судар үзүүл. Танд утга учиртай санагдсан шүлгийг сонгож, гэр бүлийн гишүүдийнхээ тогтмол харж болох газарт байрлуул. Ээлжлэн үзүүлэх судраа сонгоход гэр бүлийнхнээ урь.



"Бүдний хугацдаг тах нь Христийн бие доторх оролцоо биш үү? Тах нэг тул бид олуулаа ч нэг бие байна" (1 Коринт 10:16-17).



9-Р САРЫН 2-8

1 Коринт 14–16

“Бурхан бол самуурлын Бурхан бус, харин амар амгалангийн Бурхан мөн”

1 Коринт 14–16-г уншихдаа төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ. Сүнсний заасан зүйлсийн талаар залбирч, Тэнгэрлэг Эцэгээс таныг илүү ихийг сураасай хэмээн хүсэж байгаа зүйл байгаа эсэхийг асуу.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Сүм болон Сүмийн сургаал Коринтынхны хувьд харьцангуй шинэ учир Коринт дахь гэгээнтнүүдэд эргэлзээ төрөх нь ойлгомжтой байсан. Өмнө нь Паул сайн мэдээний үндэс суурийн талаар тэдэнд “Христ бидний нүглийн төлөө үхсэн бөгөөд оршуулагдан, . . . гурав дахь өдөртөө амилуулагджээ” (1 Коринт 15:3–4) хэмээн заасан. Гэвч зарим гишүүн удалгүй “үхэгсдийн амилалт байхгүй” 1 Коринт 15:12) хэмээн зааж эхэлсэн байна. Паул заалгасан

үнэнээ “баримтлахыг” (1 Коринт 15:2) тэднээс хүссэн. Бид сайн мэдээний үнэний талаар зөрчилдөөнтэй үзэл бодлуудтай тулгарахдаа “Бурхан бол самуурлын Бурхан бус, харин амар амгалангийн Бурхан мөн” (1 Коринт 14:33) гэдгийг санах нь зүйтэй. Их Эзэний томилогдсон үйлчлэгчдийг сонсож, тэдний ахин дахин заасан энгийн үнэнээс зууран барих нь бидэнд амар амгаланг олж, “итгэл дотроо бат зогсоход” (1 Коринт 16:13) тусалж чадна.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 КОРИНТ 14

Би бошиглолын бэлгийг эрэлхийлж чадна.

Та урьд нь бошиглолын бэлэг гэж юу болох талаар бодож байсан уу? Ирээдүйг урьдчилан хэлэх чадвар мөн үү? Ямар ч хүн энэ бэлгийг хүлээн авч чадах уу? Эсвэл энэ нь зөвхөн бошиглогчдод зориулсан бэлэг үү?

Сүмийн ерөнхийлөгч бол бүхэл Сүмийн төлөө бошиглож, Сүмийн өмнөөс илчлэлт хүлээн авч чадах цорын ганц хүн юм. Харин Судруудын удирдамж дээр *бошиглол* гэдгийг “илчлэлтээр дамжуулан Ариун Сүнснээс хүлээн авдаг сүнслэгээр нөлөөлөгдсөн үгс болон бичээсүүд. . . . Хүн бошиглохдоо өөрийнх нь сайн сайхны төлөө буюу бусдын сайн сайхны төлөө Бурханаас түүнд мэдүүлэхийг хүссэн зүйлийг ярих буюу бичдэг” (Судруудын удирдамж, “Бошиглол, бошиглох,” scriptures.lds.org мөн С ба Г 100:5–8-ыг үзнэ үү) хэмээн тодорхойлсон байдаг. Түүнчлэн Илчлэлт 19:10-т бошиглолын сүнсийг “Есүсийн гэрчлэл” хэмээн тодорхойлдог.

Та 1 Коринт 14:3, 31, 39–40-өөс энэхүү сүнсний бэлгийн талаар юу сурах вэ? Паул коринтчуудыг “эш үзүүлэхийн тулд хүслэн болж тэмүүл” гэж урихдаа ямар утгаар хэлсэн бэ? (1 Коринт 14:39). Та энэ урилгыг хэрхэн хүлээн авч болох вэ?

Түүнчлэн Тооллого 11:24–29; Иаков 4:6–7; Алма 17:3; Сургаал ба Гэрээ 11:23–28-ыг үзнэ үү.

1 КОРИНТ 14:34–35

Паул яагаад эмэгтэйчүүдийг сүм дотор чимээгүй бай гэж хэлсэн бэ?

1 Коринт 14:34–35 дахь Паулын заасан сургаал толгой эргэм санагдаж магадгүй. Учир нь тэр энэхүү захидлын эхээр эмэгтэйчүүд залбирч, бошиглож байсан гэж бичсэн байдаг (1 Коринт 11:5-ыг үзнэ үү). Иосеф Смитийн Орчуулгад 34, 35-р шүлэг дэх *ярих* гэдэг үгийг *захирах* гэдэг үгээр сольсон. Энэхүү залруулга нь Паул Сүмийн цуглаануудад эрх мэдлийг булаан авахыг оролдож байсан эмэгтэйчүүдийг хэлсэн байж болно гэж санал болгодог. (Мөн 1 Тимот 2:11–12-ыг үзнэ үү.)

1 КОРИНТ 15:1–34, 53–58

Есүс Христ үхлийг ялсан.

Есүс Христийн Амилалт Христийн шашны хувьд маш чухал үндэс суурь болдог бөгөөд үүнгүйгээр Христийн шашин гэж байхгүй байх байсан гэж хэлж болно. Паулын хэлснээр “бидний тунхаглал хоосон, та нарын итгэл ч хоосон болох юм” (1 Коринт 15:14). Гэсэн ч Коринтын гэгээнтнүүдийн зарим нь “үхэгсдийн амилалт байхгүй” (1 Коринт 15:12) хэмээн зааж байсан. Та 1 Коринт 15 дээрх Паулын хариултыг уншихдаа хэрэв та Амилалтад итгэдэггүй байсан бол таны амьдрал хэр зэрэг өөр байх байсан талаар тунгаан бодоход хэдэн хором зарцуулаарай. Энэ нь таныг хэрхэн адисалсан бэ? Есүс Христ амилсны ачаар танд ямар ямар адислал ирэх вэ? (2 Нифай 9:6–19; Алма 40:19–23; Сургаал ба Гэрээ 93:33–34-ийг үзнэ үү). “Хэрэв Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хэрэггүй ажээ” гэсэн үг хэллэг таны хувьд ямар утгатай вэ? (17-р шүлэг).



“Нарны алдар өөр” (1 Коринт 15:41).

1 КОРИНТ 15:35–54

Амилуулагдсан биес мөнх бус биесээс ялгаатай.

Та амилуулагдсан бие ямар байдаг талаар бодож байсан уу? 1 Коринт 15:35-д цэдэглэснээр зарим коринт хүн үүний талаар бодож байжээ. 36–54-р шүлэг дэх Паулын хариултыг уншаад, мөнх бус биес, амилуулагдсан биесийн хоорондын ялгааг дүрсэлсэн үгс, хэллэгүүдийг тэмдэглэж аваарай. Жишээлбэл, 40–42-р шүлэгт амилуулагдсан биес нар, сар, од нь гэрэлтэх байдлаараа ялгаатайн адил өөр өөр зэрэглэлээр алдар суундаа гэрэлтэх болно хэмээн заадаг (мөн Иосеф Смитийн Орчуулга, 1 Коринт 15:40; С ба Г 76:50–112-ыг үзнэ үү).

Түүнчлэн Алма 11:43–45; Лук 24:39-ийг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

1 КОРИНТ 15:29

Бид 29-р шүлгээс өнөө үед бидний хийдэгтэй адил эрт үеийн гэгээнтнүүд ч бас нас барагсдын төлөөх баптисмд оролцдог байсан гэдгийг сурдаг. Бид гэр бүлээрээ өвөг дээдсийнхээ нэрсийг ариун сүмийн ёслолуудад бэлдэхдээ ямархуу байдалтай байна вэ?

1 КОРИНТ 15:35-54

Та мөнх бус биес амилуулагдсан биесээс ямар ялгаатай болохыг дүрслэхдээ Паулын ашигласан зарим хэллэгийг ойлгоход нь гэр бүлийнхэндээ туслахын тулд ямар үзүүлэн эсвэл зураг үзүүлж болох вэ? Тухайлбал, *муудах* болон *үл муудах* (52-54-р шүлгийг үзнэ үү) гэсэн хэллэгүүдийн хоорондын ялгааг харуулахын тулд зэвтэй металл (төмөр) болон зэвэрдэггүй метал (ган) үзүүлж болно. Эсвэл ямар нэгэн сул дорой зүйлийг хүчирхэг зүйлтэй харьцуулж болно (43-р шүлгийг үзнэ үү).

1 КОРИНТ 15:55-57

Хэрэв танай гэр бүлийнхэн нас барсан хүнийг таньдаг бол эдгээр шүлгийн талаарх ярилцлага илүү үр дүнтэй болж чадна. Гэр бүлийн гишүүд Есүс Христ хэрхэн “үхлийн хатгуурыг” (56-р шүлэг) авдаг талаар гэрчлэлээ хуваалцаж болно. Ахлагч Пол В.Жонсоны хэлсэн “Тэнд цаашид үхэл байхгүй болно” (2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 111-113) хэмээх захиас ярилцлагад тань боломжийн нэмэлт санаа өгч болох юм.

1 КОРИНТ 16:13

Энэхүү шүлэгтэй өөрсдийгөө холбож ойлгоход нь гэр бүлийнхэндээ туслахын тулд газарт тойрог зураад, гэр бүлийнхээ нэг гишүүний нүдийг боож, бусад хүн түүнийг тойргоос гаргахыг оролдож байх үед тойрог дотроо “бат зогсохыг” түүнээс хүс. Тойрог доторх хүн нүдээ боохгүйгээр “сэрэмжтэй” байх үед ямар ялгаатай байна вэ? Бид буруу сонголт хийхээр уруу татагдах үедээ амьдралдаа “хүчтэй байж” болохын тулд юу хийж чадах вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Хэв маягийг олж хар. Бид судруудаас Их Эзэн Өөрийн ажлыг хэрхэн хийдгийг үзүүлсэн хэв маягийг олж хардаг. Та 1 Коринт 14-өөс бие биедээ хэрхэн зааж, сургахыг ойлгоход маань туслах ямар хэв маягуудыг олох вэ? С ба Г 50:13-23-ыг үзнэ үү.



Саймон Дүви, Эмэгтэй, чи юунд уйлна вэ?



9-Р САРЫН 9-15

2 Коринт 1–7

“Бурхантай эвлэрцгээ”

Та Паулын коринтчуудад хандаж бичсэн захидлуудыг судлахдаа олж мэдсэн сайн мэдээний зарим зарчмаа бичээд, амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар тунгаан бодоорой.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Заримдаа Сүмийн удирдагч байснаар зарим хэцүү зүйлийг хэлэх хэрэгтэй болдог. Энэ нь өнөө үеийн адил Паулын үед ч үнэн байсан. Коринт дахь гэгээнтнүүдэд хандан бичсэн Паулын өмнөх захидал зэмлэлийг багтаадаг ба энэ нь тэдний сэтгэлийг өвтгөсөн. 2 Коринт гэж нэрлэгдсэн захидалдаа тэр хатуу ширүүн үг хэлэхэд нь юу нөлөөлснийг тайлбарлахыг оролдсон байдаг. “Та нарыг гашуудуулъя гэсэндээ бус, харин надад байгаа та нарын төлөө гэсэн хайрыг та нарт мэдүүлэхийн тулд үлэмж зовлонгоос, бачимдах зүрхнээсээ би нулимс унаган та нарт бичсэн юм” (2 Коринт 2:4). Та удирдагчаасаа залруулгын үг хүлээн авах үедээ энэ нь Христийнтэй адил хайраар нөлөөлөгдсөн юм шүү гэдгийг

мэдвэл тустай байх нь гарцаагүй. Хэдий нөхцөл байдал тийм биш байсан ч бид бусдыг Паулын мэдэрч байсан шиг хайраар харах хүсэлтэй байвал ямар ч дайралтад зохистой байдлаар хариулахад илүү хялбар болдог. Ахлагч Жэффри Р.Холландын зөвлөснөөр “Иймээс хүмүүний алдааны тухайд аядуу зөөлөн хандаж сур, өөрийн алдаа байна уу эсвэл сайн дураараа үйлчилж буй мөнх бус хүмүүсээр удирдуулдаг энэ Сүмд чамтай хамт үйлчилдэг бусад хүний алдаа байна уу хамаагүй. Түүний цорын ганц төгс Хүүг эс тооцвол Бурхан төгс бус хүмүүстэй л ажиллаж ирсэн” (“Эзэн минь, би итгэж байна,” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 109).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

2 КОРИНТ 1:3-7; 4:6-10, 17-18; 7:4-7

Миний сорилт бэрхшээлүүд адислал байж болно.

Паул үйлчлэлийнхээ үеэр олон зовлон бэрхшээлийг амссан учраас зовлон бэрхшээлийн зорилго, адислалын талаар маш их зүйлийг бичсэн нь гайхмаар зүйл биш юм. Та 2 Коринт 1:3-7; 4:6-10, 17-18; 7:4-7-г уншихдаа сорилт бэрхшээлүүд тань адислал байж болох арга замуудын талаар бодоорой. Жишээлбэл, Бурхан хэрхэн “[таныг] бүх зовлон дотор [тань] тайвшруулдаг” хийгээд хариуд нь та хэрхэн “аливаа зовлонд орогсдыг тайвшруулж” чадах талаар тунгаан бодож болно (2 Коринт 1:4). Эсвэл та “зовсон,” “сандарсан” үедээ ч “бидний зүрхэнд гэрэлтсэн” Есүс Христийн гэрэлд анхаарлаа хандуулж болно (2 Коринт 4:6-10).

Түүнчлэн Мозая 24:13-17-г үзнэ үү.

2 КОРИНТ 2:5-11

Би уучилснаараа адислалуудыг хүлээн авч, бусдыг адисалдаг.

2 Коринт 2:5-11-д Паулын дүрсэлсэн эрэгтэйн талаар бид түүнийг зөрчил үйлдсэн (5-6-р шүлэг), Паул түүнийг өршөөхийг гэгээнтнүүдээс хүссэн (7-8-р шүлэг) гэдгээс өөр зүйлийг мэдэхгүй. Биднийг гомдоосон хүний “төлөө хайраа бататгахдаа” бид заримдаа яагаад бүтэлгүйтдэг вэ? (8-р шүлэг). Уучлахаас татгалзах нь бусдыг болон биднийг хэрхэн хохироодог вэ? (7, 10-11-р шүлгийг үзнэ үү). Бусдыг уучлахаас татгалзах нь “биднийг Сатан мэхэлж далимдуулах” нөхцөлийг бүрдүүлдэг гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ? (11-р шүлэг).

Мөн Сургаал ба Гэрээ 64:9-11-ийг үзнэ үү.

2 КОРИНТ 5:14-21

Би Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Бурхантай эвлэрүүлэгдэх боломжтой.

Паул “шинэ бүтээл” болох нь ямархуу байдгийг өөр хэний ч адил мэдэж байсан. Тэрээр Христийн шашинтнуудыг хавчин гадуурхагч байснаа Христийн эрэлхэг өмгөөлөгч болсон. Тэрээр “нүглийг үл мэдэгч” Есүс хэрхэн биднийг авч, биднийг Бурхантай эв нэгдэлтэйгээр сэргээн, Өөрийн “зөвт байдлыг” бидэнд өгч чадахыг мэдэж байсан. Та эдгээр шүлгийг уншихдаа өөр хүнтэй эвлэрүүлэгдэх нь ямар утгатай болохыг бодоорой. Энэ нь Бурхантай эвлэрүүлэгдэх нь ямар утгатай болохыг ойлгоход танд хэрхэн тусалдаг вэ? Таныг Бурханаас холдуулж байж болох зүйлийн талаар тунгаан бод. Та Түүнтэй бүрэн дүүрэн эвлэрэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?

Мөн 2 Нифай 10:23-25-ыг үзнэ үү.

2 КОРИНТ 7:8-11

Бурханлаг харуусал наманчлалд хүргэдэг.

Бид харууслыг ихэвчлэн сайн зүйл гэж боддоггүй боловч Паул “бурханлаг харууслыг” наманчлалын чухал хэсэг болох талаар ярьсан. Та дараах судруудаас бурханлаг харууслын талаар юу сурах вэ? 2 Коринт 7:8-11; Алма 36:16-21 болон Мормон 2:11-15. Та бурханлаг харууслыг хэзээ мэдэрсэн бэ? Энэ нь таны амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

2 КОРИНТ 3:1-3

Гэр бүлийн тань гишүүд ажлын эсвэл сургуулийн өргөдөл бөглөхдөө хэн нэгнээс итгэмжлэлийн захиа бичиж өгөхийг хүсэж байсан уу? Тэднээс энэхүү туршлагынхаа талаар болон захиан дээр тэдний талаар юу гэж бичсэн байсан тухай ярихыг хүс. Паул гэгээнтнүүдийн амьдрал бол Христ өөрөө “бэхээр бус, харин амьд Бурханы Сүнсээр бичсэн” сайн мэдээний итгэмжлэлийн захиатай адил хэмээн заасан. 2 Коринт 3:1-3-ыг уншихдаа бидний үлгэр жишээ хэрхэн “бүх хүнээр уншигдаж, мэдэгдэх” боломжтой сайн мэдээний итгэмжлэлийн захиатай адил болох талаар ярилц. Магадгүй гэр бүлийн гишүүн бүр өөр нэгнийгээ хэрхэн Есүс Христийн шавийн сайн үлгэр жишээ болж байгааг тайлбарласан захиа эсвэл “захидал” бичиж болох юм. Тэд захиануудаа гэр бүлийнхэндээ уншиж өгөөд, тухайн хүндээ өгч болно. Яагаад бидний амьдрал бол “Христийн захиа[нууд]” гэдгийг ойлгох нь чухал вэ?

2 КОРИНТ 5:6-7

“Үзэгдэж байгаагаар бус, харин итгэлээр алхах” гэдэг нь ямар утгатай вэ? Бид харж чадахгүй зүйлсдээ итгэж байгаагаа үзүүлэхийн тулд юу хийж байгаа вэ?

2 КОРИНТ 5:17

Гайхалтайгаар өөрчлөгдөж, шинэ бүтээл болдог зүйлсийн жишээг танай гэр бүлийнхэн бодож, олж чадах уу? (Энэ тоймын хавсралт болсон зурагнуудыг үз). Эдгээр жишээ Есүс Христийн сайн мэдээ биднийг хэрхэн өөрчилдөг талаар бидэнд юу зааж байна вэ?

2 КОРИНТ 6:1-10

Эдгээр шүлэгт цэдэглэснээр “Бурханы үйлчлэгчид” байх гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

2 КОРИНТ 6:14-18

Бид эргэн тойрныхоо хүмүүст сайн үлгэр жишээ үзүүлэхийн хажуугаар “[ёс бусчуудын] дундаас гарч тусгаар бай” гэсэн Паулын зөвлөгөөг хэрхэн дагаж чадах вэ?

Заах чадвараа сайжруулах

Үзүүлэнт хичээлүүдийг заах. Цагаатгал гэх мэт сайн мэдээний зарим ойлголт ойлгоход хэцүү байж болно. Гэр бүлийнхэндээ судруудаас олж мэдсэн зарчмуудаа ойлгоход нь туслах зураг эсвэл үзүүлэнг ашиглах талаар бодож үз.



Бид Христийн сайн мэдээнд хөрвөх үедээ Паулын дүрсэлснээр "шинэ бүтээл" (2 Коринт 5:17) болдог ба үнэхээр гүн гүнзгий өөрчлөлт ирдэг.



9-Р САРЫН 16-22

2 Коринт 8–13

“Бурхан баяртайгаар өгөгчийг хайрладаг”

Сүнслэг сэтгэгдлээ бичиж тэмдэглэх нь судар судалж байх үедээ сурсан зүйлсээ эргэн санахад тус болно. Та судрын тэмдэглэлдээ бичиж, судрынхаа зайд тэмдэглэж, Gospel Library аппликэйшнд тэмдэглэл нэмж эсвэл санаа бодлоо дуу хураагуурт бичиж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Та өөр бүсэд байдаг гэгээнтнүүд ядуурал, хомсдоос болж зовж байгаа гэж сонсвол юу хийх вэ? 2 Коринт 8–9-д Паул Коринт дахь гэгээнтнүүдэд ийм байдлыг дүрслэн хэлсэн. Тэрээр Коринт дахь гэгээнтнүүдийг элбэг хангалуун зүйлсээсээ тусламж хэрэгтэй гэгээнтнүүдэд хандивлахад ятгана гэж найдаж байсан. Харин Паулын үгс хандив хүсэхээс илүү “Хүн бүр зүрхэндээ шийдсэнчлэн харамгүйгээр, албадлага бусаар өгөгтүн. Учир нь Бурхан баяртайгаар өгөгчийг хайрладаг” (2 Коринт 9:7) хэмээх

өгөхийн бүрэн үнэнийг мөн агуулж байсан. Бидний үед ч дэлхий даяар тусламж хэрэгтэй гэгээнтнүүд байсаар *байгаа*. Заримдаа бидний хийж чадах бүх зүйл мацаг барьж, мацгийн өргөл өргөх явдал байдаг. Өөр тохиолдлуудад бид илүү хувийн байдлаар, шууд тусламж үзүүлж болдог. Бид ямар ч хэлбэрийн золиослол гаргасан бай, өгөх сэтгэлээ сорьж үзэх нь үнэ цэнтэй зүйл юм. Бидний золиослол хайрын илэрхийлэл мөн үү? Эцсийн дүнд өгөгчийг баясгадаг зүйл нь хайр байдаг.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

2 КОРИНТ 8:1–15; 9:5–15

Би ядуус, тусламж хэрэгтэй хүмүүсийг адислахын тулд өөртөө байгаа зүйлсийг баяртайгаар хуваалцаж чадна.

Дэлхий даяар тусламж хэрэгтэй маш олон хүн байдаг. Бид хэрхэн өөрчлөлт гаргах боломжтой вэ? Ахлагч Жэффри Р.Холланд “Бид ядуу эсвэл баян аль нь ч байсан ялгаагүй бусдад тусламж хэрэгтэй үед ‘хийж чадахаа л хийх ёстой’ гэдэг нь ямар гайхалтай сануулга вэ? [Марк 14:6, 8-ыг үзнэ үү]. . . . Хэрвээ бид [Бурханы] өгсөн зарлигуудыг биелүүлэх арга замуудыг чин сэтгэлээсээ хайж, залбирч, дахин дахин эрэлхийлбэл Тэрээр та нарыг шавь байх энэрэл хайрын үйлсэд тань удирдан чиглүүлж, туслах болно” (“Бид бүгд гуйлгачид бус уу?” 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 47–48) хэмээн зөвлөсөн.

2 Коринт 8:1–15; 9:6–15-ыг уншаад, ядуус, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах тухай Паулын заасан зарчмуудыг тэмдэглэж аваарай. Паулын зөвлөгөөний юу нь таныг сүнслэгээр өдөөж байна вэ? Та тусламж хэрэгтэй хүнийг адислахын тулд юу хийж болох талаар удирдамж хүсэн залбирч болно. Хүлээн авсан аливаа мэдрэмж сэтгэгдлээ бичиж аван, үйлдэл болгохоо бүү мартаарай.

Түүнчлэн Мозая 4:16–27; Алма 34:27–29 болон Хэнри Б.Айринг, “Үүний тулд мацаг барилтыг Би сонгосон бус уу?” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 3–7; Линда К.Бертон, “Намайг харь хүн байтал,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 125–128-ыг үзнэ үү.

2 КОРИНТ 11

Хуурамч бошиглогчид хууран мэхлэхийг оролддог.

Коринт дахь гэгээнтнүүдийн дунд “хуурамч элч нар” гарч ирсэн гэдгийг мэдэх нь энэхүү бүлгийг ойлгоход тань тус болох байх (2 Коринт 11:13). Та 13–15-р шүлгээс хуурамч сургаал заадаг хүмүүсийн талаар юу мэдэж болох вэ? Христийн тохинуулагчийн хувьд Паулын үзсэн туршлагын талаар уншихдаа та жинхэнэ бошиглогчийн тухай юу сурч болох вэ? (23–33-р шүлгийг үзнэ үү).

2 КОРИНТ 11:3; 13:5–8

Би Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэлтэй байдлаа “шалгах” хэрэгтэй.

Өнөө үед “Христ уруу хандсан [цэвэр,] энгийн байдлаас” (2 Коринт 11:3) биднийг холдуулахыг эрэлхийлдэг олон хүн байдаг учраас “та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга” (2 Коринт 13:5) гэсэн Паулын урилгыг хүлээн авч болно. Жишээлбэл, та Христэд төвлөрөхөд амьдралаасаа юуг холдуулбал тус болохыг тунгаан бодож болно эсвэл *Миний сайн мэдээг номло* удирдамжийн 143-р хуудсан дахь “Зан чанарын үйл ажиллагаа”-г хийж болно.

2 КОРИНТ 12:2–4

“Гурав дахь тэнгэр” гэж юу вэ? Тэнд “аваачигдсан” хүн хэн байсан бэ?

Эдгээр шүлэгт Паул өөрийнхөө гайхамшигтай үзэгдлийн тухай сайрхан ярихаас зайлсхийн, шуудхан өөрийгөө дурдахгүйгээр өөрийнхөө тухай ярьж байсан. “Гурав дахь тэнгэр” хэмээх хэллэг нь селестиел хаант улсыг хэлж байна (С ба Г 76:96–98-ыг үзнэ үү).

2 КОРИНТ 12:5–10

Аврагчийн нигүүлсэл нь сул дорой байдалдаа хүчийг олоход минь туслахад хангалттай юм.

Паулын “махан биед минь өргөс” өгөгдсөн гэж хэлсэн нь юу болохыг бид мэдэхгүй ч үүнийг авч хаях түүний хүсэлтэй өөрсдийгөө холбох нь амархан. Их Эзэний бидний амьдралаас салган холдуулах нь зохистой бус хэмээн үздэг бэрхшээл, асуудлууд бид бүгдэд бий. 2 Коринт 12:5–10-ыг уншихдаа өөрийн сорилт бэрхшээлүүдийн тухай бод. Паул сул дорой байдлын талаар юу заасан бэ? Бурханы нигүүлсэл танд хангалттай гэдэг нь таны хувьд ямар утга учиртай вэ? Та Бурханы хүчирхэгжүүлэгч хүчийг мэдэрч байсан уу?

Түүнчлэн Мозая 23:21–24; 24:10–15; Ифер 12:27; Моронай 10:32–33-ыг үзнэ үү.

2 КОРИНТ 13:1.**Паул “хоёр буюу гурван гэрч” гэж ярихдаа юуг илэрхийлсэн бэ?**

Хуучин Гэрээний үед хэн нэгний эсрэг зарга мэдүүлэхдээ хоёр буюу гурван гэрч байх шаардлагатай байсан (Дэд хууль 19:15). Паул гурав дахь

удаагаа Коринтод очихдоо энэхүү дадлыг эш татсан. Олон гэрчийн энэхүү зарчмын өнөө үеийн жишээ бол Мормоны Номын Гурван гэрч, Ариун Библи, Мормоны Ном хоёрт агуулагддаг Есүс Христийн талаарх гэрчлэл, хамтралаараа гэрчилдэг номлогчид, гэрийн болон айлчлагч багш нар юм.

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

2 КОРИНТ 8-9

Та эдгээр бүлгээс танай гэр бүлийг ядууст болон тусламж хэрэгтэй хүмүүст туслахад сүнслэгээр өдөөх юуг олж мэдсэн бэ? Энэ нь гэр бүлээрээ тусламж хэрэгтэй хэн нэгэнд үйлчлэх төлөвлөгөө гаргахад тохиромжтой цаг байж болох юм.

2 КОРИНТ 9:6-7

Танай гэр бүлийнхэн “баяртай өгөгч” хэмээн дүрслэн хэлж болох хэн нэгнийг таних уу? Бид бусдад үзүүлэх үйлчлэлээ хэрхэн илүү баяр хөөртэй болгож болох вэ?

2 КОРИНТ 10:3-7

Та гэр бүлдээ ёс бусын эсрэг “байлдааны зэвсгийн хээ” тухай хэрхэн тайлбарлаж болох вэ? Танай гэр бүл сандал, хөнжил ашиглан майхан эсвэл хана барихдаа дуртай болов уу? Энэ нь биднийг Бурханаас холдуулдаг зүйлсийг хэрхэн устгаж, “ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд [олзлуулах]” тухай ярилцахад чиглүүлж болно. Бодол санаагаа хянахад бидний ашигладаг сүнслэг “зэвсгүүд” юу вэ? (Ефес 6:11–18-ыг үзнэ үү).

2 КОРИНТ 11:3

Танай гэр бүл “Христ уруу хандсан [цэвэр,] энгийн байдалд” анхаарлаа төвлөрүүлэхийн тулд юу хийж болох вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ. Ахлагч Ричард Г.Скотт “Нягт нямбай хөтөлсөн мэдлэг бол хэрэг болсон үед бэлэн байдаг мэдлэг юм. . . . [Сүнслэг удирдамжийг тэмдэглэж авах нь] цаашид улам их гэрэл хүлээн авах магадлалыг нэмэгдүүлдэг” (“Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, Nov. 1993, 88 мөн *Аврагчийн арга барилаар заах нь*, 12, 30).



"Хүн бүр зүрхэндээ шийдсэнчлэн харамгүйгээр, албадлага бусаар өсөөглүн. Учир нь Бурхан баяртайгаар өсөгчийг хайрладаг" (2 Коринт 9:7).



9-Р САРЫН 23-29

Галат

“Сүнсээр яв”

Та Галатыг уншиж байхдаа хүлээн авсан сэтгэгдлээ бичиж тэмдэглээрэй.
Ийн үйлдэх нь тэдгээрийг ирээдүйд санаж, тунгаан бодоход танд тусална.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Есүс Христийн сайн мэдээ нь сүнслэг боолчлолоос чөлөөлөгдөх боломжийг олгодог. Гэвч заримдаа сайн мэдээний эрх чөлөөг мэдэрсэн хүмүүс эргээд “бүр дахин боолчлогдохыг хүсдэг” (Галат 4:9). Галат дахь гэгээнтнүүд ийнхүү Христийн санал болгосон эрх чөлөөнөөс нүүр буруулж байсан (Галат 1:6-г үзнэ үү). Галатчуудад зориулсан Паулын захидал тэр үед “Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд

чөлөөлсөн” (Галат 5:1) тэрхүү эрх чөлөө рүү эргэн ирэхийг хүссэн чухал дуудлага байсан. Энэ нь түүнчлэн бидний сонсож мөн анхаарвал зохих дуудлага юм. Учир нь нөхцөл байдал өөрчлөгдөж байхад эрх чөлөө, боолчлол хоёрын хоорондох тэмцэл хувирдаггүй. Паулын зааснаар “эрх чөлөө уруу дуудагдах” (Галат 5:13) нь хангалттай биш, харин бид Христэд тулгуурлан тэнд “бат зогсох” (Галат 5:1) ёстой.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ГАЛАТ 1-5

Христийн хууль надад эрх чөлөө олгодог.

Паул Галатын гэгээнтнүүдийг хуурамч сургаалыг даган замаасаа хазайж байгааг сонсоод, тэдэнд хандан бичжээ. Эдгээр сургаалын нэг нь сайн мэдээг хүлээн авсан харийнхан аврагдахын тулд хөвч хөндүүлж, Мосегийн хуулийн бусад уламжлалыг дагах хэрэгтэй гэсэн сургаал байв. Паул эдгээр уламжлалыг “боолчлолын буулга” (Галат 5:1) хэмээн нэрлэсэн учир нь эдгээр нь гэгээнтнүүдийг жинхэнэ эрх чөлөөг авчирдаг Христийн хуулийн дагуу бүрэн дүүрэн амьдрахад саад болж байсан. Та Паулын галатчуудад өгсөн зөвлөгөөнөөс жинхэнэ эрх чөлөө гэж юу болохыг ойлгоход тань тусалж болох юуг олсон бэ? Мөн та амьдралд тань ямар боолчлолын буулга байж болохыг тунгаан бодож болно. Сайн мэдээний өгдөг эрх чөлөөг мэдрэхэд тань саад болж байгаа ямар нэгэн зүйл байна уу? Христ болон Түүний сайн мэдээ хэрхэн “[тань] эрх чөлөөтэй болгосон” бэ? (Галат 5:1).

Түүнчлэн 2 Нифай 2:27; 9:10–12-ыг үзнэ үү.

ГАЛАТ 3

Би Абрахамд амлагдсан адислалын өв залгамжлагч мөн.

Галат дахь зарим гэгээнтэн Абрахамын шууд удам (“үр удам”) биш болохоор Абрахамд амлагдсан адислал, тэр дундаа өргөмжлөлийг хүлээн авахгүй хэмээн санаа зовж байсан. Галат 3:7–9, 13–14, 27–29-д цэдэглэсэнээр хүнийг “Абрахамын үр” гэж юу тодорхойлдог вэ? Абрахамд амлагдсан адислалууд, түүний үр удмын хувьд бидний өвлөн авч болох адислалуудын талаар Судруудын удирдамжийн “Абрахамын гэрээ”-г үзнэ үү.

ГАЛАТ 3:6–25

Абрахамд Есүс Христийн сайн мэдээ байсан уу?

Бошиглогч Иосеф Смит “Эрт дээр үед амьдарч байсан бүх насны хүмүүс тэнгэрийн тогтолцоонд тоомжиргүй ханддаг байсан гэж олон хүн таамагладаг ч бид үүнд итгэж болохгүй. Учир нь бүх цаг үед буюу Христийг ирэхээс өмнө мөн дараа нь амьдарч

байсан аврагдсан хүмүүс энэхүү гэтэлгэлийн агуу төлөвлөгөөний хүчээр аврагдсан юм. . . . Абрахам өргөл өргөсөн. Гэсэн ч түүнд Сайн мэдээг заасан” хэмээн тайлбарласан (“The Elders of the Church in Kirtland to Their Brethren Abroad,” *The Evening and the Morning Star*, Mar. 1834, 143, josephsmithpapers.org). Мөн Хиламан 8:13–20; Мосе 6:50–66 гэсэн судрууд Есүс Христийн сайн мэдээг Аврагчийн мөнх бус амьдрал дахь тохинууллаас өмнө номлож байсан гэдгийг харуулдаг.

ГАЛАТ 5:13–26; 6:7–10

Хэрэв би “Сүнсээр явбал” “Сүнсний үр жимсийг” хүлээн авах болно.

Эдгээр шүлгийг судлах нь танд Сүнсээр хэр зэрэг бүрэн дүүрэн явж байгаагаа дүгнэхэд туслах боломжтой. Та 22–23-р шүлэгт дурдагдсан Сүнсний үр жимсийг хүртэж байгаа юу? Та сүнслэг амьдралын өөр ямар үр жимс эсвэл үр дүнг анзаарсан бэ? Энэхүү үр жимсийг илүү гүйцэд боловсруулахын тулд юу хийх хэрэгтэйгээ тунгаан бод. Энэ үр жимсийг боловсруулах нь таны амьдралын чухал харилцаануудыг хэрхэн сайжруулж болох вэ?



Би амьдралдаа “Сүнсний үр жимсийг” эрэлхийлэх ёстой.

Та Сүнсээр явахыг хичээсэн ч таны хичээл зүтгэл амлагдсан үр жимсийг ургуулахгүй байгаа мэт санагдаж магадгүй. Галат 6:7–10-ыг унш (ихэвчлэн ургачын хууль гэгддэг). Эдгээр шүлэгт Их Эзэний танд зориулсан ямар захиас байгаа гэж танд санагдаж байна вэ? Та эдгээр шүлгийг сайн мэдээг дагахдаа бэрхшээлтэй тулгарч байгаа хүнийг урамшуулахад хэрхэн ашиглаж болох вэ?

Мөн Алма 32:28, 41–43; Сургаал ба Гэрээ 64:32–34-ийг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ГАЛАТ 3:11

“Итгэлээр амьдрах” гэдэг нь ямар утгатай вэ? Таныг итгэлээр амьдарч байгаа гэдгийг харуулахын тулд танай гэр бүл юу хийж байна вэ?

ГАЛАТ 4:1-7

Та хааны зарц нар болон түүний хүүхдүүдийн хоорондын ялгааг хэлэлцсэнээр Галат 4-ийг танилцуулж болно. Хааны хүүхдэд зарцад байхгүй ямар боломж, боллоцоонууд байдаг вэ? 1–7-р шүлгийг хамт уншихдаа энэ талаар бодоорой. Эдгээр шүлэг Тэнгэрлэг Эцэгтэй харилцах бидний харилцааны талаар юу заадаг вэ?

ГАЛАТ 5:22-23

Галат 5:22–23-ын талаарх ярилцлагаа илүү хөгжилтэй болгохын тулд “Сүнсний үр жимсийг” дүрслэхдээ ашигласан Паулын үгсээр өөр өөр төрлийн жимснүүдэд шошго тавьж болно. Тэгээд гэр бүлийн гишүүн бүр нэг нэг жимс сонгон авч, үүнийгээ

тодорхойлон, тэр жимс мэт үлгэр жишээ болсон хэн нэгний талаар ярьж болно. Энэ нь Сүнсийг гэр орондоо урих болон уг жимсээ боловсруулж болох арга замуудын талаар ярилцахад танай гэр бүлийнхнийг чиглүүлж болох юм. Ярилцлагын дараа хамтдаа жимсний салад идэж болно.

ГАЛАТ 6:1

Танай гэр бүлээс нэг нь “ямар нэгэн буруу юманд эзэмдүүлсэн” тохиолдол байж болно. Та тийм тохиолдолд юу хийх талаар Галат 6:1-ээс ямар зөвлөмж олсон бэ?

ГАЛАТ 6:7-10

Танай гэр бүл хамтдаа ямар нэгэн зүйл тарьж байсан бол “хүн юу тарьснаа л хурааж авдаг” (7-р шүлэг) гэсэн зарчмыг дүрслэхдээ тэрхүү туршлагаа ашиглаж болно. Эсвэл та гэр бүлийн гишүүдээсээ ямар жимс эсвэл ногоонд дуртайг нь асуугаад, тэр жимс, ногоог ургуулахын тулд юу хийх хэрэгтэй талаар ярилцаж болох юм. (Энэхүү тоймд хавсаргасан зургийг үзүүлэн болгон ашиглаж болно.) Дараа нь танай гэр бүл ямар адислалуудыг хүлээн авахыг хүсэж байгаа болон тэдгээрийг хэрхэн “хурааж авах” тухай ярилцаж болно.

Заах чадвараа сайжруулах

Гэр бүлдээ судруудыг өөрсөдтэйгөө адилтгахад тусал. Нифай “бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгасан билээ” (1 Нифай 19:23) хэмээн хэлсэн байдаг. Гэр бүлдээ үүнийг хийхэд нь туслахын тулд тэднийг Галат 5:22–23-т дүрслэгдсэн Сүнсний үр жимсийг хүртэж байсан үеийнхээ тухай тунгаан бодохыг хүсэж болно. (*Аврагчийн арга барилаар заах нь*, 21-ийг үзнэ үү.)



Бид Сунстэй хамт явах үедээ амьдралдаа Сүнсний үр жимсийг хүртэх болно хэмээн Паул заасан.



9-Р САРЫН 30-ААС 10-Р САРЫН 13

Ефес

“Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэхийн төлөө”

Та Ерөнхий чуулганы захиасууд ба ефесчүүдэд хандан бичсэн Паулын захидлын хоорондох ямар нэгэн холбоог харж байна уу?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Ефест сайн мэдээ түгэх үед энэ нь ефесчүүдийн дунд “багагүй үймээн” (Үйлс 19:23) дэгдээв. Тэрсүүд үзлийн охин тэнгэрт зориулан хиймэл шүтээнүүдийг хийдэг орон нутгийн гар урчууд Христийн шашныг амьдралынх нь амь зуулгад заналхийлж байна гэж үзсэн бөгөөд удалгүй “тэд хилэгнэн уурлаж, . . . хот үймээн самуунд автжээ” (Үйлс 19:27–29-ийг үзнэ үү). Ийм нөхцөл байдалд сайн мэдээнд шинээр хөрвөгдөж байна гэж төсөөл. Ефесчүүдийн олон нь энэхүү “үймээн самуун” (Үйлс 19:40) дунд сайн мэдээг

хүлээн авч, үүний дагуу амьдарч байсан ба Паул тэдэнд “Христ . . . Өөрөө бидний энх тайван” (Ефес 2:13–14) гэж итгүүлсэн. Эдгээр үг нь “аливаа хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг” (Ефес 4:31) хэмээх түүний урилгын хамт тэр үеийнхтэй адил одоо ч цагаа олж, тайтгаруулж байгаа санагддаг. Ефесчүүдийн болон таны хувьд дайсантай нүүр тулах хүч “Эзэн дотор ба Түүний чадлын агуу хүч дотроос” (Ефес 6:10–13) ирдэг.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ЕФЕС 1:4-11, 17-19

Бурхан зарим хүүхдээ аврахын тулд “сонгосон” эсвэл “урьдаас тогтоосон” уу?

Паул гэгээнтнүүдийн талаар Бурханы хүмүүс байхаар Түүгээр “урьдаас тогтоогдсон” ба “ертөнцийн сууриас урьд . . . сонгогдсон” хэмээн ярьсан. Ерөнхийлөгч Хэнри Б.Айрингийн анзаарснаар маш олон хүн сайн мэдээг хүлээн авах боломжгүй байдалд амьдарч мөн нас бардаг нь зарим хүнийг “Бурхан аль хүүхдээ аварч, алинд нь сайн мэдээнээс сонсох боломж олгохоо урьдаас тодорхойлсон бөгөөд сайн мэдээг огт сонсож байгаагүй хүмүүс ердөө л ‘сонгогдоогүй’ байх гэсэн дүгнэлт хийхэд хүргэдэг. Гэхдээ . . . Бурханы төлөвлөгөө үүнээс хамаагүй энэрэнгүй. Тэнгэрлэг Эцэг маань гэр бүлийнхнийгээ бүрэн цуглуулж, адислахыг тэсэн ядан хүлээж байгаа” (“Бурханы гэр бүлийг цуглуулах нь,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 4). Бурханы бүх хүүхэд ариун сүмүүдэд хийгддэг нас барагсдын төлөө ажлаар дамжуулан сайн мэдээг болон үүний ёслолуудыг хүлээн авах боломжтой.

Хэн ч аврагдана эсвэл аврагдахгүй гэж урьдаас тогтоогдоогүй ч хожмын үеийн илчлэлтэд зарим нь энэ дэлхийд тодорхой үүрэг хариуцлага гүйцэлдүүлэхээр мөнх бус амьдралын өмнөх дэлхийд сонгогдсон эсвэл “урьдаас тогтоогдсон” гэж заадаг. Үүнд бүх хожмын үеийн гэгээнтэн сайн мэдээг хуваалцаж, хөшигний хоёр талд байгаа Бурханы бүх хүүхдэд Христэд ирэхэд нь туслах үүрэг багтана.

ЕФЕС 1:10

Бурхан “бүх юмсыг Христ дотор нэгтгэх” болно.

Та “цагийн дүүрнийг гүйцэлдүүлэх” гэж юу болох эсвэл “бүх юмсыг Христ дотор нэгтгэх” гэж ямар утгатай талаар бодож байсан уу? Та эдгээр хэллэгийн тухай тунгаан бодохдоо дараах судруудыг уншаарай. Ефес 4:13; 2 Нифай 30:7-8; Сургаал ба Гэрээ 110:11-16; 112:30-32; 128:18-21. Та эдгээр хэллэгийн талаар өөрийн тайлбарыг бичих сүнслэг өдөөлтийг авч болох юм.

ЕФЕС 2:19-22; 4:11-16

Сүм бошиглогч, төлөөлөгчид дээр суурилагдсан бөгөөд Есүс Христ булангийн чулуу нь юм.

Төлөөлөгчид, бошиглогчдын талаар Паулын заасан зүйлсийг унших нь Ерөнхий чуулганы үеэр өнөө үеийн төлөөлөгч, бошиглогчдын захиасыг сонсоход бэлтгэхэд тань туслах боломжтой. Ефес 2:19-22; 4:11-16-д цэдэглэснээр яагаад бидэнд бошиглогч, төлөөлөгчид байдаг вэ? Тэдний сургаал “аливаа номлолын салхинд . . . туугдалгүй” байхад тань хэрхэн тусалж байсан бэ?

Мөн Үйлс 4:10-12-ыг үзнэ үү.

ЕФЕС 5:21-6:4

Би гэр бүлийнхээ харилцааг хүчирхэгжүүлж чадна.

Ефес 5:21-6:4-ийг уншиж байхад тань гэр бүлийнхээ харилцааг хэрхэн хүчирхэгжүүлэх тухай ямар ямар бодол төрж байна вэ?

Ефес 5:22 дахь Паулын үгс түүний үеийн нийгмийн уламжлалын байдлаар бичигдсэнийг анзаарах нь чухал. Өнөө үеийн бошиглогч, төлөөлөгчид эргэ-тэйчүүд бол эмэгтэйчүүдийн дарга нь биш, харин хань ижил нь буюу “адил тэгш” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign* эсвэл *Liahona*, May 2017, 145) хамтрагчид байх ёстой хэмээн заадаг. Гэсэн ч Ефес 5:23-33-аас ялангуяа та гэрлэсэн эсвэл гэрлэхээр бэлдэж байгаа бол чухал зөвлөмжийг олох боломжтой. Жишээ нь, Христ гэгээнтнүүдэд хайраа хэрхэн үзүүлдэг вэ? Энэ нь нөхрүүд эхнэрүүддээ хэрхэн хандах талаар юу заадаг вэ? Та эдгээр шүлгээс өөртөө тохирох ямар захиасыг олсон бэ?

ЕФЕС 6:10-18

“Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөх” нь хилэнцээс хамгаалахад надад туслах болно.

Та Ефес 6:10-18-ыг уншихдаа Паул яагаад хуяг дуулгын хэсэг бүрийг ийнхүү нэрлэсэн болохыг

эргэцүүлэн бод. “Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөх” нь биднийг юунаас хамгаалах вэ? Та өдөр бүр хуяг дуулгын хэсэг бүрийг бүрэн өмсөхийн тулд юу хийж чадах вэ?

Түүнчлэн 2 Нифай 1:23; Сургаал ба Гэрээ 27:15–18-ыг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ЕФЕС 1:10

Хожмын үеийн Сэргээлтээр дамжуулан Бурхан сайн мэдээний бүх зарчим, ёслол зэрэг бүхий л зүйлийг нэг болгон цуглуулж байна. Энэхүү санааг үзүүлэхийн тулд та өнөө үед сэргээгдсэн зүйлсийг төлөөлөх эд зүйлс эсвэл бичсэн хэллэг зэргийг гэртээ нууж болно (жишээ нь, *санваарын түлхүүр, ариун сүмийн ёслол, судар болон сүнсний бэлэг* байж болно). Гэр бүлийн гишүүд хамтдаа тэдгээрийг эрж хайн, цуглуулж болно. Бид яагаад “цаг хугацааны бүрэн байдлын эрин үед” амьдарч байгаадаа талархалтай байдаг вэ?

ЕФЕС 2:4–10; 3:14–21

Гэр бүлийн гишүүдээ эдгээр шүлэгт дүрслэгдсэн Бурханы болон Есүс Христийн хайр, нигүүлслийг мэдэрч байсан туршлагаасаа хуваалцахад урь.

ЕФЕС 2:12–19

Дэрээр эсвэл гэртээ байгаа ямар нэгэн зүйлээр хана босгоод, дараа нь нураах нь гэр бүлийнхний тань хувьд зугаатай байж болох юм. Өнөөдөр хүмүүсийг ямар ямар төрлийн хана тусгаарлаж байгаа вэ? Есүс Христ Бурхан болон бидний хооронд байсан “хуваагдлын ханыг ба дайсагналыг Өөрийн махан бие дотор устгав”.

ЕФЕС 6:10–18

Танай гэр бүл гэртээ байгаа зүйлсээ ашиглан өөрсдийн гэсэн “Бурханы хуяг дуулга” хийж болно. “Бурханы хуяг дуулга” видео бичлэг нь гэр бүлийн гишүүдэд энэхүү хуяг дуулгыг төсөөлөн ойлгоход тусалж болох ба тэд “Бурханы бүрэн хуяг дуулга” (*Лиахона*, 2016 оны 6-р сар, 70–71) дээрээс энгийн тайлбар олж болно. Хуяг дуулгын хэсэг бүр биднийг сүнслэг байдлаар хэрхэн хамгаалах вэ? Бид өдөр бүр “Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөхөд” (Ефес 6:11) нь нэг нэгэндээ хэрхэн тусалж чадах вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Суралцах явцыг тань удирдах боломжийг Сүнсэнд олго. Сүнс таныг өдөр бүр сурах ёстой зүйлс рүү тань чиглүүлэхэд, бүр анх судлахаар төлөвлөж байснаас өөр сэдэв рүү чиглүүлсэн ч Сүнсэнд мэдрэмжтэй ханд.



Бурханы хуяг дуулгыг өмсөх нь биднийг сүнслэг байдлаар хамгаална.



10-Р САРЫН 14-20

Филиппой; Колоссай

“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна”

Та хэзээ хамгийн сүүлд Шинэ Гэрээнээс суралцах үедээ бичиж авсан сүнслэг сэтгэгдлээ уншсан бэ? Хүлээн авч байгаа сүнслэг өдөөлтүүдээ эргэн харж байх нь тустай байж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Паул филиппойчууд болон колоссайчуудад хандсан захидлуудаа шоронд хоригдож байхдаа бичсэн. Гэвч эдгээр захидал нь шоронд байгаа хүн бичсэн гэмээр өнгө аясгүй. Паул зовлон зүдгүүр, сорилт бэрхшээлээс илүү баяр баясал, баярлах, талархах тухай илүү ярьсан байдаг. Тэрээр “Христ тунхаглагдаж байна. Үүнд л би баярладаг. Мөн баярлах ч болно” (Филиппой 1:18) хэмээсэн. “Хэдийгээр би биеэрээ байхгүй байгаа боловч . . . Христэд итгэх та нарын итгэлийн бат байдлыг хараад, баярлан би сүнсээрээ та нартай хамт байна” (Колоссай 2:5).

Паулын хүнд хэцүү нөхцөл байдалд хүлээн авсан “Бурханы амар тайван” үнэндээ “бүх оюун ухаанаас дээгүүр” (Филиппой 4:7) байсан ч тэр нь жинхэнэ байсан юм. Бид өөрсдийн сорилт бэрхшээлд энэхүү амар тайвныг мэдэрч, “Эзэний дотор үргэлж баярлаж” чадна (Филиппой 4:4). Паулын адил бид ч бас “дотор [нь] зोलилт [байдаг]” (Колоссай 1:14) Есүс Христэд бүрэн тулгуурлаж болно. Бид Паул шиг “Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13; мөн Колоссай 1:11-ийг үзнэ үү) хэмээн хэлж чадна.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ФИЛИППОЙ 2:12-13

Бид “өөрсдийн авралыг биелүүлдэг” үү?

“Өөрсдийн авралыг биелүүлэгтүн” хэмээх хэллэгийг зарим хүн бид зөвхөн өөрсдийн хичээл зүтгэлээр аврагдах болно гэсэн санааг дэмжихийн тулд хэрэглэдэг. Гэвч энэ нь “нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм” (Ефес 2:8) хэмээх Паулын заасан сургаалыг аврагдахад хичээл зүтгэл хэрэггүй гэсэн утгаар ойлгодгийн адил хязгаарлагдмал үзэл юм. Судрууд, тэр дундаа Паулын бичээсүүд авралыг хүлээж авахад Есүс Христийн нигүүлсэл, хувийн хүчин чармайлт хоёул шаардагддаг гэдгийг тодорхой заадаг. Нифайн хэлснээр “ач ивээлээр л бид аврагдаж чадна . . . бидний хийж чадах бүхний дараа буюу” (2 Нифай 25:23). Өөрсдийн авралыг биелүүлэх хүчин чармайлтад ч “та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм” (Филиппой 2:13 мөн Филиппой 1:6; Судруудын удирдамжийн “Ач ивээл”-ийг үзнэ үү).

ФИЛИППОЙ 3:5-14

Есүс Христийн сайн мэдээ гаргасан золиослол бүрийн үнэ цэнтэй.

Паул Есүс Христийн сайн мэдээнд хөрвөгдөхдөө фарисай хүний хувиар иудейчүүдийн нийгэмд эзэлж байсан байр суурь гэх мэт олон зүйлээсээ татгалзсан. Филиппой 3:5-14-өөс Паул сайн мэдээний төлөө золиослол хийхэд бэлэн байснаар юу олж авсныг эрж ол. Тэр золиослолуудынхаа талаар ямар бодолтой байсан бэ?

Дараа нь та өөрөө ямархуу шавь байгаа талаараа эргэцүүлэн бод. Та Есүс Христийн сайн мэдээний төлөө ямар золиослол хийсэн бэ? Та юу хүлээж авсан бэ? Аврагчийн илүү үнэнч шавь болохын тулд нэмж золиослох хэрэгтэй гэж бодож байгаа зүйл танд байна уу?

Түүнчлэн 3 Нифай 9:19-20; Сургаал ба Гэрээ 58:2-5; Роберт С.Гей, “Амиа сольж авахын тулд хүн юугаа өгөх юм бэ?” 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 42-45-ыг үзнэ үү.

ФИЛИППОЙ 4:1-13

Би нөхцөл байдлаасаа үл хамааран Христ дотор баяр баяслыг олж чадна.

Паулын амьдрал ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны илэрхийлсэн үнэний тод томруун жишээ юм. “Бид . . . амьдралаа . . . Есүс Христэд болон Түүний сайн мэдээнд төвлөрүүлбэл юу тохиолдож, юу тохиолдохгүй байгаагаас үл хамааран баяр баясгаланг мэдрэх боломжтой. Баяр баясгалан Түүний ачаар, Түүнээс ирдэг” (“Баяр баясгалантай байж, сүнслэг байдлын хувьд тэсэж үлдэх нь,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 71-74) хэмээн ерөнхийлөгч Рассэлл М. Нэлсон илэрхийлсэн.

Та Филиппой буюу ялангуяа 4-р бүлгийг уншихдаа амьдралынхаа ямар ч нөхцөл байдалд баяр баяслыг олоход тань туслах мэдэгдлийг эрж хай. Та хэзээ сорилт бэрхшээлтэй үедээ “Бурханы амар тайвныг” мэдэрсэн бэ? (7-р шүлэг). Та хэзээ хүнд хэцүү зүйл хийхдээ “Христээр” хүч олж байсан бэ? (13-р шүлэг). Яагаад бүх нөхцөл байдалд “сэтгэл хангалуун байх” нь чухал гэж та бодож байна вэ? (11-р шүлэг). 8-р шүлэг дэх зан чанаруудыг хэрэгжүүлэх нь байгаа нөхцөл байдалдаа баяр баяслыг олоход хэрхэн туслах вэ?

Алма 33:23-ыг мөн Дийтр Ф.Угдорфын “Ямар ч нөхцөл байдалд талархалтай байх нь” үгийг 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулганы 90-93-р хуудаснаас үзнэ үү.

КОЛОССАЙ 1:12-23

Миний итгэл Есүс Христэд суурилдаг.

Дараах суралцах арга барилыг судрын ямар ч бүлгээс суралцахдаа ашиглаж болох ч ялангуяа Колоссай 1:12-23-ыг судлахдаа ашиглавал хамгийн тохиромжтой. Есүс Христийн талаар ямар нэгэн зүйлийг сурах шүлгүүдийг хайж олоод, олсон зүйлсээ жагсаан бич. Аврагчийн талаарх эдгээр зүйлийг мэдэх нь яагаад чухал гэж та бодож байна вэ?

КОЛОССАЙ 3:1-17**Есүс Христийн шавь нар Түүний сайн мэдээний дагуу амьдарснаар “шинэ” болдог.**

Та Есүс Христийн сайн мэдээ таныг “шинэ хүн” болоход тусалж байгаа эсэхийг хэрхэн мэдэх вэ? Үүнийг мэдэх нэг арга бол Колоссай 3:1–17-г судлаад, нэг

жагсаалтан дээр “хуучин хүний” хандлага, зан чанар, үйлдлийг, өөр нэг жагсаалтан дээр “шинэ хүний” хандлага, зан чанар, үйлдлийг бич.

Эдгээр шүлгийг судалсан нь сайн мэдээ таныг хэрхэн өөрчилж байгаа тухай ямар нэгэн бодол төрүүлж байна уу? Ирээдүйд үүнийгээ дахин харж, өсөлт хөгжлийнхөө талаар тунгаан бодож болохын тулд санаа бодлоо бичиж тэмдэглэ.

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ФИЛИППОЙ

Танай гэр бүл *баяр баясал* эсвэл *баярлах* хэмээх үгс Филиппойд байнга давтагдаж байгааг анзаарсан байх. Эдгээр үгсийн аль нэгийг олох бүрдээ Паул баяр баяслыг хэрхэн олж авах тухай юу заасан талаар ярилцаж болно.

ФИЛИППОЙ 2:14-15

Бид хэрхэн “дэлхийд гэрэл мэт үзэгдэж” чадах вэ?

ФИЛИППОЙ 4:8

Танай гэр бүл энэхүү шүлэг дэх дүрслэлд тохирох “бодож санах” юмсыг тодорхойлж болох юм

(түүнчлэн Итгэлийн тунхаг 1:13-ыг үзнэ үү). Танай гэр бүл Паулын зөвлөгөөг дагаснаар хэрхэн адислагдах вэ?

КОЛОССАЙ 1:9-11; 2:2-3

Бид “Бурханы жинхэнэ мэдлэгээр” өсөхийн тулд юу хийж болох вэ? Бид сайн мэдээнээс ямар ямар “мэргэн ухаан болоод мэдлэгийн эрдэнэс” олох вэ?

КОЛОССАЙ 1:23; 2:7

Танай гэр бүл мод тойрон суугаад эсвэл модны зураг (энэхүү тоймд хавсаргасан зураг байж болно) харангаа эдгээр шүлгийг уншиж болно. Христэд “суурилагдсан” ба “бат үндэслэгдсэн” байх гэдэг нь юу гэсэн үг вэ? Бид нэг нэгэндээ сүнс-лэг үндсээ хүчирхэгжүүлэхэд нь хэрхэн тусалж чадах вэ?

Заах чадвараа сайжруулах

Гэрчлэлийнхээ дагуу амьдар. “Та хэн болохоо бусдад заадаг. Та нарын төрх байдал, үлгэр жишээ . . . тухайн хичээл дээрх бодит үнэнээс илүүтэй дурсагдан үлддэг” хэмээн ахлагч Нийл А.Максвэлл заасан (*Аврагчийн арга барилаар заах нь*, 13).



Паул бидний итгэл Есүс Христэд "үндэслэгдсэн" байх ёстой хэмээн заасан (Колоссай 2:7).



10-Р САРЫН 21-27

1 ба 2 Тесалоник

“Та нар ухаан бодлоороо тэр даруй ганхаж дайвалгүй, үймүүлэгдэхгүй байгтун”

Хэрвээ бид Сүнснээс хүлээж авсан сэтгэгдлээ бичиж тэмдэглэхгүй бол тэдгээрийг мартаж магадгүй. 1 ба 2 Тесалоникийг унших үед Сүнс танд ямар мэдрэмж төрүүлж байна вэ?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Тесалоникт Паул, Силас хоёрыг “дэлхийг үймүүлсэн” (Үйлс 17:6) хэмээн гүтгэсэн. Тэдний номлол иудейчүүдийн дундах зарим эрх баригчийн дургүйцлийг төрүүлсэн бөгөөд тэдгээр эрх баригч хүмүүсийг хутган үймүүлжээ (Үйлс 17:1–10-ыг үзнэ үү). Үр дүнд нь Паул, Салис хоёрыг Тесалоникоос явахыг зөвлөв. Паул Тесалоник дахь хөрвөгчдөд болон тэдэнд тулгарч буй хавчин гадуурхах явдлын талаар санаа зовж байсан ч эргэн ирж тэдэнтэй уулзах боломжгүй байв. “Би үүнийг цаашид тэвчиж чадахгүй болов. . . . та нарын итгэлийн талаар мэдэхийн тулд би хүн илгээсэн юм” хэмээн тэр бичсэн. Хариуд нь Тесалоникт үйлчилж байсан Паулын туслах Тимот “та нарын итгэл болон хайрын талаар сайн мэдээг . . .

дуулгав” (1 Тесалоник 3:5–6). Тесалоник дахь гэгээнтнүүд “бүх итгэгчдэд” (1 Тесалоник 1:7) үлгэр жишээ болон танигдаж, тэдний итгэлийн тухай мэдээ хотоос хотод дамжин тархав. Тэдний дунд хийсэн ажил нь “дэмий” (1 Тесалоник 2:1) зүйл биш байсан гэдгийг сонссон Паулын баяр хөөр, тайтгарлыг төсөөлөөд үзээрэй. Гэвч Паул өнгөрсөнд итгэлтэй байсан нь сүнслэг байдлын хувьд тэсэж үлдэхэд хангалттай биш гэдгийг мэдэж байсан бөгөөд гэгээнтнүүдийн дундах хуурамч багш нарын нөлөөнөөс болгоомжилж байв (2 Тесалоник 2:2–3-ыг үзнэ үү). Тэдэнд болон бидэнд хандсан түүний захиас бол үргэлжлүүлэн “итгэлд чинь юу дутагдаж байгааг нь дүүргэх,” “улам илүү” хайрлах явдал юм (1 Тесалоник 3:10; 4:10-ыг үзнэ үү).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 ТЕСАЛОНИК 1-2

Сайн мэдээг тунхаглагчид чин сэтгэл, хайраар номлодог.

1 Тесалоникт Паулын үгс Бурханы хүүхдүүдэд үйлчлэхийн тулд өөрийгөө бүрэн зориулсан хүний зовнил, баяр баяслыг хоёуланг илэрхийлдэг. Ялангуяа 1 Тесалоникийн эхний хоёр бүлгээс та жинхэнэ тохинуулагч сайн мэдээг хэрхэн заадгийг дүрсэлсэн үгс, хэллэгийг олж болно. Та сайн мэдээг заах аргаа сайжруулахын тулд юу хийхэд өдөөгдөж байна вэ?

1 ТЕСАЛОНИК 3:9-4:12

Би Есүс Христийг дагаснаар ариун болж чадна.

Бид бүгдээрээ “бидний Эзэн ирэхэд” “Бурханы . . . өмнө ариун байдал дотор . . . зүрх[ний] гэм зэмгүй” зогсох боломжтой байна гэж найддаг (1 Тесалоник 3:13). Паул 1 Тесалоник 3:9-13; 4:1-12-т илүү ариун болох талаар юу заасан бэ?

Түүнчлэн Моронай 10:32-33; Судруудын удирдамжийн “Ариун байдал” болон Кэрл Ф.Макконкигийн “Ариун байдлын гоо үзэсгэлэн” үгийг 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулганы х. 127-129-өөс үзнэ үү.

1 ТЕСАЛОНИК 4:16-18; 5:1-10; 2 ТЕСАЛОНИК 1:4-10

Хэрэв би итгэлтэй, сэрэмжтэй байвал Аврагчийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэгдсэн байх болно.

Паул 1 Тесалоник 5:1-10 дахь шүлэгт Есүсийн дэлхийд эргэн ирэх цаг хугацааны тухай чухал үнэнийг заахдаа хэд хэдэн зүйрлэл ашигласан. Та эдгээр зүйрлэлийг судлахдаа Есүс Христийн Хоёр дахь ирэлтийн талаар өөрт төрсөн сэтгэгдлийг бичиж тэмдэглэх тухай бодож болно.

“Шөнөөр ирэх хулгайч”:

“жирэмсэн эмэгтэйд төрөлтийн хүчтэй өвдөлт мэдрэгдэх”:

Таны олсон бусад зүйрлэл:

Та 1 Тесалоник 4:16-18; 5:1-10; 2 Тесалоник 1:4-10-аас Есүс Христийн Хоёр дахь ирэлтийн талаар ямар ямар нэмэлт үнэнийг сурсан бэ? Та Түүнийг ирэхэд сэрэмжтэй байж, бэлтгэхийн тулд юу хийхээр өдөөгдөж байна вэ?

Даллин Х.Өүкс, “Preparation for the Second Coming,” 2004 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

2 ТЕСАЛОНИК 2

Урвах буюу үнэнээс холдон салах явдлыг Хоёр дахь ирэлтийн өмнө тохионо гэж бошиглосон.

Өсөн нэмэгдэж буй хавчлага мөрдлөгийн дунд Тесалоникийн олон гэгээнтэн Аврагчийн Хоёр дахь ирэлт ойрхон байна гэдэгт итгэжээ. Гэвч Паул Есүсийг дэлхийд эргэж ирэхээс өмнө урвалт буюу эсэргүүцэл, үнэнээс “салах” явдал гарах болно гэдгийг мэдэж байв (2 Тесалоник 2:1-4-ийг үзнэ үү). Та дараах эх сурвалжуудын заримыг судалснаар Их урвалтын талаарх ойлголтоо мөн Сэргээлтэд талархах сэтгэлээ гүнзгийрүүлж болно.

Урвалтын талаар урьдчилан хэлсэн судрууд:

Исаиа 24:5; Амос 8:11-12; Матай 24:4-14; 2 Тимот 4:3-4

Паулын үед Урвалт аль хэдийн эхэлж байсныг харуулсан судрууд:

Үйлс 20:28-30; Галат 1:6-7; 1 Тимот 1:5-7

Христийн шашинтан шинэчлэгчдийн Их урвалтын талаарх судалгаа:

Мартин Льютер “Би Ариун судруудтай нийцдэг Сүмийг шинэчлэн байгуулахаас өөр юуг ч эрэлхийлээгүй. Энгийнээр хэлбэл, Христийн шашныг хадгалан үлдэх ёстой байсан хүмүүсийн дунд энэ нь байхаа больсон гэж хэлмээр байна” (in E. G. Schweibert, *Luther and His Times: The Reformation from a New Perspective* [1950], 590) гэжээ.

Рожер Виллиамс “Урвалт нь . . . Христ сүмүүдийг шинээр байгуулах шинэ төлөөлөгчдийг илгээхээс нааш урвалтаас сэргэн гарах гарц байхгүй болтлоо тийм ихээр завхарсан байсан” (in Philip Schaff, *The Creeds of Christendom* [1877], 851) гэж хэлжээ

Эрасмус “Одоо бид дэлхийг Христийн үнэн шашинд сэргээнэ гэж найдах ч зориггүй болтол бүх зүйл эдгээр [сургаалын] асуулт, тушаалуудад төөрөлдсөн байна” (*The Praise of Folly*, trans. Clarence H. Miller, 2nd ed. [2003], 155-56) гэж хэлсэн.

Түүнчлэн 2 Нифай 28; Судруудын удирдамжийн “Урвалт,” topics.lds.org-ыг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

1 ТЕСАЛОНИК 3:9-13

Найзуудынхаа төлөө мэдэрч байсан Паулын мэдрэмжүүдийн юу нь таныг гайхшируулсан бэ? Бид гэр бүл, найз нөхөд, гэгээнтэн найзуудынхаа төлөө хэрхэн иймэрхүү мэдрэмжтэй байж чадах вэ?

1 ТЕСАЛОНИК 4:13-18

Бид эдгээр шүлгийг хайртай хүнээ алдсан хэн нэгнийг эсвэл өөрсдийгөө тайтгаруулахад хэрхэн ашиглаж болох вэ?

1 ТЕСАЛОНИК 5:14-25

1 Тесалоник 5:14-25 дахь Паулын зөвлөгөөг дахин үзээд, гэр бүлээрээ анхаарлаа төвлөрүүлэхийг хүсэж байгаа хэллэгийг ол. Үүнийгээ том цаасан дээр бичээд, гэртээ тавьж болно. Гэр бүлийн гишүүд нэг нэгнээ цаасан дээр бичсэн зөвлөгөөний дагуу амьдарч байгааг хараад, үүн дээр тэмдэглэл нэмж болно.

2 ТЕСАЛОНИК 3:13

Бид магадгүй шавь байх шаардлагуудад дарагдан, “сайныг үйлдэхээс зүрхшээдэг” үү? Ингэж мэдрэх үед бидэнд юу тусалдаг вэ? (Галат 6:9; С ба Г 64:33-ыг үзнэ үү.) Бид ийм зүйл тохиолдоход нэг нэгэндээ хэрхэн тусалж чадах вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Өдөр бүр илчлэлт хүлээн авахыг эрэлхийл. “Илчлэлт нь нэг зэрэг биш, харин ихэнх тохиолдолд ‘шат шатаар’ (2 Нифай 28:30) өгөгддөг. . . . [Сайн мэдээний сургалтыг] цаг гарган хийдэг биш, харин үргэлж хийж байх ёстой зүйл гэж бод (Аврагчийн арга барилаар заах нь, 12).



Роберт Т. Баррэтт, Амилсан Христ



10-Р САРЫН 28-ААС 11-Р САРЫН 3

1 ба 2 Тимот; Тит; Филемон

“Чи итгэгч хүмүүст үлгэр дуурайл бол”

Заримдаа судраас судлахдаа дотроо нэг юм уу түүнээс олон асуулт бодож байх нь тустай байдаг. Судалж байхдаа хариултууд руу таныг хөтлөх Сүнсийг урьж, хүлээн авсан аливаа сүнслэг өдөөлтийг бичиж тэмдэглэ.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Тимот, Тит, Филемонд хандан бичсэн Паулын захидлуудаас бид Их Эзэний үйлчлэгчдийн зүрх сэтгэлийг зэрвэсэн хардаг. Бүхэл бүтэн цугларагсдад хандан бичсэн Паулын бусад захидлаас ялгаатай нь, тэрээр эдгээрийг Бурханы ажилд хамтран зүтгэдэг дотнын найзууддаа хандан бичсэн бөгөөд эдгээрийг унших нь харилцан яриаг сонсож байгаа мэт санагддаг. Паул цуглааны хоёр удирдагч болох Тимот, Тит нарыг Сүмийн үйлчлэлд нь урамшуулан

дэмжиж байгааг бид хардаг. Тэрээр гэгээнтэн найзаа уучилж, түүнд сайн мэдээн дэх ах шигээ хандахыг найз Филемонгоос гуйж байгааг мөн хардаг. Паулын үгс нь бидэнд шууд хандан хэлсэн үгс биш бөгөөд нэг өдөр маш олон хүн тэдгээрийг уншина гэж тэр хэзээ ч төсөөлөөгүй байх. Гэсэн ч бид Христ дэх хувийн үйлчлэл маань ямар байхаас үл хамааран эдгээр захидлаас бидэнд хандсан зөвлөмж, урамшууллыг олж уншдаг.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 БА 2 ТИМОТ; ТИТ

Тимот, Тит гэж хэн байсан бэ?

Тимот, Тит хоёр Паулын зарим номлолын аялалд хамт үйлчилж байсан. Үйлчлэлийнхээ үеэр тэд Паулын хүндлэл, итгэлийг олж авсан. Тимот хожим нь Ефес дэх Сүмийн удирдагчаар, харин Тит Кретэд удирдагчаар дуудагдсан юм. Эдгээр захидалд Паул удирдагчдад сайн мэдээг тунхаглах, эрэгтэйчүүдийг бишопоор дуудах зэрэг тэдний үүрэг хариуцлагын талаар заавар, урамшуулал өгсөн.

Судруудын удирдамжаас “Паулын захидлууд,” “Тимот, түүнд бичсэн захидлууд,” “Тит, түүнд бичсэн захидлууд”-ыг мөн үзнэ үү.

1 ТИМОТ 4:10-16

Хэрэв би “итгэгч хүмүүст үлгэр дуурайл” болох юм бол бусдыг Аврагч руу мөн Түүний сайн мэдээ рүү удирдан чиглүүлж чадна.

Тимот харьцангуй залуу байсан ч Паул түүний залуу гэдгийг үл харгалзан Сүмийн агуу удирдагч болж чадна хэмээн итгэж байсан. 1 Тимот 4:10–16-д Паул Тимотод ямар зөвлөгөө өгсөн бэ? Энэ зөвлөгөө бусдыг Аврагч болон Түүний сайн мэдээ рүү удирдан чиглүүлэхэд тань хэрхэн тусалж чадах вэ?

Мөн Алма 17:11-ийг үзнэ үү.

2 ТИМОТ

“Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн.”

2 Тимотыг Паулын бичсэн хамгийн сүүлийн захидал гэж итгэдэг ба үүнээс харахад тэрээр дэлхий дээр байх хугацаа нь богино гэдгийг мэдэж байсан мэт санагддаг (2 Тимот 4:6–8). Та энэхүү захидлыг уншихдаа удахгүй итгэлтэй багш, удирдагч нь үгүй

болох байх гэдгийг мэдэхдээ Тимотын юу мэдэрч байсан тухай бодож үзээрэй. Паул түүнд урам өгөх ямар үгсийг хэлсэн бэ? Паулын үгс танд сорилт бэрхшээл, айдастайгаа тулгарах талаар юу зааж байна вэ?

2 ТИМОТ 3

Сайн мэдээний дагуу амьдрах нь эцсийн өдрүүд дэх сүнслэг аюулаас хамгаалах хамгаалалтаар хангадаг.

Бид Паулын ярьсан “эцсийн өдрүүдэд” амьдарч байгаа бөгөөд “хэцүү цаг” ирчихээд байна (2 Тимот 3:1). Та 2 Тимот 3-ыг уншихдаа дурдагдсан эцсийн өдрүүдийн аюулуудыг бичиж ав (түүнчлэн 1 Тимот 4:1–3-ыг үзнэ үү):

Эргэн тойрондоо байгаа эсвэл таны амьдрал дахь эдгээр аюулын жишээ санаанд тань орж байна уу? Эдгээр аюул 6-р шүлэгт дүрсэлсэн хүмүүсийн адил хэрхэн “[танайд] гэтэж ороод, [таныг] олзолдог” вэ? Та 2 Тимот 3 болон энэ захидлын өөр хэсгээс таныг болон танай гэр бүлийг эдгээр сүнслэг аюулаас хамгаалж чадах ямар зөвлөгөөг олж байна вэ? (Жишээг 1 Тимот 1:3–11; 2 Тимот 2:15–16; Тит 2:1–8-аас үзнэ үү).

ФИЛЕМОН

Филемон гэж хэн байсан бэ?

Филемон Паулаар сайн мэдээнд хөрвөгдсөн Христийн шашинтан байсан. Түүнд Онесим нэртэй боол байсан ба тэр нь боолчлолоос оргон, Паултай уулзаж, мөн адил сайн мэдээнд хөрвөгдсөн. Филемонд хандан бичсэн захидалдаа Паул Онесимыг уучилж, түүнийг “боол шиг бус, харин боолоос ч илүү . . . хайрт дүүгээ” (16-р шүлэг) болгон хүлээж авахыг урамшуулан дэмждэг.

ФИЛЕМОН**Христийн дагалдагчид нэг нэгнээ өршөөдөг.**

Хэн нэгэн танаас өөрийг нь уучлаасай гэж хүссэн нөхцөл байдалд та орж байсан уу? Филемонд хандсан захидлыг уншихдаа тэрхүү нөхцөл байдлынхаа

тухай бодоорой. Паул яагаад Онесимыг уучлах хэрэгтэй талаар Филемонд юу заасан бэ? Энэ захидалд танд хандсан мэт санагдах ямар нэгэн захиас байна уу?

Түүнчлэн 1 Нифай 7:16–21; Мозая 26:30–31-ийг үзнэ үү.

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

1 ТИМОТ 2:9–10

Эмэгтэйчүүдийн зохистой хувцаслалтын талаарх Паулын зөвлөгөөний үзэл бодол бидний үед тохирдоггүй учраас бид бүгд “өөрсдийгөө даруу байдлаар . . . сайн үйлсээр чимэгтүн” хэмээх түүний зөвлөгөөнөөс суралцах боломжтой. Танай гэр бүлийн хувьд өөр өөр төрлийн сайн үйлсээр хаягласан хувцас эсвэл гоёл чимэглэлийг зүүгээд, загварын шоу үзүүлэх нь зугаатай санагдаж болох юм. Энэ долоо хоногт танай гэр бүлийнхэн ямар ямар сайн үйл хийж болох вэ?

1 ТИМОТ 4:12

Гэр бүлийн гишүүдээ “итгэгч хүмүүст үлгэр дуурайл” байх хүсэлтэй байхад нь туслахын тулд хүмүүс тэдэнд хэрхэн сайн үлгэр жишээ болж байдаг талаар зураг зурахыг тэднээс хүсэж болно. Эдгээр хүн Есүс Христийг дагахад бидэнд хэрхэн сүнслэгээр нөлөөлж байна вэ? Ерөнхийлөгч Томас С.Монсоны

“Үлгэр жишээ мөн Гэрэл байгтун” (2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 75–77) хэмээх үгс танд зарим нэг санаа өгч болно.

1 ТИМОТ 6:7–12

Яагаад “мөнгөний хайрыг” “бүх төрлийн бузар муугийн үндэс” гэж үздэг гэж та бодож байна вэ? Амьдралаа мөнгөнд төвлөрүүлэхийн аюул юу вэ? Бид байгаа адислалдаа хэрхэн сэтгэл хангалуун байж чадах вэ?

2 ТИМОТ 3:14–17

Эдгээр шүлэгт цэдэглэснээр судруудыг мэддэг, судалдаг хүмүүст ямар ямар адислал ирдэг вэ? Гэр бүлийн гишүүд нэн “тустай” гэж бодсон судруудаа хуваалцаж болно.

ФИЛЕМОН 1:17–21

Паул Онесимын төлөө юу хийхэд бэлэн байсан бэ? Энэ нь Аврагчийн сайн дураараа бидний төлөө хийсэн зүйлтэй хэр зэрэг адилхан байна вэ? (Мөн 1 Тимот 2:5–6; С ба Г 45:3–5-ыг үзнэ үү). Бид Паулын болон Аврагчийн үлгэр жишээг хэрхэн дагаж чадах вэ?

Заах чадвараа сайжруулах

Энгийн бөгөөд тодорхой сургаал заа. Сайн мэдээ энгийн байдлаараа гайхалтай сайхан (С ба Г 133:57-г үзнэ үү). Маш их бэлтгэл шаардсан хичээлээр гэр бүлийнхнээ хөгжөөх гэж хичээхийн оронд цэвэр, энгийн сургаал заахыг хичээ (1 Тимот 1:3–7-г үзнэ үү).



Бурханы үгээс суралцах нь эцсийн өдрүүд дэх сүнслэг аюулаас биднийг хамгаална.



Анн Хенри, Галледын гавар

11-Р САРЫН 4-10

Еврей 1–6

Есүс Христ, “мөнх авралын эх үндэс”

Сүнслэг мэдрэмжүүдээ бичиж тэмдэглэх нь Ариун Сүнсний танд заахыг хүссэн зүйлийг таньж мэдэхэд тусална. Мэдэрснийхээ дагуу хэрэгжүүлэх нь эдгээр сүнслэг өдөөлтийг бодит гэдэгт итгэдгийг тань илэрхийлдэг.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Бид бүгдээрээ Есүс Христийн сайн мэдээг хүлээн авахын тулд муу зуршил, буруу итгэл эсвэл зохисгүй харилцаа зэрэг ямар нэгэн юмаа орхих хэрэгтэй болдог. Харийнхны хувьд хөрвөлт бол ихэвчлэн хуурамч бурхдаас татгалзана гэсэн үг байдаг. Харин еврейчүүдийн (иудейчүүд) хувьд хөрвөлт нь илүү хэцүү биш ч арай жоохон түвэгтэй байдаг нь батлагдсан. Эцэст нь тэдний нандигнадаг итгэл, уламжлал үнэн Бурханы сүсэг бишрэл, Түүний бошиглогчдын сургаалд хэдэн мянган жилийн өмнөөс үндэслэгдсэн байдаг. Харин төлөөлөгчид Мосегийн хууль Есүс Христээр гүйцэлдэж, дээд хууль нь одоо итгэгчдийн дунд жишиг болсон гэдгийг заасан. Христийн шашныг хүлээн авах нь

еврейчүүдийн хувьд эртний итгэл үнэмшил, түүхээсээ татгалзах ёстой гэсэн үг үү? Еврейчүүдэд бичсэн захидал нь Мосегийн хууль, бошиглогчид, ёслолууд нь бүгд чухал боловч Есүс Христ илүү агуу юм гэдгийг зааснаар иймэрхүү асуудлуудыг шийдэхэд туслахыг эрэлхийлсэн (Еврей 1:1–4; 3:1–6; 7:23–28-ыг үзнэ үү). Үнэндээ энэ бүх зүйл Христийг Бурханы Хүү, иудейчүүдийн хүлээсээр байсан амлагдсан Мессиа гэдгийг зааж, гэрчилдэг. Еврейчүүдэд болон бид бүгдэд зориулсан захиас нь Христээр дамжуулан бид “өршөөлийг хүлээн авах” (Еврей 4:16) боломжтой учраас заримдаа Есүс Христийг амьдрал, сүсэг бишрэлийнхээ гол цөм болгохын тулд уламжлалаасаа татгалзах ёстой гэсэн захиас юм.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ЕВРЕЙ

Еврейчүүдэд хандсан захидлыг хэн бичсэн бэ?

Зарим судлаач еврейчүүдэд хандсан захидлыг Паул бичсэн гэдэгт эргэлздэг. Еврей номын утга зохиолын хэв маяг нь Паулын бусад захианаас зарим талаар ялгаатай бөгөөд энэхүү бичээсийн хамгийн эртний хувилбарт зохиогчийн нэрийг оруулаагүй байдаг. Гэсэн хэдий ч Еврейд дурдсан санаанууд нь Паулын бусад сургаалтай нийцдэг учраас хожмын үеийн гэгээнтнүүд Христийн шашны уламжлалыг хадгалан, Паулыг энэ захидлыг бичихэд ядаж л оролцсон гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Судруудын удирдамжаас “Паулын захидлууд”-ыг үзнэ үү.

ЕВРЕЙ 1-5

Есүс Христ бол Тэнгэрлэг Эцэгийн “бодит илэрхийлэл” мөн.

Иудейчүүдээс олон нь Есүс Христийг Бурханы Хүү гэдгийг хүлээн зөвшөөрч чадаагүй. Еврейчүүдэд хандсан захидал нь Есүсийн тухай бүх зүйл Түүний Эцэгийг гэрчилж, үлгэрлэдэг гэдгийг заадаг. Та Еврей номын эхний таван бүлгийг уншихдаа Есүс Христийн дурдагдсан нэрс, үүрэг хариуцлага, зан чанар, ажлуудын олон жагсаалтыг гаргаж болно. Эдгээр зүйл нь Аврагчийн талаар танд юу зааж байна вэ? Тэдгээр нь танд Тэнгэрлэг Эцэгийн талаар юу зааж байна вэ?

Ахлагч Жэффри Р.Холландын хэлсэн дараах мэдэгдэл эдгээр бүлэг дэх сургаалын талаарх таны ойлголтон дээр юу нэмж байна вэ? “Есүс . . . Бурханы талаарх хүмүүний ойлголтыг сайжруулж, Тэнгэрлэг Эцэг өөрсдийг нь үргэлж хайрладаг мөн цаашид ч хайрлах учраас Түүнийг хайрлахыг тэднээс гуйхаар ирсэн. Тиймээс Христ өлссөнийг хооллон, өвчтөнийг эдгээж, хоёр нүүртнийг зэмлэн, итгэлтэй байхыг гуйснаараа Эцэгийн арга замыг бидэнд харуулж байгаа юм” (“The Grandeur of God,” *Ensign* эсвэл *Liahona*, 2003 оны 11-р сар, 72).

ЕВРЕЙ 2:9-18; 4:12-16; 5:7-8

Есүс Христ намайг ойлгож, надад туслахын тулд уруу таталт, сул дорой байдлын зовлонг амссан.

Та “нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очиж” өршөөл эрж чадна гэж бодож байна уу? (Еврей 4:16). Еврейчүүдэд хандсан захидлын нэг захиас нь гэм нүгэл, сул дорой байдлаас маань үл хамааран Бурхан бидэнтэй ойр дотно байдаг бөгөөд Түүний нигүүлсэл хүрч болохуйц байдаг гэсэн захиас юм. Та Еврей 2:9-18; 4:12-16; 5:7-8-аас Есүс Христ таны мөнх бус сорилт бэрхшээлүүдэд туслах болно гэсэн итгэлтэй байдлыг тань хүчирхэгжүүлэх юуг олсон бэ? Аврагч таны төлөө юу хийсэн талаарх өөрийн бодол, мэдрэмжүүдийг тэмдэглэлдээ бичиж тэмдэглэж болно.

Түүнчлэн Мозая 3:7-11; Алма 7:11-13; 34-ийг үзнэ үү.

ЕВРЕЙ 3:7-4:11

Бурханы адислалыг хүлээн авахын тулд би зүрхээ “хатуу болгох” ёсгүй.

Хэдийгээр тэд Христийн шашинд хөрвөгдсөн ч зарим иудей гэгээнтэн Есүс Христийн сайн мэдээг болон үүний адислалуудыг бүрэн хүлээн зөвшөөрч чадахгүй байсан. Паул эртний израильчуудын түүхийг давтан ярьснаар иудейчүүдийг итгэлгүйнхээ улмаас Бурханы адислалуудыг хүлээн аваагүй эцэг өвгөдийнхөө алдаанаас зайлсхийх талаар ухуулна гэж найдаж байсан. (Та Паулын эш татсан түүхийг Тооллого 14:1-12, 26-35-аас уншиж болно.)

Еврей 3:7-4:11 тантай хэрхэн холбогдож болох талаар бод. Үүнийг хийхдээ дараах асуултуудыг тунгаан бодож болно. Үүнд:

- Израильчууд Их Эзэнийг хэрхэн уурлуулсан бэ? (Еврей 3:8-11-ийг үзнэ үү). Хатуурсан зүрх сэтгэлтэй байхын үр дагавар юу вэ?
- Би хэзээ зүрх сэтгэлээ хатууруулж байсан бэ? Итгэлгүйнхээ улмаас хүлээн авч чадахгүй байгаа Бурханы надад өгөхийг хүссэн адислал байгаа юу?

- Би зөөлөн, харууссан зүрх сэтгэлтэй болохын тулд юу хийж болох вэ? (Ифер 4:15; Сургаалт үгс 3:5–6; Алма 5:14–15-ыг үзнэ үү).

Түүнчлэн 1 Нифай 2:16; 15:6–11; Иаков 1:7–8; Алма 12:33–36-г үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ЕВРЕЙ 1:8–9

Есүс зөвт байдлыг хайрладаг, ёс бусыг жигшдэг гэдгээ ямар арга замаар харуулсан бэ? Хэрэв бид зөвт бус хүслүүдтэй бол тэдгээрийг өөрчлөхийн тулд юу хийж чадах вэ?

ЕВРЕЙ 2:1–4

“Бидний сонссон” сайн мэдээний үнэнүүдийг хичээнгүйлэн дагах гэдэг нь ямар утгатай болохыг ойлгоход гэр бүлийнхэндээ туслах ямар үзүүлэнт хичээл таны санаанд орж байна вэ? Та үүнийг барьж авахад хэцүү ямар нэгэн эд зүйлээр үзүүлж болно. Гэрчлэлээ тордох бидний хичээл зүтгэл тэрхүү эд зүйлийг барьж авахтай хэр адилхан

байна вэ? “Бидний сонссон зүйл” биднээс “урсаад явчихгүй” байхад бид хэрхэн санаа тавьж чадах вэ? (1-р шүлэг).

ЕВРЕЙ 2:9–10

“Авралын зохиогч” хэмээх хэллэгийг судлахын тулд та нар зохиогч гэж хэн болох талаар ярилцсанаар эхэлж болно. Зохиогч юу хийдэг вэ? Есүс Христ бидний болон бидний авралын хувьд хэрхэн зохиогч болдог вэ?

ЕВРЕЙ 5:1–5

Эдгээр шүлэг нь эрх мэдэлтэй хэн нэгэн санваарыг атгахаар эсвэл Сүмийн бусад дуудлагыг хийхээр Бурханаар дуудагдах нь ямар утгатай болох талаар ярилцахад тань туслах боломжтой. Бид Есүс Христийн жишээнээс дуудлага хүлээн авч, биелүүлэх талаар юу сурч болох вэ?

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Өөр өөр арга барилыг туршиж үз. Судруудыг нэг л арга замаар судлахын оронд олон янзын судлах санааг туршиж үзэх талаар бод. Өөр санаа олохын тулд энэхүү эх сурвалжийн эхэнд байх “Хувиараа судар судлах үйл явцыг сайжруулах санаанууд” хэсгийг унш.



Волтер Рэйн, Христ шинэ дэлхийд зочилсон нь



Волтер Рэйн, Мелкизедек Абрамыг адисгалсан нь

11-Р САРЫН 11-17

Еврей 7–13

“Ирэх сайн юмсын Тэргүүн Тахилч”

Та Еврей 7–13-р бүлгийг уншихдаа Ариун Сүнсээр дамжуулан өдөөлтүүд хүлээн авч болно. Тэдгээрийг бичиж авах арга замуудыг эргэцүүлэн бод. Жишээ нь, та энэхүү тойм, судрынхаа зайд эсвэл Gospel Library аппликэйшнд бичиж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Итгэлтэй гэгээнтнүүд ч итгэлтэй байдлыг нь ганхуулж болох “буруутгал болон цөхрөлийн” зовлонг амсдаг (Еврей 10:32–38-ыг үзнэ үү). Христийн шашинд хөрвөгдсөн иудейчүүд шинэ итгэлээсээ болж ноцтой мөрдлөг хавчлагад өртөж байсныг Паул мэдэж байсан. Тэрээр тэднийг гэрчлэлдээ үнэнч үлдэхэд урамшуулан дэмжихийн тулд өөрсдийнх нь түүхээс үнэнч итгэгчдийн удаан хугацааны уламжлалыг сануулсан. Абел, Енох, Ноа, Абрахам, Сара, Иосеф, Мосе нь Бурханы амлалтууд жинхэнэ

бөгөөд үүнийг хүлээснээр буруудахгүй хэмээх “гэрчлэлийн үүл” юм (Еврей 12:1). Энэхүү итгэлийн өвийг “итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлдэг” (Еврей 12:2) хүмүүс хуваалцдаг. Зовлон зүдгүүр биднийг “ухрахыг” хүсэхэд хүргэх тоолонд бид Түүний ачаар итгэлийн бүрэн амлалтад “үнэн зүрхээрээ ойртон очиж” (Еврей 10:22, 38) чадна. Эрт үеийн гэгээнтнүүдийн адил бидний хувьд ч Есүс Христ бол “ирэх сайн юмсын Тэргүүн Тахилч” (Еврей 9:11) юм.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ЕВРЕЙ 7:1–22

Мелкизедек санваар нь дээд санваар юм.

Хэдэн зууны турш Аароны санваар хэмээн нэрлэгдсэн Левитийн санваарыг иудейчүүд ашигладаг байсан. Харин Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдалтай хамт бүр илүү агуу адислалуудыг амладаг Мелкизедек санваар ирсэн. Та Еврей 7-оос Мелкизедек санваарын тухай юу сурсан бэ? Таны олж болох үнэнүүдийн зарим жишээг доор өгөв. Үүнд:

Иосеф Смитийн Орчуулга, Еврей 7:3: Мелкизедек санваарт томилогдсон хүмүүс “Бурханы Хүүтэй адил болгогддог” ба “үүрд тахилчаар байдаг”.

Еврей 7:11: Левийнхний санваар “төгс төгөлдөр байдлыг” илэрхийлдэггүй ба тиймээс Мелкизедекээр солигдсон (С ба Г 84:18–22-ыг үзнэ үү).

Еврей 7:20–21: Мелкизедек санваар нь тангаргаар хүлээн авагддаг (С ба Г 84:19–44-ийг үзнэ үү).

Та Мелкизедек санваар болон үүнтэй холбоотой ёслолуудаас ямар ямар адислал хүлээн авсан бэ?

Түүнчлэн Алма 13:1–13; Сургаал ба Гэрээ 121:36–46; Судруудын удирдамжийн “Мелкизедек,” scriptures.lds.org; Henry B. Eyring, “Faith and the Oath and Covenant of the Priesthood,” *Ensign or Liahona*, May 2008, 61–64 мөн Даллин Х.Өүксийн “Санваарын түлхүүрүүд ба эрх мэдэл” үгийг 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулганы х. 68–71-ээс үзнэ үү.

ЕВРЕЙ 9:1–10:22

Эртний болон өнөө үеийн ёслолууд бидний оюун бодлыг Есүс Христ рүү чиглүүлдэг.

Энэхүү захидлын анхны еврей уншигчид нь Паулын дүрсэлсэн эртний асар, ёслолуудыг маш сайн мэддэг байсан болов уу. Гэвч зарим нь эдгээр ёслолын зорилго нь Есүс Христийн цагаатгагч золиослол руу чиглүүлэх байсан гэдгийг бүрэн ухаараагүй.

Ариун Библийн үед эвлэрүүллийн өдөр хэмээгддэг жил бүрийн амралтын өдөр тэргүүн тахилч Иерусалимын ариун сүмийн хамгийн ариун (Ариунаас ариун) газарт орон, Израилийн нүглүүдийг цагаатгахын тулд ямаа эсвэл хургаар золиослол өргөдөг байжээ. Паул Есүс Христ бол дэлхийнхний гэм нүглийг цагаатгахын тулд цор ганц золиослол буюу өөрийнхөө амьдралыг өргөсөн тэргүүн тахилч юм хэмээн тайлбарласан (Еврей 9:24–10:14-ийг үзнэ үү).

Оролцдог ёслолуудынхаа талаар бод. Эдгээр ёслол таныг Есүс Христ рүү хэрхэн чиглүүлж байна вэ?

Эртний иудейчүүдийн ёслол, бэлгэдлүүдийн талаар дэлгэрэнгүй судлахын тулд “Асар,” “Золиослол ба ариун ёслол” зэрэг видео бичлэгүүдийг (LDS.org) үзнэ үү.

ЕВРЕЙ 11

Итгэл нь Бурханы амлалтуудад найдахыг шаарддаг.

Хэрэв хэн нэгэн танаас итгэлийг тодорхойлохыг хүсвэл та юу гэж хариулах вэ? Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн асан Анн С.Пингрий эгч энэхүү тодорхойлолтыг өгөхдөө Еврей 11-ийн хэллэгүүдийг ашигласан. Тэрээр “Итгэл буюу ‘алсаас’ харагддаг амлалтуудад итгэхээр үнэмшүүлэгдсэн боловч энэ амьдралд хүлээн авч чадахгүй байж болох сүнслэг чадвар нь үнэнээр итгэдэг хүмүүсийн жишиг юм” хэмээсэн (“Seeing the Promises Afar Off,” *Ensign* эсвэл *Liahona*, 2003 оны 11-р сар, 14).

Та Еврей 11 дээрх санаануудыг тунгаан бодохдоо итгэлийн талаарх өөрийн гэсэн тодорхойлолт гаргахыг бодоорой. Энэ бүлэгт дурдагдсан хүмүүсийн үлгэр жишээ танд итгэлийн талаар юу зааж байна вэ? (Мөн Ифер 12:6–22-ыг үзнэ үү.)

Түүнчлэн Алма 32:21, 26–43; Жэффри Р.Холланд, “An High Priest of Good Things to Come,” *Ensign*, 1999 оны 11-р сар, х. 36–38-ыг үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ЕВРЕЙ 10:32-36

Та гэр бүлийн гишүүдээсээ үнэнд “гэгээрүүлэгдсэн” мэт мэдрэмж хүлээн авсан үеийнхээ сүнслэг туршлагыг хуваалцахыг хүсэж болно. Эдгээр туршлага бидэнд сорилт бэрхшээлтэй эсвэл эргэлзээтэй үедээ “итгэлээ хаяхгүй” байхад хэрхэн тусалж болох вэ?

ЕВРЕЙ 11

Та гэр бүлийнхэндээ Еврей 11-д гардаг итгэлтэй байдлын үлгэр жишээнээс суралцахад хэрхэн тусалж чадах вэ? Эдгээр жишээний зарим түүхийг жүжигчлэн тоглох нь зугаатай байж болох юм. Эсвэл танай гэр бүлийнхэн өвөг дээдэс, Сүмийн удирдагчид, орон нутгийн тань гишүүн зэрэг таньдаг итгэлтэй хүмүүсийнхээ жишээг ярилцаж болох юм.

ЕВРЕЙ 12:2

Энэ шүлэгт цэдэглэснээр Есүс Христ яагаад загалмай дээрх өвчин шаналал, зовлон зүдгүүрийг тэвчих хүсэлтэй байсан бэ? Энэ нь бидэнд сорилт бэрхшээлдээ тэвчих талаар юу зааж байна вэ? Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон “Баяр баясгалантай байж, сүнслэг байдлын хувьд тэсэж үлдэх нь” (2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 71–75) хэмээх захиастаа энэхүү шүлгийн талаарх тус болох ойлголтуудыг өгсөн.

ЕВРЕЙ 12:5-11

Яагаад Их Эзэн биднийг сахилгажуулж, засаж залруулдаг вэ? Эдгээр шүлгийг хамтдаа судалж байхдаа гэр бүлийн гишүүд тань Их Эзэн сахилгажуулахыг ямар байдлаар хардаг тухай юуг олж анзаарсан бэ? Эдгээр шүлэг сахилгажуулалт хүлээн авах эсвэл өгөх арга замд тань хэрхэн нөлөөлж байна вэ?

Заах чадвараа сайжруулах

Сүнсийг урьж, сургаалаас суралцахад дуу хөгжим ашигла. Тэргүүн Зөвлөлийнхөн “Дуу хөгжим нь [биднийг] илүү агуу сүнслэг байдалд хүргэдэг хязгааргүй их хүч чадалтай” (“First Presidency Preface,” *Сүмийн дуулал*, х) хэмээн хэлсэн байдаг. “True to the Faith” (*Сүмийн дуулал*, д. 254) зэрэг итгэлийн тухай дуу нь Еврей 11-ийн тухай гэр бүлийн ярилцлагыг баяжуулж болох юм.



Эртний ариун сүмийн тэмдгүүд болон үүний ёслолууд Есүс Христийн үүрэг хариуцлагыг заасан.



Грант Ромни Клуусон, Абрахам Мамрегийн царс модны дэргэд

11-Р САРЫН 18-24

Иаков

“Зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бологтун”

Та Иаковын захидлыг уншихдаа онцгой санагдсан үг хэллэгүүдэд анхаарлаа хандуулж, бичиж тэмдэглэ. Та эдгээр үнэний дагуу амьдрахаар хэрхэн өдөөгдөж байна вэ?

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Заримдаа судрын ганцхан шүлэг дэлхийг өөрчилж чаддаг. Иаков 1:5 нь хэрэв танд мэргэн ухаан хэрэгтэй бол Бурханаас асуу гэсэн энгийн зөвлөгөө мэт санагддаг. Гэвч 14 настай Иосеф Смит энэ шүлгийг унших үед “энэ нь [түүний] зүрх сэтгэлийн бодол болгонд агуу хүчтэйгээр нэвтрэн орох мэт санагджээ” (Иосеф Смит—Түүх 1:12). Сүнслэгээр өдөөгдсөн Иосеф Иаковын зөвлөгөөг даган, залбирлаар дамжуулан Бурханаас мэргэн ухааныг эрэлхийлсэн. Бурхан тийн өгөөмрөөр хандаж, Иосефт хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн гайхамшигтай тэнгэрлэг айлчлалын нэг болох Анхны үзэгдлийг өгсөн юм. Энэхүү үзэгдэл Иосефын амьдралын чигийг өөрчилж, дэлхий дээрх Есүс Христийн Сүмийг

сэргээхэд хөтөлсөн. Иосеф Смит Иаков 1:5-ыг уншиж, үүнийг үйлдэл болгосны ачаар өнөөдөр бид бүгд адислагдаж байна.

Та Иаковын захидлыг судлаад юу олох вэ? Магадгүй ганц, хоёр шүлэг таныг эсвэл хайртай хэн нэгнийг тань өөрчлөх болно. Та амьдралынхаа үүргийг биелүүлэхийг эрэлхийлэхдээ удирдамж олж болно. Та найрсаг ярих эсвэл илүү тэвчээртэй байх урмыг олж болно. Юу ч танд сүнслэгээр нөлөөлсөн бай, эдгээр үгийг “зүрх сэтгэлийн[хээ] бодол болгонд . . . нэвтрэн орох” боломж олго. Иаковын бичсэнээр “үгийг даруухнаар хүлээж авагтун. Тэр үг та нарын сэтгэлийг аврах чадалтай” (Иаков 1:21).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИАКОВ

Иаков гэж хэн байсан бэ?

Иаковын захидлын зохиогчийг Есүс Христийн ээж Мариагийн хүү буюу Аврагчийн дүү гэж нийтээрээ итгэдэг. Иаковыг Матай 13:55; Марк 6:3; Үйлс 12:17; 15:13; 21:18 болон Галат 1:19; 2:9-д дурдсан байдаг. Эдгээр судраас Иаков бол Иерусалим дахь Сүмийн удирдагч байсан бөгөөд төлөөлөгчөөр дуудагдсан гэдэг нь харагддаг (Галат 1:19-ийг үзнэ үү).

ИАКОВ 1:2-4; 5:7-11

Тэвчих нь төгс төгөлдөр байдал руу хөтөлдөг.

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф “Хүлээх нь хэцүү байж болно. Бид хүссэн юмаа яг одоо авахыг боддог. Тиймээс тэвчээр гэдэг нь таагүй, заримдаа бүр хэцүү зүйл байж болно” (“Тэвчээрээр үргэлжлүүл,” 2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 67) хэмээн заасан. Иаков 1:2-4; 5:7-11-ийг уншсанаах дараа тэвчээрийн талаарх Иаковын гол захиас нь юу байсан гэж та хэлэх вэ? Ерөнхийлөгч Угдорфын захиасыг уншиж дууссаны дараа танд ямар нэмэлт санаа, ойлголт төрж байна вэ? Та тэвчээртэй байх хүсэлтэй байгаагаа Их Эзэнд хэрхэн харуулж чадах вэ?

ИАКОВ 1:3-8, 21-25; 2:14-26; 4:17

Итгэл нь үйлдлийг шаарддаг.

Та Есүс Христэд итгэлтэй эсэхээ яаж мэдэх вэ? Таны үйлдэл Бурханд итгэх итгэлийг тань хэрхэн харуулдаг вэ? Та итгэлийн тухай заасан Иаковын сургаалыг судлахдаа эдгээр асуултын талаар бодоорой. Мөн Иаковын дурдсан хоёр жишээ болох Абрахам, Рахаб нарын тухай унших нь сонирхолтой байж болох юм (Эхлэл 22:1-12; Иошуа 2-ыг үзнэ үү). Тэд Бурханд итгэдэг гэдгээ хэрхэн харуулсан бэ?

Иаков 1:3-8, 21-25; 2:14-26; 4:17-г унших нь танд үгийн илүү сайн үйлдэгч байхад туслах арга замуудыг бодоход тань тусалж болно. Хүлээн авсан аливаа сэтгэгдлээ бичиж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга.

Түүнчлэн Алма 34:27-29; 3 Нифай 27:21-ийг үзнэ үү.

ИАКОВ 1:26; 3:1-18

Миний хэлдэг үгс бусдыг шархлуулах эсвэл адислах хүчтэй.

Захидлынхаа турш ашигласан Иаковын нарийн дүрслэлийн дунд хэлний *талаарх* зөвлөгөөнөөс түүний хамгийн ойлгомжтой тод хэллэгүүд олддог. Хэл эсвэл амыг дүрсэлсэн Иаковын бүх хэрэглээг жагсаан бичих талаар бодож үзнэ үү. Харьцуулалт эсвэл дүрс бүр бидний хэлдэг үгсийн талаар юу санал болгож байна вэ? Үгээрээ хэн нэгнийг адислахын тулд хийж болох зүйлсийг бод (С ба Г 108:7).

ИАКОВ 2:1-9

Есүс Христийн шавийн хувьд би бүх хүнийг нөхцөл байдлаас нь үл хамааран хайрлах хэрэгтэй.

Иаков гэгээнтнүүдэд баян чинээлэг хүмүүст тал засаж, ядуусыг гадуурхахын эсрэг тодорхой сэрэмжлүүлсэн бөгөөд түүний сэрэмжлүүлэг бусдад хандан бидний гаргаж болох нэг талыг баримтлах эсвэл ялгаварлах байдалд хамаарч болно. Бусдыг сөргөөр шүүх байдлаа анзаарахад хэцүү байж болох ч Их Эзэн бидэнд сайжруулах хэрэгтэй талуудаа олж харахад туслах болно хэмээн амласан (Ифер 12:27-г үзнэ үү). Та Иаков 2:1-9-ийг залбирч судлахдаа өөрийн зүрх сэтгэлийг сонсож, Ариун Сүнсний өдөөлтүүдэд анхаарлаа хандуулаарай. Бусдад хэрхэн ханддагтаа эсвэл тэдний талаар юу гэж боддогтоо өөрчлөлт хийх хэрэгтэй гэсэн мэдрэмж төрж байна уу?



Гэр бүлээрээ судар судлахад болон гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИАКОВ 1:5

Иаков 1:5-ыг уншаад, гэр бүлийн нэг гишүүнээс Анхны үзэгдлийн түүхийг (Иосеф Смит—Түүх 1:8–13 эсвэл LDS.org дээрээс “Бурханаас асуу: Иосеф Смитийн анхны үзэгдэл” видео бичлэгийг олж үзнэ үү) тоймлон ярихыг хүс. Гэр бүлийнхээ гишүүдийг бошиглогч Иосеф Смитийн талаарх гэрчлэл, Тэнгэрлэг Эцэг залбиралд нь хариулсан тухай туршлагаасаа хуваалцахад урь.

ИАКОВ 1:26–27

Эдгээр шүлэгтэй холбогдуулан “Жинхэнэ Христийн шашин” (LDS.org) видео бичлэгийг үзэж болно. Дараа нь цэвэр шашны талаарх Иаковын тодорхойлолтыг уншаад, гэр бүлийнхээ шашин шүтэх дадлыг илүү цэвэр ариун болгох арга замуудын тухай ярилц.

ИАКОВ 3

Иаков 3 дээр танай гэр бүлд найрсаг ярих тухай санахад туслах дурсамжтай үзүүлэнт хичээлүүдийн

санаа өгч болох олон зураг байгаа. Тухайлбал, та нар жижигхэн оч эсвэл шүдэнзнээс хэрхэн том гал түймэр гарч болдгийг ярилцаж, гэр бүлийн гишүүдийн найрсаг бус үг хэрхэн асуудал үүсгэж байсан мөчийн талаар бодож болох юм (5–6-р шүлгийг үзнэ үү). Эсвэл та савтай зөгийн баланд ордог лемоны шүүс зэрэг ихэвчлэн чихэрлэг хүнсэнд хэрэглэдэг ямар нэгэн исгэлэн эсвэл гашуун зүйлийг гэрийнхэндээ амсуулж болно. Энэ нь бидний үгс чихэрлэг бөгөөд урам хайрлаж байгаа эсэхэд анхаарч байх талаарх яриа руу хөтөлж болох юм.

ИАКОВ 4:5–8

Бид уруу таталттай тулгарах үедээ хэрхэн “Бурханд ойртох” вэ?

ИАКОВ 5:14–16

Санваарын адислал хүлээж авсан тухай хувийн гэрчлэлээ хуваалцах нь гэр бүлийн гишүүдэд “Сүнсний хүч чадал хэрэгтэй болсон үедээ санваарын адислал хүсэхэд” (Даллин Х.Өүкс, “Санваарын адислалуудын ач холбогдол,” *Лиакона*, 2012 оны 7-р сар,) нь урам өгч болох юм.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүл. Та суралцаж байхдаа сурч байгаа зүйлсээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар Сүнсний өдөөлтүүдийг сонс. Эдгээр мэдрэмжээ дагаж, сайн мэдээний дагуу илүү бүрэн дүүрэн амьдрах амлалт өг. (*Аврагчийн арга барилаар заах нь*, 35-р хуудсыг үзнэ үү.)



Жон Макностон, Бурханаас Гуйт



Роберт Т. Барретт, Христ сүнсийг дэлхийд номлож байгаа нь

11-Р САРЫН 25-ААС 12-Р САРЫН 1

1 ба 2 Петр

“Та нар хэлэхийн аргагүй, алдраар дүүрэн баяр хөөрөөр ихэд баярла”

Та Петрийн захидлыг уншихдаа хэрэгжүүлэх сүнслэг өдөөлтүүдийг хүлээн авч болно. “Сүнсэнд байх зуур” (С ба Г 76:80) сүнслэг өдөөлтүүдээ бичиж тэмдэглэснээр заалгаж байгаа зүйлээ ойлгож чадна.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ

Аврагч амилсныхаа дараахан Петрийг зовоож байсан байж болох зүйлийн талаар бошиглол хэлсэн. Тэрээр Петрийг өтөл насандаа “хүсээгүй газарт[аа] аваачи[гдаж] . . . , ямар үхлээр үхэж Бурханыг алдаршуулахыг” (Иохан 21:18–19) хэлсэн юм. Петр захидлуудаа бичихдээ энэхүү бошиглогдсон зовлонг үхэл ойртож буйг мэдсэн бөгөөд “бидний Эзэн Есүс Христийн надад тодорхой болгосончлон, би удахгүй асраа тайлахаа мэдэж байна” (2 Петр 1:14) хэмээжээ. Харамсалтай нь Петрийн хандан бичиж байсан Ром нутагт гэгээнтнүүдийн хувьд хатуу чанга хавчлага мөрдлөг түгээмэл байсан (1 Петр 1:1-ийг

үзнэ үү). Гэсэн ч түүний үгс айдас эсвэл гутралаар дүүрээгүй байв. Үүний оронд, тэрээр гэгээнтнүүдэд “элдвийн зовлонг эдэлж байгаа ч гэсэн” “үлэмж баярла” хэмээн заажээ. Тэр “Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэл” болон “сэтгэлийн аврал” руу хөтлөх “итгэлийн шалгуураа” (1 Петр 1:6–7, 9) санахыг тэдэнд зөвлөсөн. Петрийн итгэл “Христийн зовлонгуудыг хуваалцдаг, . . . ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд . . . баяр хөөртэйгөөр баярладаг” (1 Петр 4:13) өнөө үеийн гэгээнтнүүдэд урам өгдгийн адил эрт үеийн гэгээнтнүүдийг бас тайтгаруулж байсан нь лавтай.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 ПЕТР 1:3-9; 2:19-24; 3:14-17; 4:12-19

Би сорилт бэрхшээл, зовлон зүдгүүртэй үедээ баяр баяслыг олж чадна.

Петр *баярлах, аз жаргал, алдар болон баяр хөөртэйгөөр баярлах* зэрэг үгсийг бидний ерөнхийдөө *элдвийн зовлон, зовох, галт сорилт* болон *зовлон* гэх мэт зовлон бэрхшээлтэй холбон ашигладаг үгстэй хамааруулж ашигласан нь эхэндээ сонин санагдах байх (1 Петр 1:6; 2:19; 4:12-13-ыг үзнэ үү). Эрт үеийн гэгээнтнүүдэд заасан Петрийн захиас ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны захиастай адил байсан. “Гэгээнтнүүд ямар ч нөхцөл байдалд аз жаргалтай байж чадна. . . . Бид . . . амьдралаа Бурханы авралын төлөвлөгөө, Есүс Христ, Түүний сайн мэдээнд төвлөрүүлбэл юу тохиолдох, юу тохиолдохгүй байгаагаас үл хамааран баяр баясгаланг мэдрэх боломжтой. Баяр баясгалан Түүний ачаар, Түүнээс ирдэг. Тэр бол бүхий л баяр баясгалангийн эх үүсвэр юм” (“Баяр баясгалантай байж, сүнслэг байдлын хувьд тэсэж үлдэх нь,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 72).

Таныг 1 Петр 1:3-9; 2:19-24; 3:14-17; 4:12-19-ийг уншиж байхад хэцүү хүнд нөхцөл байдал дунд ч баяр баясалтай байж чадна гэсэн найдварыг юу өгч байна вэ?

1 ПЕТР 3:18-20; 4:1-6

Сайн мэдээ нас барагсдад тунхаглагдсанаар тэд шударгаар шүүгдэх боломжтой.

Нэг өдөр хүн бүр шүүхийн тавцангийн өмнө зогсож, “амьд болоод үхэгсдийг шүүхэд бэлэн байгч Түүнд тайлагнах болно” (1 Петр 4:5). Зарим хүн сайн мэдээг ойлгох, үүний дагуу амьдрах боломж хүмүүст өөр өөр байхад Бурхан яаж бүх хүнийг шударгаар шүүж чадах вэ гэж гайхаж болно. 1 Петр 3:18-20; 4:6-д заасан Бурханы шүүлт шударга байх болно гэдгийг ойлгоход тэр үеийн гэгээнтнүүдэд туслахын тулд Петрийн заасан сургаалыг анзаар. Эдгээр шүлэг Бурханы шударга ёсонд итгэх таны итгэлийг хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ?

Энэхүү сургаалыг лавшруулан судлахын тулд Сургаал ба Гэрээ 138-д гардаг ерөнхийлөгч Жозеф Ф. Смит Петрийн эдгээр бичээсийг тунгаан бодож

байхдаа хүлээн авсан илчлэлтийг судална уу. Нас барсан, сайн мэдээний ёслолуудыг хийлгэхээр хүлээж байгаа гэр бүлийнхээ гишүүдэд эдгээрийг боломжтой болгож өгдөг хүмүүст ямар ямар адислал ирдэг вэ?

2 ПЕТР 1:1-11

Би Есүс Христийн хүчээр дамжуулан бурханлаг мөн чанараа хөгжүүлж чадна.

Есүс Христтэй адил болж, Түүний зан чанарыг хөгжүүлэх нь танд боломжгүй мэт санагдаж байсан уу? Ахлагч Роберт Д.Хэйлс бид хэрхэн Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлж чадах талаар урам хайрласан бодлоо хуваалцсан. “Аврагчийн зан чанарууд бол . . . өөр хоорондоо сүлжилдсэн зан чанарууд бөгөөд бидний дотор харилцан нөлөөлөх маягаар өсөж хөгждөг. Өөрөөр хэлбэл, бид Христийн бусад зан чанарыг хөгжүүлэхгүй мөн бусдад нь нөлөөлөхгүйгээр ганц нэгийг нь хөгжүүлэх боломжгүй юм. Нэг зан чанар нь хүчтэй болж ирэхэд бусад зан чанар нь мөн адил хүчтэй болдог” (“Бидний Их Эзэн Есүс Христийн шавь болох нь,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 31-32).



Бидний хөгжүүлдэг Христийнхтэй адил зан чанар бүр бидэнд шавь байхын сүнслэг хивсийг нэхэхэд тусалдаг.

2 Петр 1:1-11-ийг ахлагч Хэйлсийн захиастай холбож уншаарай. Та энэ хоёр төлөөлөгчөөс Христтэй илүү адил болох хичээл зүтгэлд тань туслах юуг сурсан бэ?

Түүнчлэн 1 Петр 4:8; Дэвид А.Бэднарын “Үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтууд” хэлсэн үгийг 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулганы х. 87-91-ээс үзнэ үү.



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

1 ПЕТР 2:5-10

Та эдгээр шүлгийг гэр бүлийнхэнтэйгээ уншихдаа Аврагч бол бидний “булангийн үнэт чулуу” хэмээх Петрийн сургаалыг төсөөлөн бодоход гэр бүлийнхэнд тань туслах чулуунуудыг ашиглаж болно. Бид Бурханы хаант улсаа барихад ашиглаж байгаа “амьд чулуутай” юугаараа адилхан бэ? Бид Аврагч, Түүний хаант улс дахь өөрсдийн үүргийн талаар Петрээс юу сурдаг вэ? Танай гэр бүлийнхэнд хандсан Петрийн захиас юу вэ?

1 ПЕТР 3:8-17

Бид хэрхэн итгэлийн маань талаар асуух хүмүүст “хариу өгөхөд ямагт бэлэн байж” чадах вэ? Танай гэр бүлийнхэнд хэн нэгнийг сайн мэдээний тухай

асуулт тавьж байгаагаар жүжигчлэн тоглох нь зугаатай санагдаж болох юм.

1 ПЕТР 3:18-20; 4:6

Гэр бүлээрээ нас барсан өвөг дээдсийнхээ тухай мэдэж авахын тулд юу хийж болох вэ? Нас барсан өвөг дээдсийнхээ төрсөн өдрөөр түүний дуртай хоолыг хийж, зургийг нь тавьж эсвэл түүний амьдралын түүхийг ярьж болно. Боломжтой бол түүний төлөө ариун сүмд ёслолуудыг хийлгэхээр төлөвлөж болно.

2 ПЕТР 1:16-21

Эдгээр шүлэгт Петр гэгээнтнүүдэд Хувиралтын уулан дээрх өөрийн туршлагыг сануулсан (мөн Матай 17:1–9-ийг үзнэ үү). Бид эдгээр шүлгээс бошиглогчдын сургаалын талаар юу сурч болох вэ? (мөн С ба Г 1:38-ыг үзнэ үү). Өнөөгийн амьд бошиглогчоо дагах итгэлийг бидэнд юу өгдөг вэ?

Заах чадвараа сайжруулах

“Ямагт бэлэн бай.” Гэртээ санаандгүй байдлаар заах боломж хурдан ирж, хурдан өнгөрдөг учраас ийм боломж гарч ирсэн тохиолдолд тэр даруй ашиглах нь чухал. Та заах боломж гарсан үед гэр бүлийнхэндээ сайн мэдээний үнэнүүдийг зааж, “өөрийн доторх найдварыг” (1 Петр 3:15) хуваалцахад “ямагт бэлэн байхын” тулд хэрхэн хичээн чармайх вэ? (*Аврагчийн арга барилаар заах нь*, 16-г үзнэ үү).



Хэдийгээр Петр маш их хавчлага мөрдлөг, сэргэлдөөнтэй тулгарч байсан ч Христийн тухай гэрчлэлдээ зүйлшгүй хэвээр үлдсэн.



Дэл Парсон, Төгс хайр

12-Р САРЫН 2-8

1–3 Иохан; Иуда

“Бурхан бол хайр мөн”

Та Иохан, Иудагийн захидлуудыг уншихдаа Бурханд хайраа хэрхэн харуулах талаар сүнслэг мэдрэмжийг эрэлхийл. Эдгээр ойлголт, сэтгэгдлээ бичиж, хэрэгжүүл.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Иохан, Иуда хоёрыг захидлуудаа бичих үед хүчтэй хавчлага мөрдлөг болон гуйвуулагдсан сургаалын аль алиных нь үр дүнд урьдаас хэлэгдсэн урвалт үүсэж байсан. Зарим хуурамч багш Есүс Христ үнэхээр “махан биеэр” ирсэн эсэхэд хүртэл эргэлзэж байв (жишээ нь, 1 Иохан 4:1–3; 2 Иохан 1:7-г үзнэ үү). Тиймээс төлөөлөгч Иохан Аврагчийн тухай хувийн гэрчлэлээ хуваалцсанаар анхны захидлаа эхлүүлсэн. “Энэ бол эхнээсээ байсан бөгөөд бидний сонсож, нүдээрээ үзэж, харж, гараараа барьж үзсэн Амийн Үгийн тухай бидний өгсөн гэрчлэл юм”

(Иосеф Смитийн Орчуулга, 1 Иохан 1:1 [1 Иохан 1:1 дэх зүүлт тайлбар а]). Гэвч Иоханы захидлын хамгийн хүчирхэг захиас бол хайр буюу биднийг хайрлах Бурханы хайр, Түүнийг болон Түүний хүүхдүүдийг хайрлах ёстой бидний хайр юм. Эцэст нь Иохан өөрөө Аврагчийн хайрыг мэдэрсэн (Иохан 13:23; 20:2-ыг үзнэ үү) бөгөөд “хайрын дотор айдас байдаггүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулж” (1 Иохан 4:18) болохын тулд гэгээнтнүүдийг хүнд бэрхшээл, сөргөлдөөнтэй тулгарахдаа ийм хайрыг мэдрээсэй хэмээн хүссэн.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

1 ИОХАН

Бурхан бол гэрэл ба хайр мөн.

Хэрэв та нэг юм уу хоёр үгээр Бурханыг дүрслэх байсан бол ямар ямар үг сонгох байсан бэ? Иохан захидлууддаа “гэрэл” ба “хайр” гэсэн үгсийг ашигласан (1 Иохан 1:5; 4:8, 16). Та 1 Иоханыг уншихдаа Иоханы сайн мэдээнд цэдэглэгдсэн түүний туршлагаудын талаар тунгаан бодож, эдгээр туршлага Иоханд Бурханы гэрэл, хайрын тухай хэрхэн заасныг эргэцүүл. Бурхан бол гэрэл ба хайр гэдгийг танд ямар ямар хувийн туршлага тань заасан бэ?

Түүнчлэн Иохан 3:16–21; 15:9–17; 2 Нифай 26:24; Сургаал ба Гэрээ 50:24; 88:6, 12–13; 93:36–37-г үзнэ үү.

ИОХАН 2:24–3:3

Би Есүс Христтэй адилхан болж чадна.

Христтэй адил болох зорилго танд хэт өндөр санагдаж байсан уу? Иоханы “Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар Түүний дотор бай. Тэгвэл Түүнийг үзэгдэх үед бид Түүний өмнө зоригтой байж, . . . [мөн] бид Түүнтэй адил болно” (1 Иохан 2:28; 3:2) хэмээх урам хайрласан зөвлөгөөг эргэцүүлэн бодоорой. Та 1 Иохан 2:24–3:3-аас Есүс Христийн шавийн хувьд танд итгэл, тайтгарал өгч байгаа юуг олсон бэ? Та Иоханы захидлуудыг уншихдаа Христтэй адил болох хичээл зүтгэлд тань тус болох бусад зарчим, зөвлөгөөг эрж хайгаарай.

Мөн Моронай 7:48; Сургаал ба Гэрээ 88:67–68; “Becoming Like God,” Gospel Topics, topics.lds.org-ыг үзнэ үү.

ИОСЕФ СМИТИЙН ОРЧУУЛГА, 1 ИОХАН 4:12

“Хэн ч, хэзээ ч Бурханыг хараагүй” юу?

“Хэн ч, хэзээ ч Бурханыг хараагүй” гэдгийг Иосеф Смитийн Орчуулга, 1 Иохан 4:12-т “*итгэдэг тэднээс бусад хүмүүс*” хэмээн тодруулсан (1 Иохан 4:12, Зүүлт тайлбар а мөн Иохан 6:46; 3 Иохан 1:11-ийг үзнэ үү). Бурхан Эцэг Өөрийгөө Иохан зэрэг итгэлтэй хүмүүст харуулсан тухай хэд хэдэн тохиолдлыг судруудад цэдэглэсэн байдаг (Илчлэлт 4 мөн Үйлс 7:55–56; 1 Нифай 1:8; Сургаал ба Гэрээ 76:23; Иосеф Смит—Түүх 1:16–17-г үзнэ үү).

1 ИОХАН 5

Би Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, дахин төрснөөр ертөнцийг ялж чадна.

Иоханы бичээсүүдэд ертөнцийг ялах тухай хэд хэдэн удаа гардаг. Есүс “Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан” (Иохан 16:33) хэмээн хэлснийг Иохан тэмдэглэн авчээ. Мөн Илчлэлт 2–3 дахь бүлэгт Иохан ертөнцийг ялсан хүмүүст амласан Их Эзэний амлалтыг бичсэн байдаг. Иохан 1 Иохан 5:3–5-д ертөнцийг ялах тухай юу хэлсэн бэ? Та 1 Иохан 5-ыг уншихдаа бид ертөнцийг ялж, мөнх амьдралыг олж авахын тулд юу хийх ёстойг эрж олоорой. Таны амьдралд ертөнцийг ялах гэдэг нь ямархуу харагдаж болох вэ? Мөн та ахлагч Нийл Л.Андэрсэны “Дэлхийг ялах нь” хэмээх захиасаас хариулт, ойлголтуудыг олж болно (2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 46–50).



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

1 ИОХАН 2:8-11

Иоханы сургаалыг тунгаан бодоход нь гэр бүлийнхэндээ туслахын тулд харанхуй өрөөнд цуглаж, гэр бүлийн гишүүдээ “харанхуй дотор” алхах, “гэрлийн дотор” алхах хоёрын хоорондын ялгааг мэдэж авах боломж олго. Үзэн ядалт биднийг харанхуй дотор алхан, бүдэрч явахад хэрхэн нөлөөлдөг вэ? Нэг нэгнээ хайрлах нь бидний амьдралд гэрлийг хэрхэн авчирдаг вэ?

1 ИОХАН 3:21-22

Эдгээр шүлгийн юу нь бидний Бурханд болон залбиралдаа хариулт хүлээн авах чадвартаа итгэх “итгэлтэй байдлыг” өсгөдөг вэ? Та Судруудын удирдамжаас “Залбирал”-ыг хайж болно.

1 ИОХАН 5:2-3

Бидний “хүнд дарамт” эсвэл дагахад хэцүү гэж боддог ямар нэгэн зарлиг тушаал байна уу? Бурханыг

хайрлах бидний хайр Түүний зарлиг тушаалуудын талаарх бодол, мэдрэмжийг хэрхэн өөрчилдөг вэ?



Бурханы зарлигуудыг дагах нь бидэнд ертөнцийг ялахад тусалдаг.

ИУДА 1:3-4

Бидний амьдрал, гэр бүл рүү “сэм шургалан орсон” ямар нэгэн сүнслэг аюул байна уу? (Иуда 1:4). Бид “итгэлийн төлөө тэмцэж”, тэдгээрийн аюулыг сөрөн зогсох Иудагийн зөвлөмжийг хэрхэн дагаж чадах вэ? (Иуда 1:3). Бид гэр бүлдээ “амар тайван, хайр улам арвин болохыг” бататгахын тулд юу хийж чадах вэ? (Иуда 1:2).

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Бурханы хайрыг ол. Ахлагч М.Рассэлл Баллард “Сайн мэдээ нь Бурханыг болон нэг нэгнээ хайрлах хайрын сайн мэдээ юм” (“God’s Love for His Children,” *Ensign*, May 1988, 59) хэмээн заасан. Та судруудыг уншихдаа Бурханы хайрын илэрхийллийг харуулсан үгс, хэллэгийг тэмдэглэж, зурж болно.



Грэг К.Олсен, Надтай хамт алх



Дэл Парсон, Сайн Хоньчин

12-Р САРЫН 9-15

Илчлэлт 1–11

“Хурганд . . . алдар, сүр хүч нь үеийн үед байх болтугай”

Илчлэлтээс уншсан зүйлийнхээ талаар асуулт байвал бичиж аваарай. Та асуултуудынхаа хариултыг хайх эсвэл гэр бүлтэйгээ юм уу Сүмийн ангидаа энэ талаар ярилцаж болно.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Та хүчтэй сүнслэг туршлага авах үедээ юу мэдэрснээ бусдад илэрхийлэхийг хичээж байсан уу? Өдөр бүрийн хэл сүнслэг мэдрэмж, сэтгэгдлийг дүрслэхэд хангалтгүй санагдаж болно. Тиймээс Иохан сүр жавхлант илчлэлтээ дүрслэх гэж олон төрлийн бэлгэдэл, дүрслэлийг ашигласан байж болох юм. Тэрээр Есүс Христийг харсан гэдгээ энгийн байдлаар бичиж болох байсан ч туршлагыг нь ойлгоход бидэнд туслахын тулд Аврагчийг дүрслэхдээ “Түүний нүд нь галын дөл мэт,” “Түүний амнаас хоёр талдаа хурц иртэй илд цухуйх бөгөөд нүүр нь өөрийн хүчээр гэрэлтэх нар мэт байлаа”

(Илчлэлт 1:14–16) хэмээх үгсийг ашигласан байдаг. Та Илчлэлт номыг уншихдаа бэлгэдэл бүрийн цаад утгыг ойлгохгүй байсан ч таныг ойлгож, мэдрээсэй гэж хүссэн Иоханы захиасуудыг мэдэж авахыг хичээ. Тэр яагаад Сүмийн цугларагсдыг дэнлүүний сууриудтай, Сатаныг луутай, Есүс Христийг хургатай зүйрлэсэн байж болох вэ? Эцсийн дүнд та Есүс Христ, Түүний дагалдагчид хүмүүний болоод Сатаны хаант улсуудын дээр ялалт байгуулах болно гэсэн хамгийн чухал сэдвийг багтаасан чухал санааг нь ойлгохын тулд Илчлэлт дэх бэлгэдэл бүрийг ойлгох шаардлагагүй.



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИЛЧЛЭЛТ

Би Илчлэлт номыг яаж ойлгох вэ?

Илчлэлт ном нь ойлгоход хэцүү байж болох ч бүү шантраарай. Иоханы амлалт нь таныг хичээсээр байхад сүнслэгээр өдөөж болно. “Энэхүү бошиглолын үгсийг *уншдаг* мөн *сонсож*, *ойлгодог*, түүнчлэн тэнд бичигдсэн зүйлүүдийг *сахиддаг* тэд адислагдсан болой, учир нь Их Эзэний ирэлтийн цаг ойрхон байна” (Иосеф Смитийн Орчуулга, Илчлэлт 1:3 [Судруудын удирдамжид], тодотгол нэмэгдсэн).

Дараах асуулт, эх сурвалжууд Илчлэлтийг судлахад тань ойлголтуудаар хангаж болно.

- Иохан гэж хэн байсан бэ? (1 Нифай 14:18–27; Судруудын удирдамж, “Иохан”-ыг үзнэ үү.)
- Уг ном хэрхэн зохион байгуулагдсан бэ? Хайж болох ямар ямар сэдэв байгаа вэ? (Судруудын удирдамжийн “Иоханы илчлэлт”-ийг үзнэ үү.)
- Илчлэлт дэх бэлгэдлүүд юуг төлөөлдөг вэ? (Сургаал ба Гэрээ 77; *New Testament Student Manual* [Сүмийн Боловсролын Системийн гарын авлага, 2014], 525–68.)

Илчлэлтийн олон хэсэг дэх Иосеф Смитийн Орчуулгаас ойлголтуудыг хайх нь тустай байж болох юм. (Судруудын удирдамж дахь Иосеф Смитийн Орчуулгыг үзнэ үү.)

ИЛЧЛЭЛТ

Иоханы үзэгдэл Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүдийг хэрхэн авардгийг заадаг.

Та Илчлэлт номыг судалж эхлэхдээ, таны уншиж байгаа зүйлс Тэнгэрлэг Эцэгийн гэтэлгэлийн төлөвлөгөө, хүүхдүүдийнх нь өргөмжлөлийн талаар таны мэддэг зүйлстэй хэрхэн холбогдож байгаа тухай бод. Та *Миний сайн мэдээг номло* (51–65-р хуудас) дахь авралын төлөвлөгөөний тоймыг сэргээн харснаар эхэлж болно. Дараа нь Иоханы үзэгдэл дэх түүний түүхийг уншихдаа дараахтай төстэй асуултуудыг өөртөө тавь. Тэнгэрлэг Эцэг Өөрт нь эргэж очиход надад туслахын тулд юу хийсэн тухай ямар ямар үнэнийг би Илчлэлтээс сурах вэ? Энэ нь Бурханы надад зориулсан төлөвлөгөөг ойлгоход хэрхэн туслах вэ?

Дараах зүйлсийг ерөнхийд нь мэдэх нь тустай байж болно.

- 12-р бүлгийн ихэнх нь мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь үйл явдлуудыг авч үздэг.
- 6–11, 13–14, 16–19-р бүлэгт мөнх бус амьдрал, дэлхийн түүхийн үйл явдлуудыг дүрсэлдэг.
- 2–3, 15, 20–22-р бүлэгт эцсийн шүүлт, мөнх амьдралд итгэлтэй хүмүүсийг хүлээж буй алдар сууг дүрсэлсэн байдаг.

ИЛЧЛЭЛТ 2-3

Есүс Христ намайг мэддэг бөгөөд сорилтуудыг даван гарахад надад туслах болно.

Илчлэлт 2–3 дээрх Аврагчийн үгс Түүнийг Иоханы өдрүүд дэх Сүмийн салбар бүрийн амжилт, бэрхшээлийг ойлгодог байсан гэдгийг илэрхийлдэг. Тэрээр хэд хэдэн цуглааны гэгээнтнүүдэд тэдний “ажил үйлс”, “зовлон шаналал”, “ядуу байдал”, “хайрыг” (Илчлэлт 2:2, 9, 19) сайжруулж болох арга замыг нь бусад зүйлийн хамт мэддэг гэдгийг нотлон хэлсэн.

Эдгээр бүлэг нь Аврагч таны хүчирхэг болон сул талуудыг мэддэг бөгөөд дэлхийн сорилтуудыг даван гарахад тань туслахыг хүсдэг гэдгийг сануулж болно. Есүс Христ сорилтоо даван гардаг хүмүүст юу амладаг вэ? Та сорилтуудаа даван гарахын тулд ямар ямар өөрчлөлтийг хийхэд сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

ИЛЧЛЭЛТ 5

Зөвхөн Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг боломжтой болгож чадсан.

Хэдийгээр та санадаггүй ч Илчлэлт 5-р бүлэгт Иоханы дүрсэлсэн үйл явдалд оролцсон байх. Та эдгээр үйл явдлын талаар уншихдаа бид бүгдэд Есүс Христийг (“Хурга”) Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг боломжтой болгоно (хуйлмал номыг нээж, долоон лацыг эвдэх) гэдгийг ойлгоход ямар байсан болохыг бодож үзээрэй. Есүс Христ яагаад үүнийг хийж чадах цорын ганц нь байсан бэ? Та Аврагч болох Түүнд итгэх итгэлээ хэрхэн үзүүлж болох вэ?

Түүнчлэн Иов 38:4–7-г үзнэ үү.

ИЛЧЛЭЛТ 6-11**Сэргээлт нь Есүс Христийн Хоёр дахь ирэлтийн өмнө тохиох устгалын өмнө болно.**

Илчлэлт 6-11-д хожмын өдрүүдэд болох сайн мэдээний сэргээлт зэрэг дэлхийн түр зуурын

оршихуйн (С ба Г 77:6-г үзнэ үү) үед болох үйл явдлуудыг дүрсэлдэг (Илчлэлт 7-г үзнэ үү). Та Иоханы бошиглосон үйл явдлуудын тухай уншаад, заримынх нь тохиож байгааг харахдаа өөрийгөө болон гэр бүлээ Хоёр дахь ирэлтэд илүү сайн бэлтгэхийн тулд юу хийхээр сүнслэгээр өдөөгдөж байна вэ?

**Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд**

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИЛЧЛЭЛТ 2-3

Иохан амьдарч байсан үеийнхээ сүмүүдэд захиас өгсний адил танай гэр бүлд захиасаа хүргэхийг хүссэн гэж бод. Юу нь сайн болж байна гэж тэр хэлэх бол? Та хэрхэн сайжирч болох вэ?

ИЛЧЛЭЛТ 3:20

Аврагчийн хаалга тогшиж буй зургийг үзүүл (энэхүү тоймын хавсралтад байгаа зургийг үзнэ үү). Гэр


бүлийнхнээ Илчлэлт 3:20-ийг уншиж, дараахтай адил асуултуудыг хэлэлцэхэд урь. Яагаад Есүс Христ дотогшоо шууд орохын оронд хаалга тогшиж байгаа вэ? Бид Түүний нөлөөг хэрхэн гэр орондоо урьж болох вэ?

ИЛЧЛЭЛТ 7:9, 13-14

Эдгээр шүлэг нь бид яагаад ариун сүмийн ёслолуудад цагаан хувцас өмсдөг тухай юу зааж болох вэ?

Заах чадвараа сайжруулах

Асуулт тавихыг дэмж. Асуултууд нь гэр бүлийн гишүүд суралцахад болон заалгасан зүйлдээ хэрхэн хариу өгч байгаа бодлоосоо хуваалцахад бэлэн байгааг илэрхийлдэг. Гэр бүлийнхэндээ судруудаас хариултаа хэрхэн олохыг заа. (*Аврагчийн арга барилаар заах нь, 25-26-г үзнэ үү.*)



Грэг К.Олсон, Түүнийг дотогш оруул



Ден Берр, Малын хашаанд аюулгүй

12-Р САРЫН 16-22

Христийн мэндэлсний баяр

“Үлэмж баярлуулах сайн мэдээ”

Зарим хүний хувьд Христийн мэндэлсний баяр тайван бус үе байж болох юм. Шинэ Гэрээнээс судлах нь амар амгалан, ариун нандин байдлын сүнсийг амьдралдаа авчрахад тань хэрхэн тусалж болох талаар эргэцүүлэн бод. Өөрийн амьдрал дахь Аврагчийн төрөлт, номлолын нөлөөг тунгаан бодож, өөрт төрсөн аливаа сүнслэг сэтгэгдлийг бичиж тэмдэглэ.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

Хүүхдийн төрөлт хэрхэн тийм үлэмж баяр баяслыг авчирдаг вэ? Магадгүй шинэ хүүхэд найдварын бэлгэ тэмдэг байж чадах болохоор тэр байх. Боломжуудаар дүүрэн цоо шинэ амьдрал биднийг амьдрал тэр хүүхдийн ирээдүйд юу бэлдсэн бол, ямар гайхалтай зүйлсийг хийж, гүйцэлдүүлэх бол гэж бодоход хүргэдэг. Энэ нь Бурханы Хүү, Есүс Христийг төрөхөд юу юунаас илүү үнэн байсан юм. Хүүхдэд хэзээ ч тийм их найдвар хүлээлгэж байгаагүй бөгөөд асар их амлалттай төрсөн хүүхэд Түүнээс өөр байгаагүй.

Тэнгэр элч хоньчдыг тэжээлийн тэвшинд төрсөн нялх хүүхдийг ол хэмээн урихдаа тэр хүүхдийн талаар

захиас өгсөн. Энэ нь тэр хүүхэд ариун нандин үүрэг гүйцэтгэхээр дэлхийд ирсэн гэсэн найдварын захиас байсан юм. Хоньчид захиасыг “мэдүүллээ . . . хоньчдын тэдэнд ярьсан зүйл нь сонссон бүгдийн гайхлыг төрүүлжээ. Харин энэ үгийг Мариа зүрхэндээ тунгаан бодож, энэ бүхнийг нандигнан хадгалсан юм” (Лук 2:17-19). Энэ Христийн мэндэлсний баяраар Мариагийн жишээг даган, энэ жил Аврагчийн талаар сурсан зүйлсээ зүрхэндээ тунгаан бодох нь сайхан зүйл байж болно. Тэрээр таны уншсан түүхүүдэд гэтэлгэлийн номлолоо хэрхэн гүйцэлдүүлсэн бэ? Илүү чухал нь, Түүний номлол таны амьдралыг хэрхэн өөрчилсөн бэ?



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

МАТАЙ 1:18–25; 2:1–12; ЛУК 1:26–38; 2:1–20

Есүс Христ дэлхий дээр бидний дунд төрөхөөр доош бууж ирсэн.

Та өмнө нь Есүс Христийн төрөлтийн түүхийг олон удаа уншиж эсвэл сонсож байсан ч энэ удаа “Христийн мэндэлсний баяр бол Есүс дэлхийд зөвхөн *яаж* ирснийг тэмдэглэх биш, харин Түүнийг *хэн* болохыг буюу Есүс Христ, бидний Их Эзэн, Аврагч гэдгийг мөн *яах* гэж ирснийг нь мэдэж тэмдэглэх баяр юм” гэдгийг дотроо бодож судлаарай (Крэйг С.Кристенсэн, “The Fulness of the Story of Christmas” [Тэргүүн Зөвлөлийн Христийн мэндэлсний баяр, 2016 оны 12-р сарын 4], broadcasts.lds.org).

Та Есүс Христийг төрөхөөсөө өмнө хэн байсан талаар юу мэдэх вэ? (жишээ нь, Иохан 17:5; Мозая 3:5; С ба Г 76:13–14, 20–24; Мосе 4:2-ыг үзнэ үү). Энэхүү мэдлэг нь Түүний төрөлтийн талаар унших үед төрөх мэдрэмжид тань хэрхэн нөлөөлж байна вэ?

Та Есүс Христийн дэлхийд яах гэж ирсэн тухай юу мэдэх вэ? (жишээ нь, Лук 4:16–21; Иохан 3:16–17; 3 Нифай 27:13–16; С ба Г 20:20–28-ыг үзнэ үү). Энэхүү мэдлэг Аврагчийн талаарх таны мэдрэмжид хэрхэн нөлөөлж байна вэ? Энэ нь амьдрах хэв маягт тань хэрхэн нөлөөлж байна вэ?

Түүнчлэн 2 Коринт 8:9; Еврей 2:7–18; 1 Нифай 11:13–33; Алма 7:10–13; “Христийн төрөлт” (LDS.org) видео бичлэгийг үзнэ үү.

**1 КОРИНТ 15:21–26; КОЛОССАЙ 1:12–22;
1 ПЕТР 2:21–25**

Есүс Христ үүргээ биелүүлж, мөнх амьдралыг өвлөн авах боломжийг надад олгосон.

Хэдийгээр Христийн төрөлтийн түүх гайхамшигт үйл явдлуудаар дүүрэн байдаг ч хожим нь Тэр амьдралдаа агуу ажлыг хийж гүйцэтгээгүй бол Түүний төрөлт энгийн л нэг төрөлт байх байсан. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли “Гетсемани болон Калвари дахь гэтэлгэгч Христ, Амилалтын гайхамшигт нотолгоогүйгээр Бетлехемийн нялх Есүс энгийн л нэг нялх хүүхэд байх байсан” (“The Wondrous and True Story of Christmas,” *Ensign*, Dec. 2000, 5) гэжээ.

Аврагчийн бурханлаг номлол, бусдыг хайрлах хүчит хайрын нотолгоо Шинэ Гэрээгээр дүүрэн байдаг. Ямар хэсэг болон түүх таны санаанд орж ирж байна вэ? Та энэхүү эх сурвалж, судлах тэмдэглэлээ дахин харж, тэмдэглэж авсан сэтгэгдлүүдээ үзэж болно. Та түүнчлэн 1 Коринт 15:21–26; Колоссай 1:12–22; 1 Петр 2:21–25-ыг уншаад, Аврагч болон Түүний ажил таны амьдралыг хэрхэн адисалсан тухай тунгаан бодож болно. Та амьдралдаа юуг өөрчлөхөөр сүнслэгээр өдөөгдөж байна вэ? Та Аврагчийн хүчинд хэрхэн ойртож болох вэ?



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцолж, хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

МАТАЙ 1:18-25; 2:1-12; ЛУК 1:26-38; 2:1-20

Та гэр бүлтэйгээ Есүс Христийн төрөлтийг хэрхэн тэмдэглэж болох вэ? Хэд хэдэн санааг доор дурдав. Мөн та нар өөрсдөө бодож олж болно.

- Христийн төрөлтийн түүхийн хэсгээс хамтдаа уншиж эсвэл жүжигчлэн тоглож болно.
- “Христийн төрөл” (LDS.org) видео бичлэгийг үз.
-
- Христийн мэндэлсний баярт зориулсан Тэргүүн Зөвлөлийн онцгой цугларалтыг үзэж болно (broadcasts.lds.org;).
- Хамтдаа Христийн мэндэлсний баярын дууг дуулах юм уу айлчилж очин дуу дуулж өгч болох хөрш, найзуудаа сонго (*Сүмийн дуулал*, 201-214 дэх дууллыг үзнэ үү).
- Үйлчлэл үзүүл.

- Гэр бүлийн гишүүдээсээ Христийн төрөлтийн түүхээс Есүс Христийг санагдуулах чимэглэл, тоглоом хийх санаа өгөх дэлгэрэнгүй мэдээллийг эрж олохыг хүсэж болно.

1 КОРИНТ 15:21-26; КОЛОССАЙ 1:12-22; 1 ПЕТР 2:21-25

Яагаад бид Есүс Христийг төрсөнд талархдаг вэ? Тэр бидэнд ямар ямар бэлэг өгсөн бэ? Бид Түүнд талархлаа хэрхэн илэрхийлэх вэ?

“АМЬД ХРИСТ: ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ГЭРЧЛЭЛ”

Та гэр бүлийнхэндээ Христийн мэндэлсний баярын үеэр Аврагчид анхаарлаа төвлөрүүлэхэд нь туслахын тулд хамтдаа “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл” (*Ensign* эсвэл *Liahona*, May 2017, inside front cover)-ийг судалж, уншихад цаг зарцуулж болох юм. Та нар “Амьд Христ” хэсгийг цээжилж эсвэл үүн дээрх мэдэгдлүүдийг дэмждэг Шинэ Гэрээн дэх Аврагчийн амьдралын тухай дүрслэлийг хайж олж болно. Та гэр бүлийн гишүүн бүрээ Есүс Христийн тухай гэрчлэлээ бичээд, сүнслэгээр өдөөгдөж байгаа бол гэрийнхэндээ уншиж өгөхөд урьж болно.

Хувиараа судлах үйл явцаа сайжруулах

Есүс Христийг эрж хай. Судрууд бидэнд бүх зүйл Есүс Христийг гэрчилдэг хэмээн заадаг (Моше 6:62-63-ыг үзнэ үү). Тиймээс бид бүх зүйлд Түүнийг эрж хайх хэрэгтэй. Та судруудыг уншихдаа Түүний тухай заадаг шүлгүүдийг тэмдэглэж, зурж болно. Христийн мэндэлсний баярын өмнөх өдрүүдэд Есүс Христийн тухай гэрчилдэг эргэн тойрондоо байгаа зүйлсийг эрж хайхад цаг гарга.



Брайн Колл, Христ мэндэлсэн нь



Кэйт Парсон, Мөнхийн холг

12-Р САРЫН 23-29

Илчлэлт 12–22

“Ялагч нь бүх зүйлийг өвлөнө”

Та Илчлэлт 12–22-ыг уншихдаа өнөөгийн дэлхийд Иоханы харсан зүйлс болон өөрийн харж байгаа зүйлсийн хооронд адил зүйл байгаа эсэхийг олж хар. Иоханы бэлгэдлийн хэл ярианд автахдаа хувийн сургамж олоход тань туслах сүнслэг удирдамжийг эрэлхийл.

ТӨРСӨН СЭТГЭГДЛЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ _____

“Хэвлийдээ үртэй . . . төрөхөөр өвдөж” байгаа эмэгтэйг төсөөлөн бод. Одоо “долоон толгойтой, арван эвэртэй агуу том улаан луу” уг эмэгтэйн дээрээс “төрмөгц хүүхдийг нь залгихын тулд” (Илчлэлт 12:2–4) бэлэн байж байна гэж төсөөл. Иоханы илчлэлтийн эдгээр шүлгийг ойлгохын тулд эдгээр дүр зураг Сүм, Бурханы хаант улс, тэдэнд учрах аюул эрсдэлийг төлөөлж байгаа гэдгийг санаарай. Иоханы үед хүнд мөрдлөг хавчлагыг биеэр үзсэн ариун хүмүүсийн хувьд хилэнцийг ялах ялалт үгүй мэт санагдаж байсан байх. Энэхүү ялалт бидний

үед ч гэсэн дайсан “ариун хүмүүстэй дайн хийж,” “аливаа овог, ард түмэн, хэлтэн, үндэстнүүдийг захирах эрх мэдэлтэй” (Илчлэлт 13:7) байгаа үед урьдчилан харахад хэцүү байж болно. Гэвч Иоханы илчлэлтийн төгсгөлд сайн сайхан хилэнцийг ялан дийлэх болно гэдгийг алдар суутайгаар харуулдаг. Вавилон нурах болно. Есүс Христ Хаадын Хаан болон засаглах болно. “Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина” мөн итгэлтнүүд Түүнтэй хамт засаглаж, “эдгээр зүйлийг өвлөх” болно (Илчлэлт 21:4, 7).



Хувиараа судар судлахад зориулсан санаанууд

ИЛЧЛЭЛТ 12:7-17

Тэнгэр дэх дайн дэлхий дээр үргэлжилдэг.

Бид тэнгэр дэх дайны тухай ихийг мэдэхгүй ч Илчлэлт 12:7-17-д үүний тодорхой атлаа товчхон дүрслэл байдаг. Та эдгээр шүлгийг уншихдаа өөрийгөө мөнх бус байдлын өмнөх зөрчилдөөний нэг хэсэг болж байснаар төсөөл. Эдгээр шүлэг нь та болон Бурханы бусад итгэлтэй хүүхэд Сатаныг хэрхэн ялан дийлэх талаар юу зааж байна вэ? Тэр бидний үед “Есүсийн гэрчлэлийг сахидаг [хүмүүстэй] дайтсаар” байхад түүнийг хэрхэн ялан давах тухай энэ нь юу ойлгуулдаг вэ? (17-р шүлэг).

Түүнчлэн 1 Нифай 14:12-14; Судруудын удирдамжийн “Михаил,” “Тэнгэр дэх дайн”-ыг үзнэ үү.

ИЛЧЛЭЛТ 14:6-7

Сайн мэдээг номлож байсан, Иоханы харсан тэнгэр элч хэн бэ?

Эдгээр шүлэг дэх энэхүү бошиглолын нэгэн биелэл бол Моронай Иосеф Смитэд үзэгдсэн мөн орчуулж, Мормоны Ном болгон хэвлэсэн цэдгүүд рүү түүнийг удирдсан явдал юм. Энэхүү ном нь “аливаа үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд” тунхаглахаар бидний цэнэглэгдсэн “мөнхийн сайн мэдээг” (Илчлэлт 14:6) агуулдаг.

ИЛЧЛЭЛТ 17-18

Их Эзэн Вавилон болон үүний гэм нүглээс зугтахад урьдаг.

Илчлэлт 17-18-д дэлхийн, ёс бус байдлын тэмдэг болсон Вавилоны нүгэл, материаллаг үзэл, шуналыг дүрсэлсэн сэтгэл санаа зовоосон дүр төрхийг агуулдаг. Өнөө үед дэлхий дээр байгаа Вавилонтой адил нөхцөл байдлын жишээг бодож, Вавилоноос “гарч,”

“тэр эмийн нүглүүдэд хамтрагч болохгүй” (Илчлэлт 18:4) байх зөвлөгөөг дагахын тулд юу хийж чадах эсэхээ тунгаан бод.

ИЛЧЛЭЛТ 20:12-15

Бурханы бүх хүүхэд амийн номын дагуу шүүгдэх болно.

Нэгэн зохиолч таны амьдралын тухай ном бичих санал тавьсан гэж бод. Та ямар туршлага, мэдээллийг оруулахыг хүсэх вэ? Таны ирээдүйн үйлдэл ч бас бичигдэх болно гэдгийг мэдвэл та амьдралдаа хэрхэн өөрөөр хандах вэ? Илчлэлт 20:12-15-д гардаг шүүлтийн өдрийн тухай уншихдаа энэ талаар бодоорой. Амийн номонд таны тухай юу бичигдэнэ гэж та найдаж байна вэ?

Мөн Судруудын удирдамжийн “Амийн ном”-ыг үзнэ үү.

ИЛЧЛЭЛТ 22:1-5

Би итгэлтэй байвал селестиел алдар сууг хүлээн авах болно.

Вавилоны дүрслэлийн эсрэг Илчлэлт 21-22-т селестиел алдар суу нь Христийн үнэн дагалдагчийг дүрсэлсэн байдаг. Эдгээр бүлэг дэх ямар дүр зураг, хэллэг эсвэл амлалтууд таныг хүнд хэцүү байсан ч итгэлтэй хэвээр байхад сүнслэгээр өдөөж байна вэ?

ИЛЧЛЭЛТ 22:18-19

Эдгээр шүлэг Ариун Библиэс гадна ямар ч нэмэлт судар байж болохгүй гэсэн утгыг илэрхийлж байна уу?

Зарим хүн Мормоны Ном болон хожмын үеийн бусад судрыг эсэргүүцэх шалтгаанаар Илчлэлт 22:18-19-ийг эш татдаг. Гэсэн ч ахлагч Жэффри Р.Холланд:

“Библи судалдаг эрдэмтэд энэ шүлэг нь бүхэл бүтэн Библид *биш* зөвхөн Илчлэлтийн номонд хамаатай гэсэн нэг бодол санаатай байдаг. Манай үеийн эрдэмтэд Шинэ Гэрээний хэд хэдэн ном нь эргэл-зээгүйгээр Патмын арал дээр хүлээн авсан Иоха-ны илчлэлтийн *дараа* бичигдсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөг. . . .

Гэвч илүү энгийн хариулт байгаа. . . . Яагаад гэвэл, тухайн шүлгийг бичих үед бидний мэддэгээр бүхэл бүтэн Библи нь олон номыг ганц боть болгосон хэлбэрээр байгаагүй юм” хэмээн заасан (“My Words . . . Never Cease,” *Ensign* эсвэл *Liahona*, May 2008, 91).



Гэр бүлээрээ судар судлахад мөн гэр бүлийн үдэшт зориулсан санаанууд

Гэр бүлээрээ судар судлах үед тань гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулахын тулд ямар зарчмуудыг онцлох мөн хэлэлцэхийг мэдэхэд Сүнс танд туслах болно. Дараах саналуудыг хавсаргав. Үүнд:

ИЛЧЛЭЛТ 12:19 21

Гэр бүлийн зарим гишүүний хувьд Илчлэлтэд дүрс-лэгдсэн үзэгдлийг зурах нь зугаатай, үр дүнтэй байж магадгүй. Тухайлбал, Илчлэлт 12-т тулгуурлан зурах нь Тэнгэр дэх дайны тухай яриа руу хөтөлж болох юм (7-11-р шүлэг-ийг үзнэ үү). Илчлэлт 21-д тулгуурласан зургууд селестиеел хаант улсын тухай яриаг өдөөж магадгүй. Мөн та энэхүү тоймд хавсаргасан зургийг үзүүлж, тухайн зургийн дүрсэлсэн шүлгүүдийг Илч-лэлт 19-өөс олохыг гэр бүлийн гишүүдээсээ хүс.

ИЛЧЛЭЛТ 12:11

“Гэрчлэлийн үгээр” гэдэг үгс ямар утгатай байж болох вэ? Есүс Христийн тухай бидний гэрчлэл

Сатаныг ялан дийлэхэд бидэнд болон бусдад хэрхэн туслах вэ?

ИЛЧЛЭЛТ 13:11-14

Мэхлэгч араатны талаар танай гэр бүлийнхэн ямар бодолтой байна вэ? Бид өнөөгийн дэлхийд харагд-даг хууран мэхлэлтийг хэрхэн илрүүлж, түүнээс зайлсхийх вэ?

ИЛЧЛЭЛТ 20:2-3

1 Нифай 22:26; Сургаал ба Гэрээ 43:30-31 нь бидэнд Сатан “хүлэгдэх” гэдэг нь ямар утгатай байж боло-хыг ойлгоход хэрхэн туслах вэ?

ИЛЧЛЭЛТ 22:1-4

“[Бидний] духан дээр” Аврагчийн нэр байх нь бэл-гэдлийн ямар утгатай байж болох вэ? Илчлэлт 22:4 мөн Илчлэлт 13:16-17-г үзнэ үү.

Заах чадвараа сайжруулах

Үйлдэх урилгын дагуу үйлдсэн эсэхийг эргэн шалга. “Та үйлдэх урилгын гүйцэтгэлд хяналт тавьснаар [гэр бүлийн гишүүддээ] санаа тавьдаг гэдгээ мөн сайн мэдээ тэдний амьдралыг хэрхэн адисалж байгааг харуулж байгаа юм. Түүнчлэн та тэдэнд туршлагаасаа хуваалцах боломж олгохоос гадна эргээд үүргээ биелүүлэхэд нь тэднийг хүчирхэгжүүлж, сайн мэдээний дагуу амьдрахад нэг нэгэндээ дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжийг олгодог” (*Аврагчийн арга барилаар заах нь*, 35).



Цагаан морь унасан, улаан орхимжтой Христ.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

